



Монгол Улс дахь алтны бичил уурхайн салбар:

planetGOLD Монгол төслийн бүс
нутгийн нөхцөл байдлын судалгаа



2021 ОНЫ 1-Р CAP



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Агуулга

Судалгааны тайлангийн тухай.....	3
Хүснэгтийн жагсаалт.....	7
Зургийн жагсаалт.....	8
Тайлангийн хураангуй	11
Нэр томъёо, товчилсон үг, тайлбар	26
1. Ерөнхий мэдээлэл	28
1.1 Монгол Улсын алтны салбар	28
1.2 Судалгааны зорилго ба хамаарал	34
1.3 Судалгааны загвар, аргачлал.....	35
1.4 Хүндрэл бэрхшээл, хязгаарлалтууд.....	42
2. Судалгааны бүс нутгийн нийгэм-эдийн засгийн асуудлууд.....	46
2.1 Зорилтот аймаг, сумдын хүн ам, нийгэм-эдийн засгийн байдал	46
2.2 Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтүүд	49
2.3 Судалгаанд оролцогчдын нийгэм-эдийн засгийн байдал.....	51
2.4 Бичил уурхайчдын ажлын зохион байгуулалт ба орлого	54
2.5 Нийгмийн үйлчилгээний хүртээмж	60
2.6 КОВИД-19 цар тахлын нөлөөлөл	65
2.7 Дүгнэлт	67
3. Алтны бичил уурхайн эрх зүйн орчин, албажуулалт.....	69
3.1 Алтны бичил уурхайн түүх ба Засгийн газрын арга хэмжээнүүд.....	69
3.2 Бичил уурхайн зохицуулалтын бодлого, эрх зүйн орчин	70
3.3 Холбогдох төрийн байгууллагууд.....	73
3.4 Бичил уурхайн албажуулалт.....	75
3.5 Судалгааны бүс нутаг дахь албажуулалтын нөхцөл байдал	78
3.6 Дүгнэлт	83
4. Уул уурхайн практик үйл ажиллагаа.....	85
4.1 Хүдэр олборлолт ба баяжуулалт.....	85
4.2 Байгаль хамгаалал болон байгаль орчны менежмент	101
4.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	108
5. Мөнгөн усны хэрэглээ	120
5.1 Мөнгөн усны хэрэглээг зохицуулах талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ.....	120
5.2 Мөнгөн усны хэрэглээний тооцоолол.....	122
5.3 Мөнгөн ус эрүүл мэндэд нөлөөлөх талаар мэдлэг, ойлголт	128
5.4 Дүгнэлт	130
6. Алтны бичил уурхай дахь жендэрийн зураглал.....	132
6.1 Эмэгтэй, эрэгтэй уурхайчдын нийгэм-эдийн засгийн байдал	132
6.2 Алтны бичил уурхай дахь жендэрийн динамик.....	136
6.3 Ахуйн хүрээн дэх жендэрийн динамик	160
6.4 Дүгнэлт	164
7. Алтны худалдаа ба нийлүүлэлтийн сүлжээ.....	168
7.1 Алтны худалдааны хууль эрх зүйн орчин	168
7.2 Судалгааны бүс нутаг дахь алтны худалдаа.....	170

7.3	Гарал үүслийг мөшгөх тогтолцоо ба магадлан шинжилгээ	178
7.4	Санхүү, хөрөнгө оруулалтын хүртээмж	181
7.5	Дүгнэлт	183
8.	Уул уурхайн сайн туршлага хэрэгжүүлэх чадавх	186
8.1	Уурхайчдын мэдээллийн эх сурвалж	186
8.2	Бичил уурхайчдын сургалтад хамрагдсан туршлага ба сургалтын хэрэгцээ шаардлага	189
8.3	Дүгнэлт	194
9.	Зөвлөмж	195
10.	Ашигласан номын жагсаалт	208
11.	Хавсралтууд	213
	Хавсралт А: Тоон судалгааны асуулга	213
	Хавсралт Б: Ганцаарчилсан ярилцлагад оролцсон байгууллага, албан тушаалтнууд	224
	Хавсралт В: Ганцаарчилсан ярилцлагын асуултууд	225
	Хавсралт Г: Жендэрийн гүнзгийрүүлсэн судалгааны арга зүй	238

Судалгааны тайлангийн тухай

Энэхүү тайланг planetGOLD Монгол төслийн гүйцэтгэгч байгууллага болох Алтны бичил уурхайн зөвлөл (АБУЗ)-өөс төсөл хэрэгжиж буй газруудад (цаашид судалгааны бүс нутаг гэх) үйл ажиллагаа явуулж буй алтны бичил уурхайн нөхцөл байдлыг судалж, төслийн хүрээнд цаашид гарах өөрчлөлтийг үнэлэх жишиг үзүүлэлтүүдийг тодорхойлон, суурь мэдээллээр хангах зорилгоор боловсруулсан болно. Судалгаа нь төслийн хэрэгжилтэд нэн чухал хэрэгцээтэй мэдээллээр хангахаас гадна зарим тохиолдолд төслийн суурь мэдээллийн эх сурвалж болно.¹

Даян дэлхийн байгаль орчны сан (ДДБОС)-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөрөөр удирдуулан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр болон Байгаль хамгаалах олон улсын байгууллагатай хамтран planetGOLD хөтөлбөрийг дэлхийн 9 улсад хэрэгжүүлж байна. Монгол Улсын хувьд Алтны бичил уурхайн зөвлөл нь Монгол Улсын Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран planetGOLD Монгол төслийг хэрэгжүүлж байна. planetGOLD төсөл нь алтны бичил уурхайн салбарыг албажуулах үйл явцыг сайжруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх, төслийн зорилтот бүс нутгийн уурхайчдад албан ёсны алтны зах зээлд нэвтрэх, мөнгөн усгүй баяжуулах техник, тоног төхөөрөмж худалдаж авах, хариуцлагатай уул уурхай, жендэрийн болон байгаль орчны хариуцлагатай практик дадлыг нэвтрүүлэхэд шаардагдах хөрөнгө олоход нь зуучлах замаар мөнгөн усны хэрэглээг халахад хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж байгаа билээ. Төсөл хэрэгжсэнээр бичил уурхайчид олборлолтын нөхцөл байдал, тухайн нутгийн хэрэгцээнд тохирсон мөнгөн усгүй алт баяжуулах технологийг нэвтрүүлэх боломжтой болно.

Төсөл нь дараах 4 бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд 2023 оныг дуусталх хугацаанд хэрэгжинэ:

Төслийн үр дүнд (I) Алтны бичил уурхайн албажуулалт нэмэгдэж, (II) Уурхайчдын хариуцлагатай алтны худалдааны зах зээлд нэвтрэх боломж сайжран, (III) Алтны бичил уурхай дахь мөнгөн усны ялгарал буурах бөгөөд (IV) олон улсад мэдээлэл түгээлт нэмэгдсэн байна.

Энэхүү тайланг Эс Ай Си Эй ХХК-ийн дэмжлэгтэйгээр боловсруулсан. Эс Ай Си Эй ХХК нь судалгааны арга аргачлал болон мэдээлэл цуглуулах хэрэгсэл боловсруулах, мэдээлэл цуглуулах, шивэх, мэдээллийн анхан шатны боловсруулалтын ажлыг хариуцаж гүйцэтгэсэн болно. Эдгээр бүх үе шатуудад АБУЗ болон planetGOLD Монгол төслийн багтай хамтран ажилласан. Түүнчлэн planetGOLD Монгол төслийн баг мэдээлэл цуглуулах явцад орон нутагт ажиллаж, судалгааны уулзалтуудад оролцсон юм².

¹ Нөхцөл байдлын судалгаа нь төслийн суурь түвшнийг бүрэн харуулахгүй бөгөөд төслийн баримт бичигт тодорхойлсноор төслийн суурь мэдээллийн матрицыг тусад нь бөглөж эцэслэнэ.

² planetGOLD Монгол төсөл нь АБУЗ-ийн жендэрийн шинжээчтэй хамтран тухайн салбар дахь жендэрийн гүнзгийрүүлсэн судалгааг явуулсан.

Энэхүү судалгаанд зөвхөн Сэлэнгэ, Говь-Алтай, Ховд аймгуудаас төсөлд хамрагдсан газруудыг хамруулсан хэдий ч бичил уурхай эрхэлж буй иргэдийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, тэдний эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хүртээмж, жендэрийн асуудал, алтны үндсэн ордын хүдэр олборлох, баяжуулах үйл ажиллагаа, технологи, мөнгөн усны хэрэглээ, байгаль орчны менежмент ба нөхөн сэргээлт, уурхайчдын сургалтын хэрэгцээ зэрэг алтны бичил уурхайн бүхий л асуудлуудыг судалж, тус тайланд тусгасан болно. Судалгааны үр дүн, зөвлөмж нь уурхайчдын хүний эрхийг хамгаалах, жендэрийн тэгш байдлыг хангах, хариуцлагатай уул уурхайд чиглэсэн бодлого, дүрэм журмын төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

Монгол Улс 2015 онд Минамата конвенцыг соёрхон баталж, улмаар Монгол Улсын Засгийн газраас Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр (ҮХ)-ийг 2019 оны 8-р сарын 19-нд баталсан. Энэхүү Үндэсний хөтөлбөр нь бичил уурхайд ашиглаж буй хоцрогдсон технологийг бүрэн халах, албажуулах үйл явцыг эрчимжүүлэх, бичил уурхайгаар алт олборлогчид болон тэдний гэр бүлийн гишүүд, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, мөнгөн усны сөрөг нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дөрвөн зорилт дэвшүүлж, 13 стратегийг тодорхойлсон. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд planetGOLD төсөл нь өөрийн үйл ажиллагаагаар дамжуулан дорвитой хувь нэмэр оруулах юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр ба Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аж Үйлдвэрийн Хөгжлийн Байгууллагын тухай

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр (НҮББОХ) нь даян дэлхийн байгаль орчны тэргүүлэгч байгууллага бөгөөд байгаль орчны бодлогыг тодорхойлж, НҮБ-ын хүрээнд тогтвортой хөгжлийн байгаль орчны асуудлуудыг харилцан уялдаатайгаар хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг даян дэлхийн байгаль орчныг сурталчлах эрх бүхий байгууллага юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага (НҮБАҮХБ) нь ядуурлыг бууруулах, улс орнуудад даяарших боломж болон байгаль орчны тогтвортой байдлыг бий болгох аж үйлдвэрийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг НҮБ-ын төрөлжсөн байгууллага юм. planetGOLD хөтөлбөрийг хэрэгжүүлэгч эдгээр байгууллагуудын хувьд НҮББОХ нь 1, 2 ба 4-р бүрэлдэхүүн хэсгүүдийг, НҮБАҮХБ нь 3-р бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтийг хариуцна.

Дээрх хоёр байгууллагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.unep.org/> болон <https://www.unido.org/> веб хуудаснуудаас авна уу.

Алтны бичил уурхайн зөвлөлийн тухай

Алтны бичил уурхайн зөвлөл нь (АБУЗ) Канад Улсын Викториа хотод төвтэй, хөгжиж буй орнуудын бичил уурхайчдын тогтвортой хөгжлийг дэмжих зорилго бүхий ашгийн бус байгууллага юм. АБУЗ нь мэдээлэл түгээх, сургалт, боловсрол олгох, чадавх бий болгох замаар алтны бичил уурхайн салбарын нөхцөл

байдлыг сайжруулах зорилт тавин ажиллаж байна. Түүнчлэн АБУЗ-аас хэрэгжүүлж байгаа олон төрлийн арга хэмжээ болон бичил уурхайчдын хандлага нь практик үйл ажиллагааг үндэсний болон олон улсын бодлоготой үр дүнтэй холбох боломжийг бий болгож байна. Дэлхий дахины алтны бичил уурхайн салбарын нөхцөл байдлыг сайжруулах, дэлхийн 80 гаруй орны бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байгаа сая сая хүнд эерэг үр нөлөө үзүүлэхийн тулд өөрсдийн гүн гүнзгий практик мэдлэг дээр үндэслэн дараах стратегийн асуудлуудад гол анхаарлаа хандуулж ажилладаг. Үүнд: сайн туршлага, засаглал, амьжиргаа, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, жендэрийн тэгш байдал, зах зээлийн хүртээмж болон хөгжлийн асуудлууд болно. Баялгийн үр дүнтэй хуваарилалтыг дэмжсэн байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, албан ёсны алтны бичил уурхайн салбарыг бий болгоход цогцоор нь хандахыг зорьж байна.

АБУЗ-ийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг www.artisanalgold.org веб хуудаснаас авна уу.

ЭС АЙ СИ ЭЙ ХХК-ийн тухай

Зөвлөгөө, дүн шинжилгээний статистикийн байгууллага (Эс Ай Си Эй ХХК) нь статистикийн судалгаа, дүн шинжилгээ, мэргэжлийн зөвлөх үйлчилгээгээр дамжуулан Монгол Улсын нийгэм, бизнесийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор 2010 онд байгуулагдсан. Эс Ай Си Эй ХХК нь суурь судалгаа, мониторинг ба дунд шатны үнэлгээ, бичиг баримтын судалгаа, төгсгөлийн шатны үнэлгээ явуулах зэрэг судалгаа, үнэлгээний ажлын төсөл боловсруулах, хэрэгжүүлэх туршлагатай. Эс Ай Си Эй ХХК өөрийн судалгааны загвар, арга зүйд шинжлэх ухааны хандлага, үр дүнтэй мэдээлэл цуглуулах, тодорхой дүн шинжилгээ хийх шинэлэг шинэ технологийг тусгасан болно. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг www.sica.mn болон www.datamon.mn холбоосоор орж авна уу.

Талархал

Энэхүү суурь үнэлгээг хийхэд үнэтэй зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, Эс Ай Си Эй ХХК, Сэлэнгэ, Ховд, Говь-Алтай аймаг зэрэг судалгааны бүс нутгийн аймаг, сум, багийн төр захиргааны байгууллагуудын ажилтнууд, уул уурхайн салбарын холбогдох орон нутгийн байгууллагууд, байгаль орчны идэвхтнүүдэд талархал илэрхийлж байна.

Уг судалгааг зохион байгуулж, явуулахад болон төслийн хэрэгжилтийн явцад бидэнтэй хамтран ажиллаж байсан алтны бичил уурхайчид, бичил уурхайн нөхөрлөлүүд, ТББ-уудын дэмжлэг, туслалцаагүйгээр энэ ажлыг хийж гүйцэтгэх боломжгүй байсан бөгөөд эдгээр хүмүүст талархал илэрхийлж байна.

Мэдэгдэл

Энэ тайланг planetGOLD Монгол төслийн албан хэрэгцээнд зориулж боловсруулсан бөгөөд олон нийтэд түгээх зорилгоор хийгдээгүй болно. Зохиогчид судалгааны тоон өгөгдөл, мэдээллийн үнэн зөвийг нягтлах, бүрэн бүтэн байдлыг хангахын тулд маш их хүчин чармайлт гаргасан хэдий ч энэ

тайланд тусгагдсан зөвлөмжийг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь авч хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа үр дагаварт хариуцлага хүлээхгүй болно. Дэвшүүлсэн санал, тоон мэдээллийг тайлан гарсан өдрийн байдлаар гаргасан тул урьдчилж мэдэгдэлгүйгээр өөрчлөх боломжтой.

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.3-1. Анхан шатны мэдээлэл цуглуулахад ашигласан аргууд	35
Хүснэгт 1.3-2. Түүврийн хүрээ (нөхөрлөл, гишүүдийн тоо, зохион байгуулалтгүй уурхайчдын тоо, судалгааны бүс нутгаар)	39
Хүснэгт 1.3-3. Албажсан байдал (харьяалагддаг байгууллага, гишүүнчлэл, судалгааны бүс нутгаар).....	40
Хүснэгт 1.3-4. Түүврийн хэмжээ (судалгааны бүс нутаг, хүйсээр).....	40
Хүснэгт 2.1-1. Судалгааны бүс нутгийн нийт хүн ам (хүйсээр) (Эх сурвалж: ҮСХ, 2020 он).....	46
Хүснэгт 2.2-1. Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдал (судалгааны бүс нутгаар, хүйсээр).....	50
Хүснэгт 2.3-1. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин (судалгааны бүс нутаг, хүйсээр).....	51
Хүснэгт 2.3-2. Судалгаанд оролцогчдын сууцны төрөл (судалгааны бүс нутаг, хүйсээр).....	52
Хүснэгт 2.3-3. Судалгаанд оролцогчдын орлогын эх үүсвэрт бичил уурхайн эзлэх хувь (судалгааны бүс нутаг, хүйсээр).....	53
Хүснэгт 2.3-4. Судалгаанд оролцогчдын үндсэн хөдөлмөр эрхлэлт (судалгааны бүс нутаг, хүйсээр)	53
Хүснэгт 2.3-5. Бичил уурхайгаас үндсэн орлого олдог уурхайчдын хоёрдогч хөдөлмөр эрхлэлт (судалгааны бүс нутаг, хүйсээр)	54
Хүснэгт 2.4-1. Судалгаанд оролцогчдын зохион байгуулалт, гишүүнчлэл (судалгааны бүс нутаг, хүйсээр)	55
Хүснэгт 2.4-2. Судалгаанд оролцогчдын алтны бичил уурхайд эрхэлдэг ажил үүрэг (судалгааны бүс нутаг, хүйсээр)	56
Хүснэгт 2.4-3. Судалгаанд оролцогчдын алтны бичил уурхай эрхэлсэн туршлага (судалгааны бүс нутаг, хүйсээр).....	56
Хүснэгт 2.4-4. Зорилтот аймгууд болон улсын хэмжээнд ажиллагсдын сарын дундаж цалин хөлс.....	57
Хүснэгт 2.4-5. Судалгаанд оролцогчдын алтны бичил уурхайгаас олдог сарын дундаж орлого (судалгааны бүс нутаг, хүйсээр).....	59
Хүснэгт 2.4-6. Алтны бичил уурхайгаас олдог сарын дундаж орлого (эрхэлдэг ажил, албан тушаал, албажсан байдлаар)	59
Хүснэгт 2.4-7. Сарын дундаж орлого (зохион байгуулалтын хэлбэрээр).....	59
Хүснэгт 2.5-1. Судалгаанд оролцогчдын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж (судалгааны бүс нутаг, хүйсээр).....	64
Хүснэгт 2.6-1. Цар тахлын алтны бичил уурхайд үзүүлж буй нөлөөлөл (судалгааны бүс нутаг, хүйсээр) ..	65
Хүснэгт 2.6-2. Судалгаанд оролцогчдын амьжиргаанд коронавируст халдварын цар тахлын үзүүлж буй нөлөөлөл (олон төрлийн хариултууд; нийт=404)	67
Хүснэгт 3.5-1. Нөхөрлөлүүд болон гишүүдийн тоо (судалгааны бүс нутгаар).....	78
Хүснэгт 3.5-2. Уурхайн талбайн мэдээлэл (судалгааны бүс нутгаар (АМГТГ, 2019))	80
Хүснэгт 3.5-3. Уурхайн холбогдолтой зөвшөөрөл авах, гэрээ байгуулахад тулгарч байсан бэрхшээл, сорилтууд (судалгааны бүс нутгаар)	83
Хүснэгт 4.1-1. Уурхайн амны байрлал ба төрөл	87
Хүснэгт 4.1-2. Хүдэр олборлолтын жилийн дундаж хэмжээ (судалгааны бүс нутгаар).....	89
Хүснэгт 4.1-3. Уурхайчдад тохиолддог нийтлэг бэрхшээл (судалгааны бүс нутгаар)	90
Хүснэгт 4.1-4. Монгол Улсын хэмжээнд байгаа бичил уурхайн алтны хүдэр баяжуулах цех болон тээрмүүд	92
Хүснэгт 4.1-5. Уурхайчид хүдрээ баяжуулдаг байршил.....	93
Хүснэгт 4.1-6. Тухай баяжуулах цех буюу тээрэм сонгодог шалтгаан	94
Хүснэгт 4.1-7. Баяжуулах цехүүдийн үйл ажиллагааг сайжруулах талаарх уурхайчдын санал	98
Хүснэгт 4.1-8. Алтны үйлдвэрлэлийн хэмжээ.....	98
Хүснэгт 4.1-9. Алтны үйлдвэрлэлийн харьцуулалт	99
Хүснэгт 4.1-10. Баяжуулалтын дундаж өртөг	99
Хүснэгт 5.2-1. Судалгааны бүс нутгийн мөнгөн үсны хэрэглээ (мэдээлэл авах боломжтой бол) (Эх сурвалж: Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн Алтны бичил уурхайн цогц судалгаа, Монгол Улсын Засгийн газар, 2020)	122
Хүснэгт 6.2-1. Бичил уурхайд ажилладаг хугацаа (сар, долоо хоног, өдөр тутамд) (хүйсээр)	136
Хүснэгт 6.2-2. Удирдах ажилд эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн оролцоо, (судалгааны бүс нутгаар) (ногоон $\geq 50\%$, шар $\geq 25\%$).....	140
Хүснэгт 6.2-3. Олборлолтын талбайд гардаг хүндрэл, бэрхшээл (судалгааны бүс нутгаар, хүйсээр, олон сонголттой, нийт= 490)	156
Хүснэгт 6.3-1. Судалгаанд оролцогч гэрлэсэн иргэдийн өрхийн түвшинд гол шийдвэр гаргагчид (хүйсээр болон нийт)	163
Хүснэгт 7.2-1. Алтны дундаж худалдаа, долоо хоногт, сард, жилд (судалгааны бүс нутгаар болон нийт) 171	
Хүснэгт 7.2-2. Алтны худалдааны судалгааны хураангуй хүснэгт.....	172

Хүснэгт 7.2-3. Алтаа худалдаалах сонголт (нөхөрлөлийн ахлагч нарын хариулснаар)	175
Хүснэгт 7.2-4. Монголбанканд алтаа худалдаалж байсан туршлага (хүйсээр)	176
Хүснэгт 7.3-1. Судалгааны бүс нутаг дахь бичил уурхайчдын үйл ажиллагааны бүртгэл хийх дадал	180
Хүснэгт 7.3-2. Бүртгэл хийх дадал (байгууллагын төрлөөр)	180
Хүснэгт 7.4-1. Олборлолтын үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжууд (судалгааны бүс нутгаар, олон хариулттай, нийт=545)	182
Хүснэгт 8.2-1. Сургалт зохион байгуулагчид (судалгаанд оролцогчдын мэдээлснээр n=141)	191
Хүснэгт 8.2-2. ТББ болон нөхөрлөлүүдийн ахлагч нарын онцолж хэлсэн сургалтуудын хэрэгцээ шаардлага (судалгааны бүс нутгаар) (сургалтын хэрэгцээ шаардлагын дэлгэрэнгүй жагсаалт байхгүй)	193

Зургийн жагсаалт

Зураг 1-1. Бичил уурхайгаар олборлодог ашигт малтмал (Хөгжил ба байгаль орчны төв, 2015 он)	33
Зураг 1-2. Төсөл хэрэгжиж буй 5 газар	36
Зураг 1-3. Мэдээллийг удирдах үйл явц	41
Зураг 2-1. Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгон (planetGOLD)	47
Зураг 2-2. Говь-Алтай аймгийн Алтай сумын Замын ам уурхайн талбай (planetGOLD)	48
Зураг 2-3. Ховд аймгийн Алтай сумын Майхан уурхайн талбай (planetGOLD)	49
Зураг 2-4. Монгол гэр (planetGOLD Монгол)	52
Зураг 2-5. Судалгаанд оролцогчдын нийгмийн даатгалд хамрагдалт (судалгааны бүс нутаг, хүйсээр)	61
Зураг 2-6. Судалгаанд оролцогчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалт (судалгааны бүс нутаг, хүйсээр)	63
Зураг 2-7. Ковид-19 цар тахлын арга хэмжээг уурхайн талбайд хэрэгжүүлж буй байдал (planetGOLD)	65
Зураг 2-8. Ажлын байран дахь Ковид-19-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ (судалгааны бүс нутаг, хүйсээр)	66
Зураг 2-9. Судалгаанд оролцогчдын мэдээлсэн хамгаалах арга хэмжээ (n=371; олон төрлийн хариулт тэмдэглэгдсэн, нийт=461)	66
Зураг 3-1. Ховд аймаг, алтны шороон орд (planetGOLD)	71
Зураг 3-2. Газрын дүгнэлттэй нөхөрлөл, гишүүдийн тоо (судалгааны бүс нутгаар)	81
Зураг 3-3. Олборлолтын гэрээ хийсэн байгууллагаас судалгаанд оролцогчид (судалгааны бүс нутгаар) ...	81
Зураг 3-4. Олборлолтын гэрээ хийсэн байгууллагаас судалгаанд оролцогчид (зохион байгуулалтын хэлбэрээр)	82
Зураг 3-5. Бичил уурхайтай холбоотой зөвшөөрөл авахад хүндрэлтэй тулгарч байсан судалгаанд оролцогчид (судалгааны бүс нутгаар)	82
Зураг 3-6. Бичил уурхайтай холбоотой зөвшөөрөл авахад хүндрэлтэй тулгарч байсан судалгаанд оролцогчид (зохион байгуулалтын хэлбэрээр)	83
Зураг 4-1. Уурхайд ажиллах нэг ээлжийн хугацаа (судалгааны бүс нутгаар (n=165))	87
Зураг 4-2. Судалгаанд оролцогчдын ашигладаг багаж, техник, тоног төхөөрөмж (n=371)	88
Зураг 4-3. Нэг шуудай хүдрийн дундаж жин (n=371)	89
Зураг 4-4. Бизнес хөгжүүлэх сонголт (n=371; 100 эмэгтэй, 271 эрэгтэй)	91
Зураг 4-5. Олборлолтын талбайн ойролцоо (<25 км) баяжуулах цех байгаа эсэх	93
Зураг 4-6. Хүдэр баяжуулах технологийн схем	94
Зураг 4-7. Хүдэр бутлах арга (судалгааны бүс нутгаар)	96
Зураг 4-8. Тээрмийн төрөл (судалгааны бүс нутгаар)	96
Зураг 4-9. Хүдэр баяжуулах арга, судалгааны бүс нутгаар	97
Зураг 4-10. Алт барилтын хэмжээ (%), судалгаанд оролцогчдын мэдээлснээр (n=371)	98
Зураг 4-11. Байгаль орчныг нөхөн сэргээх төлөвлөгөөтэй эсэх	102
Зураг 4-12. Олборлосон талбайг нөхөн сэргээсэн байдал (n=371)	103
Зураг 4-13. Уурхайн талбайд бий болдог хог хаягдлын төрлүүд	104
Зураг 4-14. Судалгаанд оролцогчдын хог хаягдал зайлуулах туршлага (олон хариулттай; нийт=494)	105
Зураг 4-15. Уурхайн талбай дээр ашиглаж буй усны эх үүсвэр	105
Зураг 4-16. НБХХ өмссөн бичил уурхайчид (planetGOLD)	108
Зураг 4-17. Уурхайн амны бэхэлгээ хийдэг эсэх (оролцогчдын тоо, судалгааны бүс нутгаар)	109
Зураг 4-18. Уурхайн цооног, амны бэхэлгээ хийдэг эсэх (оролцогчдын тоо, зохион байгуулалтын хэлбэрээр)	110
Зураг 4-19. Бэхэлгээтэй аманд ажиллаж байгаа нь (planetGOLD)	110

Зураг 4-20. Оролцогчдын нэрлэсэн уурхайн амны аюулгүй ажиллагааг хангахад авч хэрэгжүүлдэг арга хэмжээнүүд (n=371; олон хариулттай, нийт=744)	110
Зураг 4-21. Олборлолтын үед НБХХ-ийн хэрэглээ (судалгааны бүс нутгаар)	111
Зураг 4-22. Олборлолтын үйл ажиллагаанд оролцогчдын НБХХ-ийн хэрэглээ, (зохион байгуулалтын хэлбэрээр)	111
Зураг 4-23. Хэрэглэгдэж буй НБХХ-ийн төрөл (n=293; олон хариулттай, нийт=1,318)	112
Зураг 4-24. Олборлолт эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа авдаг оролцогчид (судалгааны бүс нутаг, хүйсээр)	113
Зураг 4-25. Олборлолт эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа авдаг оролцогчид (зохион байгуулалтын хэлбэрээр)	113
Зураг 4-26. Эрсдэлийг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлын төлөвлөгөөтэй эсэх (судалгааны бүс нутгаар)	114
Зураг 4-27. Эрсдэлийг бууруулах, ажлын байрны аюулгүй байдлын төлөвлөгөөтэй эсэх (зохион байгуулалтын хэлбэрээр)	114
Зураг 4-28. Уурхайн талбайд ХАБЭА хариуцсан ажилтантай эсэх (судалгааны бүс нутгаар, хүйсээр)	115
Зураг 4-29. Уурхайн талбайд ХАБЭА хариуцсан ажилтантай эсэх (зохион байгуулалтын хэлбэрээр)	115
Зураг 4-30. Олборлолтын талбайд аюулгүй ажиллагааны анхааруулга тэмдэг, тэмдэглэгээ тавьдаг эсэх (зохион байгуулалтын хэлбэрээр)	116
Зураг 4-31. Уурхайн цооногт ямар нэг аюулгүй ажиллагааны эрсдэл байгааг ажигласан эсэх (судалгааны бүс нутаг, хүйсээр)	116
Зураг 4-32. Уурхайн ам, цооногт эрсдэл байгаа гэж мэдээлсэн оролцогчид (n=112)	117
Зураг 4-33. ХАБЭА сургалтад хамрагдаж байсан эсэх (судалгааны бүс нутаг, хүйсээр)	117
Зураг 4-34. Судалгаанд оролцогчдын уурхайн талбай дээр ХАБЭА стандартыг мөрддөг талаарх өөрийн үнэлгээ (судалгааны бүс нутгаар, хүйсээр)	118
Зураг 5-1. Мөнгөн усаар бариулсан “спонж” алт (Өнөөдөр сонин)	120
Зураг 5-2. Сүүлийн 2 жилийн хугацаанд аймгийн түвшинд мөнгөн усны хэрэглээ байгааг ажигласан эсэх, судалгаанд оролцогчид (судалгааны бүс нутаг, хүйсээр)	123
Зураг 5-3. Сүүлийн 2 жилийн хугацаанд аймгийн түвшинд мөнгө усны хэрэглээ байгааг ажигласан судалгаанд оролцогчид (зохион байгуулалтын хэлбэрээр)	123
Зураг 5-4. Тухайн аймагт мөнгөн ус зарагддаг эсэх (судалгааны бүс нутгаар, хүйсээр)	124
Зураг 5-5. Мөнгөн усны хүний эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөний талаарх мэдлэг, хүйсээр	129
Зураг 6-1. Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдал (хүйсээр (n=100 эмэгтэй, 271 эрэгтэй))	133
Зураг 6-2. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)	134
Зураг 6-3. Судалгаанд оролцогчдын нийгмийн үйлчилгээний хүртээмж (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)	135
Зураг 6-4. Алтны бичил уурхайд идэвхтэй ажилладаг сарууд (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)	136
Зураг 6-5. Судалгаанд оролцогчдын байгууллагын зохион байгуулалтад орсон байдал (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)	137
Зураг 6-6. Судалгаанд оролцогчдын бичил уурхайн үе шатуудад оролцдог оролцоо	138
Зураг 6-7. Судалгааны 5 бүс нутгийн алтны бичил уурхайн ажил хөдөлмөрийн жендэрийн хуваарь (n=100 эмэгтэй, 271 эрэгтэй; олон хариулттай, нийт=3,732)	139
Зураг 6-8. Түнхэл тосгоны уурхайн талбай дээрх хянагч ээлжийн хуваарь бөглөж байгаа нь (planetGOLD Монгол)	140
Зураг 6-9. Эмэгтэй бичил уурхайчид уурхайн талбай дээр. (planetGOLD)	141
Зураг 6-10. Тухайн салбарт эмэгтэй хүн хийх ёстой эсвэл хийхийг зөвшөөрдөггүй ажил байдаг эсэх талаарх судалгаанд өгсөн хариулт (олон хариулттай, нийт=407)	142
Зураг 6-11. Тодорхой үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах үйл явцад эмэгтэй болон эрэгтэй уурхайчдын бичил уурхайчдын оролцоо (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй, нийт=1,139, олон сонголттой хариулт)	144
Зураг 6-12. Алтны бичил уурхайн байгууллагын гишүүд, ахлагч нарын тоо, (хүйсээр, n=282)	145
Зураг 6-13. Эмэгтэй болон эрэгтэй ахлагч нарын тоо (судалгааны бүс нутгаар, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)	145
Зураг 6-14. Манлайллын жендэрийн сонголт (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)	146
Зураг 6-15. Манлайллын жендэрийн сонголт (судалгааны бүс нутгаар, хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй 108)	147
Зураг 6-16. Эрэгтэй эсвэл эмэгтэй манлайлагчийг сонгодог шалтгаан (хүйсээр)	147
Зураг 6-17. Эмэгтэй уурхайчдад санхүүжилт авахад асуудал тулгардаг эсэх, (судалгааны бүс нутгаар, n=100 эмэгтэй)	151
Зураг 6-18. Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн жирэмсэн үедээ авч хэрэгжүүлсэн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга хэмжээ (n=100)	154

Зураг 6-19. Гэр орны ажилд оролцох оролцоо болон зарцуулдаг цаг (долоо хоногт), (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй).....	161
Зураг 6-20. Гэрийн ажилд оролцоход зарцуулдаг цаг	161
Зураг 6-21: Гэрийн ажлын жендэрийн хуваарь (n=100 эмэгтэй, 271 эрэгтэй; олон сонголттой хариулт, нийт=1,651).....	162
Зураг 7-1. Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээний зураглал (planetGOLD, 2021 он)	169
Зураг 7-2. Орон нутаг дахь алтны худалдаа (planetGOLD)	171
Зураг 7-3. Алтны үнийн мэдээллийн эх үүсвэр (судалгааны бүс нутгаар, олон хариулттай, нийт=488)	172
Зураг 7-4. Монголбанканд алтаа борлуулахгүй байх шалтгаан (n=371, олон хариулттай, нийт = 443)	176
Зураг 7-5. Банкны зээлтэй нийт оролцогчдын тоо, хүйсээр ба нийт	183
Зураг 8-1. Судалгаанд оролцогчдын ашигладаг бичил уурхайн талаарх мэдээллийн эх сурвалж (хүйсээр, олон хариулттай, нийт=503)	187
Зураг 8-2. Бичил уурхайн мэдлэгийн төвийн талаарх мэдээлэл (судалгааны бүс нутгаар ба хүйсээр).....	187
Зураг 8-3. Мэдээ, мэдээлэл авах олж авахыг илүүд үздэг мэдээллийн хэрэгсэл (хүйсээр, олон хариулттай, нийт=757).....	188
Зураг 8-4. Бичил уурхайчдын санал болгосон мэдээллийн төрлүүд (судалгааны бүс нутгаар)	189
Зураг 8-5. Сүүлийн 2 жилийн хугацаанд бичил уурхайчдын сургалтад хамрагдсан байдал (хүйсээр болон нийт)	190
Зураг 8-6. Сүүлийн 2 жилийн хугацаанд сургалтад оролцсон хүний тоо, судалгааны бүс нутгаар (хүйсээр болон нийт)	191
Зураг 8-7. Судалгаанд оролцогчдын сургалтын хэрэгцээ шаардлага (хүйсээр, олон хариулттай, нийт=850)	192

Тайлангийн хураангуй

Энэхүү тайланг planetGOLD Монгол төслийн гүйцэтгэгч байгууллага болох Алтны бичил уурхайн зөвлөл (АБУЗ)-өөс төсөл хэрэгжиж буй газруудад (цаашид судалгааны бүс нутаг гэх) үйл ажиллагаа явуулж буй алтны бичил уурхайн одоогийн нөхцөл байдал болон төслийн хүрээнд цаашид гарах өөрчлөлтийг үнэлэх жишиг үзүүлэлтүүдийг тодорхойлж, суурь мэдээллээр хангах зорилгоор боловсруулсан болно. Судалгаа нь төслийн хэрэгжилтэд нэн чухал хэрэгцээтэй мэдээллээр хангахаас гадна зарим тохиолдолд төслийн суурь мэдээллийн эх сурвалж болно.³

Даян дэлхийн байгаль орчны сангийн (ДДБОС) санхүүжилтээр хэрэгжиж буй planetGOLD төсөл нь алтны бичил уурхайн салбарыг албажуулах үйл явцыг сайжруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх, төслийн зорилтот бүс нутгийн уурхайчдад албан ёсны алтны зах зээлд нэвтрэх, мөнгөн усгүй баяжуулах техник, тоног төхөөрөмж худалдаж авах, хариуцлагатай уул уурхай, жендэрийн болон байгаль орчны хариуцлагатай практик дадлыг нэвтрүүлэхэд шаардагдах хөрөнгө олоход нь зуучлах замаар мөнгөн усны хэрэглээг халахад хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж байгаа билээ.

Судалгааны загвар

Монгол Улс уламжлалт мал аж ахуйд суурилсан эдийн засагтай байсан. 1990-ээд онд зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед эдийн засаг уналтад орж, ажилгүйдэл хурдацтай нэмэгдэж, улс орон даяар ядуурлын түвшин нэмэгдсэн. Гэр бүлээ тэжээх, амин зуулгаа залгуулахын тулд иргэд ямар нэг гарц, боломжийг эрэлхийлж байсан бөгөөд эдийн засгийн хэрэгцээ шаардлагаас үүдэн бичил уурхай руу татагдан орсон билээ. 2000-аад оны үед 100,000 гаруй хүн бичил уурхайгаас олсон орлогоор гэр бүлийн 400,000 гаруй хүний амьдралыг шууд бусаар тэтгэж байсан нь судалгаагаар тогтоосон байдаг (Дэлхийн банк, 2007он). Түүнчлэн үндэсний хэмжээнд хийгдсэн саяхны судалгаанд оролцсон (11,962) бичил уурхайчдын 74% нь алт олборлодог болохыг харуулсан юм. (ҮСХ, 2017он). Эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах, тогтворжуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газар 1991 оноос “Алт” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд алт олборлолтыг дэмжих, уул уурхайн компаниудад ашигт малтмал ашигласны төлбөр, татварын таатай орчныг бүрдүүлэх, алтны бичил уурхайн техник технологи, зохицуулалт, худалдааны орчныг сайжруулах зорилгоор “Алт-2” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж эхлээд удаагүй байна.

Энэхүү нөхцөл байдлын судалгааг Сэлэнгэ аймгийн Баянгол сум, Мандал сум, Түнхэл тосгон, Ховд аймгийн Алтай сум болон Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын бичил уурхайн үйл ажиллагааны практик туршлага, стандарт, одоогийн нөхцөл байдлын суурь үнэлгээг хийх зорилгоор боловсруулсан болно. Энэ судалгаанд судалгааны бүс нутгийн бичил уурхайчдын байгууллагын зохион байгуулалтын хэлбэр, албажуулалтын байдлыг үнэлэх, тодорхойлох зорилгоор анх удаа албажсан, албан бус болон хууль бус уурхайчдын ангиллыг ашигласан

³ Нөхцөл байдлын судалгаа нь төслийн суурь түвшнийг бүрэн харуулахгүй бөгөөд төслийн баримт бичигт тодорхойлсноор суурь мэдээллийн матрицыг тусад нь бөглөж эцэслэнэ.

юм. Тоон судалгаанд нийт 371 уурхайчин (100 эмэгтэй, 271 эрэгтэй) хамрагдаж, чанарын мэдээлэл авах зорилгоор явуулсан ганцаарчилсан ярилцлагад төрийн төв болон орон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчид, бичил уурхайн ТББ, нөхөрлөлийн ахлагч нар, баяжуулах цехийн ажилчид болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл болох 73 хүн оролцлоо. Мөн түүнчлэн салбарын жендэрийн асуудлаар гүнзгийрүүлсэн судалгаа болон нийлүүлэлтийн сүлжээ, алтны худалдааны асуудлыг судалсан болно.

Судалгааны бүс нутгийн нийгэм-эдийн засгийн байдал

Энэ судалгааг Сэлэнгэ, Говь-Алтай, Ховд аймагт уул уурхайн идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй таван сумдын бичил уурхайчдыг хамруулан явуулсан. Сэлэнгэ аймаг бичил уурхай болон том уурхайтай бөгөөд тус аймгийн Баянгол суманд 1997 онд анхны бичил уурхайн нөхөрлөл байгуулагдаж байсан түүхтэй билээ. Мандал сум болон Түнхэл тосгонд нутгийн иргэдийн амьжиргааны гол эх үүсвэрийг бичил уурхай бүрдүүлж байна. Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд одоогийн байдлаар алтны үндсэн орд байхгүй бөгөөд бичил уурхайчид тус аймгийн Алтай суманд хүдэр олборлож, Есөнбулаг суманд авчирч баяжуулдаг байна. Одоогийн байдлаар Есөнбулаг суманд 2 баяжуулах цех үйл ажиллагаа явуулж байна. Ховд аймгийн Алтай суманд бичил уурхайчид алтны хүдэр олборлож эхэлсэн боловч аймгийн хэмжээнд баяжуулах цех байхгүй байна. Судалгаанд хамрагдсан 371 уурхайчдын дийлэнх нь 30-50 насны иргэд бөгөөд 10-аас дээш жил бичил уурхай эрхэлж байгаа ажээ. Тэдний дийлэнх (78%) нь хамгийн багадаа ахлах сургуулийн боловсрол эзэмшсэн байгаа бол 10% гаруй нь дээд боловсролтой байна. Бичил уурхайчдын дийлэнх (76%) нь бичил уурхай эрхлэхийн тулд холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүртгэгдсэн нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон байна.

Судалгаанд оролцогчдын 50%-ийн үндсэн эрхэлдэг ажил, 77%-ийн орлогын гол эх үүсвэр нь бичил уурхай байгаа бол 33% нь зөвхөн бичил уурхайн орлогоор амин зуулгаа залгуулдаг байна. Ялангуяа Есөнбулаг сумын бичил уурхайчдын амьжиргаа бичил уурхайгаас хамааралтай болсон байна. Судалгаанд оролцогчдын тал хувь нь бичил уурхайд ажиллахын зэрэгцээ нэмэлт орлого олохын тулд хувиараа хөдөлмөр эрхэлдэг, газар тариалан, мал аж ахуйд болон төрийн байгууллагад ажилладаг гэж хариулжээ. Уурхайчдын 20% нь бичил уурхайгаас сард дунджаар 1,000,000-аас дээш төгрөг⁴ (бүсийн дундаж орлогоос дээгүүр)-ийн орлого олдог бол ихэнх уурхайчдын алтны бичил уурхайгаас олсон орлого нь амьдралд нь хүрэлцдэггүй байна. Хэдийгээр тэдний орлогын хэмжээ гүйцэтгэж буй ажил үүрэг, албан тушаалаас нь хамаардаг ч ихэнх бичил уурхайн нөхөрлөлүүд олсон орлогоо тэнцүү хуваадаг гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Бичил уурхайчдын 40% нь нийгмийн даатгалд, 63% нь эрүүл мэндийн даатгалд хамрагддаг ч даатгалд хамрагдалтын хувь төдийлөн хангалттай бус байна. Энэ байдалд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь бичил уурхайн үйл ажиллагаа тогтмол бус, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын ач холбогдлын талаар уурхайчдын мэдлэг, ойлголт дутмаг байгаа явдал байж болох юм. Мэргэжлээс

⁴ Энэ нь 2020 оны 7-р сарын 1-ий өдрийн байдлаар 350 америк доллартай тэнцэж байв. (Монголбанкны ханш: \$1 = ₮2,849.25)

шалтгаалах өвчний тогтмол үзлэгт хамрагдах болон нийгмийн даатгал хамрагдахын ач холбогдлын талаар мэдлэг, ойлголт өгөх компаниг ажил зохион байгуулах нь даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх чухал алхам юм.

Ковид-19 цар тахлын нөлөөллийг үнэлж үзэхэд уурхайчдад хамгийн их тулгарч байсан асуудал нь ажилгүй болсноор орлогоо алдсан, ажилд явах боломжгүй болсон, уурхайн талбай дээр ажиллах уурхайчдын тооны хязгаарлалтаас болж үйлдвэрлэлийн хэмжээ буурсан зэргийг дурдсан байна.

Албажуулалт

Монгол Улсын Засгийн газар 2010 онд бичил уурхайг эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрч бичил уурхайг зохицуулах чухал алхам хийсэн. Одоогийн байдлаар 18 төрлийн хууль, тогтоомжоор тухайн салбарыг зохицуулж байна. Судалгаанд оролцсон 5 газрын уурхайчид бүртгэгдсэн, бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад орж бичил уурхай эрхэлж байна. Мөн түүнчлэн өөрсдийн эрхээ хамгаалах зорилгоор нэгдэж ТББ байгуулжээ.

Гэсэн хэдий ч Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын гол зүйл заалтуудын хэрэгжилтийг түдгэлзүүлж, журмыг шинэчлэн боловсруулах ажил хойшлогдсонтой холбоотойгоор бичил уурхайчдын хэвийн ажиллах орчинг бүрдүүлэх асуудал хүндрэлтэй хэвээр байгаа төдийгүй тухайн салбарт тодорхойгүй нөхцөл байдлыг бий болгоод байна. Алтны бичил уурхайг албажуулах үйл явцын чухал алхам нь зөвшөөрөгдсөн уурхайн газартай байх явдал бөгөөд бусад талбайтай давхцалгүй талбайтай болох боломж хязгаарлагдмал байна.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээг богино хугацаагаар байгуулж байгаа нь зөвшөөрөгдсөн цөөхөн олборлолтын талбайн нөхцөл байдлыг улам дордуулж байна. Хэдийгээр Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор баталсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээг эрдэс баялгийн нөөцийг бүрэн ашиглаж дуусталх хугацаагаар байгуулахаар заасан боловч, гэрээг зөвхөн 3-12 сарын хугацаагаар байгуулдаг байна. Ийм богино хугацааны гэрээ нь уурхайчдын үйл ажиллагаагаа албажуулах урам зоригийг мохоож байгаа гол хүчин зүйл юм. Ашигт малтмал олборлох урьдчилсан нөхцөл болох газрын дүгнэлт гаргах үйл явцыг хойшлуулах, хүнд суртал гаргах, гэрээ сунгахад гардаг хүндрэл зэргээс шалтгаалан уурхайчид албан бус статус руу амархан шилжихэд хүргэж байна. Мөн түүнчлэн, Засгийн газрын 2019 оны 355 дугаар тогтоолоор бичил уурхайн талбайн дүгнэлт гаргуулах хүсэлт гаргах, шинээр талбайн дүгнэлт гаргах, гэрээ байгуулахыг түдгэлзүүлсэн нь салбарын албан бус байдлыг улам гүнзгийрүүлж байна. Энэхүү тайлангийн үр дүнгээр бичил уурхайчид үйл ажиллагаагаа албажуулах эхний алхамыг хийхэд бэрхшээл тулгарч байгааг харуулж байна. Монгол Улсын Засгийн газар Минаматагийн конвенцоор хүлээсэн үүрэг, амлалтыг биелүүлэхийн тулд эдгээр асуудлуудыг Үндэсний хөтөлбөр (ҮХ)-ийн алтны бичил уурхайг албажуулах стратегийн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай байна.

Алтны бичил уурхайн онцлог, тухайн салбарыг хамарсан ядуурлаас үүдэлтэй нарийн төвөгтэй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатайг харгалзан бичил уурхайгаар ашигт малтмал

олборлох журмыг боловсронгуй болгох замаар дээр дурдсан бэрхшээлүүдийг шийдвэрлэж болох юм. Түүнчлэн, газрын дүгнэлт гаргахад тулгарч буй саад бэрхшээлийг арилгах, ашигт малтмал олборлох гэрээний хугацааг сунгах замаар бичил уурхайг албажуулах үйл явцыг хөхиүлэн дэмжиж болно. Гэрээний нөхцөл, гүйцэтгэлийг үндэслэн ашигт малтмал олборлох гэрээний хугацааг сунгахдаа уул уурхайн үйл ажиллагааны тогтвортой байдлыг харгалзан үзэх шаардлагатай. Газрын дүгнэлт гаргах, гэрээний хугацааг сунгах үйл явцыг удаашруулж байгааг арилгах, шийдвэрлэх нь хариуцлагатай уурхайг төлөвшүүлэхэд чухал юм.

Уул уурхайн үйл ажиллагаа

Техникийн үйл ажиллагаа

Монгол орны хувьд бичил уурхайгаар алтны үндсэн ордоос хүдэр олборлох болон баяжуулах үйл ажиллагаа нь салангид байдлаар явагддаг онцлогтой. Өөрөөр хэлбэл, бичил уурхайчдын олборлосон хүдрийг тусдаа баяжуулах үйл ажиллагааг эрхэлдэг хүмүүс гүйцэтгэдэг.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд бичил уурхайд ашиглаж болох техникийн хөдөлгүүрийн хүчин чадлын дээд хэмжээг зааж өгсөн байдаг тул энгийн гар болон цахилгаан тоног төхөөрөмж ашиглан үндсэн ордод олборлолт хийдэг. Уурхайн ажил нь уурхайчдын сонгож гаргасан босоо ам, алтны өргөн судал дагуу малтсан хонгилын системээс бүрдэнэ. Тэсэлгээний ажлын зөвшөөрөл авахад төвөгтэй, өртөг өндөртэй тул цөөн тооны уурхай тэсэлгээ хийдэг бөгөөд лицензтэй компаниар гүйцэтгүүлэх нь найдвартай, өртөг багатай байдаг байна. Уул уурхайн технологи сайтай бүс нутагт бол олборлолтын хэмжээгээ нэмэгдүүлэхийг чухалчилдаг бол, ийм боломж муу бүс нутагт нэн тэргүүний асуудал нь газрын болон олборлолтын зөвшөөрлүүд байдаг.

Монгол Улсад албан ёсны зөвшөөрөлтэй зөвхөн 2 баяжуулах цех байдаг тул алтны хүдэр баяжуулалт ихэвчлэн албан бус баяжуулах цехүүдэд явагддаг. Хүдрээс алт ялгаж авахын тулд ихэнх баяжуулах цехүүдэд шлюз, баяжуулах ширээнээс бүрдсэн дамжлага бүхий энгийн гравитацийн аргыг ашигладаг. Уурхайчид баяжуулах процесс, алт барилтыг хянахдаа өөрсдийн практик туршлагадаа найдаж нүдэнд харагдах алтыг илрүүлэх төдий энгийн, хоцрогдсон аргыг ихэнхдээ хэрэглэдэг.

Монгол Улсад бичил уурхайчид өөрсдөө хүдэр баяжуулах цех байгуулах, зөвшөөрөл авахад саад бэрхшээл ихтэй байдаг тул гуравдагч этгээдийн баяжуулах цехэд хүдрээ баяжуулах шаардлагатай болдог. Иймд бичил уурхайчид баяжуулах цехийн эзэдтэй ашиг орлогоо шударгаар хуваах нь тулгамдсан асуудал болж байна. Бичил уурхайчдад үүнээс өөр сонголт хийх боломж хомс тул баяжуулах цехийн эзэд бичил уурхайчдад хохиролтой, хүлээн зөвшөөрөхөд хэцүү нөхцлийг санал болгодог байна. Баяжуулсан хүдрийн хаягдалд их хэмжээний алтны хэсэг үлддэг бөгөөд цехийн эзэд хаягдлыг цианидаар баяжуулах үйлдвэрт худалдаж нэмэлт ашиг олдог байна. Иймээс, зарим тохиолдолд бичил уурхайчид эрүүгийн хариуцлагад татагдаж ял шийтгэл хүлээх өндөр эрсдэлтэй ч гэсэн мөнгөн ус ашиглан өөрсдөө арай илүү их алт

гаргаж авах оролдлого хийдэг байна. Илүү шударга нөхцөлтэй, илүү сайн баяжуулалтын технологи нэвтрүүлэх нь уурхайчид мөнгөн ус ашиглахаа зогсоох чухал нөхцөлийг бүрдүүлэх юм.

Байгаль орчны хамгаалал

Засгийн газрын 2017 оны 151-р тогтоолоор батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмаар тавигддаг шаардлагын дагуу судалгааны бүс нутгийн ихэнх бичил уурхайн нөхөрлөлүүд (судалгаанд оролцогчдын 69%) нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлдэг хэдий ч бодит амьдрал дээр ухсан нүх, цооногийг дүүргэх, битүүлэх төдийгээр хязгаарлагдаж байна. Ялангуяа биологийн нөхөн сэргээлтийг нөхөрлөлүүд ихэвчлэн хийдэггүй байна. Хэдийгээр нөхөрлөлүүд орон нутгийн байгаль орчны нөхөн сэргээлтийн санд мөнгө байршуулдаг ч шаардлагатай үед энэ мөнгийг гаргаж авахад бэрхшээл тулгардаг гэдгийг ганцаарчилсан ярилцлагын үр дүн харуулж байна. Нөхөн сэргээлтийн сангийн санхүүжилтэд хяналт тавих, зарцуулалтыг үр ашигтай болгох, нөхөн сэргээх ажлыг хэрэгжүүлэх, биелэлтийг хянадаг байх нь бичил уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх удаан хугацааны сөрөг нөлөөллийг багасгахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Судалгаанаас харахад уурхайчид хогоо ихэвчлэн булж, шатааж, хогийн цэг рүү зөөдөг. Гэсэн хэдий ч бичил уурхай эрхэлдэг газруудаас хуванцар хог хаягдал, зай хураагуур зэрэг хортой, биологийн задралд ордоггүй хаягдал их хэмжээгээр гардаг тул уурхайчдын хувьд ялангуяа сумын хэмжээнд аюултай материалыг зохих ёсоор зайлуулах системийг бий болгох хэрэгтэй. Энэ нь химийн бодисын хаягдлыг зайлуулахад ч мөн хамаарна. Уурхайчид хог хаягдлаа зохих ёсоор хаяагүй тохиолдолд ногдуулдаг шийтгэлээс эмээж энэ талаар ярихаас зайлсхийж байсан. Гэсэн хэдий ч бичил уурхайчид нууцаар химийн бодис ашигласан тохиолдолд бохирдол, хаягдлыг зохих ёсоор зайлуулахад хүндрэлтэй болно.

Ганцаарчилсан ярилцлагад оролцогчид байгаль орчинд чиглэсэн практик үйл ажиллагаагаа сайжруулахад чиглэсэн сургалтын хэрэгцээ шаардлага бичил уурхайчдад их байгаа гэж тодорхойлсон. Гэхдээ бичил уурхайчид хог хаягдлаа зохих ёсоор зайлуулах шийдлийг олох, олборлолтын талбайн орчинд тавигдах байгаль орчны шаардлагуудыг мөрдөх зэрэгт хүчин чармайлт нь гаргах ёстой юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Монгол Улсад 2010 оноос хойш бичил уурхай дахь уул уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг Засгийн газраас зохицуулж ирсэн бөгөөд “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг 2010 онд баталж, улмаар 2017 онд боловсронгуй болгосон. Үүнээс гадна үйлдвэрлэлийн ослыг бүртгэх, тайлагнах, авран туслах, урьдчилан сэргийлэх дүрэм байдаг хэдий ч практикт бичил уурхайтай холбоотой ослын талаарх мэдээллийг энэхүү тайлагналын системд тодорхой ангилаагүй байна.

Энэхүү судалгаанд ХАБЭА-н стандартууд болон алтны бичил уурхайн сайн туршлагыг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлууд байгааг онцлон тэмдэглэжээ. Тухайлбал, судалгаанд оролцогчдын дөнгөж 57% нь хувийн хамгаалалтын

хэрэгслийг байнга ашигладаг, 54% нь эрсдэлийг бууруулах, аюулгүй ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан бөгөөд 53% нь ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтантай гэж хариулсан байна. Албажсан бичил уурхайчдын ХАБЭА-н холбогдох дүрэм, журамд нийцэж ажилладаг хувь албан бус уурхайчид, ялангуяа хууль бус уурхайчдынхаас илүү өндөр байна. Энэ нь аюулгүй байдлыг хангах практик дадал нь тухайн салбарын албажуулалтын түвшинтэй шууд холбоотой нь харагдаж байна. Харин ХАБЭА-н сургалтын хөтөлбөрт албан бус, хууль бус бүлгийг онцгойлон хамруулах шаардлагатай.

Бичил уурхайн журамд зааснаар орон нутгийн засаг захиргааны албан хаагчид, ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтнууд уурхайчдад хууль эрх зүйн орчин, ХАБЭА-н чадавх бэхжүүлэх сургалт явуулах үүрэгтэй. Гэхдээ орон нутгийн ажилтнуудын ХАБЭА-н талаарх мэдлэг хангалтгүй байна. Тиймээс бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, аюулгүй ажиллагааны дүрэм, үүрэг хариуцлагын талаар мэдлэг, мэдээлэл олгож чадавхжуулах шаардлагатай байна.

Судалгааны дүнгээс харахад бичил уурхайн байгууллага зөвхөн уурхайн талбай дахь аюултай нөхцөлөөс сэргийлэх арга хэмжээ авахаас гадна ХАБЭА-н эрсдэлийг хэрхэн тодорхойлох, ХАБЭА-н төлөвлөгөөг боловсруулах, амжилттай хэрэгжүүлэх тал дээр чадавхжих хэрэгцээ байгаа юм.

Мөнгөн усны хэрэглээ

Монгол Улсад уул уурхайд мөнгөн ус ашиглахыг 2008 оноос хориглосон хэдий ч бүхэл хүдэрт эсвэл баяжуулах цехээс гарсан дундын хаягдалд мөнгөн усыг нууцаар ашиглан алт баяжуулах явдал нийтлэг байна. Минаматагийн Конвенцоор хүлээсэн үүрэг, амлалтаа хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газар "Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр" (ҮХ)-ийг 2019 онд баталсан. planetGOLD төслийн үр дүн нь ҮХ-ийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах бөгөөд энэхүү судалгааны ажлын эхний алхам нь судалгааны бүс нутгийн хэмжээнд мөнгөн усны хэрэглээ, туршлагыг үнэлэх явдал байв. Уурхайчид хууль бусаар ажилладаг, мөн хэрэгт орохоос эмээж мэдээлэл өгөхөөс болгоомжилж байгаа зэрэг байлаас шалтгаалан мөнгөн ус хэдий хэмжээгээр ашиглагдаж байгааг тогтоох, тооцоолоход төвөгтэй байлаа. Гэсэн хэдий ч асуулга болон ганцаарчилсан ярилцлагын үеэр цуглуулсан мэдээллээс дүгнэвэл судалгааны бүс нутгуудад мөнгөн ус хэрэглэх, худалдан борлуулах, мөнгөн усаар хөрс бохирдох тохиолдол гарч байсан байна. Энэ нь мөнгөн усны далд хэрэглээ байгааг харуулж байгаа юм.

Алтны бичил уурхайн салбарт мөнгөн усны хэрэглээг бууруулах, цаашид ашиглахаас урьдчилан сэргийлэхэд шийдвэр гаргах түвшинд хууль эрх зүйн сайжруулалт хийх, бичил уурхайн байгууллагуудын түвшинд үр ашигтай, өөр технологийн хувилбарыг нэвтрүүлэх зэрэг бусад олон арга хэмжээг түвшин бүрт хослуулан хэрэгжүүлсэн тохиолдолд үр дүнд хүрч болох юм. Хүдэр баяжуулах үйлчилгээ үзүүлэгчид буюу баяжуулах цехийн эзэд нь одоогийн байгаа технологийн боломжоор (цехийн алт барилт) уурхайчдын олборлосон хүдрийг боловсруулж, мөн алтыг нь худалдаж авдагаараа бичил уурхайчдын орлогод нөлөөлж байдаг нэг чухал оролцогч тал юм. Мөн мөнгөн ус нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд ямар их хор хөнөөлтэйг бичил уурхайчдад ойлгуулах нь

мөнгөн усгүй хүдэр баяжуулах системд шилжихэд түлхэц өгөх чухал урьдчилсан нөхцөл болно.

Жендэр

Жендэрийн зураглалд орлого, манлайлал, нөөцийн хүртээмж, шийдвэр гаргах эрх мэдэл зэрэг хэд хэдэн асуудлаар дүн шинжилгээ хийж үзэхэд ажил хөдөлмөрийн хувьд жендэрийн тодорхой ялгаа байгаа боловч алтны бичил уурхайд ажиллаж байгаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн харилцаа нь харьцангуй эрх тэгш байна. Бичил уурхайн байгууллагуудад ажилладаг олон эмэгтэйчүүд захиргаа, менежмент, манлайлал, эрх зүйн орчны талаар мэдлэг, ойлголт сайтай, цаашид суралцах, чадавхаа дээшлүүлэх хүсэл сонирхолтой байгаа нь тэд бичил уурхайн салбарт өөрчлөлт авчрах чухал төлөөлөгчид нь байх боломжтой юм. Энэ давуу тал, бололцоог төрийн байгууллагууд, бусад оролцогч талууд хүлээн зөвшөөрч, сургалтын хөтөлбөр боловсруулахдаа тэднийг чадавхжуулах тал дээр анхаарч үзэх хэрэгтэй.

Гэсэн хэдий ч эмэгтэйчүүд гэр бүлийн хүрээнд төдийгүй ажлын байран дээр (хэл амаар дарамтлах гэх мэт), эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох хөдөлмөрийн уламжлалт хуваарийн улмаас давхар ачаалал үүрэх зэргээр жендэрт суурилсан хүчирхийлэлд илүү өртөмтгий байдаг. Жендэрийн гүнзгийрүүлсэн судалгааны үр дүн бичил уурхайчдын дунд жендэрийн үзэл баримтлал, жендэрийн шинж төрхийн талаарх ойлголт мэдлэг муу байгаа бөгөөд жендэрийн үүргийн талаарх ойлголтыг бий болгох, жендэрийн тэгш байдлыг сайжруулах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд эрэгтэй, эмэгтэй уурхайчдад зориулсан жендэрийн сургалт зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

Алтны худалдаа ба нийлүүлэлтийн сүлжээ

Монгол Улсын Засгийн газраас алтны худалдааг албажуулах арга хэмжээ авч хэрэгжүүлж, холбогдох журмуудыг 2020 онд баталсан боловч хөдөө орон нутгийн алтны худалдаа эрхлэгчид, алт олборлогчдын дунд алтны худалдааг албажуулах талаарх мэдлэг мэдээлэл, чиглэл заавар дутагдалтай байна. Судалгаанд хамрагдсан бүс нутаг тус бүрт цөөн тооны алтны худалдаа эрхлэгчид байгаа нь зах зээлийг харьцангуйгаар өрсөлдөх чадваргүй болгож, хараат байдлыг бий болгон, уурхайчдын зөвшилцөх, хэлэлцээр хийх эрх мэдлийг багасгаж байна. Монголбанк Лондонгийн үнэт металлын биржийн үнийг үндэслэн өрсөлдөхүйц үнээр алтыг худалдаж авдаг. Гэсэн хэдий ч албан ёсны алтны нийлүүлэлтийн сүлжээний талаарх дүрэм журмын мэдлэг хомс, хүнд суртал, сорьцлох алтанд тавигддаг хамгийн бага жингийн шаардлага, газарзүйн байрлалын хувьд зах зээлийн хүртээмжгүй байдал зэргээс шалтгаалан ихэнх уурхайчид алтаа орон нутгийн худалдаачдад зардаг. Одоо үйлчилж байгаа эрх зүйн орчны дагуу Монголбанк нийлүүлж байгаа алтанд магадлан шинжилгээ хийдэггүй, алтны гарал үүслийг шаарддаггүй. Түүнчлэн судалгаанд хамрагдсан бүс нутагт хүдэр олборлолт, алтны борлуулалтын бүртгэл хөтлөлт хангалтгүй байсан.

Уурхайчдын албан ёсны санхүүжилтийн хүртээмж нь хариуцлагатай алтны бичил уурхайг төлөвшүүлэхэд чухал түлхэц болж чадна. Гэсэн хэдий ч Монгол

Улсад бичил уурхайн салбарт мөрдөгдөж байгаа одоогийн эрх зүйн зохицуулалтууд нь тухайн салбарт хөрөнгө оруулагчдын сонирхлыг хязгаарлаж байгаа тул бичил уурхайчдад санхүүжилт олдох боломж байхгүй байна. Цаашилбал, банк гэх мэт санхүүгийн салбарын тоглогчид бичил уурхайн талаар хангалттай мэдээлэл, мэдлэггүй, энэ салбарыг өндөр эрсдэлтэй гэж үздэг тул уурхайчид өөрсдийн хөрөнгөнд найдах эсвэл орон нутгийн алтны ченжүүдээс тусламж хүсэхэд хүрдэг. Тиймээс хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах үндэс суурийг бий болгохын тулд бичил уурхайн холбогдох хууль тогтоомжийг эргэж судалж үзэх, боломжит хөрөнгө оруулалтын ашиг тус болон болзошгүй эрсдэлийг зөв тооцох, үнэлэхэд зориулж алтны бичил уурхайн талаарх холбогдох санхүүгийн мэдээллийг боловсруулж, санхүүгийн салбаруудад энэхүү мэдээллийг түгээх нь чухал байна. Нэмж дурдахад санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах, алтны албан ёсны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хариуцлагатай алтны бичил уурхайг төлөвшүүлэхэд чиглэсэн алтны бичил уурхайн тусгай зээлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх замаар бичил уурхайчид, алтны худалдаа эрхлэгчдийг урамшуулахыг холбогдох талуудад зөвлөж байна.

Чадавх бэхжүүлэх

Мэдээллийн хүртээмжийг хангах нь бичил уурхайчдад алтны үнэ ханш, уул уурхайн сайн туршлага, албажуулалтын талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээлэл авахад чухал ач холбогдолтой юм. Судалгаанд хамрагдагсдын тал хувь нь алтны бичил уурхайн салбарт ажилладаг бусад хүмүүс, найз нөхөд, хамаатан саднаасаа мэдээлэл авахаас гадна ТВ, гар утас, фэйсбүүкээс мэдээлэл авахыг илүүд үздэг байна. Гэсэн хэдий ч ихэнх уурхайчид алтны одоогийн үнэ ханшийг судлахын тулд интернет ашигладаггүй байна.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд уурхайчдын гуравны нэг нь албажуулалт, хариуцлагатай уул уурхайн стандарт, нөхөн сэргээлт, байгаль орчны менежмент, нийлүүлэлтийн сүлжээний талаарх сургалтанд дор хаяж нэг удаа хамрагдсан байна. Сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь харьцангуй өндөр байна. Уурхайчдын өөрсдийн тодорхойлсон хэрэгцээ шаардлагатай сургалтуудад бичил уурхайн албажуулалт, хариуцлагатай уул уурхайн практик, нөхөн сэргээлттэй холбоотой сэдвүүд орж байна. Төвийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын зүгээс бичил уурхай эрхлэгчдэд мөнгөн усны хэрэглээний хор уршиг, эрсдэл, хууль тогтоомж, уул уурхайн үйл ажиллагааг албажуулах, байгаль орчны асуудлаар ажлын байранд нь богино хугацааны сургалт явуулах шаардлагатай байгааг дурдаж байсан.

Нөхцөл байдлын судалгааны төслийн суурь мэдээлэлд холбогдох дүгнэлтүүд

Нөхцөл байдлын судалгааны зорилго нь Монгол Улсын бичил уурхайн салбарын одоогийн байдлын талаар ойлголт өгөх, ялангуяа судалгааны бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй алтны бичил уурхайд хэрэгжиж буй практик дадал, бичил уурхайд оролцогч талуудын хандлага, мэдлэгийн түвшинг үнэлэх явдал юм. Судалгаа нь төслийн хэрэгжилтэд нэн чухал хэрэгцээтэй мэдээллээр хангахаас гадна зарим тохиолдолд төслийн суурь мэдээллийн эх сурвалж болно.

Төслийн баримт бичигт тодорхойлсноор төслийн суурь мэдээллийн матрицыг тусад нь боловсруулна.

Доорх хүснэгтэд төслийн хэрэгжилттэй холбогдох зарим мэдээллийг харууллаа. Үүнд:

- **Тоон үзүүлэлтүүд** нь төслийн хэрэгжилтийг хянахад туслах бөгөөд төслийн хүрээнд гарсан өөрчлөлтүүдийг хэмжихэд хэрэглэгдэнэ. Эдгээр үзүүлэлтүүдийг нөхцөл байдлын судалгааны хэсэг болох судалгааны аргачлалд тусгасан бөгөөд төслийн зорилтот түвшний болон үр дүнгийн зарим суурь үзүүлэлтүүдийг хангаж байгаа юм.
- **Чанарын үзүүлэлтүүдээр** судалгааны болон ганцаарчилсан ярилцлагын дүгнэлтүүдийг нэгтгэн харуулж салбарын одоогийн байдлыг 3 түвшнээр (бага/дунд/өндөр) үнэлсэн. Хэдийгээр энд харуулсан чанарын үзүүлэлтүүд нь нийлмэл (системтэйгээр хандах) үзүүлэлтийг төлөөлж чадахгүй ч энэ тайланг уншигчдад салбарын байдлыг үнэлэхэд тусална. Доорх хүснэгтэд энэ байдлыг товч тайлбарласан бөгөөд илүү нарийвчилсан мэдээллийг тайланд харуулна.

Төслийн үзүүлэлтүүд	Тоон үзүүлэлтүүд (судалгааны)	Чанарын үзүүлэлтүүд (ганцаарчилсан ярилцлага ба судалгаа)
Зорилтот түвшний үзүүлэлтүүд		
Бууруулсан мөнгөн усны хэмжээ ⁵	Үндэсний хөтөлбөрт ⁶ тооцоолсон мөнгөн усны хэмжээ төслийн бүс нутгаар: - Сэлэнгэ аймаг: 120 кг (Мандал сум: 8 кг, Түнхэл тосгон: 40 кг, Баянгол сум: 40 кг) - Говь-Алтай аймаг: 23 кг - Ховд аймаг: 20 кг⁷	Төслийн бүс нутаг дахь мөнгөн усны хэрэглээ: <u>НОТЛОГДСОН</u>: Баянгол сумын (Сэлэнгэ аймаг) алтны хуалдаачид болон Алтай (Ховд аймаг) болон Есөнбулаг (Говь-Алтай аймаг) сумдын ажилтнууд мөнгөн усны нууц хэрэглээ байгааг дурдсан. Судалгаанд оролцогчдын 15% нь сүүлийн 2 жилийн хугацаанд өөрсдийн аймагт мөнгөн ус хэрэглэж байгааг харсан (албан бус (29%) болон and хууль бус уурхайчдын (14%) дунд илүү өндөр), харин 7% нь мөнгөн ус худалдаалж байхыг (Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд илүү өндөр-11%)) харсан гэж хариулсан байна. Хуулийн хариуцлага хүлээхээс эмээж мэдээллийг дутуу өгсөн байж болох талтай.

⁵ Монгол Улсад мөнгөн усны хэрэглээг хуулиар хориглосон, түүнчлэн хэрэглэсэн тохиолдолд уурхайчид хуулийн хариуцлага хүлээдэг. Тиймээс мөнгөн усны хэрэглээний талаар шууд асуугаагүй. Хэдийгээр олборлосон болон баяжуулсан хүдэр, худалдаалсан алтны хэмжээнд үндэслэн сумын түвшинд мөнгөн усны хэрэглээг НҮББОХ-ийн гарын авлагыг (О Нэйл/Телмэр, 2017 он) ашиглан тооцоолох оролдлого хийсэн ч Монголын уул уурхайн онцлог шинж байдлаас хамаарч мөнгөн усны бодит тооцооллыг гаргах боломжгүй байсан (өөрөөр хэлбэл, энэ тооцоо нь завсрын бүтээгдэхүүнээс мөнгөн усаар бариулж алт гаргах явцаар ихэнхдээ хязгаарлагддаг). Цаашид төслийн бүс нутаг дахь мөнгөн усны хэрэглээний бодит тооцооллыг хийх аргачлал дээр ажиллана.

⁶ Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах Монгол Улсын Засгийн газрын Үндэсний хөтөлбөр 2019-2023. (2020). http://www.mercuryconvention.org/Portals/11/documents/NAP/Mongolia_NAP_June-2020.pdf

⁷ Үндэсний хөтөлбөрт Говь-Алтай болон Ховд аймгийн төслийн сумд дахь мөнгөн усны тооцооллоын талаар мэдээлэл үзүүлээгүй болно. Төслийн хүрээнд цаашдаа төслийн бүс нутаг дахь мөнгөн усны хэрэглээний бодит тооцооллыг хийх аргачлал дээр ажиллана.

# Мөнгөн үсгүй технологи, тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх үйлчилгээ авах боломжтой эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдын тоо	Арилжааны банкнаас санхүүжилт авсан судалгаанд оролцогчдын эзлэх хувь: 3% Уурхайн үйл ажиллагаанд өөрийн хөрөнгөө ашигласан судалгаанд оролцогчдын хувь: 83%	Орон нутгийн банкнаас зээл авах боломж: БАГА Ярилцлагын явцад бичил уурхайн байгууллагуудын дүрдсанаар ихэнх бичил уурхайчид нийгмийн даатгал төлдөггүй учраас банкинд орлогоо нотолж чаддаггүй. Түүнчлэн бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу бичил уурхайчид газрын зөвшөөрлийн бичиг баримтаа зээлийн барьцаа хөрөнгөөр ашиглаж, олборлох эрхээ бусдад шилжүүлэх эрхгүй шалтгаан нь мөн банканд хандах боломжийг хязгаарлаж байна Нөгөөтээгүүр бичил уурхайгаас олж байгаа орлого нь эрсдэл өндөртэй бөгөөд тогтвортой бус хэмээн тооцогддог. Тиймээс бичил уурхайчдыг хөрөнгийн баталгаа өгөх боломжгүй гэсэн үзэл нийтлэг бөгөөд энэ нь санхүүгийн системд банкуудыг эргэн төлөх төлбөрийн чадваргүй зээлээс хамгаалж байдаг нэг шаардлага нь болж байна. Санхүүгийн хүртээмжид жендэрийн тэгш бус байдал нөлөөлөх нь: БАГА Судалгаа болон ганцаарчилсан ярилцлагаар санхүүгийн хүртээмжид жендэрийн ялгаа нөлөөлөөгүй болохыг харуулсан.
Хариуцлагатай алтны зах зээлийн үйлчилгээ авах боломжтой эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдын тоо (олборлогчоос цэвэршүүлэгч руу)	Хариуцлагатай алтны зах зээлийн үйлчилгээ авах боломжтой судалгаанд оролцогчдын хувь: 0%⁸ Судалгаанд оролцогчдын бүртгэл хөтөлдөг хувь: 24% (алтны худалдаа), 43% (хүдэр олборлолт)	
Албан ёсны үндэсний байгууллагуудад алтаа шүүд худалддаг эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдын тоо	Монгол Банкнд алтаа худалдаалдаг хувь: 2% нь үргэлж, 3% нь хааяа, 94% нь алтаа худалддаггүй	
Үр дүн 1		
Алтны бичил уурхайг албажуулахад чиглэсэн Засгийн газрын хөшүүргийг хэрэгжүүлсэн эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчны тоо	Гаргах боломжгүй (ГБ)–төслийн суурь мэдээлэлтэй холбоотой учраас энэ судалгаанд хамруулаагүй.	Засгийн газраас албажуулалтыг дэмжих хөшүүрэг хэрэгжүүлэх: БАГА Бичил уурхайн журмыг түр зогсоосны дараа Засгийн газраас алтны бичил уурхайн үйл ажиллагааны чиглэлээр одоогийн мөрдөж буй эрх зүй, бодлогын орчинг үнэлэх, шинэчлэхээр зорьж байна⁹. Эрх зүйн үнэлгээнд

⁸ Монгол Улсад одоогоор хариуцлагатай алтны зах зээл хөгжөөгүй учраас судалгааны хүрээнд энэ үзүүлэлтүүдээр мэдээлэл цуглуулаагүй. Монголбанк одоогоор олон улсын магадлан шинжилгээний стандартыг (тухайлбал, олборлолтын гарал үүсэл) дагаж мөрдөөгүй байгаа учраас бичил уурхайчид хариуцлагатай алтны зах зээлд нэвтрэх боломжгүй юм.

⁹ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах захиргааны эрх зүйн үндсэн бичиг баримт нь Засгийн газрын 2017 оны 5-р сарын 24-ний өдрийн 151-р тогтоолоор батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам (Бичил уурхайн журам) юм.

		албажуулалтад нөлөөлж буй саад бэршээлтэй асуудлуудыг (газар эзэмшил, олборлох эрх, зүй зохистой ажлын байрны нөхцөл, алт худалдаалах журам болон дотоодын болон олон улсын зах зээлийн хүртээмж) тодорхойлж, илүү өргөн хүрээг хамарсан цогц бодлого, журмыг боловсруулахад тусгах юм. Албажуулах үйл явцын одоогийн ил тод байдал: ДУНД Бичил уурхайчдын хувьд нөхөрлөл байгуулах бичиг баримт бүрдүүлэх нь хоршоо байгуулахаас хамаагүй хялбар байдаг. Нөхөрлөл, хоршоо хоёулаа тухайн нутаг дэвсгэртээ улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсний дараа хуулийн этгээдийн албан ёсны эрхтэй болдог.
Төслийн бүс нутгуудад албажсан эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдын тоо	- Төслийн бүс нутагт бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх зорилгор байгуулагдсан нөхөрлөл ба гишүүдийн тоо: 100 нөхөрлөл 790 гишүүн - Төслийн бүс нутаг дахь зохион байгуулалтад ороогүй уурхайчдын: 2,100-3,600 (албан бүс тооцоолол) - Албан ёсны бичил уурхайчдын хувь¹⁰ (БУ-н байгууллагын гишүүн + газрын дүгнэлт + сумын засаг даргатай байгуулсан гэрээ): 49%¹¹ - БУ-н байгууллагын гишүүдийн эзлэх хувь: 76% - Олборлолттой холбоотой зөвшөөрөл авахад бэрхшээл тулгардаг гэж мэдээлсэн судалгаанд оролцогчдын эзлэх хувь: 37% (БУ-н байгууллагын гишүүдийн хувь-42%) - Сумын засаг даргатай гэрээтэй ажиллаж байгаа судалгаанд оролцогчдын хувь: 59%	Ганцаарчилсан ярилцлагын дүнгээр албажуулалтад тулгамдаж байгаа бэрхшээлүүд: Гэрээний асуудал, шударга бус, хүнд сурталтай, баримт бичиг бүрдүүлэх асуудал, Монгол Банканд алт худалдаалахад тавигддаг шаардлагуудыг хангаж чадахгүй байдал гэх мэт.
Үр дүн 2		
Хөрөнгө оруулагчид ба санхүүгийн байгууллагаас гаргасан мөнгөний нийт хэмжээ	Гаргах боломжгүй (ГБ)–төслийн суурь мэдээлэлтэй холбоотой учраас энэ судалгаанд хамруулаагүй.	Хөрөнгө оруулагчид болон санхүүгийн байгууллагаас бичил уурхайчдын санхүүжилт авах боломж: БАГА

Энэхүү журам нь үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмалыг зүй зохистой олборлох журмыг тогтоож, байгаль орчныг хамгаалах, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж ядуурлыг бууруулах зорилготой.

¹⁰ Албан ёсны бичил уурхайчин гэж 18-аас дээш насны, уурхайчнаар ажиллаж байгаа тухайн аймаг, сумынхаа иргэний бүртгэлд бүртгэгдсэн иргэнийг хэлнэ. Албан ёсны бичил уурхайчин дор дурдсан аль нэг байгууллагуудын (бүртгэлтэй, бүртгэлгүй нөхөрлөлийн эсвэл хоршооны эсвэл ТББ-ын) гишүүн байна. Түүнчлэн албан ёсны уурхайчин АМГТГ-аас уг газар нь бичил уурхайгаар олборлох боломжтой болохыг баталгаажуулсан баримт бичиг болох Газрын дүгнэлт гаргасан талбайд Засаг даргатай гэрээ байгуулсан байдаг.

¹¹ Түүвэрлэлтийн аргачлалтай (зорилтот түүвэр) холбоотойгоор энэ үзүүлэлтээр албан ба албан бус уурхайчдын хувийг харуулах боломжгүй юм.

	Арилжааны банкнаас болон бусад санхүүгийн байгууллагаас санхүүжилт авсан судалгаанд оролцогчдын эзлэх хувь: 6%	Судалгаанд оролцогчдын ихэнх нь үйл ажиллагаагаа өөрсдийн хөрөнгөөр санхүүжүүлдэг. Зөвхөн 3% нь арилжааны банкнаас, мөн 3% нь банк бус санхүүгийн байгууллагаас, 9% нь алтны худалдаачнаас, харин 6% нь баяжуулах цехээс санхүүжилт авсан байна. Үүнээс гадна бичил уурхайчдад тулгарч буй нэг саад бэрхшээл нь бичил уурхайд хөрөнгө оруулагчдыг татах эрх зүйн орчин дутмаг байгаа явдал юм. Бичил уурхайн олборлолтын зөвшөөрөл нь барьцаа хөрөнгө болж чадахгүй байгаагаас гадаадын хөрөнгө оруулалт татахад саад болж байна. Энэ нь бичил уурхайчдад хөрөнгийн зах зээлд гарах боломж буюу уул уурхайн төслүүдийн эхний шатны санхүүжилт олох уламжлалт эх үүсвэр олох боломжийг хаадаг.
Уурхайчдад олгосон мөнгөний нийт хэмжээ.	Гаргах боломжгүй (ГБ)–төслийн суурь мэдээлэлтэй холбоотой учраас энэ судалгаанд хамруулаагүй.	
Хариуцлагатай алтны зах зээлд оролцох боломжтой уурхайчдын тоо	Зорилтот түвшний үзүүлэлт #3-ыг үзнэ үү	
Төслийн бүс нутгаас ил тод нийлүүлэлтийн сүлжээнд худалдсан хариуцлагатай алтны хэмжээ	0 ¹²	
Ил тод нийлүүлэлтийн сүлжээнд алтаа худалдсан уурхайчдын тоо	0 ⁹	
Үр дүн 3		

¹² Монгол Улсад одоогоор хариуцлагатай алтны зах зээл хөгжөөгүй учраас судалгааны хүрээнд энэ үзүүлэлтүүдээр мэдээлэл цуглуулаагүй. Монгол Банк одоогоор олон улсын магадлан шинжилгээний стандартыг (тухайлбал, олборлолтын гарал үүсэл) дагаж мөрдөөгүй байгаа учраас бичил уурхайчид хариуцлагатай алтны зах зээлд нэвтрэх боломжгүй юм.

Төслийн бүс нутагт уул уурхайн сайн туршлагыг хэрэгжүүлсэн уурхайчид/олон нийт иргэдийн тоо	Байгаль орчны практик¹³: - Мөнгөн үсгүй технологи бүхий баяжуулах цехийг сонгодог судалгаанд оролцогчдын эзлэх хувь: 12% - Мөнгөн үс ашиглан хүдэр баяжуулдаг оролцогчдын эзлэх хувь: 1.5% (дутуу мэдээлсэн) (Баянгол: 6%) - Тухайн уурхайчдын бүлэг нь байгаль орчны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөтэй гэж хариулсан хувь: 69%¹⁴ - Тухайн уурхайчдын бүлэг нь уурхайн талбайд нөхөн сэргээлт хийсэн гэж хариулсан хувь: 82%¹⁵ - Тухайн уурхайчдын бүлэг нь биологийн нөхөн сэргээлт явуулсан гэж хариулсан хувь: 3.8%	Төслийн бүс нутгуудад байгаль орчны сайн туршлагыг хэрэгжүүлж буй байдал: БАГА ТҮВШНЭЭС ДУНД ТҮВШИНД Судалгааны хүрээнд байгаль орчны одоогийн практик үйл ажиллагаа нь албажуулалтын байдал, мөнгөн үсгүй технологийн боломж, чадавх бэхжүүлэх талаар явуулж буй арга хэмжээнээс хамаарч янз бүрийн түвшинд байна. Хэдийгээр судалгааны олон оролцогчид нөхөн сэргээлтийн дүрэм, журмыг мөрдөж байгаа гэж хариулсан боловч тэдний хийж буй нөхөн сэргээлт нь ухсан нүхээ шороогоор дүүргэхээр хязгаарлагдаж, маш бага хэмжээгээр биологийн нөхөн сэргээлт хийдэг байна. Завсрын бүтээгдэхүүнийг боловсруулахдаа хууль бусаар мөнгөн үс хэрэглэж байгааг судалгааны хүрээнд тооцоолох боломжгүй байсан боловч төслийн бүс нутгуудад мөнгөн үсыг худалдаж, хэрэглэж байгаа нь батлагдсан.
	ХАБ-ын хэрэгжилт: - Хувийн хамгаалах хэрэгсэл үргэлж хэрэглэдэг хувь: 57% - Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө зааварчилгаа авдаг хувь: 72% - Тухайн уурхайчдын бүлэг нь эрсдэл бүүруулах төлөвлөгөөтэй гэж хариулсан хувь: 54% - Тухайн уурхайчдын бүлэг нь ХАБ-ын ажилтантай гэж хариулсан хувь: 53% - Уурхайн талбайд ХАБ-ын стандарт мөрддөг гэж хариулсан хувь: 58%	Төслийн бүс нутгуудад ХАБ-ын сайн туршлагыг хэрэгжүүлж буй байдал: БАГА ТҮВШНЭЭС ДУНД ТҮВШИНД Нийт уурхайчдын бараг тал хувь нь дүрэм журмыг мөрдөж, ХАБ-ын зарим сургалтуудад хамрагдсан байгаа боловч зарим үйл ажиллагааны (тухайлбал, ХАБ-ын төлөвлөгөө, ХАБ-ын асуудал хариуцсан ажилтантай байгаа эсэх) чанар тодорхой бүс байна. Түүнээс гадна ХАБ-ын үйл ажиллагаа албан бус болон хууль бус уурхайчдын дунд хангалтгүй байгаа бөгөөд ганцаарчигсан ярилцлагад оролцсон төрийн албан хаагчид ХАБ-ын сургалт хэрэгцээтэй байгааг дурдсан.
	Жендэрийн тэгш эрхийг хангасан уурхайн практик: - Уурхайн талбайд шийдвэр гаргахад оролцдог эмэгтэй, эрэгтэйчүүдийн хувь: 88% ба 95%	Жендэрийн тэгш эрхийг хангасан сайн туршлага, үйл ажиллагаа: ДУНД ТҮВШНЭЭС ДЭЭД ТҮВШИНД Жендэрийн гүнзгийрүүлсэн судалгааны дүгнэлт, үр дүнгээс харахад уул уурхайн үйл ажиллагаанд

13 Уул уурхайн сайн туршлагын үзүүлэлтүүдтэй холбоотой мэдээллийг уурхайчдаас өөрсдөөс нь асуусан бөгөөд нийгмийн хүсэл эрмэлзэлд нийцүүлэх үүднээс илүү өндрөөр тайлагнасан байж болно. Түүнчлэн практик үйл ажиллагааны чанарыг, тухайлбал ХАБ-ын төлөвлөгөөний бүрэн байдал, хэрэгжүүлсэн нөхөн сэргээлтийн чанар зэрэгт үнэлгээ хийгээгүй.

¹⁴ Өөрсдийн талбайд нөхөн сэргээлт хийхэд оролцсон бичил уурхайчид (69%) ухсан нүхээ шороогоор дүүргэсэн нь нөхөн сэргээлтийн нэг хэсэг болсныг дурдсан. Гэвч зөвхөн энэ ажил нь нөхөн сэргээлтийг амжилттай хийсэн гэдгийг харуулж чадахгүй юм. Нарийвчилсан асуултаар дүүргэлт хийсэн үндсэн зорилго нь нөхөн сэргээлтэд зориулагдаагүй, харин бусад уурхайчдыг хүдэр хулгайлахыг зогсоох, газрын тогтвортой байдлыг хангах зорилготой байсан гэдгийг тодруулсан. Тиймээс бичил уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг үнэн хэрэг дээрээ хэт дөвийлгөж мэдээлсэн байж болно.

	- Судалгаанд оролцогчдын дунд эмэгтэй, эрэгтэй удирдагчдын эзлэх хувь: 19% ба 10% - Эрэгтэй удирдагчтай болохыг дэмждэг эмэгтэй, эрэгтэйчүүдийн хувь: 36% ба 44% - Уурхайн талбайд бэлгийн дарамттай холбоотой асуудал гардаг гэж хариулсан эмэгтэйчүүдийн хувь: 1% - Сүүлийн 2 жилд алтны бичил уурхайтай холбоотой сургалтанд хамрагдсан эмэгтэй, эрэгтэйчүүдийн эзлэх хувь: 47% ба 35%	ерөнхийдөө жендэрийн тэгш эрхийг хангасан гэж байгаа боловч нарийвчилсан асуулгаар уурхайчид жендэрийн үзэл баримтлалын талаар сайн ойлголтгүй, жендэрийн уламжлалт хөдөлмөрийн хуваариас үүдэн эмэгтэйчүүдийн хувьд өрх гэрийн давхар ажлын ачаалалтай байдаг, түүнчлэн Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэл нь асуудал болсон энэ нь эмэгтэй уурхайчдад нөлөөлж байгааг олж илрүүлсэн.
	Сүүлийн 2 жилд хамрагдсан сургалтууд ба сургалтын хэрэгцээ: Сүүлийн 2 жилд сургалтанд хамрагдсан хувь: 35% (141 уурхайчид), (эмэгтэйчүүдийн 47%, эрэгтэйчүүдийн 38% хамрагдсан) - Албажуулалт: 19% - Хариуцлагатай уул уурхай: 18% - Нөхөн сэргээлт: 9% - Нийлүүлэлтийн сүлжээ: 8% - Эрүүл мэнд: 8% - Байгаль орчны практик: 8% - Бизнесийн удирдлага: 7% - Технологи: 6% - Санхүүгийн удирдлага: 5% - Хувь хүний хөгжил: 5% - Жендэр ба хүний эрх: 2% Судалгаанд оролцогчдын тодорхойлсон сургалтын хэрэгцээ: - Албажуулалт: 35% - Хариуцлагатай уул уурхай: 26% - Технологи: 25% - Нөхөн сэргээлт: 25% - Байгаль орчны практик: 19% - ХАБ: 19% - Нийлүүлэлтийн сүлжээ: 16% - Санхүүгийн удирдлага: 15% - Хувь хүний хөгжил: 14% - Бизнесийн удирдлага: 13% - Байгууллагын удирдлага: 7% - Жендэр ба хүний эрх: 8%	Төслийн бүс нутаг дахь бичил уурхайчдын сургалтын хэрэгцээ: ДУНД ТҮВШНЭЭС ДЭЭД ТҮВШИНД Хэдийгээр бичил уурхайчдын 35% нь сүүлийн 2 жилийн хугацаанд сургалтанд хамрагдсан боловч бүх оролцогчид хэд хэдэн сургалтын хэрэгцээг тодорхойлсон. Төрийн байгууллагын ажилтнуудын зүгээс бичил уурхайчдад дараах чиглэлээр сургалтын өндөр хэрэгцээ байгааг дурдсан. Үүнд: хууль эрх зүйн хүрээ/албажуулалт, байгаль орчин, ХАБ болон мөнгөн усны эрүүл мэндэд үзүүлэх хор хөнөөл зэрэг болно.
Үр дүн 4.1 ба 4.2		
Олон талт платформ/мэдлэгийн төвийг хэрэгжүүлсэн болон ашигласан АБУ-н хамтран ажиллагсдын тоо	ГБ	Алтны бичил уурхайчдын одоогийн мэдлэгийн төвөөс мэдээлэл авах боломж, хүртээмж (ТБУТ төсөл): БАГА <i>planetGOLD</i> Монгол төслийн хүрээнд мэдлэгийн төвийн талаарх үйл ажиллагаа хараахан хэрэгжээгүй байна. Одоо байгаа мэдлэгийн төвийн хэрэгжилтийн байдлыг үнэлэхийн тулд доорх мэдээллийг цуглуулсан. - Одоогийн мэдлэгийн төвийн талаар мэддэг хүмүүсийн хувь: 10% (эмэгтэйчүүдийн 13%, эрэгтэйчүүдийн 10%); - Мэдлэгийн төвөөс мэдээлэл авсан хүмүүсийн эзлэх хувь: 6%

АБУ-н олон нийт болон ЗГ-ын хооронд мэдээлэл хүргэх талаар зөвшилцсөн арга замуудын тоо	Судалгаанд оролцогчдын мэдээлэл авах эх үүсвэрүүд: - Телевиз (эрэгтэйчүүдийн 52%, эмэгтэйчүүдийн 62%), - Гар утас (эмэгтэйчүүдийн 37%, эрэгтэйчүүдийн 49%), - Фэйсбүүк (эмэгтэйчүүдийн 55%, эрэгтэйчүүдийн 52%)	
--	--	--

Нэр томъёо, товчилсон үг, тайлбар

Нэр томъёо

Аймаг	Монгол Улсын нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгж
Сум	Аймгийн засаг захиргааны нэгж
Баг	Сумын засаг захиргааны нэгж

Товчилсон үг

АБУЗ	Алтны бичил уурхайн зөвлөл
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БУ	Бичил уурхай
БҮТШҮАЖ	Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагааны журам
ГААСХ	Говь-Алтай аймгийн Статистикийн хэлтэс
ДДБОС	Даян дэлхийн байгаль орчны сан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
МБУНДХ	Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НБХХ	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл
НҮБАҮХБ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага
НҮББОХ	Нэгдсэн Үндэсний байгууллагын Байгаль орчны хөтөлбөр
НҮБССХ	Нэгдсэн үндэсний байгууллагын Сургалт, судалгааны хүрээлэн
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
САСХ	Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтэс
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ТБУТ	Тогтвортой бичил уурхай төсөл
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮМСХГ	Үнэт металлын сорьцын хяналтын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХАСХ	Ховд аймгийн Статистикийн хэлтэс
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг

Тайланд ашигласан нэр томъёоны тайлбар

Уншигчдад ойлгомжтой болгох үүднээс энэхүү тайланд “бичил уурхайчид” буюу “уурхайчид” гэдэг нэр томъёог тус судалгаанд оролцсон хүн ам, алтны бичил уурхайчдыг төлөөлүүлж хэрэглэсэн. Хууль тогтоомж, байгууллагын нэршлүүдэд

бичил уурхайг “БУ” болон алтны бичил уурхайг “АБУ” гэж томъёолох нь зохимжтой байсан.

Мөн түүнчлэн, энэхүү тайланд жендэрийн хэвшмэл ойлголт, нэг талыг барьсан хандлагаас зайлсхийхийн тулд жендэрийн мэдрэмжтэй хэлийг хэрэглэх удирдамжийг дагаж мөрдөхийг зорьсон болно. "Хүйс" гэдэг нэр томъёоны оронд илүү хүртээмжтэй нийгмийн үзэл баримтлал учраас "Жендэр" гэдэг нэр томъёог, "эм", "эр" гэх биш "эмэгтэй", "эрэгтэй" гэсэн нэр томъёог ашигласан. Гэсэн хэдий ч "эм", "эр" гэдэг үгийг тохирох, хамааралтай хэсэгт тодотгол үг болгон ашиглалаа.

1. Ерөнхий мэдээлэл

Энэ бүлэгт Монголын эдийн засагт алт олборлолтын эзлэх байр суурь, түүнд алтны бичил уурхайн гүйцэтгэж буй үүргийн талаар товч танилцуулахын зэрэгцээ, судалгааны зорилго, загвар, аргачлал, судалгааны ажилд тулгарч байсан хязгаарлалтуудыг тайлбарлаж, тайлангийн үр дүнг тоймлон харуулсан болно.

1.1 Монгол Улсын алтны салбар

Уул уурхайн салбар нь Монгол Улсын ДНБ-ий 20%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 69%-ийг бүрдүүлдэг тэргүүлэгч салбар юм. 2020 оны 9-р сарын байдлаар уул уурхайн салбар экспортын орлогын 94%-ийг, улсын төсвийн орлогын 20%-ийг тус тус бүрдүүлж байна (УУХҮЯ, 2020). Монгол Улс зэс, нүүрс, алт зэрэг ашигт малтмалын тэргүүлэгч үйлдвэрлэгч болохын зэрэгцээ төмрийн хүдэр, цайр, хайлуур жонш зэрэг бусад ашигт малтмалыг үйлдвэрлэж экспортод гаргадаг. Уул уурхайн салбарыг Ашигт малтмалын тухай хууль болон байгаль орчны менежмент ба байгаль хамгаалал, химийн бодисын ашиглалт, тэсэлгээ, худалдаа, хүний нөөц гэх мэт бусад хэд хэдэн хууль тогтоомжоор зохицуулдаг (Бүлэг 2). Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) нь уул уурхайн салбарын асуудлыг хариуцдаг төрийн захиргааны төв байгууллага юм (Шигтгээ 1).

Шигтгээ 1: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)

УУХҮЯ нь эрдэс баялаг, уул уурхайн салбарын бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэд мониторинг хийж, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог хангах үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага бөгөөд дараах стратегийн томоохон зорилтыг хэрэгжүүлж байна:

- Уул уурхайн салбарын хууль тогтоомж, урт, дунд хугацааны стратегийн бодлогыг боловсруулах;
- Хууль тогтоомж, стратеги бодлого, хөтөлбөр, арилжааны төслүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд мониторинг хийж, үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах.

Монгол Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, дотоодын мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангахад нүүрс, зэсийн дараа ордог чухал түүхий эд бол алт юм. Монголын алт олборлох салбар нь том, дунд хэмжээний уул уурхайн (ТДХУУ) компаниуд болон бичил уурхай (БУ)-аас бүрддэг. ТДХУУ-н компаниуд үйл ажиллагаа явуулахын тулд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл авах шаардлагатай байдаг. Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) -аас (Шигтгээ 3-ыг үзнэ үү) 2020 оны 10-р сарын 31-ний байдлаар улсын хэмжээнд нийт газар нутгийн 4.0% буюу 6,254.7 мянган га газрыг хамарсан 2,644 тусгай зөвшөөрөл олгосны 1,696 нь ашиглалтын, 948 нь хайгуулын тусгай зөвшөөрөл байна (АМГТГ, 2020 он). Нийт 1,696 ашиглалтын тусгай зөвшөөрлийн 533 нь алтны ордны зөвшөөрөл бөгөөд үүний 442 нь (26.1%) нь алтны шороон орд, 91 нь алтны үндсэн ордын тусгай зөвшөөрөл юм. 2019 оны байдлаар Монгол Улс 1,587.1 тонн алтны нөөцтэй байгаагаас 1,513 (95%) тонн нь үндсэн орд, 73.8 тонн нь шороон ордын нөөц байна (АМГТГ, 2019 он).

Шигтгээ 2: Монголын алтны салбарын хууль эрх зүйн орчны өөрчлөлт

1991 он: “Алт” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн
1994 он: АМНАТ-ыг 1.5-12.5%-аар тогтоосон
1997 он: “Алт 2000” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн хөтөлбөр
1997 он: АМНАТ-ыг үндсэн ордод 2.5%, шороон ордын нөөцийг 7.5%-аар тогтоосон.
2006 он: АМНАТ-ыг 5%-аар тогтоосон.
2006 он: ЗБҮӨАТТХ-иар алтны үнэ 500\$/унцаас илүү бол 68%-иар татвар ногдуулсан.
2008 он: Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татварын тухай хууль (ЗБҮӨТТ)-иар алтны үнэ 850\$/унцаас илүү бол 68% -аар татвар ногдуулсан.
2009 он: “Урт нэртэй” хууль батлав.
2010 он: Алтны үнэ 900\$/унцаас илүү бол 5% хүртэл АМНАТ нэмж ногдуулах болов.
2011 он: ЗБҮӨТТ хүчингүй болсон. 68%-ийн татварыг зогсоосон.
2014 он: АМНАТ 2014-2019 оны хооронд 2.5% болж буурсан.
2017 он: “Алт-2” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн.
2019 он: АМНАТ-ыг дахин 5% болгож, нэмэлт роялтийг тэглэсэн.

Сүүлийн 30 жилийн хугацаанд Монголын алтны салбарт янз бүрийн түвшинд нөлөөлөх зохицуулалтын олон арга хэмжээнүүд хэрэгжиж ирсэн (Шигтгээ 2). Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай орноос зах зээлийн эдийн засагтай ардчилсан системд шилжсэн. Зөвлөлт Холбоот Улсаас үзүүлдэг эдийн засгийн дэмжлэгээ алдсаны дараа эдийн засагт тулгарсан хүнд сорилтуудыг даван туулах үүрэг Засгийн газарт тулгарсан. Эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд Засгийн газар эрдэс баялгийн нөөцдөө тулгуурлан “Алт” хөтөлбөрийг боловсруулан Засгийн газрын 1991 оны 11-р сарын 1-ний өдрийн 304 тоот тогтоолоор баталж, Засгийн газрын төсөл

болгон хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна (Сонинбаяр, 2019 он).

Алт хөтөлбөр нь 1996 он хүртэл хэрэгжсэн бөгөөд уг хөтөлбөрийг дараагийн хөтөлбөрүүдээс ялгах үүднээс “Алт-1” гэж нэрлэх болжээ. Энэ хөтөлбөр нь хөрөнгө оруулалт татах, улс орны эдийн засгийн хүнд хэцүү үеийг даван туулахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад алтны жилийн олборлолтын хэмжээ 0.7 тонноос 11 тонн болж өссөн ба алтны шороон ордууд хувийн хөрөнгө оруулалтад түшиглэн ашиглалтад орж, их хэмжээний татварын орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн. 1992-1996 оны хооронд Алт хөтөлбөрийн хүрээнд 13 тонн алт олборлосон гэсэн тооцоо байдаг. Гэсэн хэдий ч байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн чиглэлээр арга хэмжээ аваагүй тул байгаль орчинд халтай төсөл гэж шүүмжлэгдэж байсан. Энэ үед компаниудын техникийн нөхцөл байдал муу, нөхөн сэргээлтийн талаар ойлголт багатай байсан нь сөрөг үр дагавар дагуулсан байна. Түүнчлэн алтны шороон ордуудад олборлолтын хаягдал ихээр хуримтлагдсан нь төвийн бүсэд гар аргаар ашигт малтмал олборлогчид гэнэт олноор цугларах боломжийг бий болгожээ.

Алт-1 хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа 1997 онд “Алт-2000” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үйл ажиллагааны хувьд амжилттай хэрэгжсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд нийт 53 тонн алт олборлосон байна. 2000-2010 оны хооронд үндэсний алтны үйлдвэрлэл эрчимжиж, 2005 онд алт олборлолтын хэмжээ анх удаа 24.1 тонн хүрч байжээ. Гэсэн хэдий ч Улсын Их Хурал 2006 оны 5-р сарын 12-ны өдөр "Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль"-ийг баталж, алтны үнэ 500 \$/ унцаас дээш гарсан тохиолдолд гэнэтийн ашгийн 68%-ийн татвар ногдуулах болсон байна. Татварын огцом өсөлт нь алтны олборлолт, Монголбанк (МБ)-нд алт тушаалт буурахад хүргэсэн.

2009 онд “Гол мөрний эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль” (Урт нэртэй хууль гэгддэг) -ийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн нь алтны салбарт маш их сөргөөр нөлөөлжээ. Энэ нь ашигт малтмалын болон хайгуулын олон лицензийг түдгэлзүүлж, алт олборлож, хайгуул хийж байсан олон компанийг дампууруулахад хүргэсэн. 2007 онд жилд 17.5 тонн алт олборлож байсан бол энэ хэмжээ 3 дахин буурч, 2011 онд 5.7 тонн болжээ (АМГТГ, 2015 он).

Гэсэн хэдий ч алтны салбарын хууль эрх зүй, татварын орчин сайжирснаар 2013 оноос хойш алтны үйлдвэрлэл, борлуулалт өсөх хандлага ажиглагдсан. Ялангуяа 2011 онд Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар (ЗБҮӨТ)-ын тухай хуулийг хүчингүй болгож, Ашигт малтмал ашигласны татварыг 2014 онд 2.5% болгон бууруулсан нь онцгой үр нөлөө үзүүлсэн байна. 2017 онд Засгийн газар Алт-2000 хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж алтны үйлдвэрлэлийг дэмжих "Алт-2" хөтөлбөр гэж нэрлэсэн байна (АМГТГ, 2015 он).

Шигтгээ 3: Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)

АМГТГ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны харьяа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд эрдэс баялгийн нөөцийг удирдах, хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой. Монголын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх болон бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх таатай орчныг сурталчилж, мэдээллээр хангадаг. АМГТГ нь Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор хайгуулын болон ашиглалтын лицензтэй холбоотой үйлчилгээ үзүүлдэг. Үүнд: уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалттай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгодог. Түүнчлэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийг удирдаж, ашигт малтмалын эрэл, хайгуул, олборлолт, боловсруулалттай холбоотой бүхий л тайлан, судалгааг хянаж баталдаг.

Эдийн засгийг сэргээх ажлын хүрээнд Засгийн газар 2017 оны 1-р сарын 19-ний өдөр Алт-2 хөтөлбөрийг баталсан бөгөөд энэхүү хөтөлбөр нь үндэсний хэмжээнд алтны олборлолтыг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах замаар гадаад валютын нөөцийг бүрдүүлэх, геологийн судалгаа, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, алтны үйлдвэрлэлийг дэмжих, технологи сайжруулах, байгаль орчны менежмент, байгаль хамгааллын үр дүнтэй системийг бий болгох, бичил уурхайгаар алт олборлох, борлуулах ажлыг сайжруулах гол зорилготой юм. Хөтөлбөр нь 2025 он гэхэд алтны үйлдвэрлэлийн хэмжээг 25 тонн-д хүргэх, алтны нөөцийг 100-150 тонноор нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Алт-2 хөтөлбөрт алтны бичил уурхай (АБУ)-тай холбоотой тодорхой зорилтуудыг багтаасан болно (Монгол Улсын Засгийн газар, 2017 он). Үүнд:

- Бичил уурхайгаар алт олборлоход ашиглаж байгаа техникийн стандартыг боловсронгуй болгох, хаягдал багатай ашиглах технологийг нэвтрүүлэх, бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авах болон борлуулах албан ёсны сүлжээ бий болгох;
- Бичил уурхай эрхлэх талбайг улсын хэмжээнд нарийвчлан тогтоож, бүртгэж байх;
- Бичил уурхайгаар алт олборлогч иргэдийг албан ёсны болгох, нөхөрлөлийг чадавхижуулж бүртгэх замаар цаашид хуулийн этгээд болгон өөрчлөн зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хүн амын орлогын болон бусад татвар, төлбөр, хураамж ногдуулах оновчтой тогтолцоог бий болгох;
- Алтны ордыг ашиглах явцад үүссэн хаягдал нөөцийг бүртгэлжүүлж, үнэлгээ хийх;
- Бичил уурхай эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник хангамж болон нөхөн сэргээлтийн талаар сургалт явуулах;
- Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болж орхигдсон талбайд байгаа үүсмэл ордуудыг ашиглах үйл ажиллагаанд орон нутгийн бичил уурхайн нөхөрлөлүүдийг оролцуулахад дэмжлэг үзүүлэх.

Одоогийн байдлаар Алт-2 хөтөлбөрийн хэрэгжилт төдийлөн хангалттай бус байгаа бөгөөд уул уурхайн гол хууль тогтоомжуудыг батлах ажил хүлээгдэж, хайгуулын лиценз олгох ажил хязгаарлагдмал хэвээр байна. Засгийн газраас 2017 оны 5-р сард Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам баталсныг эс тооцвол бичил уурхайтай холбоотой бусад зорилтууд хэрэгжээгүй байна. Гэсэн хэдий ч Монголбанканд тушаасан алтны хэмжээ 2018 онд 21.9 тонн болж өссөн байна. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2019 онд 5% болгон сэргээсэн нь алтны борлуулалт 2019 онд 15.2 тонн болж буурахад хүргэсэн бол 2020 онд 23.6 тонн болж нэмэгдсэн (Бүлэг 7).

1.1.1 Алтны бичил уурхай

Монгол Улсын эдийн засаг уламжлалт мал аж ахуйд суурилж ирсэн. Бичил уурхайн үйл ажиллагаа сүүлийн 30 жилээс эхэлж явагдсан. 1990-ээд оны үед улс орон зах зээлийн эдийн засагт шилжсэнээр нийгмийн ялгаа, бүрэн бус хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл ихээхэн нэмэгдсэн. Ялангуяа хөдөө нутагт амьдардаг иргэд илүүтэйгээр нийгмийн тэгш бус байдалд өртөж, зудын гамшиг, байгалийн хатуу ширүүн нөхцөл байдлыг улам дордуулсан. Үүний улмаас хөдөө аж ахуй болон бусад салбарт ажиллаж байсан хүмүүс эдийн засгийн хэрэгцээ шаардлагаа даган бичил уурхай руу татагдан орсон байна (Levin Sources, 2017 он).

Гар аргаар алт олборлогчдын тоо сүүлийн хорин жилийн хугацаанд улирлын чанартай хэлбэлзэж байна. 2000-аад оны эхэн үеэс 100,000-120,000 гаруй иргэд энэ салбарт ажиллаж, шууд бусаар хүн амын 15 орчим хувь буюу 400,000 гаруй монголчуудын амьжиргааг залгуулж байгааг тооцож гаргасан байдаг (Дэлхийн банк, 2003, 2007 он). Хэдийгээр энэ тоо баримтыг хэт өндрөөр мэдээлсэн байх магадлалтай боловч энэ нь монголчуудын дунд бичил уурхай эрхлэх явдал түгээмэл байсныг харуулж байна. Ер нь бичил уурхайн үйл ажиллагаа ихэвчлэн далд шинжтэй, хууль бус, албан бусаар явагддаг, мөн өвөл газар шороо хөлдөж олборлолт явуулах боломжгүйгээс улирлын чанартай байдаг тул энд хамрагдсан хүмүүсийн тоог тодорхой гаргахад хэцүү байдаг (Levin Sources, 2017 он).

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-оос 2012 онд БУ-н салбарын суурь түвшинг тогтоох, мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор улсын хэмжээнд анхны судалгааг хийсэн. Энэхүү судалгааг 2016 онд дахин хийснээр судалгааны үр дүнг дөрвөн жилийн хугацаагаар харьцуулах боломж бий болсон. ТБУТ-ийн санхүүжилтээр хийгдсэн уг хоёр судалгаанд (Шигтгээ 4) бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу бичил уурхайн нөхөрлөл, хоршоо байгуулсан уурхайчид хамрагджээ.

Шигтгээ 4: Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ)

Швейцарийн хөгжлийн агентлагийн ТБУТ нь Монгол Улсад 2005-2019 онд хэрэгжсэн олон улсын томоохон төсөл байсан юм. ТБУТ нь байгаль орчинд хор хөнөөлтэй, бичил уурхайн аюултай практикаас тогтвортой, аюул осолгүй, хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагаанд шилжихэд хувь нэмэр оруулсан байна. Төслийн үр дүнд хууль эрх зүйн орчин сайжирч, технологи, аюулгүй ажиллагаа сайжирсан төдийгүй байгаль орчны нөхөн сэргээлтийн шилдэг туршлагаудыг хэрэгжүүлж, бичил уурхайн байгууллагууд хөгжиж, МБУНДХ-ны уурхайчдын эрхийг хамгаалах чадавх бэхжиж, бичил уурхайн менежмент, засаглал, олон талт оролцогч талуудын хамтын ажиллагаа, хамтын ажиллагааг сайжруулах талаарх төрийн төв ба орон нутгийн засаг захиргааны мэдлэг, чадавх дээшилсэн (Монгол Улсын Засгийн газар, 2020 он). Вэбсайт: <http://sam.mn/>

2012 оны судалгаанд албан ба албан бус уурхайчдыг ялгаж үзэлгүйгээр нийт 13,375 бичил уурхайчныг хамруулсан. Эдгээр уурхайчид 20 аймгийн 76 сум, Улаанбаатарын нэг дүүрэгт байршилтай ашигт малтмалын нөөц бүхий 238 ордод үйл ажиллагаа явуулж байжээ. Судалгаанд оролцсон 13,400 бичил уурхайчдаас 10,500 (78%) нь алт, 1,400 (10%) нь нүүрс, 1,000 (8%) нь жонш, 300 (2%) нь вольфрам, 47 (0.4%) нь цагаан тугалга, 10 (0.1%) нь шохойн чулуу, 100 (1%) нь үнэт чулуу, 49 (0.4%) нь давс олборлосон байна. (ҮСХ, 2013 он).

2016 оны судалгаанд 18 аймгийн 97 сум, Улаанбаатар хотын нэг дүүргийн 113 ордын 332 талбайд үйл ажиллагаа явуулж буй 11,962 бичил уурхайчдыг хамруулсан байна. Эдгээр уурхайчдын 74% нь алт, 11% нь жонш, 11% нь нүүрс, 6% нь шохойн чулуу, үнэт чулуу, вольфрам зэргийг бага хэмжээгээр олборлодог байсан бөгөөд ашигт малтмалын үйлдвэрлэлийг хот, аймгийн төвийн ойролцоо явуулж байсан (ҮСХ, 2017 он).


Зураг 1-1-т үзүүлснээр бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагаа нь Монгол Улсын баруун болон төв хэсэгт идэвхтэй, тархалттай байдаг бол жонш ба вольфрамын олборлох үйл ажиллагаа зүүн бүсэд төвлөрдөг.

МБУНДХ (Шигтгээ 5)–ны мэдээллээр зохион байгуулалтад орсон 1,181 нөхөрлөлд 10,671 уурхайчин бүртгэлтэй ажиллаж байгаа бөгөөд 2019 оны байдлаар 6,705 нь газрын зөвшөөрөлтэй, үүний 86% нь алт олборлогчид байна (МБУНДХ, 2019 он).

Шигтгээ 5: Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо (МБУНДХ буюу Дээвэр холбоо)

Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо нь салбарын нийгэм-эдийн засагт үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх, бичил уурхайд хандах олон нийтийн эерэг хандлагыг сурталчлах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нөхцлийг сайжруулах замаар тогтвортой бичил уурхайг төлөвшүүлэх бичил уурхайчдын хэрэгцээ шаардлагын дагуу 2013 онд байгуулагдсан юм. Дээвэр холбоо байгуулагдсан цагаас хойш гишүүдийн хувь нэмэр, үүрэг амлалтад мэдэгдэхүйц ахиц дэвшил гарсан. 2018 оны байдлаар Дээвэр холбоо 15 аймагт 7,500 гишүүнтэй болсон бөгөөд салбараа хөгжүүлэх чиглэлээр гишүүддээ чадавхижуулах сургалтуудыг тогтмол явуулж байна (МБУНДХ, 2020 он)

Бичил уурхай эрхлэгчдийн олборлодог ашигт малтмал (сумаар)



Зураг 1-1. Бичил уурхайгаар олборлодог ашигт малтмал (Хөгжил ба байгаль орчны төв, 2015 он)

1.2 Судалгааны зорилго ба хамаарал

Төслийн баримт бичиг бэлтгэх үе шатанд алтны бичил уурхай (АБУ) дахь мөнгөн усны хэрэглээ, байгаль орчны менежмент, жендэрийн асуудлууд болон санхүүгийн урсгалын талаарх Монголын нөхцөл байдлыг судалсан хэд хэдэн судалгаа хийгдсэн. Гэсэн хэдий ч эдгээр бүх судалгаанд төсөл хэрэгжих бүх газрууд болон шаардлагатай асуудлуудыг тухайлбал, уурхайчдын сургалтын хэрэгцээ зэргийг хамруулж чадаагүй байна. Тиймээс эдгээр судалгааны хүрээнд цуглуулж, дүн шинжилгээ хийсэн мэдээлэл ялангуяа байгаль орчин, албажуулалт, жендэр, мөнгөн усны хэрэглээ, чадавх бэхжүүлэх талаарх мэдээлэл нь төслийн суурь үзүүлэлт болж, төслийн үйл ажиллагааг чиглүүлэхэд хангалтгүй байсан юм. Тиймээс энэхүү судалгааг төслийн сонгогдсон таван бүс нутаг, харьяалах засаг захиргааны нутаг дэвсгэрийг хамруулан бүрэн гүйцэд, хангалттай, бодит суурь мэдээллийг цуглуулах, төслийн цаашдын үр дүнг хянаж үнэлэх, мэдээллээр хангах зорилгоор хийсэн болно.

Энэхүү судалгааны гол зорилго нь судалгааны таван бүс нутагт дараах үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг хамарсан суурь үнэлгээ хийхэд чиглэгдсэн. Үүнд:

- Нийгэм-эдийн засгийн суурь судалгаа: Бичил уурхай эрхлэгчдийн боловсрол, нас, гэрлэлтийн байдал, нийгмийн үйлчилгээний хүртээмж болон даатгалын хамрах хүрээ, үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлт, орлого, бичил уурхайн байгууллагын харьяалал зэрэг нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг баримтжуулах (Бүлэг 2).
- Албажуулалтын байдал: Бичил уурхайчид болон БУ-н байгууллагуудад одоо хэрэгжиж байгаа Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, орон нутгийн засаг захиргааны бодлого, шийдвэрийг дагаж мөрдөхөд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох (Бүлэг 3).
- Уул уурхайн практик: Уул уурхайн техникийн, байгаль орчин болон нөхөн сэргээлт болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн практик үйл ажиллагаа нь хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг үнэлэх (Бүлэг 4).
- Мөнгөн усны хэрэглээ: Алт олборлоход мөнгөн усыг хэрэглэж байгаа эсэх, мөнгөн усны хэрэглээ, хаягдал бохирдолтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг дагаж мөрдөж байгаа эсэхийг тодорхойлох (Бүлэг 5).
- Жендэрийн зураглал: Бичил уурхай эрхэлж буй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд, алтны бичил уурхайн салбарын жендэрийн нөхцөл байдал (жишээлбэл, байгууллагын түвшин, ажил хөдөлмөрийн хүрээн дэх жендэрийн хуваарь, эрх мэдэл ба манлайлал, нөөц ашиглах хүртээмж гэх мэт), салбарын эмэгтэйчүүдийн жендэрийн онцлог бэрхшээл, гэр бүл дэх хөдөлмөрийн хуваарь болон шийдвэр гаргалт зэрэг гэр бүлийн хүрээний жендэрийн нөхцөл байдлыг судлах (Бүлэг 6).
- Алтны зах зээл: Алтны нийлүүлэлтийн сүлжээ, бичил уурхайчдын олборлосон хүдэр, үйлдвэрлэсэн алтны хэмжээг тооцоолох, түүнчлэн бичил уурхайчдын санхүүгийн хүртээмжийг үнэлэх (Бүлэг 7).
- Сургалтын хэрэгцээ: Уул уурхайн практик, хууль эрх зүйн орчны талаарх мэдлэгийг үнэлэх, сургалтын хэрэгцээг тодорхойлох, мэдээллийн янз бүрийн сувгуудын одоогийн хэрэглээнд дүн шинжилгээ хийх (Бүлэг 8).

Судалгааны нарийвчилсан зорилтуудыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Төслийг судалгааны бүс нутгийн өнөөгийн байдлыг үнэлэх мэдээллээр хангах, төслийн явц, үр дүнд мониторинг хийх суурь мэдээлэл болгон ашиглах;
- Бичил уурхай эрхлэгчид болон төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээг АБУ-н албажуулалт, нийлүүлэлтийн сүлжээний менежмент, байгаль орчин, нийгмийн хяналт, гарал үүслийг мөшгих, хууль эрх зүй, захиргаа, жендэрийн зэрэг асуудлын хүрээнд тодорхойлох;
- Төсөл хэрэгжих газруудад төслийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад авч үзэх шаардлагатай чухал асуудлуудыг тодорхойлох;
- АБУ-н салбарын гол оролцогч талуудад салбарын уул уурхайн практикийг сайжруулах, түүний дотор мөнгөн усны хэрэглээг хэрхэн бууруулах, жендэрийн тэгш байдлыг сайжруулах талаар зөвлөмж гаргах.

1.3 Судалгааны загвар, аргачлал

Энэхүү нөхцөл байдлын судалгаанд тоон судалгаа (Хавсралт А), чанарын мэдээллээр хангах ганцаарчилсан ярилцлага (Хавсралт Б), жендэрийн асуудлыг хамруулсан гүнзгийрүүлсэн судалгаа (Хавсралт Г) болон бичиг баримт судлах аргыг нэгтгэсэн холимог аргыг ашигласан болно.

Хүснэгт 1.3-1. Анхан шатны мэдээлэл цуглуулахад ашигласан аргууд

Аргачлал	Зорилтот хүн ам	Хамарсан судалгааны сэдвүүд
Тоон судалгаа	Судалгааны 5 бүс нутгийн 371 алтны бичил уурхайчид	- Нийгэм, эдийн засгийн мэдээлэл - Хууль, эрх зүйн орчин - Хүдэр олборлох, тээвэрлэх, баяжуулах - Алтны үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээ - Хөдөлмөрийн болон техникийн аюулгүй байдал - Байгаль орчны практик үйл ажиллагаа - Чадавхи бэхжүүлэх, мэдээллийн эх үүсвэр - Ажил үүрэг, шийдвэр гаргах - Мөнгөн усны хэрэглээ - COVID-19 цар тахлын нөлөөлөл Нийт 126 асуулт бүхий асуулгыг Хавсралт А-аас үзнэ үү.
Ганцаарчилсан ярилцлага	Төв болон орон нутгийн 73 хүнтэй ярилцлага хийсэн: - Төрийн холбогдох байгууллагууд - ТББ-үүд - Орон нутгийн иргэдийн төлөөлөл - Алтны нийлүүлэлтийн сүлжээний экспертүүд Хавсралт Б-г үзнэ үү.	- Монголд болон судалгааны бүс нутаг дахь АБУ-н нөхцөл байдал, тулгамдсан асуудлууд - Холбогдох хууль эрх зүйн орчин, хэрэгжилт, дагаж мөрдөх байдал - Мөнгөн усны хэрэглээ - Жендэртэй холбоотой бэрхшээл ба жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгаж буй байдал - Нийгмийн үйлчилгээний хүртээмж - Сургалтын хэрэгцээ - Одоогийн практик үйл ажиллагааны техникийн асуудлууд - Алтны худалдаа, нийлүүлэлтийн сүлжээ - Орон нутгийн цехүүдийн хүчин чадал - Байгаль орчны менежмент ба нөхөн сэргээлт Удирдамжийг Хавсралт В-ээс үзнэ үү.


Жендэрийн гүнзгийрүүлсэн судалгаа	Судалгааны 5 бүс нутгийн 30 эмэгтэй	- Эмэгтэй бичил уурхайчдын гол бэрхшээл ба давуу тал - Шийдвэр гаргах, нөөц боломжийг тэгш хүртэх эрх - Хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудал - Мэдлэгийн хомсдол ба сургалтын хэрэгцээ - Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт Аргачлалыг Хавсралт Г-ээс үзнэ үү.
---	--	--

Тоон болон чанарын мэдээлэл цуглуулах аргачлалыг судалгаанд оролцогч талууд болон судалгааны аргуудын хооронд мэдээллийг харьцуулан шалгах боломжтой байхаар боловсруулсан. Гэсэн хэдий ч судалгаанд хамруулж үзсэн дээрх бүрэлдэхүүн хэсгүүдийн зарим асуудлуудыг тусгай аргаар судалсан болно. Жишээлбэл, тоон судалгааны аргачлалыг шалгах зорилгоор 20 бичил уурхайчдыг хамруулан туршилтын судалгаа хийж, хууль эрх зүйн орчин, алт олборлох үйл ажиллагаа, алтны жин хэмжилт, алтны нийлүүлэлтийн сүлжээний талаар уурхайчид хязгаарлагдмал мэдлэгтэй байсныг тогтоосон. Тиймээс хууль эрх зүйн орчин, техникийн боловсруулалтын талаарх тодорхой асуултуудыг зөвхөн менежмент, борлуулалт, логистикийн зохицуулалтыг хариуцдаг бичил уурхайн нөхөрлөлийн ахлагч нартай хийсэн ярилцлагад оруулсан болно. Жендэрт суурилсан хүчирхийлэл гэх зэрэг жендэрийн мэдрэмжтэй сэдвүүдийг тоон судалгаанд тусгахгүйгээр зөвхөн ганцаарчилсан ярилцлага, гүнзгийрүүлсэн судалгааны хүрээнд авч үзсэн.

1.3.1 Судалгааны бүс нутаг

Энэхүү судалгаанд төсөл хэрэгжиж буй гурван аймгийн дөрвөн сум, нэг тосгон хамрагдсан. (Зураг 1-2):

- 1) Сэлэнгэ аймгийн Баянгол сум (цаашид “Баянгол” гэх),
- 2) Сэлэнгэ аймгийн Мандал сум (Түнхэл тосгоноос бусад) (цаашид “Мандал” гэх),
- 3) Мандал сумын Түнхэл тосгон (цаашид “Түнхэл” гэх),
- 4) Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум (цаашид “Есөнбулаг” гэх),
- 5) Ховд аймгийн Алтай сум (цаашид “Алтай” гэх).



Зураг 1-2. Төсөл хэрэгжиж буй 5 газар

2019 оны 11-р сард planetGOLD Монгол төсөл болон АБУЗ-ийн ажилтнуудын хамтарсан баг алтны бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж буй есөн газарт үнэлгээ хийж, төсөл хэрэгжих газруудыг тодорхойлсон. Газар тус бүрийг, орон нутгийн захиргааны байгууллагын дэмжлэг, техникийн шаардлага, АБУ-н боломжит ашиг шим хүртэгчид, мөнгөн усны хэрэглээ, алтны худалдаа, магадлан шинжилгээ, санхүүгийн хэрэгцээ, АБУ-н талбайн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа гэсэн долоон шалгуур үзүүлэлтээр үнэлсэн. Шалгуур үзүүлэлтээр хамгийн өндөр үнэлгээ авсан Алтай сум, Түнхэл тосгон гэсэн хоёр газарт мөнгөн усгүйгээр алт баяжуулах системийг хэрэгжүүлэхээр сонгосон байна. Үнэлгээний баг нь алтны бичил уурхайн салбарт сайжруулах шаардлагатай олон асуудал, боломжууд байгааг тодорхойлсон бөгөөд төслийн Удирдах хорооноос сургалт, семинар, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг төслийн бичиг баримтад тодорхойлсон Есөнбулаг, Түнхэл тосгон байрлах Мандал сум, Мандалтай залгаа орших Баянгол гэсэн гурван газарт хэрэгжүүлэх нь зүйтэй гэдгийг зөвлөж, баталсан юм.

1.3.2 Судалгааны хүн ам

Энэхүү судалгаанд хамрагдах бичил уурхайчдын олонлог, түүврийг тодорхойлохын тулд зорилтот бүлгүүдийн тодорхойлолтыг боловсруулсан. Энэ нь судалгааны зорилтот хүн амаа сонгох, ангилахад аль алинд нь нийцэж байв. Судалгааны үеэр оролцогч аль бүлэгт хамаарагдаж байгааг нь өөрөөр нь тодорхойлуулсан. Бүлгүүдийг албан ёсны бичил уурхайчин (3), албан бус (1), хууль бусаар ашигт малтмал олборлогч (1) гэсэн нийт 5 бүлэгт ангилсан болно. (албан ёсны байдлын / статусыг тодорхойлолтыг 3.4-бүлгээс үзнэ үү).

(1-3): Албан ёсны бичил уурхайчин: Албан ёсны бичил уурхайчин гэж 18-аас дээш насны, уурхайчнаар ажиллаж байгаа тухайн аймаг, сумынхаа иргэний бүртгэлд бүртгэгдсэн иргэнийг хэлнэ. Албан ёсны бичил уурхайчин дор дурдсан аль нэг байгууллагуудын гишүүн байна. Түүнчлэн албан ёсны уурхайчин АМГТГ-аас уг газар нь бичил уурхайгаар олборлох боломжтой болохыг баталгаажуулсан баримт бичиг болох газрын дүгнэлт гаргасан талбайд Засаг даргатай гэрээ байгуулсан байдаг (3.4-р бүлгийг үзнэ үү). Судалгаанд хамрагдсан албан ёсны бичил уурхайчин нь дараах 4 байгууллагын аль нэгэнд харьяалагдаж болно.

- I. **Бүртгэлтэй нөхөрлөл:** Хуулийн этгээдэд харьяалагддаг, эсвэл орон нутаг болон/ аймгийн Бүртгэлийн албанд бүртгүүлсэн уурхайчдын бүлэг. Нөхөрлөлд гишүүнээр элссэн тухай гэрээ нь үйл ажиллагааных нь үндэс суурь болдог. Тэд ихэвчлэн илүү сайн технологи, тоног төхөөрөмж ашиглах боломжтой байдаг бөгөөд холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх шаардлагатай байдаг.
- II. **Бүртгэлгүй нөхөрлөл:** Монгол Улсын Иргэний хуульд заасны дагуу бүртгэлгүй нөхөрлөлийн гишүүдтэй байгуулсан хамтран ажиллах гэрээнд үндэслэн байгуулагдсан уурхайчдын бүлэг. Бүртгэгдээгүй нөхөрлөл нь аймаг орон нутгийн засаг захиргаанд хуулийн этгээдээр бүртгүүлдэггүй тул санхүүжилт, шинэ технологийн хүртээмж бэрхшээлтэй байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөхгүй байж болзошгүй юм.

III. Хоршоо: Сайн дурын үндсэн дээр байгуулагдсан эдийн засаг, нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор хэд хэдэн хүн хамтран байгуулсан, нэгдсэн, ардчилсан, хамтарсан удирдлага, хяналттай, дундын хөрөнгөд суурилсан үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд. Хоршооны гишүүд хоршоо үүсгэн байгуулах дүрмээ баталдаг бөгөөд энэ нь Улсын бүртгэлийн байгууллагад албан ёсоор бүртгүүлэх үндэслэл болдог.

IV. Бичил уурхайн ТББ: Бичил уурхайчид сайн дурын үндсэн дээр нэгдэж гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, санал бодол, дуу хоолойг илэрхийлэх зорилгоор байгуулдаг ашгийн бус байгууллага. Бичил уурхайн ТББ-ын гишүүд нь бүртгэлгүй, бүртгэлтэй нөхөрлөлийн гишүүн байж болно, эсвэл хувиараа ашигт малтмал олборлогч байж болно

(4): Албан бус уурхайчин: Албан бус уурхайчин нь тухайн орон нутагт бүртгэлтэй, албан ёсны байгууллагад харьяалагддаг боловч тухайн сумын Засаг даргатай ямар нэг гэрээгүйгээр буюу АМГТГ-аас газрын дүгнэлтгүй ажилладаг иргэн юм. Тиймээс албан бус уурхайчид зөвшөөрөгдөөгүй уурхайн талбайд албан бусаар ажилладаг.

(5): Хууль бус ашигт малтмал олборлогч: Хууль бус ашигт малтмал олборлогч гэдэгт аливаа нэг албан ёсны байгууллагад харьяалагддаггүй хувь хүн эсвэл бүлэг хүмүүс хамаардаг. Хууль бусаар зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал ашиглахыг хориглосон, хязгаарласан болон тусгай хамгаалалттай газар нутагт байгаль орчинд халтай үйл ажиллагаа явуулдаг тул холбогдох хууль тогтоомж, орон нутгийн дүрэм, журмыг дагаж мөрддөггүй.

Тухайн бичил уурхайчныг аль нэг ангилалд шууд тохирно гэж үзэх амаргүй, тэдний статус өөрчлөгдөж байдаг. Иймд нөхцөл байдалд тохируулж тодорхой хэмжээгээр таацуулсан тал бий (1.4-р бүлгийг үзнэ үү). Тухайлбал, Засаг даргатай байгуулсан гэрээгээ сунгасан эсэхээс хамаарч бичил уурхайчны албан ёсны статус өөрчлөгдсөн бол эсрэгээр нь авч үзэхээс илүүтэй албан бус байдлаас албан ёсны байдал руу шилжих үргэлжлэл гэж тайлбарлаж болно. Бичил уурхайчдыг зохион байгуулалтын түвшнээр нь мөн бүлэглэж болно. Эхний дөрвөн бүлгийг зохион байгуулалтад орсон уурхайчин, харин хууль бус уурхайчдыг зохион байгуулалтад ороогүй уурхайчин гэж ангилсан. Энэ ангиллыг түүврийн стратегид мөн ашиглав. Үүнээс гадна өөр өөр ангилал бүлгүүдэд хамаарах бичил уурхайчдын тоог гаргахдаа төрөл бүрийн мэдээллийн эх сурвалж, аргуудыг ашигласан болно.

1.3.3 Түүврийн стратеги

Тоон судалгааны түүврийн хүрээг өөрөөр хэлбэл төсөл хэрэгжиж байгаа 5 газрын (цаашид "судалгааны бүс нутаг" гэх) зохион байгуулалттай, зохион байгуулалтгүй бичил уурхайчдын нийт тоог тооцохдоо бичил уурхайн талаар хийсэн сүүлийн үеийн судалгаануудын мэдээллийг ашигласан. 2016 онд Швейцарийн хөгжлийн агентлагийн ТБҮТ-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хийсэн ҮСХ-ны судалгаа нь зохион байгуулалттай бичил уурхайчдын түүврийн хэмжээг хамгийн бодит байдлаар тооцох мэдээллийн эх сурвалж болсон. Энэхүү мэдээлэлд үндэслэн орон нутгийн төрийн бус байгууллагууд (ТББ)-ууд болон МБУНДХ-той холбогдож судалгааны бүс нутгуудын бичил уурхайчдын тоог

хамгийн сүүлийн үеийн байдлаар авсан. МБУНДХ нь бичил уурхайн нөхөрлөлүүд (ТББ оруулан) болон тэдгээрийн гишүүдийн тоог гаргаж өгсөн. Харин зохион байгуулалтгүй уурхайчдын тоог урьдчилсан судалгаа, орон нутгийн албан тушаалтнуудтай хийсэн ярилцлагын үр дүнд үндэслэн тооцоолсон (Хүснэгт 1-2).

Хүснэгт 1.3-2. Түүврийн хүрээ (нөхөрлөл, гишүүдийн тоо, зохион байгуулалтгүй уурхайчдын тоо, судалгааны бүс нутгаар)

№	Аймаг	Сум/ тосгон	Зохион байгуулалттай уурхайчид		Зохион байгуулалтгүй (хууль бүс) уурхайчид
			Нөхөрлөлийн тоо	Гишүүдийн тоо	Зохион байгуулалтгүй уурхайчдын тоо
1	Говь-Алтай	Есөнбулаг	22	214	500 – 1,000
2	Сэлэнгэ	Баянгол	27	108	300
3		Мандал (Түнхэл ороогүй)	32	189	500 – 800
4		Түнхэл	8	180	300 – 500
5	Ховд	Алтай	11	99	500 – 1,000
НИЙТ			100	790	2,100 – 3,600

Бичил уурхайчид зургаан сараас дээш хугацаагаар оршин суусан тохиолдолд тухайн сумандаа бүртгүүлэх ёстой байдаг учраас судалгааны түүвэрлэлтийн хүрээ нь зөвхөн бүртгүүлсэн сумандаа олборлолт хийдэг уурхайчдаар хязгаарлагдаж болно. Зарим уурхайчид уурхайн талбайд ажиллахаар бусад сум руу түр хугацаагаар шилжин суурьшдаг боловч тэнд бүртгүүлдэггүй. Жишээлбэл, Есөнбулагт албан ёсны зөвшөөрөлтэй олборлолтын талбай байхгүй боловч бичил уурхайчдын тоо өндөр, хэд хэдэн баяжуулах цех байдаг. Тиймээс энэ бүлгийн судалгаанд хамрагдагсад тус аймгийн Алтай сум руу (цаашид “Алтай, Г.А.” гэх) явж хүдэр олборлоод, Есөнбулаг дахь баяжуулах цехэд хүдрээ баяжуулдаг байна.

Судалгааны бүс нутгийн хэмжээнд зохион байгуулалтад орсон 100 нөхөрлөл, нөхөрлөлийн 790 гишүүний түүврийн эх олонлогийг (жендэрээр нь ангилах боломжгүй) тодорхойлсон. Гэсэн хэдий ч АБУ-н салбарын тогтмол бус ажлын хуваарь, улирлын шинж чанартай байдлаас шалтгаалан тухайн газарт ажиллаж буй уурхайчдын тоог яг тодорхой гаргаж чадаагүй юм. Мөн түүнчлэн бүртгэгдсэн гишүүдийн 15 орчим хувь нь ТББ болон нөхөрлөлийн гишүүдэд захиргааны болон менежментийн дэмжлэг үзүүлдэг уурхайн үндсэн үйл ажиллагаанд оролцдоггүй хүмүүс байгаа юм.

Зохион байгуулалтгүй уурхайчдын түүврийн эх олонлогийг 2100-3600 уурхайчдаас бүрдэнэ гэж тооцоолсон ч тэдний талаарх мэдээлэл тодорхойгүй, уурхайчдын ажлын хуваарь тогтмол бус, тэдэнтэй хамтарч ажиллахад бэрхшээл тулгарч байсан зэргээс шалтгаалан хэрэглэхэд хүндрэлтэй болсон.

Судалгааны бүс нутгийн хэмжээнд урьдчилан тодорхойлсон таван бүлгийн уурхайчдыг хамруулах зорилгоор зорилтот түүврийн аргыг сонгож, судалгаанд оролцогчдыг байгууллагын зохион байгуулалт (зохион байгуулалттай болон зохион байгуулалтгүй), ажил үүргээр (гишүүн болон ахлагч) болон жендэрээр ялгасан. Салбарын ажиллагсдын 25%-30%-ийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг гэсэн мэдээллийг үндэслэн уурхайчин эмэгтэйчүүдийн дор хаяж 25%-ийг хамруулах зорилго тавьсан. Судалгаанд зориулж квотын түүвэрлэлтийн аргыг хэрэглэхээр

анх төлөвлөж дээр дурдсан ангилал тус бүрт хамрагдах судалгаанд оролцогчдын тоог урьдчилан тодорхойлсон байсан боловч уурхайчдын судалгаанд хамрагдах боломжоос шалтгаалан мэдээлэл цуглуулах явцад дээрх аргыг ашиглах боломжгүй болсон (1.4-өөс судалгааны хязгаарлалтыг үзнэ үү).

Судалгаанд 371 хүнийг хамруулж, ярилцлага хийсэн (Хүснэгт 1-3). Үүнээс 81% нь зохион байгуулалттай уурхайчид, 27% нь эмэгтэйчүүд (Хүснэгт 1-4), 83% нь нөхөрлөл, ТББ-ын гишүүд, 17% нь ахлагч нар байв.

Хүснэгт 1.3-3. Албажсан байдал (харьяалагддаг байгууллага, гишүүнчлэл, судалгааны бүс нутгаар)

Зохион байгуулалтын статус		Баянгол	Мандал	Түнхэл	Есөнбулаг	Алтай	Нийт
Зохион байгуулалттай	Бүртгэлтэй нөхөрлөл	21	84	39	20	33	197 (53%)
	Гишүүн	19	73	34	17	28	171 (46%)
	Ахлагч	2	11	5	3	5	26 (7%)
	Бүртгэлгүй нөхөрлөл	10	6	11	6	1	34 (9%)
	Гишүүн	8	5	10	5		28 (8%)
	Ахлагч	2	1	1	1	1	6 (2%)
	БУ ТББ	1	7	16	27	0	51 (14%)
	Гишүүн	0	4	13	19	0	36 (10%)
Зохион байгуулалтгүй	Ахлагч	1	3	3	8		15 (4%)
	Албан бүс уурхайчин	9	4	3	1	0	17 (5%)
	Хууль бүс уурхайчин	11	11	2	8	40	72 (19%)
Нийт		52	112	71	62	74	371

Хүснэгт 1.3-4. Түүврийн хэмжээ (судалгааны бүс нутаг, хүйсээр)

	Баянгол	Мандал	Түнхэл	Есөнбулаг	Алтай	Нийт
Эмэгтэй уурхайчид	15	28	20	23	14	100 (27%)
Эрэгтэй уурхайчид	37	84	51	39	60	271 (73%)
Нийт	52	112	71	62	74	371

Ганцаарчилсан ярилцлагад оролцогчдыг зорилтот түүврийн стратегид үндэслэн үндэсний болон орон нутгийн түвшинд тухайн салбартай холбоотой үйл ажиллагааг хариуцдаг (жишээлбэл, төрийн төв болон орон нутгийн байгууллагын байгаль орчны мэргэжилтнүүд), ажил үүргээсээ шалтгаалан салбарын талаар гүнзгий мэдлэгтэй (жишээлбэл, алтны худалдаачин, боловсруулах үйлдвэрийн эзэн) эсвэл салбарыг сайжруулахад оролцсон (тухайлбал: ТББ) гол гол хамтран ажиллагч талуудыг хамруулах зорилгоор сонгосон. Нийт 73 ярилцлага (35 эмэгтэй) хийсэн. Үүнд: Улаанбаатарт 5, Сэлэнгэд (Сүхбаатар сум) 6, Баянголд 12, Мандалд 12, Түнхэлд 7, Есөнбулагт (Говь-Алтай) 19, Алтай болон Жаргалантад 12 (Ховд¹⁶) ярилцлага хийсэн.

Жендэрийн талаар гүнзгийрүүлэн судлахын тулд тоон судалгааны үед ганцаарчилсан ярилцлагад хамрагдах боломжтой оролцогчдыг уг сэдвийн талаарх сонирхол, АБУ дахь жендэрийн асуудлаар мэдээлэл хуваалцах эрмэлзэл, туршлага, жендэрийн мэдлэгийн түвшинг үндэслэн тодорхойлсон. Нийт 30 уурхайчин эмэгтэйтэй ярилцлага хийсэн болно.

¹⁶ Жаргалант сум нь Ховд аймгийн төв бөгөөд аймгийн хэмжээнд бүх сумдыг удирдлагаар хангаж, мониторинг хийдэг. Иймээс аймгийн төрийн байгууллагын ажилтнууд ганцаарчилсан ярилцлагад оролцсон болно.

Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Тоон өгөгдлийг цуглуулахад нээлттэй хариулт, нэмэлт тэмдэглэлийг бүртгэхэд хялбар болгох үүднээс цаасан санал асуулгын хуудсыг ашиглан биечлэн ярилцлага хийв (Хавсралт А). Мэдээлэл цуглуулах явцад баг бүр мэдээллийн чанарыг хянах удирдагчтай байсан. Гурван аймагт ажиллаж буй баг, ахлах ажилтнуудтай мэдээлэл цуглуулах ажлын явцын талаар ярилцах, асуудлыг тухай бүрт нь шийдвэрлэх цахим уулзалтуудыг өдөр бүрийн төгсгөлд зохион байгуулж байсан. Орон нутагт судалгааны мэдээлэл цуглуулж дууссаны дараа өгөгдлийг оруулж, цэвэрлээд судалгааны CsPro программаас SPSS программ руу хөрвүүлж, үр дүнг нь дүн шинжилгээ хийх, нягталж үзэхэд нь зориулж төслийн экспертүүдэд хүргүүлсэн (Зураг 1-3).

Судалгааны асуулгын бүтцийн дагуу мэдээллийг кодчилсон болно. Нээлттэй асуултуудын хувьд кодлохоос өмнө нэмэлт алхамууд хийгдсэн. Тухайлбал, хариултыг нь мэдээлэл цуглуулах баг хянан үзэж, хувь хүн бүрийн мэдэгдэл болгон боловсруулсан. Дараа нь эдгээр хувь хүний хариултуудын ижил төстэй байдлыг судалж, багцлан ангилж дүн шинжилгээ хийсэн бөгөөд өвөрмөц хариултуудыг “бусад” гэсэн ангилалд оруулсан.



Зураг 1-3. Мэдээллийг удирдах үйл явц

Чанарын мэдээллийг үндэсний болон судалгааны бүс нутгийн хэмжээнд оролцогч талуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагаар дамжуулан цуглуулсан. Үр дүнгийн үнэн зөв байдлыг хангах үүднээс багийн ахлагч, мэргэжилтэн, мэдээлэл цуглуулах ахлах менежерүүд ярилцлага хийсэн. Судалгааны зорилгыг танилцуулж, үндэсний болон орон нутгийн байгууллагын гол төлөөллийг ганцаарчилсан ярилцлагад оролцохыг урьсан албан бичиг бэлтгэсэн. Ярилцлага хийх байгууллагуудтай уулзах цагийг урьдчилан товлож, ярилцлагын үед тэмдэглэл хөтөлж, зөвшөөрсөн тохиолдолд ярилцлагын бичлэг хийж байсан. Мэдээлэл цуглуулах үе шат дууссаны дараа ярилцлага хийсэн хүмүүс бичлэгийг бичиж тэмдэглэх, бичлэг хийхийг зөвшөөрөөгүй тохиолдолд бичсэн гар тэмдэглэлээ хуулж тэмдэглэх, эцсийн ярилцлагын протокол боловсруулах ажлыг хийсэн. Хавсралт В-д оролцогч бүлэг тус бүрт ашигласан ярилцлагын асуултуудын удирдамж, Хавсралт Б-д ганцаарчилсан ярилцлагад орсон байгууллага, бүлгүүдийн жагсаалтыг оруулсан болно.

1.3.4 Мэдээллийн нууцлал

Судалгааны явцад оролцогчдыг илүү нээлттэй байлгах, оролцоог идэвхжүүлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, оруулах, дүн шинжилгээ үйл явцын турш судалгаанд оролцогчдын нэрийг нууцлах, мэдээллийн нууцлалыг хангахад анхаарч тодорхой зарчмуудыг баримталсан. Ярилцлагад оролцогчдын нэрийг нууцлах зорилгоор зорилтот асуултуудыг зөвхөн ганцаарчилсан ярилцлага,

судалгаагаар асуусан болно. Судалгааны бүх мэдээллийг судалгаанд оролцогчийн нэрийг нууцалж, өөрөөр хэлбэл мэдээллийг хэн нэгэн таних боломжгүй байдлаар хувь хүмүүсийн санаа бодол гэж бүртгэсэн. Тиймээс мэдээллийг зөвхөн хүйсээр ангилж бүртгэсэн болно.

1.4 Хүндрэл бэрхшээл, хязгаарлалтууд

Бичил уурхайн үйл ажиллагаа хөдөлгөөнтэй, нүүдлийн байдал, эрх зүйн хувьд тодорхойгүй байгаагаас шалтгаалан олборлолт идэвхтэй явуулж байгаа газрыг олж очих, бичил уурхайчид, ахлагч нараас мэдээлэл авахын тулд араас нь хөөцөлдөх зэрэг хүндрэлтэй асуудлууд гарч байв. 2020 оны хувьд мэдээлэл цуглуулахтай холбоотой хэд хэдэн онцлог бэрхшээлүүд тулгарч байсан.

1.4.1 Мэдээлэл цуглуулахтай холбоотой бэрхшээлүүд

- КОВИД-19-ийн халдвар Монгол Улсад дэгдэж, энэ нь бичил уурхайчдын үйл ажиллагаа, мөн төслийн гүйцэтгэлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн. Цар тахлыг дотооддоо алдахгүйн тулд Засгийн газар 2020 оны 3-р сарын 13-ны өдрөөс эхлэн мөрдөж буй хязгаарлалтаа нэмэгдүүлж, хилээ бүрэн хаах, бүс нутаг, хот хоорондын зорчих хөдөлгөөнийг хориглох шийдвэр гаргасан. Энэхүү дотоодын зорчих хөдөлгөөний хязгаарлалт нь 5-р сарын 1-ээс 9-р сарын 15-ны хооронд аажмаар тавигдсан. Үүссэн нөхцөл байдал мэдээлэл цуглуулах, ярилцлага хийх хуваарь, хугацаанд нөлөөлж улмаар судалгааны ажлын гүйцэтгэл, төслийн төлөвлөлт хойшлогдоход хүрсэн.
- КОВИД-19-тэй холбоотойгоор орон нутгаас мэдээлэл цуглуулах ажлыг 6-р сарын 15-наас 7-р сарын 2-ны хооронд хийхээр төлөвлөсөн байсан. Энэ нь 6-р сарын 23-нд зохион байгуулахаар төлөвлөсөн УИХ-ын сонгууль, 7-р сард болох Үндэсний их баяр наадмын өмнөхөн байв. Сонгуулийн өмнөх үе байсан учраас төрийн төв болон орон нутгийн төр захиргааны байгууллагууд орон нутгийн үйл ажиллагаанд хэт анхаарал хандуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээний хүрээнд байгаль орчны байцаагч, экологийн цагдаагийн албан хаагчдын хяналт шалгалт явагдсан. Ихэнх уурхайн талбайд олборлолт зогсож, ажиллахгүй болсон байв. Түүнчлэн уурхайчдыг бүртгэлтэй сумандаа очиж сонгуульд саналаа өгөхийг шаардсан тул зөвшөөрөлтэй уурхайчид, нөхөрлөлийн ахлагч нарыг олоход бэрхшээлтэй байв.
- Фокус бүлгийн ярилцлагуудыг жендэр гэх мэт тодорхой сэдвээр зохион байгуулахаар төлөвлөсөн байсан боловч КОВИД-19-ийн улмаас Засгийн газраас орон даяар бүх арга хэмжээ, цугларалтыг хориглосон тул зохион байгуулах боломжгүй болсон.

1.4.2 Түүврийн стратеги ба нөлөөлөх хүчин зүйлүүд

- Сэлэнгэ аймагт орон нутгийн экологийн цагдаагийн албан хаагчид үзлэг, шалгалт явуулж байсантай холбоотойгоор уурхайн олборлолт зогссон байв. Нутгийн иргэд, бичил уурхайчид ял шийтгэлээс болгоомжлон мэдээлэл өгөх хүсэлгүй байв. Засгийн газрын 2019 оны 355 дугаар тогтоолтой (3-р бүлэг) холбогдуулан 2020 онд газрын зөвшөөрөл олгоогүйн улмаас хууль ёсны

нөхөрлөлүүд тарах, орлого олох өөр хувилбар, арга зам хайх нөхцөлд орсон байсан.

- Говь-Алтай аймагт ашигт малтмалын ордын олборлох боломжтой нөөц буурч байгаатай холбоотойгоор олборлолтын хэмжээ буурч, идэвхтэй уурхайчдын байршлыг тогтооход бэрхшээлтэй байлаа. Энэхүү нөхцөл байдал нь сонгууль болон хяналт шалгалт нэмэгдсэний улмаас илүү төвөгтэй болсон байв.
- Ярилцлагыг уурхайн талбай дээр бус, сум, багийн төвд явуулсан. Иймд оролцогчдын өгсөн олборлолттой холбоотой тодорхой мэдээллийг газар дээр нь шалгаж чадаагүй болно. Мөн олон уурхайчид хаана олборлолт хийж байгаагаа тодорхой хэлэхийг хүсэхгүй байсан.
- Судалгаанд оролцогчид хуулийн хариуцлага хүлээхээс эмээж өөрсдийгөө өөр суманд голчлон олборлолт явуулдаг гэдгээ илчлэхгүй байх магадлалтай байсан. Тиймээс судалгааны таван бүс нутгийн аль нэгэнд харьяалалттай уурхайчид тогтоосон талбайгаас гадна хүдэр олборлох өөр эх үүсвэртэй байж болзошгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

1.4.3 Хоёрдогч мэдээллийн хүртээмжтэй байдал

- Хэдийгээр судалгааны бүс нутгийн хүн ам зүйн зарим хоёрдогч мэдээллийг хүйсээр ангилж болох боловч эдгээр сумдын орлого, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, боловсролын талаарх хүйсээр ангилсан мэдээлэл хязгаарлагдмал байлаа. Сумын түвшинд уг мэдээллийг хүйсээр нь ангилдаггүй бөгөөд ийм мэдээллийн сан байхгүй байна.
- Монгол Улсад уул уурхайн томоохон орд газруудын талаарх мэдээлэл нээлттэй олддог ч олон нийтэд хүртээмжтэй геологи, хайгуулын талаарх мэдээлэл хомс байдаг байна. Хууль тогтоомжийн дагуу бичил уурхайчид үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд олборлолт явуулах ёстой. Гэвч тухайн сум, бүс нутагт бичил уурхайгаар олборлох боломжит нөөцтэй газруудын тодорхой байршил, холбогдох зураглал байдаггүйгээс бичил уурхайчид мэдээлэлгүй байдаг. Төслийн хувьд газарзүйн мэдээллийн нэгдсэн эх үүсвэр байхгүй байгаа нь албан ёсоор бүртгэгдээгүй бичил уурхайн талбайн байршил, боломжит нөөцийг тогтооход бэрхшээлтэй болгож байгаа юм.
- Түнхэл тосгон нь Мандал сумын 5-р баг юм. Мандал сумын түвшинд ихэнх хоёрдогч мэдээллийг нэгдсэн байдлаар авах боломжтой. Тиймээс зөвхөн уг тосгоны мэдээллийг хоёрдогч эх үүсвэрээс олж авах нь бэрхшээлтэй байсан.

1.4.4 Мэдээллийн зөрүү

- Зарим уурхайчид гэмт хэрэгт холбогдсон эсвэл урьд нь баривчлагдаж байсан гэж мэдэгдсэн. Тиймээс зарим уурхайчид буруутгагдаж болзошгүй гэж үзсэн мэдээлэл өгөхдөө эргэлзэж байсан юм. Энэ нь түүвэрлэлтийн чанарт нөлөөлж судалгааны үр дүнг гажуудуулахад хүргэж болох бөгөөд ялангуяа энэ нь эрх зүйн байдал, мөнгөн усны хэрэглээтэй холбоотой мэдээлэлд хамаатай байв.
- Ховд аймагт саяхнаас бичил уурхайтай холбоотой хэрэг зөрчил илрүүлэх, хууль сахиулах ажиллагаа эрчимжиж зарим уурхайчид баривчлагдаж,

тэнсэн суллагдсан гэсэн мэдээлэл авсан байсан. Уурхайчид ерөнхийдөө алт баяжуулахтай холбоотой асуултанд хариулахдаа маш их болгоомжилж байв. Түүнчлэн газрын зөвшөөрөл олгох үйл явц тодорхойгүй хугацаагаар хойшлогдож, зөвшөөрөл олгохгүй байгаагаас зарим уурхайчид албан бусаар ажиллаж байсан.

- Одоогийн байдлаар уурхайчдыг хууль бус алт олборлогчид (нинжа гэж нэрлэдэг) ба бичил уурхайчид (ТББ, нөхөрлөл, хоршоо) гэсэн хоёр ангилалд хувааж байна. Бид бичил уурхайн албажуулалт, зохион байгуулалтын талаарх (албан, албан бус, хууль бус) тодорхойлолтуудыг энэхүү судалгаанд ашиглах зорилгоор анх удаа боловсруулсан болно. Гэсэн хэдий ч судалгааны явцад уурхайчид хууль бус статусаа илчлэхээс зайлсхийж, өөрсдийгөө албан бус гэх ангилалд оруулж байсан. Тиймээс өөрсдийгөө албан болон албан бус гэж тодорхойлсон уурхайчид нь хууль бусаар ашигт малтмал олборлогчид байж болзошгүй юм.
- Бичил уурхай эрхлэгчдийн уул уурхайн туршлага, хууль эрх зүйг дагаж мөрдөх, хүдэр, алтны үйлдвэрлэлийн мэдээлэл гэх мэт тодорхой сэдвүүдийн талаарх мэдлэг харилцан адилгүй байв. Судалгааны асуулгыг туршилтын судалгаагаар туршиж үзэхэд уурхайчид тухайн асуултын хариултыг мэдэхгүйгээр нийгмийн зөрүүтэй ойлголт хандлагад үндэслэн хариулт өгсөн байхыг үгүйсгэх аргагүй. Судалгааны асуултуудын хязгаарлалтууд
- Судалгаанд гар аргаар алт олборлох үйл ажиллагаан дахь хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг хөндөөгүй ба оролцогчдын хүүхдүүдийн тоо, олборлолтын талбайд хүүхдүүд байгаа эсэхийг авч үзээгүй. Гэхдээ planetGOLD Монгол төслийн баг судалгааны үед хэд хэдэн газар дээр очиж танилцах үеэр хүүхдийн хөдөлмөр ажиглагдаагүй. Жендэрийн гүнзгийрүүлсэн судалгаанд оролцсон Алтай сумын нэг оролцогч хүүхдийн хөдөлмөрийг тулгамдсан асуудал гэж дурдсан. Бусад судалгааны тайлангуудаас харахад хүүхдийн хөдөлмөр эрхлэлт нь Монгол Улсын албан бус бичил уурхайд асуудал дагуулсан хэвээр байна (Азийн сан, 2013 он). ОУХБ-ын 2015 оны тооцооллоор албан бус алт олборлогчдын 21% гаруй нь хүүхдүүд байгаа бөгөөд сурагчдын амралтын үеэр тоо нь нэмэгддэг гэжээ. ҮСХ-ны судалгаагаар (ҮСХ, 2017 он) 18-аас доош насны 188 хүүхэд бичил уурхайн салбарт ажиллаж байгаагийн 36 нь алт олборлодог болохыг тогтоожээ. Эдгээр хүүхдүүдийн 61.8% нь сургуулийн амралтын үеэр, 34.2% нь хичээлийн бус цагаар, үлдсэн нь бүтэн жилийн турш ажиллаж байжээ.
- Уурхайчдын шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл их эмзэг байдгаас тул үнэлээгүй. Уурхайчин ажиллаж байгаа аймагтаа бүртгэлтэй байх ёстой, ингэснээр нийгмийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй авах бололцоо бий болно гэдгийг шилжин явагч уурхайчин ойлгож авах нь чухал юм. Гэхдээ зохион байгуулалттай уурхайчдын хувьд уурхайчнаар ажиллаж байгаа тухайн аймагтаа 151 хоногийн дараа бүртгүүлэх шаардлагатай байдаг. Иймд мэдээллийн эмзэг байдал нь зөвхөн хууль бусаар ашигт малтмал олборлож буй иргэдэд хамаатай юм.
- Энэхүү судалгаанд зөвхөн алтны үндсэн ордын олборлолтыг судалж үзсэн бөгөөд үр дүнг алтны шороон ордод хамааруулж үзэх боломжгүй юм. Жишээлбэл, эмэгтэйчүүд шороон ордны уурхайд илүү ихээр ажилладаг хандлагатай байдаг (Азийн сан, 2013 он).
- Энэхүү судалгаа нь судалгааны бүс нутгийн мөнгөн усны хэрэглээний суурь түвшинг тооцоолох зорилготой байв. Энэ зорилгоор судалгааны бүс нутгаас

холбогдох анхдагч мэдээллийг цуглуулсан боловч арга зүйн хэд хэдэн хязгаарлагдмал байдлаас (5-р бүлэгт авч үзсэн) шалтгаалан найдвартай тооцоолол хийх боломжгүй байв.

2. Судалгааны бүс нутгийн нийгэм-эдийн засгийн асуудлууд

Энэ бүлэгт зорилтот аймаг, сумдын нийгэм, эдийн засгийн ерөнхий нөхцөл байдлыг товч танилцуулж, бичил уурхайчдын хүн ам зүй, нийгэм эдийн засгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж тайлбарлан харуулав. Энэхүү мэдээлэлд судалгаанд хамрагдагсдын нас, хүйс, гэрлэлтийн байдал, боловсрол, ажил эрхлэлт, орлогын түвшин, нийгмийн үйлчилгээний хүртээмж болон тэдний амьжиргаанд КОВИД-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийг хамруулсан болно.

2.1 Зорилтот аймаг, сумдын хүн ам, нийгэм-эдийн засгийн байдал

Судалгааны таван бүс нутаг нь Монгол Улсын хойд хэсэгт байрлах Сэлэнгэ аймаг, баруун хэсэгт орших Ховд, Говь-Алтай аймгуудад (Зураг 1-1) байрладаг. Эдгээр аймаг, сумдын хүн амын тоог Хүснэгт 2.1-1-д үзүүлсэн болно. Таван бүс нутгаас Мандал, Есөнбулаг сумд хамгийн олон хүн амтай байгаа бөгөөд хүн амын нягтрал ч хамгийн өндөр байна. Хүйсийн харьцааны хувьд эрэгтэй, эмэгтэй хүн амын хооронд мэдэгдэхүйц ялгаа байхгүй байна.

Хүснэгт 2.1-1. Судалгааны бүс нутгийн нийт хүн ам (хүйсээр) (Эх сурвалж: ҮСХ, 2020 он)

Бүс	Хүн амын тоо	Улсын хэмжээнд эзлэх %	Эмэгтэйчүүд %	Хүн амын % (тухайн аймагт)
Говь-Алтай аймаг	57,479	1.8%	50%	100%
Есөнбулаг сум	18,444	0.6%	51%	32%
Ховд аймаг	88,078	2.8%	50%	100%
Алтай сум	3,318	0.1%	51%	4%
Сэлэнгэ аймаг	107,755	3.4%	49%	100%
Баянгол сум	5,567	0.2%	48%	5%
Мандал сум (Түнхэл тосгон орсон)	2,7011	0.8%	49%	25%
Түнхэл тосгон	3,042	0.1%	48%	3%
Улсын нийт тоо	3,197,020	100%	51%	-

2.1.1 Сэлэнгэ аймаг

Сэлэнгэ аймаг нь Монгол Улсын нутгийн хойд хэсэгт оршдог. Эдийн засгийн үндсэн үйл ажиллагаа нь хөдөө аж ахуй бөгөөд Монгол Улсын үр тарианы үйлдвэрлэлийн 45 орчим хувийг хангадаг. Нийт 1,6 сая гаруй малтай. Хөдөлмөрийн насны хүн ам нь аймгийн нийт хүн амын 65%-ийг бүрдүүлдэг. Харин хөдөлмөрийн насны 55%-ийг бүрдүүлэх эрэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээл дээр илүү идэвхтэй байдаг (ҮСХ, 2020 он). Сэлэнгэ аймаг нь гар аргаар алт олборлодог хамгийн идэвхтэй бүсүүдийн нэг юм. 1997 оноос хойш Баянгол сумын Бороогийн алтны уурхайн ойролцоо хүмүүс алт олборлож эхэлсэн. 2014 оны байдлаар тус аймгийн 13 суманд 197 уул уурхайн компани үйл ажиллагаа явуулж байсан. Мандал, Баянгол сумдын нутаг дэвсгэрт Пурам ХХК, Бороо ХХК зэрэг томоохон уул уурхайн хэд хэдэн компани үйл ажиллагаа явуулдаг.

Сэлэнгэ аймгийн Баянгол сум: Баянгол сум нь Улаанбаатар хотоос 156 км, Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатараас 170 км зайд хойд аймгийн нутгийг урд талтай

холбосон төв хурдны зам, төмөр замын дагуу оршдог. 2019 оны байдлаар сумын нийт хүн амын 61 хувь нь хөдөлмөрийн насны хүмүүс байв. Сумын эдийн засаг нь мал аж ахуй, газар тариаланд суурилсан. Сэлэнгэ аймгийн хамгийн олон малтай сумдын нэг бөгөөд улсын ноосны үйлдвэрлэлийн 10 орчим хувийг хангаж байна (САСХ 2020 он). Баянгол сум бол Монгол Улсад гар аргаар алт олборлож эхэлсэн бүс нутгуудын нэг юм. 1997 оноос хойш Баянгол суманд Канадын хөрөнгө оруулалттай Бороогийн алтны уурхайн ойролцоо бичил уурхайчид алт олборлож байна. Тус суманд томоохон хэмжээний уул уурхайн 65 лиценз олгосноос 2020 оны байдлаар 40% нь ашиглалтын лизенц байгаа бөгөөд (Ганцаарчилсан ярилцлага ¹⁷, 2020 он) эдгээрээс 5 компани идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Нэг өрхөөс дор хаяж нэг хүн алтны бичил уурхайд идэвхтэй оролцдог бөгөөд орон нутгийн иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр нь болсон гэж сумын Засаг даргын тамгын газар мэдээлсэн.

Сэлэнгэ аймгийн Мандал сум: Мандал сумын төв нь Сүхбаатараас 220 км зайд, Улаанбаатар хотоос 174 км зайд байрладаг. Мандал сум нь 2019 оны байдлаар 27,011 хүн амтай гэж бүртгэгдсэн, Монгол Улсын хамгийн том сум юм. Тухайн жилд хөдөлмөрийн насны хүн ам 16,717 хүн байсан нь нийт хөдөлмөрийн насны хүн амын 62% -ийг эзэлж байна. Тус сум нь нийт 484,373 га газартай бөгөөд дийлэнх газарт хөдөө аж ахуй, газар тариалан эрхэлдэг. Аймгийн нийт хүнсний ногоо үйлдвэрлэлийн 21%-ийг хангадаг (САСХ, 2020 он). Алтны бичил уурхай нь орон нутгийн иргэдийн амьжиргааны гол эх үүсвэрийн нэг болсон бөгөөд сумын ЗДТГ (Ганцаарчилсан ярилцлага, 2020 он)-аас тус салбарыг дэмжиж, зохион байгуулах чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа талаар мэдэгдсэн. Тус суманд уул уурхайн ашиглалтын нэг лиценз, 1,000 орчим гар аргаар алт олборлогчид байдаг гэж Засаг даргын Тамгын газраас мэдээлсэн.



Зураг 2-1. Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгон (planetGOLD)

Мандал сумын Түнхэл тосгон: Түнхэл тосгон нь Улаанбаатар хотоос хойд зүгт 150 км, сумын төвөөс 40 км зайд орших Мандал сумын засаг захиргааны нэгж юм. Тосгон нь хөдөлмөрийн насны 1,400 хүн амтай бөгөөд үүнээс 250 хүн байнгын ажлын байртай бөгөөд 650 орчим нь ажилгүй байна. Тосгоны олон оршин суугчид эдийн засгийн хүндрэлтэй цаг үед олборлолт хийж эхэлсэн. Энд уламжлалт мал аж ахуй, хөдөө аж ахуйгаас гадна гол ажил олгогчид нь тосгоны мод бэлтгэдэг аж ахуйн нэгжүүд байдаг. Мод бэлтгэдэг аж ахуйн нэгжүүд жилд хоёр удаа улирлын чанартай ажил санал болгодог бөгөөд ойролцоогоор 300-400 хүнийг авч ажиллуулдаг байна. Түнхэлд үндсэн ордын алт олборлох үйл ажиллагаа нь албан бус

¹⁷ Ганцаарчилсан ярилцлагад оролцогчдоос авсан шууд ба шууд бус бүх ишлэлүүдийг тайланд тусгахдаа нэрийг нь нууцалсан бөгөөд судалгаанд оролцогчдын нэрийг нууцлахыг баталгаажуулсан болно. Хүйс, ажил үүрэг/албан тушаал, байршил (сум/аймаг) зэрэг мэдээллийг оролцогчийн нэрийг нууцалж болох хэмжээнд оруулсан.

байдлаар “Булаг” нэртэй олборлолтын талбайд 2007 оноос эхэлсэн. Тус газарт саяхан албан ёсоор алтны бичил уурхай эрхлэхийг хүлээн зөвшөөрсөн байна.

2.1.2 Говь-Алтай аймаг

Говь-Алтай аймаг улсын баруун өмнөд хэсэгт байрладаг 141,400 хавтгай дөрвөлжин км газар нутагтай, Монгол Улсын хоёр дахь том аймаг юм. 2019 онд нийт хүн амын 27,151 нь буюу 47% нь эдийн засгийн идэвхитэй насны иргэд байсан. Аймаг нь 3.5 сая гаруй малтай бөгөөд мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл аймгийн ДНБ-ий 44% -ийг бүрдүүлдэг (УБЕГ, 2020 он).

Аймгийн хэмжээнд төрөл бүрийн ашигт малтмалын шороон болон үндсэн ордод үйл ажиллагаа явуулах хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл 145 компанид олгогдсон байдаг. Одоогийн байдлаар Бигэр, Тонхил, Есөнбулаг сумдад байршилтай шороон ордын алт олборлох хоёр компанийг нийлүүлээд таван компани үйл ажиллагаагаа явуулж байна (Нямбаяр, 2019). Бигэр сум дахь Алтайн Хүдэр ХХК-ийн төмрийн хүдрийн уурхай нь нэлээд том уурхай бөгөөд 600 орчим хүн ажилладаг. Үүний 200 нь орон нутгийн иргэд байдаг (ГААСХ, 2020 он)

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум:

Есөнбулаг сум нь аймгийн төвийн сум бөгөөд Улаанбаатар хотоос 1001 км зайтай, ихэвчлэн засмал замтай. Тус сум нь нийт 18,456 оршин суугчтай бөгөөд энэ нь аймгийн нийт хүн амын гуравны нэгийг бүрдүүлж байна. Аймгийн нийт аж ахуйн нэгж байгууллагуудын 50 гаруй хувь буюу ихэнх бизнес, үйлчилгээний төвүүд тус суманд байрладаг (ГААСХ, 2020 он). Есөнбулаг суманд бичил уурхай эрхлэх зөвшөөрөлтэй газар байхгүй ч



Зураг 2-2. Говь-Алтай аймгийн Алтай сумын Замын ам уурхайн талбай (planetGOLD)

хүдэр баяжуулах хоёр цех байдаг. Говь-Алтай аймгийн Алтай суманд ("Алтай, Г.А." гэх) зөвхөн "Замын ам" гэдэг газарт алтны үндсэн ордод бичил уурхайчид хүдэр олборлох үйл ажиллагаа явуулж байна. "Замын ам" (5.7 га талбай) талбай нь сумын төвөөс 60 км зайд байрладаг бөгөөд 2017 оноос 2019 оны 3-р сар хүртэл уг талбайд олборлолт явуулж байсан боловч Засгийн газрын 355-р тогтоол (2-р бүлгийг үзнэ үү), мөн геологийн нөхцөл хүндэрснээс шалтгаалж нэмэлт дэд бүтэц шаардлагатай болсон тул зогссон (ГААСХ, 2020 он).

2.1.3 Ховд аймаг

Ховд аймаг нь Улаанбаатар хотоос баруун тийш 1,580 км зайд оршдог бөгөөд 17 гаруй үндэстэн, ястан амьдардгаараа онцлог юм. Сумдын орон нутгийн эдийн засаг нь хөдөө аж ахуй, ялангуяа хүнсний ногооны аж ахуй, мал аж ахуйгаас ихээхэн хамааралтай байдаг. Нийт 22,513 өрхийн 89,712 оршин суугч амьдардаг. Хөдөлмөрийн насны хүн ам нь аймгийн нийт хүн амын 44%-ийг бүрдүүлдэг (ХАСХ, 2020).

Орон нутгийн засаг захиргааны мэдээлснээр аймгийн хэмжээнд 560 орчим бичил уурхайчид байгаагаас 23% нь БУ-н байгууллагын зохион байгуулалтад орсон бол 2017 оны байдлаар 78% нь албан бусаар уурхай эрхэлж байна. Орон нутгийн иргэдийн амьжиргаанд чухал хувь нэмэр оруулах боломжтой тул бичил уурхайн байгууллагуудыг албажуулахыг дэмжиж байгаа гэдгээ илэрхийлсэн (Ганцаарчилсан ярилцлага, 2020).

Ховд аймгийн Алтай сум: Алтай суманд дэд бүтцийн сайжруулалт хийгдэж шинээр байгуулагдсан 300 км урттай хатуу хучилттай авто зам сумыг аймгийн төвтэй холбосон байна. Алтай сум өндөрлөг газарт оршдог тул бусад сумдыг бодвол өргөн цар хүрээтэй газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй. Иймд зөвхөн мал аж ахуй эрхлэх боломжтой бөгөөд бичил уурхай нь орлогын хоёрдогч эх үүсвэр болдог. Тус сум 3,318 оршин суугчтай бөгөөд үүний 66% нь хөдөлмөрийн насны хүмүүс байдаг (ХАСХ, 2020 он). Бичил уурхай нь иргэдийг ажилтай, орлоготой болгодог тул сумын удирдлага уурхайчдыг дэмжиж, зохион байгуулалтад оруулж албан ёсны болгохыг хичээдэг. Түүнчлэн тэднээс орлогын татвар төлөхийг шаарддаг. Ховд аймгийн БУ-н холбооноос мэдээлснээр орон нутгийн уурхайчид 2017 оноос хойш албан ёсны бичил уурхайн байгууллагын зохион байгуулалтад орж, 80 гишүүнтэй арван нөхөрлөл байгуулжээ. 2019 оны 9-р сард эдгээр нөхөрлөлийн хоёр нь 'Майхан-1' ба 'Майхан-2' нэртэй 2 байршилд газрын зөвшөөрөл авсан (Ганцаарчилсан ярилцлага, 2020 он).



Зураг 2-3. Ховд аймгийн Алтай сумын Майхан уурхайн талбай (planetGOLD)


Судалгааны таван бүс нутгийн олборлолт, баяжуулах дэд бүтцийг харьцуулж үзэхэд Мандал сум болон Түнхэл тосгонд баяжуулах цех болон бичил уурхай эрхлэх талбай байдаг бол Есөнбулаг суманд Говь-Алтай аймгийн Алтай сум болон бусад хөрш зэргэлдээ аймгуудаас ирсэн хүдрийг баяжуулах зориулалтын баяжуулах цехүүд байна. Баянгол суманд ямар ч баяжуулах цех байдаггүй. Гэхдээ гар аргаар алтны үндсэн ордын хүдэр олборлолт явагддаг газруудад хууль

бусаар тээрэм ажиллуулдаг бөгөөд тус суманд болон бусад аймгийн нутаг дэвсгэрт хууль бусаар олборлосон хүдрийг баяжуулдаг байна. Ховд аймгийн Алтай сум нь бичил уурхайн талбайн дүгнэлт гарсан газартай боловч энэ бүс нутагт баяжуулах цех байхгүй байна.

2.2 Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтүүд

Судалгаанд хамрагдсан нийт 371 уурхайчдын 73% (n=271)-ийг эрэгтэйчүүд, 27% (n=100)-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд энэ нь бичил уурхайн салбарын нийт ажиллах хүчний 25-30%-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаатай ойролцоо түвшинд байна. Зураг 2-Ү-ээс харахад уурхайчдын дийлэнх нь 30-55 насны бүлэгт багтаж байна. Хүйсийн хувьд авч үзэхэд тухайн судалгаанд оролцсон болон

салбарын хэмжээнд эмэгтэйчүүдийн тоо ерөнхийдөө цөөн байдагтай холбоотойгоор насны бүлэг бүр дэх эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн хуваарилалт харьцангуй тэгш байна. Нас, хүйсийн суваргаас харахад 18-29 насны эрэгтэйчүүдийн тоо өндөр байгаа бөгөөд энэ нь гэрлээгүй уурхайчин эрчүүдийн тоо харьцангуй их байгаатай холбоотой байж болох юм. Нөгөөтэйгүүр, 54-өөс дээш насны бүлэгт эмэгтэйчүүд харьцангуй олон байна.




Зураг 2-4. Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн байдал (n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)

Судалгаанд хамрагдагсдын дийлэнх (80%) нь гэрлэсэн, харин 14% нь ганц бие байна (Хүснэгт 2.2-1). Алтайд гэр бүлтэй уурхайчдын хувь (89%) хамгийн өндөр, дараа нь Түнхэл (86%) болон Есөнбулаг (86%) сумд орж байна. Харин эсрэгээрээ Мандалд ганц бие уурхайчдын эзлэх хувь хамгийн өндөр буюу 21%, Алтайд хамгийн бага буюу 8% байгаа бөгөөд бэлэвсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь бусад сумдтай харьцуулахад 3%-иар их байна. Гэр бүлтэй эрэгтэйчүүд (78%-тэй харьцуулахад энэ салбарт ажиллаж байгаа гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувь (87%) арай илүү байв. Энэ нь эмэгтэйчүүд нөхөр эсвэл гэр бүлийн бусад гишүүдтэйгээ хамт энэ салбарт ордог хандлагатай холбоотой байж болох юм.

Хүснэгт 2.2-1. Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдал (судалгааны бүс нутгаар, хүйсээр)

	Бүс					Нийт		
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)	Нийт (n=371)
Огт гэрлээгүй	15%	21%	10%	11%	8%	7%	16%	14%
Гэрлэсэн	77%	71%	86%	82%	89%	87%	78%	80%
Хамтран амьдардаг	4%	6%	3%	3%	0%	2%	4%	4%
Тусдаа амьдардаг	2%	0%	1%	0%	0%	0%	1%	1%
Цуцалсан	0%	0%	0%	2%	0%	1%	0%	0%
Бэлэвсэн	2%	2%	0%	2%	3%	3%	1%	2%

Дэлхийн Банкны хамгийн сүүлийн судалгаагаар (2018 он) Монгол Улсад төрөлтийн түвшин 2.9 байгаа бөгөөд ам бүлийн тоо өсөх хандлагатай байгааг харуулсан. Энэ судалгаанд оролцогчдын 72%-нь 4-7 ам бүлтэй (Зураг 2-2) байна. Мандалд цөөн ам бүлтэй өрхийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 33% нь 2-3 ам бүлтэй байсан бол Алтайд олон ам бүлтэй (6-7) өрхийн эзлэх хувь 24% байв.



Зураг 2-5. Судалгаанд оролцогчдын ам бүлийн тоо (n=371)

2.3 Судалгаанд оролцогчдын нийгэм-эдийн засгийн байдал

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох нь хөдөө орон нутгийн ядуу иргэдэд, ялангуяа гэр бүлээ санхүүгийн хувьд дэмжих өөр сонголтгүй хүмүүст орлогын томоохон эх үүсвэр болж байгааг энэхүү судалгаа харуулж байна. Бичил уурхайгаас орон нутгийн иргэд шаардлагатай орлого олохоос гадна энэ үйл ажиллагааг дагаж бий болсон үйлчилгээний бизнес нь ажлын байр нэмэгдүүлж, орлого олох боломжийг бий болгосноор орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг байна. Бичил уурхайгаар алт олборлогчдын онцлог шинж чанарыг тодорхойлохын тулд тэдний нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг ойлгох нь чухал юм. Энэ хэсэгт судалгаанд хамрагдагсдын боловсролын түвшин, сууцны төрөл, орлого, ажил эрхлэлтийн эх үүсвэрийн талаарх тоймыг танилцуулах болно.

2.3.1 Боловсрол

Судалгаанд хамрагдсан уурхайчдын дийлэнх нь (78%) хамгийн багадаа бүрэн дунд боловсрол эзэмшсэн, 12% нь бакалаврын зэрэгтэй байсан бол 4% нь зөвхөн бага боловсролтой буюу огт боловсролгүй хүмүүс байна. Бүс нутгаар авч үзвэл, дээд боловсролтой уурхайчдын эзлэх хувь Алтай (19%), Мандал (12%) сумдад хамгийн өндөр байна. Түнхэлд боловсрол эзэмшээгүй болон бага, бүрэн бус дунд боловсрол эзэмшсэн уурхайчдын эзлэх хувь хамгийн өндөр буюу 35%-тай байсан бол бусад бүс нутагт 11-25%-тай байсан. Жендэрийн хувьд эрэгтэйчүүдтэй (78%) харьцуулахад илүү олон эмэгтэйчүүд (88%) хамгийн багадаа л гэхэд бүрэн дунд сургууль төгссөн байна (Бүлэг 6.1-ийг үзнэ үү).

Хүснэгт 2.3-1. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин (судалгааны бүс нутаг, хүйсээр)

	Бүс					Нийт		
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)	Нийт (n=371)
Боловсрол эзэмшээгүй	2%	2%	4%	2%	1%	0%	3%	2%
Бага болон суурь (1-4 анги)	0%	4%	1%	3%	1%	2%	3%	2%
Бүрэн бус дунд (5-9 анги)	17%	16%	30%	19%	9%	10%	21%	18%
Бүрэн дунд (10-12)	65%	61%	52%	63%	68%	67%	59%	62%
Техник болон мэргэжлийн коллеж	6%	5%	4%	5%	1%	6%	4%	4%
Дээд боловсрол (бакалавр)	10%	12%	8%	8%	19%	15%	10%	12%

Орон сууц

Улсын хэмжээнд нийт хүн амын амьдарч буй сууцны төрөлд ажиглагдаж буй ерөнхий хэв шинжтэй төстэй бүтэц энэ судалгаанд харагдаж байна. Уурхайчдын талаас илүү хувь нь амины сууцанд, 39% нь гэрт, 6 орчим хувь нь орон сууцанд, 1 хувь нь дотуур байранд амьдарч байна. Байршлаар авч үзвэл, амины орон сууцанд амьдардаг уурхайчдын тоо Мандал (71%) болон Түнхэлд (85%) илүү, Есөнбулаг (16%) болон Алтайд (21%) цөөн байна. Харин хөдөө орон нутгийн иргэд түгээмэл амьдардаг уламжлалт сууц буюу монгол гэрт¹⁸ Есөнбулагийн уурхайчдын 81%, Алтайн уурхайчдын 69% нь амьдарч байв.



Зураг 2-4. Монгол гэр (planetGOLD Монгол)

Хүснэгт 2.3-2. Судалгаанд оролцогчдын сууцны төрөл (судалгааны бүс нутаг, хүйсээр)

	Бүс					Нийт		
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)	Нийт (n=371)
Монгол гэр	25%	19%	11%	81%	69%	38%	39%	39%
Амины орон сууц	67%	71%	85%	16%	28%	55%	55%	55%
Дотуур байр	0%	2%	0%	0%	0%	1%	0%	1%
Орон сууц	8%	9%	4%	3%	3%	6%	6%	6%

planetGOLD Монгол төслийн багийн судалгааны мэдээлэл цуглуулах үеэр хийсэн ажиглалтаар бичил уурхайн талбайнууд байрлах сууршлын бүсэд ихэвчлэн зөөврийн сууц болох уламжлалт гэрт уурхайчид ээлжээр ажиллах хугацаандаа амьдардаг байна. Нийт судалгаанд оролцогчдын 44 орчим хувь нь ээлжээр ажилладаг гэж хариулсан байна (Бүлэг 4.1-ийг үзнэ үү).

Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Судалгаанд оролцсон нийт уурхайчдын 50 хувь нь бичил уурхайг тэдний үндсэн ажил гэж мэдэгдсэн (Хүснэгт 2.3-3) бөгөөд тэдний 123 (нийт оролцогчдын 33%) нь бичил уурхайгаас өөр ямар нэгэн орлогын эх үүсвэргүй байна. Үндсэн болон хоёрдогч ажил эрхлэлтийн байдлыг тодорхойлохдоо орлогын үндсэн эх үүсвэрээс гадна өөр бусад хүчин зүйлс (жишээлбэл, албан ёсны гэрээт ажил)-тэй холбож асуусан бөгөөд нийт уурхайчдын зөвхөн 33 хувь нь бичил уурхайг цорын ганц орлогын эх үүсвэр гэж мэдэгдсэн ч бүс нутгуудын хувьд энэ нь ихээхэн ялгаатай байна. Тухайлбал, Алтайн уурхайчдын 9% нь зөвхөн бичил уурхайгаас олсон орлогоороо амьдардаг бол Түнхэл, Есөнбулагт энэ тоо харьцангуй өндөр буюу 45%-тай байна.

¹⁸ Эсгийгээр давхарласан, тойрог хэлбэрийн нүүж явахад тохирсон уламжлалт сууц бөгөөд хөдөө орон нутгийн иргэдийн амьдардаг сууцны түгээмэл хэлбэр юм.

Хүснэгт 2.3-3. Судалгаанд оролцогчдын орлогын эх үүсвэрт бичил уурхайн эзлэх хувь (судалгааны бүс нутаг, хүйсээр)

	Бүс					Нийт		
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)	Нийт (n=371)
Үндсэн орлогын эх үүсвэр	31%	66%	70%	60%	14%	49%	51%	50%
Цорын ганц орлогын эх үүсвэр	17%	41%	46%	45%	9%	36%	32%	33%
Хоёрдогч эх үүсвэр	69%	34%	30%	40%	86%	51%	49%	50%

2.3.2 Үндсэн хөдөлмөр эрхлэлт

Судалгаанд оролцогчдын 50% буюу 184 нь бичил уурхайг үндсэн ажлынхаа зэрэгцээ эрхэлдэг буюу тэдний хоёрдогч хөдөлмөр эрхлэлт гэж хариулсан бөгөөд эдгээр хүмүүсийн 15% нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 13% нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг, 7% нь малчид байна. Мандал, Есөнбулаг, Түнхэлийн бичил уурхайчдын 55% гаруй нь бичил уурхайгаар алт олборлох нь тэдний үндсэн хөдөлмөр эрхлэлт гэж мэдэгдсэн бол Баянголын бичил уурхайчдын 31%, Алтайн 14% нь алтны бичил уурхайг тэдний үндсэн ажил гэж хариулсан нь судалгаанд оролцогчдын хамгийн бага хувийг эзэлж байна. Алтайн судалгаанд оролцогчдын үндсэн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл 24% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 23% нь мал аж ахуйд ажилладаг, харин 14% нь төрийн байгууллагад ажилладаг байна.

Хүснэгт 2.3-4. Судалгаанд оролцогчдын үндсэн хөдөлмөр эрхлэлт (судалгааны бүс нутаг, хүйсээр)

	Бүс					Нийт		
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Есөнбулаг (n=6162)	Алтай (n=74)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)	Нийт (n=371)
Алтны бичил уурхай	31%	66%	70%	60%	14%	49%	51%	50%
Төрийн байгууллага	0%	3%	0%	6%	14%	5%	4%	5%
Хувийн хэвшил	10%	1%	3%	10%	5%	6%	4%	5%
ТББ	2%	6%	1%	3%	0%	3%	3%	3%
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	17%	13%	10%	11%	24%	13%	15%	15%
Газар тариаланч	12%	4%	0%	2%	3%	5%	3%	4%
Малчин	6%	1%	6%	2%	23%	1%	9%	7%
Оюутан	4%	1%	1%	0%	0%	0%	1%	1%
Тэтгэвэрт	6%	3%	4%	2%	3%	10%	1%	3%
Ажилгүй	13%	3%	4%	5%	15%	7%	7%	7%
Хөгжлийн бэрхшээлтэй (тэтгэмж авдаг)	0%	1%	0%	0%	0%	1%	0%	0%

Жендэрийн хувьд авч үзэхэд бичил уурхайг тэдний үндсэн хөдөлмөр эрхлэлт гэж хариулсан эрэгтэйчүүд (51%) ба эмэгтэйчүүдийн (49%) хооронд маш бага ялгаа байна. Харин үндсэн ажлынхаа зэрэгцээ бичил уурхайн үйл ажиллагаа давхар эрхэлдэг хүмүүсийн дунд хувийн хэвшилд ажилладаг, газар тариалан эрхэлдэг эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдээс 2 пунктээр илүү байгаа бол хувиараа хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүдийн хувь 2 пунктээр илүү байна. Мөн бичил уурхайд давхар хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн 10%, харин эрэгтэйчүүдийн 1% нь тэтгэврийг тэдний үндсэн орлого гэж үзсэн бол эрчүүдийн 9%, эмэгтэйчүүдийн 1% нь мал аж ахуй нь тэдний үндсэн орлого гэж нэрлэж байлаа.

2.3.3 Уурхайчдын орлогын хоёрдогч эх үүсвэр

Бичил уурхай нь орлогын үндсэн эх үүсвэр болдог гэж хариулсан (n=187, 50%) уурхайчдын 66% буюу нийт судалгаанд оролцогчдын 33% нь алтны бичил уурхайгаас өөр орлогын ямар нэгэн эх үүсвэргүй байна. Судалгаанд хамрагдсан уурхайчдын хоёрдогч орлогын эх үүсвэрийн дийлэнхийг хувиараа хөдөлмөр эрхлэлт (14%) ба газар тариалан, мал аж ахуй (15%)-н орлого эзэлж байв. Эмэгтэйчүүдтэй харьцуулахад (63%) илүү олон эрэгтэйчүүд (73%) орлогын хоёрдогч эх үүсвэртэй байна. Хоёрдогч орлогын эх үүсвэргүй бичил уурхайчдын тоо Есөнбулагт (76%) өндөр байна (Хүснэгт 2.3-3).

Хүснэгт 2.3-5. Бичил уурхайгаас үндсэн орлого олдог уурхайчдын хоёрдогч хөдөлмөр эрхлэлт (судалгааны бүс нутаг, хүйсээр)

	Бүс					Нийт		
	Баянгол (n=16)	Мандал (n=74)	Түнхэл (n=50)	Есөнбулаг (n=37)	Алтай (n=10)	Эмэгтэй (n=49)	Эрэгтэй (n=138)	Нийт (n=187)
Хоёрдогч орлогын эх үүсвэр байхгүй	56%	62%	66%	76%	70%	73%	63%	66%
Төрийн байгууллага	0%	3%	0%	0%	10%	2%	1%	2%
ТББ	0%	1%	2%	0%	0%	2%	1%	1%
Хувиараа хөдөлмөр эрхлэлт	6%	14%	14%	19%	10%	6%	17%	14%
Газар тариаланч	13%	16%	10%	0%	10%	10%	11%	11%
Малчин	13%	3%	4%	3%	0%	4%	4%	4%
Тэтгэвэрт	13%	1%	4%	3%	0%	2%	4%	3%

Хоёрдогч орлогын эх үүсвэрийн дийлэнхэд хувийн бизнес (12%), мал аж ахуй (9%), хөдөө аж ахуй (7%) орж байна. Бичил уурхайгаас орлогын гол эх үүсвэрээ бүрдүүлдэг гэж хариулсан хүмүүсийн эзлэх хувь Түнхэл (87%), Мандал, Есөнбулаг (хоёуланд нь 79%) сумдад хамгийн өндөр байв.

Судалгаанд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг бичил уурхайн салбарт татаж, түлхэж байгаа хүчин зүйлийг судалж үзээгүй болно. Орон нутгийн төрийн байгууллагын ажилтнуудын мэдэгдсэнээр уламжлалт орлогын эх үүсвэрээ алдах (жишээлбэл, малаа алдах) болон ажилгүйдэл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг алтны бичил уурхайн салбарт орох гол хөшүүрэг болсон гэж мэдэгдсэн.

Бичил уурхай эрхлэгчдийн талаар ний нуугүй хэлэхэд тэд өөр орлогын эх үүсвэргүй, эсвэл малаа алдсан хүмүүс байдаг, тиймээс тэд бичил уурхай руу явдаг. Эдгээр хүмүүсийг хууль, тогтоомжоор дэмжих хэрэгтэй. Тэдний ажлын байр, орлого олох боломжийг дэмжих үүднээс бичил уурхайн үйл ажиллагааг дэмжихийг хичээж байна. Учир нь эдгээр уурхай тэднийг тэжээдэг. Нөгөөтэйгүүр, эдгээр иргэд нийгмийн даатгал, татвараа төлдөг нь тэдний зүгээс оруулж буй хөрөнгө оруулалтын нэг хэлбэр юм.

Ганцаарчилсан ярилцлага, төрийн байгууллагын ажилтан, эрэгтэй, Ховд аймаг

Ажилгүй, орлогогүй хүмүүс ихэвчлэн бичил уурхай руу ордог. Газар ухах, хүнд техник хэрэгсэлтэй ажиллах - энэ бүхэн эмэгтэйчүүдийн хувьд хүнд хэцүү ажил байдаг.

Ганцаарчилсан ярилцлага, төрийн байгууллагын ажилтан, эрэгтэй, Говь-Алтай аймаг

2.4 Бичил уурхайчдын ажлын зохион байгуулалт ба орлого

Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.23-т заасны дагуу бичил уурхай эрхэлж буй иргэд бүртгэлтэй болон бүртгэлгүй нөхөрлөл, хоршоо хэлбэрээр зохион

байгуулагдсан байх шаардлагатай (Бүлэг 3.4-ийг үзнэ үү). Бичил уурхайчдын албан ёсны статусыг тодорхойлдог уурхайчдын байгууллагын гишүүнчлэл (Бүлэг 1.2-ийг үзнэ үү) уурхайчдад чухал бөгөөд ялангуяа санхүүжилт, чадавхжуулах болон албан ёсны алтны нийлүүлэлтийн сүлжээний хүртээмжид чухал нөлөө үзүүлдэг. Үүний зэрэгцээ энэхүү зохион байгуулалт нь уурхайчид, орон нутгийн засаг захиргааны оролцогч талууд болон эрх баригчдын хоорондын харилцаа холбоо, эрх мэдлийн хуваарилалтад нөлөөлдөг.

2.4.1 Зохион байгуулалт

Ярилцлагад хамрагдсан уурхайчдын дийлэнх нь зохион байгуулалтад орсон (81%) байгаа бөгөөд тэд ихэвчлэн бүртгэлтэй нөхөрлөл (53%) эсвэл бичил уурхайн төрийн бус байгууллагын (14%) зохион байгуулалтад орсон байна (Хүснэгт 2.4-1). Нийт уурхайчдын 5% нь байгууллагуудад харьяалагддаг боловч одоогоор гэрээгүй ажиллаж байгаа тул албан бус уурхайчдын ангилалд багтаж (Бүлэг 1-2-ийг үзнэ үү) байна. Судалгаанд оролцогчдын 19% нь ямар нэгэн байгууллагад албан ёсоор харьяалагдаагүй бөгөөд хууль бусаар ашигт малтмал олборлогчдын ангилалд багтжээ. Судалгааны бүс нутгаар харьцуулж үзвэл, Мандалд уурхайчдын 75% нь Түнхэлд 55% нь бүртгэлтэй нөхөрлөлийн гишүүн байна. Баянгол нь бичил уурхай анх эхэлсэн сумдын нэг гэж тооцогддог боловч албан ёсны бүртгэлтэй нөхөрлөлийн гишүүн уурхайчдын эзлэх хувь дунджаас 13%-иар доогуур байна. Алтайд хууль бусаар ашигт малтмал олборлогчдын эзлэх хувь хамгийн өндөр буюу 54% байна. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа энэ бүс нутагт харьцангуй шинэ бөгөөд зөвхөн хоёр нөхөрлөл АМГТГ-аас 2019 онд дүгнэлт гаргасан талбайд бичил уурхайн олборлолт хийхээр сумын Засаг даргатайгаа гэрээ байгуулжээ. Хэдийгээр Есөнбулаг суманд бүртгэлтэй нөхөрлөлийн уурхайчдын эзлэх хувь хамгийн бага байгаа боловч ТББ-ын гишүүн уурхайчдын эзлэх хувь хамгийн өндөр байгаа нь ТББ-ын гишүүнчлэл нь тухайн орон нутгийн бичил уурхайчдын хувьд бүртгэгдсэн нөхөрлөлийн гишүүнчлэлтэй адил нийтлэг байдгийг харуулж байна.

Хүснэгт 2.4-1. Судалгаанд оролцогчдын зохион байгуулалт, гишүүнчлэл (судалгааны бүс нутаг, хүйсээр)

	Бүс					Нийт		
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)	Нийт (n=371)
Бүртгэгдсэн нөхөрлөл	40%	75%	55%	32%	45%	49%	55%	53%
Гишүүн	37%	65%	48%	27%	38%	43%	47%	46%
Ахлагч	4%	10%	7%	5%	7%	6%	7%	7%
Бүртгэгдээгүй нөхөрлөл	19%	5%	15%	10%	1%	13%	8%	9%
Гишүүн	15%	4%	14%	6%	0	10%	6%	7%
Ахлагч	4%	1%	1%	3%	1%	3%	1%	2%
БУ ТББ	2%	6%	23%	44%	0	24%	10%	14%
Гишүүн	0	4%	18%	31%	0	14%	8%	10%
Ахлагч	2%	3%	4%	13%	0	10%	2%	4%
Албан бус уурхайчин	17%	4%	4%	2%	0	3%	5%	5%
Хууль бус уурхайчин	21%	10%	3%	13%	54%	11%	23%	19%

Хүйсээр ангилсан мэдээллээс харахад эмэгтэй уурхайчдын 86%, эрэгтэй уурхайчдын 72% нь албан ёсны уул уурхайн байгууллагад харьяалагддаг байна.

Үүнээс гадна эрэгтэйчүүдтэй харьцуулахад (2%) илүү олон эмэгтэйчүүд (10%) ТББ-ын удирдах албыг хашиж байна (Бүлэг 6.2-ийг үзнэ үү).

2.4.2 Бичил уурхайн ажил, албан тушаал

Судалгаанд хамрагдагсдыг бичил уурхайд гүйцэтгэж буй ажил, албан тушаалаар ангилж үзвэл нийт уурхайчдын 54% нь туслах ажилчин, 32% нь уурхайчин, 10% нь амны эзэн, үлдсэн 4% нь "бусад" гэдэг ангилалд орсон байгаа бөгөөд тус ангилалд зохицуулагч, нөхөрлөлийн ахлагч, ТББ-ын тэргүүн, тээрмийн ажилчид, алтны худалдаачид орж байна. Хүснэгт 2.4-2-оос харахад судалгааны бүс нутгуудад уурхайчид болон туслах ажилчдын харьцаа харилцан адилгүй байгаа бөгөөд Алтайд уурхайчдын эзлэх хувь (59%), Баянголд туслах ажилчдын эзлэх хувь (75%) хамгийн өндөр байв. Баянголд уурхайчдын тоо цөөхөн байгаагийн нэг шалтгаан нь зөвшөөрөлтэй алтны үндсэн орд байхгүй боловч цөөн хэдэн тээрэм хууль бусаар ажиллаж байгаатай холбоотой байж болно.

Хүснэгт 2.4-2. Судалгаанд оролцогчдын алтны бичил уурхайд эрхэлдэг ажил үүрэг (судалгааны бүс нутаг, хүйсээр)

	Бүс					Нийт		
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)	Нийт (n=371)
Уурхайчин	15%	24%	27%	31%	59%	13%	38%	32%
Амны эзэн	4%	8%	15%	13%	8%	9%	10%	10%
Туслах ажилчин	75%	63%	52%	52%	31%	68%	49%	54%
Бусад	6%	4%	6%	5%	1%	10%	2%	4%

Жендэрийн үүргийн хувьд эрэгтэйчүүд уурхайчнаар (эрэгтэйчүүдийн 38%, эмэгтэйчүүдийн 13%), эмэгтэйчүүд туслах ажилтнаар (эмэгтэйчүүдийн 68%, эрэгтэйчүүдийн 49%) гол төлөв ажилладаг байна. "Бусад" гэдэг ангилалд эмэгтэйчүүд гол төлөв ТББ, нөхөрлөлийн ахлагч, зохион байгуулагч, удирдагчийн үүргийг гүйцэтгэдэг гэж хариулсан байв (Бичил уурхай дахь хөдөлмөрийн жендэрийн хуваарийн нарийвчилсан дүн шинжилгээг бүлэг 6.2-оос үзнэ үү).

2.4.3 Ажлын туршлага

Судалгаанд оролцогч нийт уурхайчдын 44% нь 10-аас дээш жил энэ салбарт ажиллаж байгаа бол 12% нь нэг жил хүрэхгүй хугацаанд ажиллаж байна. Түнхэлд 10-аас дээш жил ажилласан туршлагатай уурхайчдын эзлэх хувь хамгийн өндөр буюу 58%, харин Баянголд хамгийн бага буюу 38% байгаа бөгөөд уурхайчдын гуравны нэг орчим нь (35%) сүүлийн нэг жилийн хугацаанд бичил уурхайд ажиллаж эхэлсэн байна. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн дунд 10-аас дээш жил ажилласан туршлагатай эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс илүү өндөр байсан бол эмэгтэйчүүдээс илүү олон эрэгтэйчүүд саяхан энэ салбарт орж ирсэн байна.

Хүснэгт 2.4-3. Судалгаанд оролцогчдын алтны бичил уурхай эрхэлсэн туршлага (судалгааны бүс нутаг, хүйсээр)

	Бүс					Нийт		
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)	Нийт (n=371)
1 хүртэл жил	35%	16%	10%	2%	3%	9%	14%	12%
1-5 жил	23%	29%	20%	32%	38%	33%	27%	29%

6-9 жил	4%	14%	13%	16%	23%	7%	17%	15%
10-аас дээш жил	38%	40%	58%	50%	36%	51%	42%	44%

2.4.4 Орлого

Монгол Улсын хүн амын сарын дундаж орлогын түвшинг хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн дундаж орлого 1,222,600 ¹⁹ төгрөг (447 ам.доллар), эмэгтэйчүүдийнх 1,021,300 төгрөг (375 ам.доллар) (Хүснэгт 2.4-4) (ҮСХ, 2019 он) байна. Гэвч хүйсийн хувьд ялгаатай байгаа орлогын энэхүү түвшин нь аймгуудын хооронд ч мөн харагдаж байна. Төслийн бүс нутагт хүн амын сарын дундаж орлого улсын дунджаас доогуур байна (Хүснэгт 2.4-4)


Хүснэгт 2.4-4. Зорилтот аймгууд болон улсын хэмжээнд ажиллагсдын сарын дундаж цалин хөлс

Аймаг	Эрэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй % (эрэгтэйтэй харьцуулахад)
Говь-Алтай	766,400 ₮	809,500 ₮	105.6%
Ховд	771,200 ₮	774,600 ₮	100.4%
Сэлэнгэ	1,001,200 ₮	843,400 ₮	84.2%
Улсын дундаж	1,222,600 ₮	1,021,300 ₮	83.5%

Нийт орлого

Судалгаанд оролцогчдын 67% нь нэгээс илүү орлогын эх үүсвэртэй байсан (Хүснэгт 2.3-3). Судалгааны бүс нутгуудад бичил уурхайчдын 63%-ийн нийт орлогын хэмжээ (зөвхөн бичил уурхайн төдийгүй бусад орлогын эх үүсвэрийг оролцуулаад) нь улсын дунджаас доогуур байна (Зураг 2-7). Орлогын хэмжээ нь өөрөө эмзэг асуудал учраас орлогын нийт хэмжээ нь аймгийн дунджаас доогуур байгааг харуулах боломжгүй юм. Гэхдээ бичил уурхайчдын 21%-ийн сарын дундаж орлогын хэмжээ нь улсын дунджаас дээгүүр буюу 1,500,000 төгрөгнөөс дээш орлоготой байгаа нь тодорхой харагдаж байна. Судалгааны бүс нутгуудаар харьцуулж үзвэл Түнхэлд бичил уурхайчдын орлогын түвшин өндөр, Баянгол ба Есөнбулагт хамгийн бага байна. Эрэгтэй бичил уурхайчдын орлого эмэгтэйчүүдийнхээс ялимгүй өндөр байна. (Бүлэг 6.2).

¹⁹ 2019 оны 12-р сарын 31-ий өдрийн байдлаар төгрөгийн америк доллартай тэнцэх ханш (Монгол банкны ханш: \$1 = ₮2,734.33)



Зураг 2-7. Бусад эх үүсвэрээс олдог сарын дундаж орлого (судалгааны бүс нутаг, хүйсээр (n=371))

Бичил уурхайн орлого

Судалгаанд оролцогчдын дөрөвний гурав нь (77%) алтны бичил уурхайг орлогын үндсэн эх үүсвэр, 33% нь орлогын цорын ганц эх үүсвэр гэж тодорхойлсон байна (Хөдөлмөр эрхлэлтийн хэсгийг үзнэ үү). Хүснэгт 2.4-5-д үзүүлснээр судалгаанд оролцогчдын 80% нь сард бичил уурхайгаас улсын дунджаас бага орлого олсон бол 13% нь 1,500,000-аас дээш төгрөгийн орлого олжээ. Гэхдээ Говь-Алтай, Ховд аймгийн сарын дундаж цалин, хөлс улсын дунджаас доогуур байна (Хүснэгт 2.4-4). Есөнбулагийн уурхайчдын 29%, Алтайн уурхайчдын 42%-ийн бичил уурхайгаас олсон орлого нь аймгийн дунджаас доогуур байна.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны сарын орлого нь улирлын чанартай олборлолт, алтны үнэ, хүдрийн чанар, алт барилтын хувь болон бусад хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүй байдаг гэдгийг нөхөрлөлийн ахлагч нар ганцаарчилсан ярилцлагадаа дурдсан.

“Бид тогтмол ажилтай байхдаа сард 1,500,000-2,000,000 төгрөг олдог.”

Ганцаарчилсан ярилцлага, Нөхөрлөлийн ахлагч, эрэгтэй, Ховд аймаг

Олборлосон хүдрийн хэмжээнээс орлого хамаарна. Заримдаа энэ нь нэг граммаас бага, заримдаа 5-6 грамм алт олдог. Хамгийн ихдээ 10-20 грамм алт олдог ч энэ нь ховор тохиолддог. Энэ газар нутагт хэр их нөөц байгаагаас хамаарна. Бид өвлийн улиралд талбай дээр очдоггүй. Миний үеийн хүмүүс аль хэдийн өвөө, эмээ болсон, багачуудаа харж ханддаг. Бид зөвхөн цаг зав гарахаар л 1-2 сараар ирдэг. Манай гэр бүл алт ухахаас өөр орлогогүй. Бид ингэж л амьдралаа залгуулдаг. Хүүхдүүдийн маань цаг зав гарвал би алтанд явдаг. Тэгэхээр орлогын хэмжээ үнэхээр өөр өөр байдаг. Намайг газар ухахаар явахад манайхан тодорхой хэмжээний орлоготой байдаг. Яваагүй үедээ би ач зээ нараа харж ханддаг.

Ганцаарчилсан ярилцлага, Нөхөрлөлийн ахлагч, эрэгтэй, Говь-Алтай аймаг

Хүснэгт 2.4-5. Судалгаанд оролцогчдын алтны бичил уурхайгаас олдог сарын дундаж орлого (судалгааны бүс нутаг, хүйсээр)

	Бүс					Нийт		
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)	Нийт (n=371)
500,000 ₮	42%	40%	34%	29%	42%	41%	37%	38%
500,001-1,000,000 ₮	42%	46%	37%	52%	32%	39%	43%	42%
1,000,001-1,500,000 ₮	8%	8%	7%	8%	9%	10%	7%	8%
1,500,001-2,000,000 ₮	4%	3%	13%	5%	5%	5%	6%	6%
2,000,001-2,500,000 ₮	2%	1%	4%	2%	3%	1%	3%	2%
2,500,001-3,000,000 ₮	2%	0%	6%	2%	0%	0%	2%	2%
3,000,001+	0%	1%	0%	3%	7%	4%	1%	2%
Хариулаагүй	0%	2%	0%	0%	1%	0%	1%	1%

Судалгааны бүс нутгаар харьцуулж үзэхэд, бичил уурхайгаас олсон орлогын хэмжээ Түнхэлд хамгийн өндөр буюу 23% нь 1,500,000 төгрөгнөөс дээш орлоготой, Мандал, Баянгол сумдад хамгийн бага (86% ба 84%) буюу 1,000,000 төгрөгөөс доош орлоготой байна. Алтайд судалгаанд оролцогчдоос хэд хэдэн хүн 3,000,000 төгрөгөөс дээш орлоготой гэж мэдүүлсэн нь уурхайчин (n=3), амны эзэн (n=1), туслах ажилчин (n=1) байсан нь сонирхолтой байсан бөгөөд хэтрүүлж мэдээлсэн байж болзошгүй юм. Орлогын жендэрийн нарийвчилсан дүн шинжилгээг Бүлэг 6.2-оос үзнэ үү.

Бичил уурхайн олон байгууллагууд орлогоо тэгш хуваарилдаг гэж мэдэгдэж байсан ч орлогын хэмжээ нь тухайн салбарт гүйцэтгэж буй ажил, үүргээс хамаардаг байна. Хүснэгт 2.4-6-аас үзэхэд уурхайчид (77%) болон амны эзэдтэй (69%) харьцуулахад 1,000,000 төгрөгөөс доош орлоготой туслах ажилчдын хувь (85%) хамгийн өндөр байсан. Ерөнхийдөө эдгээр бүлгүүдийн хооронд орлогын томоохон зөрүү байхгүй байна.

Хүснэгт 2.4-6. Алтны бичил уурхайгаас олдог сарын дундаж орлого (эрхэлдэг ажил, албан тушаал, албажсан байдлаар)

	Эрхэлдэг ажил, албан тушаал				Зохион байгуулалтын статус	
	Уурхайчин (n=117)	Амны эзэн (n=36)	Туслах ажилчин (n=202)	Бусад (n=16)	Зохион байгуулалтад орсон (n=282)	Зохион байгуулалтад ороогүй (n=89)
500,000 ₮ хүртэл	38%	25%	41%	25%	34%	48%
500,001-1,000,000 ₮	39%	44%	44%	25%	44%	36%
1,000,001-1,500,000 ₮	8%	14%	7%	13%	10%	3%
1,500,001-2,000,000 ₮	6%	6%	5%	13%	5%	8%
2,000,001-2,500,000 ₮	3%	6%	0%	13%	2%	2%
2,500,001-3,000,000 ₮	2%	3%	1%	6%	2%	1%
3,000,001-ээс дээш	3%	3%	1%	0%	2%	1%
Хариулаагүй	2%	0%	0%	6%	1%	0%

Байгууллагын зохион байгуулалтад орсон байдлаар харьцуулж үзэхэд албан ёсны бүртгэлтэй нөхөрлөл, бичил уурхайн ТББ-ын гишүүн уурхайчид албан бус бүлгүүдээс бага зэрэг илүү, хууль бусаар ашигт малтмал олборлогчдын орлогоос илүү их орлого олдог байна (Хүснэгт 2.4-7).

Хүснэгт 2.4-7. Сарын дундаж орлого (зохион байгуулалтын хэлбэрээр)

	Бүртгэлтэй нөхөрлөл	Бүртгэлгүй нөхөрлөл	БУ ТББ	Албан бус уурхайчин	Хууль бус ашигт малтмал олборлогч
Сарын дундаж орлого	₮1,005,385	₮891,176	₮1,083,000	₮929,412	₮894,444

Судалгаанд оролцогчдын ердөө 37% нь бичил уурхайгаас өөртөө болон гэр бүлийнхээ хэрэгцээнд хангалттай орлого олдог гэсэн бөгөөд энэ нь эмэгтэйчүүдээс (33%) илүүтэй эрэгтэйчүүдийн (38%) дунд өндөр байна. Түүнчлэн хууль бус ашигт малтмал олборлогчидтой харьцуулахад (31%) зохион байгуулалтад орсон уурхайчид (албан ба албан бус) (37-41%) хангалттай орлого илүү олж байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байсан. Харин судалгаанд оролцогчдын гуравны нэг орчим нь (30%) заримдаа хангалттай орлого олдог байхад нөгөө гуравны нэг нь (30%) бичил уурхайгаас хангалттай орлого олж чаддаггүй гэжээ.

Ерөнхийдөө тоон мэдээллээс харахад судалгаанд оролцогчдын тал хувь нь бичил уурхайгаас орлогын гол эх үүсвэрээ хангадаг байна. Гэсэн хэдий ч орлогын хэмжээ нь ихэвчлэн улсын төдийгүй аймгийн дунджаас бага, мөн улирлын шинж чанартай ажил байдаг зэргээс шалтгаалж бичил уурхайчид амьжиргаагаа тэтгэх орлогын өөр эх үүсвэрийг хайдаг байна. Бүртгэгдсэн нөхөрлөлүүд болон бичил уурхайн ТББ-ын хэлбэрээр зохион байгуулагдсан уурхайчид нь, ялангуяа хууль бусаар ашигт малтмал олборлогчидтой харьцуулахад илүү их орлого олох хандлагатай байсан.


2.5 Нийгмийн үйлчилгээний хүртээмж

Уурхайчдын хувьд үйлдвэрлэлийн ослын эрсдэлээс үүдэн хөдөлмөрийн чадвараа алдахад хүргэж болзошгүй тул нийгмийн болон эрүүл мэндийн даатгал нь нийгмийн чухал үйлчилгээ юм. Гэсэн хэдий ч уул уурхайн албан бус статус, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжгүй байдал нь уурхайчдыг даатгалд хамрагдах эсвэл даатгалын шимтгэл төлөхөд нь саад бэрхшээл болж болзошгүй юм.

2.5.1 Нийгмийн даатгал

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуульд зааснаар (1994), бичил уурхайчид сайн дурын нийгмийн даатгалд хамрагдаж болно. Энэхүү сайн дурын даатгалд тэтгэврийн даатгал, тэтгэмжийн даатгал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал ордог. Тэтгэмжийн даатгал нь жирэмслэлт ба төрөлт, өвчний чөлөө, оршуулгын зардлыг хамардаг. Сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлд сарын тайлагнасан орлогын 13.5% буюу Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үндэслэн сар бүр хамгийн багадаа 56,700 төгрөгийг төлдөг.

Судалгаанаас харахад дийлэнх нь (60%) нийгмийн даатгалын шимтгэлээ тогтмол хугацаанд төлдөггүй байна. Зураг 2-8-т харуулснаар судалгааны бүс нутгуудын бичил уурхайчдын нийгмийн даатгалд хамрагдалтын хувь харилцан адилгүй байгаа бөгөөд Түнхэлд (52%) өндөр бол харин зохион байгуулалтад ороогүй уурхайчдын тоо ихтэй Баянголд (25%)-д бага байна.



Зураг 2-5. Судалгаанд оролцогчдын нийгмийн даатгалд хамрагдалт (судалгааны бүс нутаг, хүйсээр)

Бичил уурхайн байгууллагын хууль ёсны байдлаас шалтгаалж албан бус уурхайчдаас (27%) албажсан уурхайчдын нийгмийн даатгалд хамрагдалт (39%) өндөр байсан. Энэ нь Ховд аймгийн төрийн байгууллагын ажилтны ярилцлагаар баталгаажиж байна:

Одоогийн байдлаар хууль бус нинжа нар хөндөгдөөгүй газар ухаж, нөхөн сэргээлт хийлгүй орхиж байгаа төдийгүй эрүүл мэнд, даатгалын шимтгэл, татвар төлөхөөс зайлсхийж эрүүл мэнд, амь насаа эрсдэлд оруулж байна. Тиймээс хариуцлагатай бичил уурхай руу шилжих шаардлагатай байна.

Ганцаарчилсан ярилцлага, төрийн байгууллагын ажилтан, эмэгтэй, Ховд аймаг

Ярилцлагаас харахад бичил уурхайн албажуулалт нь даатгалд хамруулах нэг нөлөөлөгч хүчин зүйл болох ч энэ нь эмэгтэй, эрэгтэй уурхайчдын нийгмийн даатгалд хамрагдалтын түвшин доогуур байгаагийн шалтгааныг тайлбарлахад хангалттай бус юм. Ховд аймгийн байцаагчийн тайлбарласнаар уурхайчид өөрсдийн нөхөрлөлийн байгууллагаа бүртгүүлэх үедээ зөвхөн нэг жилийн хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөөд дараа нь уул уурхайн тогтмол бус орлогын улмаас үргэлжлүүлэн төлдөггүй байна.

Бидний мэдэж байгаагаар суманд 4-5 нөхөрлөл байдаг. 2018 онд даатгалд хамрагдсан бичиг баримтаа нөхөрлөлийн бүртгэлийн баримт бичгийн хамт Бүртгэлийн байгууллагад өгөх шаардлагатай болсон учраас эдгээр нөхөрлөлийн гишүүн бүх уурхайчид нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн. Тэд нэг жилийн даатгалын шимтгэл төлсөн боловч уул уурхайн үйл ажиллагаа тогтмол биш эсвэл олборлолтын үйл ажиллагаа зогссоноос цөөхөн хэд нь үргэлжлүүлэн төлж байна. Тэгэхээр уурхайчид олборлолт явуулж буй газарт нөхөрлөл байдлаар ажилладаггүй бол дангаараа даатгал төлдөг. ... Бичил уурхай эрхлэгчидтэй гэрээ байгуулахдаа даатгалыг шимтгэл, татвар төлөхийн ашиг тусын талаар мэдээлэл өгч, бичил уурхайчдыг албажуулж, эрүүл мэнд, нийгмийн даатгал төлөхийг үүрэг болгох нь чухал юм.

Ганцаарчилсан ярилцлага, төрийн байгууллагын ажилтан, эрэгтэй, Ховд аймаг

Алтай сумын нөхөрлөлийн ахлагч байгууллагын бичил уурхайчдын нийгмийн даатгалын шимтгэлийг бичил уурхайчдад зориулсан тусгай кодын дагуу тусад нь дансанд тушаадаг гэж тайлбарлав. Энэ нь уурхайчдад хүнд нөхцөлд ажилласны тэтгэвэр, дэмжлэг авах боломжийг олгодог. Нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан хамгийн бага хувиар төлж болно. Уурхайчдын нийгмийн даатгалд хамрагдалт

бага байгаад нөлөөлж буй гол хүчин зүйлд уул уурхайн тогтвортой биш үйл ажиллагаа, орлогын хомсдол орж байна. Өөр нэг төрийн байгууллагын ажилтан тэтгэвэрт гарах нас нь ойртохоор олон уурхайчид нийгмийн даатгал төлж эхэлдэг гэж тайлбарлав:

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох нь эрсдэлтэй ажил тул уурхайчид албан ёсны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдах ёстой. Зөвхөн тэтгэврийн насанд ойрхон хүмүүс тэтгэврийн тэтгэмж авахын тулд нийгмийн даатгалын шимтгэлийг тогтмол төлдөг.


Ганцаарчилсан ярилцлага, төрийн байгууллагын ажилтан, эрэгтэй, Сэлэнгэ аймаг

Ярилцлагад оролцсон орон нутгийн төлөөллүүд бичил уурхай эрхлэгчдэд чиглэсэн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын сурталчилгааны кампанит ажил зохион байгуулсан нь тодорхой эерэг үр дүнд хүргэснийг тэмдэглэв. Түүнчлэн уул уурхайн үйл ажиллагааны улирлын шинж чанартай онцлогийг даатгалын шимтгэлийн тогтолцоонд харгалзан үзэх ёстой гэсэн санааг бичил уурхайн нөхөрлөлийн гишүүн дэвшүүлж байсан.

2.5.2 Эрүүл мэндийн даатгал

Монгол Улсын иргэд “зайлшгүй шаардлагатай” эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багц үйлчилгээг анхан шатны түвшинд үнэ төлбөргүй авах боломжтой бөгөөд эрүүл мэндийн нэмэлт үйлчилгээ авахын тулд даатгалд заавал хамрагдах ёстой. Монгол Улсад эрүүл мэндийн даатгал нь эрүүл мэндийн бүх үйлчилгээг хамардаггүй боловч эрүүл мэндийн үйлчилгээнд эрүүл мэндийн салбараас гарч байгаа зардал маш өндөр байдаг (Жигжидсүрэн нар, 2019 он).

Судалгаанд оролцогчдын дунд эрүүл мэндийн даатгалын хамрагдалт нийгмийн даатгалтай харьцуулахад 27%-аар өндөр байна. Хэдийгээр Монгол Улсын иргэн эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулах үүрэгтэй боловч нийт оролцогчдын 63% нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тогтмол төлдөг гэж хариулжээ (Зураг 2-9). Судалгааны бүс нутгаар авч үзвэл эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хүрээ ойролцоо түвшинд байгаа бөгөөд уурхайчид нийгмийн даатгалаас илүү эрүүл мэндийн даатгал төлдөг байна. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь Есөнбулаг (76%) болон Түнхэл (72%)-д хамгийн их, Баянгол (58%), Мандал (55%) сумдад бага байна. Нийгмийн даатгал төлдөг эмэгтэй, эрэгтэй уурхайчдын эзлэх хувь ижил байсан (36%) бол илүү олон эмэгтэйчүүд эрүүл мэндийн даатгалын шимтгэл (77% ба 58%) төлдөг байна.



Зураг 2-6. Судалгаанд оролцогчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалт (судалгааны бүс нутаг, хүйсээр)

2.5.3 Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж

Эрүүл мэндийн даатгал төлдөг (n=235, 63%) гэж хариулсан иргэдийн 70% (n=162) нь эрүүл мэндийн үйлчилгээ авдаг гэж хариулжээ. Харин эрүүл мэндийн даатгал төлөөгүй хүмүүсээс (35%, n=128) 53% (n=67) нь эрүүл мэндийн үйлчилгээ авдаг гэж хариулжээ. Жишээлбэл, эрүүл мэндийн даатгалгүйгээр зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй авах, эсвэл улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас төлбөртэй үйлчилгээ авах зэргийг дурдаж болох юм.

Судалгаагаар уурхайчид уурхайн талбайд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах сонголтууд байгаа эсэхийг үнэлэх зорилготой байсан. Зарим уурхайчид уурхайд ээлжээр ажиллахын тулд уурхайн талбайн хажууд байрлах түр сууцанд амьдрах шаардлагатай болдог нь тэднийг эрүүл мэндийн үйлчилгээ авахад бэрхшээл учруулдаг байж болзошгүй юм. Нөгөө талаас судалгаанд хамрагдагсад түр оршин суух байрнаасаа илүү байнга оршин суудаг газартаа эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой гэсэн үүднээс энэ асуултанд хариулсан байхыг үгүйсгэхгүй. Нийт судалгаанд хамрагдагсдын 37% нь бичил уурхайд ажиллаж байхдаа эрүүл мэндийн хангалттай үйлчилгээ авах боломжгүй гэж хариулсан байна. Үүний шалтгааныг асуухад 59% нь эрүүл мэндийн үйлчилгээ шаардлагагүй гэж хариулсан боловч судалгаанд хамрагдагсдын зарим нь эрүүл мэндийн үйлчилгээ авахад бэрхшээлтэй байдаг тухай сонссон гэж хариулсан байна. Үлдэх хувь нь эрүүл мэндийн үйлчилгээ авахад олон бэрхшээл, тухайлбал институцийн бэрхшээл (эрүүл мэндийн үйлчилгээний зардал), хууль эрх зүйн асуудал (эрүүл мэндийн даатгалгүй) зэргийг дурьдсан байна (Хүснэгт 2.5-1). Түнхэлд ихэнх уурхайчид уурхайн талбай руу өдөртөө ирж очих боломжтой бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж нь (80%) өндөр хувьтай байсан бол судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь хууль бус уурхайчид ажиллаж байсан Алтай суманд хамгийн бага (50%) хувьтай байсан.

Хүснэгт 2.5-1. Судалгаанд оролцогчдын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж (судалгааны бүс нутаг, хүйсээр)

	Бүс					Нийт		
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=112)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)	Нийт (n=371)
Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой	60%	68%	80%	52%	50%	65%	62%	63%
Эрүүл мэндийн үйлчилгээ авах болосжгүй	40%	32%	20%	48%	50%	45%	38%	37%
Эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байгаа шалтгаан								
Эрүүл мэндийн үйлчилгээ хэрэггүй	25%	16%	11%	29%	34%	17%	24%	22%
Хууль зүйн бэрхшээл	2%	5%	4%	2%	3%	2%	4%	4%
Эрүүл мэндийн даатгалгүй	0%	4%	4%	2%	3%	2%	3%	3%
Аймагт оршин суух зөвшөөрөлгүй	2%	1%	0	0	1%	0	1%	1%
Институцийн бэрхшээл	6%	5%	3%	2%	10%	4%	5%	5%
Эрүүл мэндийг үйлчилгээ муу	2%	0	0	0	3%	1%	1%	1%
Хүнд суртал, урт дарааллал	0	4%	0	2%	0	1%	1%	1%
Үнэтэй	4%	1%	3%	0	7%	2%	3%	3%
Хувь хүний бэрхшээл	4%	3%	0%	12%	1%	8%	1%	5%
Цаг зав байхгүй	4%	2%	0	8%	0	6%	1%	2%
Хэт хол зайтай	0	0	0	2%	1%	1%	0	1%
Мэдээллийн хомсдол	0	1%	0	2%	0	1%	0	1%
Бусад	4	3	1	3	0	2	2	2
Мэдэхгүй	0	2	0	2	1	2	1	1

Судалгаагаар бичил уурхайчдын эрүүл мэндийн зан үйлийг үнэлээгүй болно. Уурхайчид эрүүл мэндийн хүндрэлтэй асуудал тулгарсан үедээ л эмнэлэгт очиж байгаа эсэх эсвэл ажлын байрны болон ерөнхий эрүүл мэндийн асуудлыг эрт үед нь илрүүлэхийн тулд эрүүл мэндийн ээлжит урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах зорилгоор эрүүл мэндийн байгууллагад хандаж байгаа эсэх талаар цаашид нэмэлт судалгаа хийх шаардлагатай байна. Ховд аймгийн нэгэн нөхөрлөлийн ахлагчийн мэдээлснээр нөхөрлөлийн гишүүн уурхайчид эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдахаар явдаггүй боловч заримдаа мэргэжлийн эмч нар ажлын байран дээр ирж үнэ төлбөргүй эрүүл мэндийн үзлэг хийвэл хамрагддаг болохыг дурдсан.

Манай суманд ноцтой гэмтэл бэртэл, осол аваар бүртгэгдээгүй тул манай нөхөрлөлийн гишүүд урьд өмнө нь эмнэлгийн яаралтай тусламж авч байгаагүй. Бид сар, жилдээ тэр бүр тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамрагддаггүй. Улаанбаатраас эмч нар ирж үнэгүй оношлогоо, үзлэг хийх санал тавьсан тохиолдолд л эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг. Бид хүнд өвчтэй л биш бол эмчид хандах төрлийн хүмүүс биш.

Ганцаарчилсан ярилцлага, Нөхөрлөлийн ахлагч, эрэгтэй, Ховд аймаг

Бүс нутаг тус бүрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохих түвшинд хүртдэггүй уурхайчид байгаа нь судалгаанаас харагдаж байна. Судалгаанд оролцогчид эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг тэдэнд тулгамдсан томоохон асуудал гэж тодорхойлоогүй ч энэ хүртээмжид хууль эрх зүй, институцийн саад бэрхшээлүүд нөлөөлж байна.

2.6 КОВИД-19 цар тахлын нөлөөлөл

КОВИД-19 цар тахлын дэгдэлт Монгол Улсад ихээхэн нөлөө үзүүлсэн. Цар тахлын эхний үеэс эхлэн Монгол Улс хүн амынхаа эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг хамгийн бага байлгах арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлж ирсэн. Эрүүл мэндийн яамнаас 2020 оны 1-р сарын 6-ны өдөр КОВИД-19-ын ажлын хэсгийг байгуулж, 1-р сарын 31 гэхэд бүх сургуулиудын танхимын үйл ажиллагааг зогсоож, БНХАУ-тай хилээ хаасан. Үүний дараа улс хоорондын аяллыг хориглож, улмаар хот хооронд зорчихоос урьчилан сэргийлж дотоод аялал жуулчлал, бүх нийтийн хурал цуглааныг хориглосон. Эдгээр хязгаарлалтуудыг 5-р сарын 1-ээс 9-р сарын 15 хүртэлх хугацаанд шат дараатайгаар сулруулсан боловч 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар хилээр зорчихыг хориглосон хэвээр байна.



Зураг 2-7. Ковид-19 цар тахлын арга хэмжээг уурхайн талбайд хэрэгжүүлж буй байдал (planetGOLD)

Цар тахалын алтны зах зээлд үзүүлж буй нөлөөллын талаар мэдээлэл авахын тулд судалгааны бүс нутагт буй уурхайчдад цар тахлын үзүүлэх нөлөөллийг үнэлэв. Судалгааг явуулж байх үед Монгол Улсад КОВИД-19-ийн тархалт маш бага байсан тул зах зээлийн хямралаас үүдсэн цар тахлын шууд бус нөлөөлөл болон өвчлөлийн талаарх уурхайчдын мэдлэг, мэдээллийг planetGOLD Монгол төслөөс цаашид зохион байгуулах сургалтын хэрэгцээтэй уялдуулан авахад чиглэсэн.


Судалгаанд оролцсон нийт 248 хүн (67%) коронавирусын цар тахал нь тэдний АБУ-н үйл ажиллагаанд нөлөөлсөн гэж мэдэгджээ. Тэдний мэдээлснээр судалгааны бүс нутгуудаас КОВИД-19-д хамгийн бага өртсөн газарт Алтай (49%) ба Түнхэл (63%) орж байсан бол бусад гурван газарт нийт судалгаанд оролцогчдын 3/4 орчим нь уурхайн үйл ажиллагаа КОВИД-19-тэй холбоотойгоор тасалдсан гэж мэдээлсэн. Хорио цээрийн хязгаарлалт нь ажиллагсдын тоо буурахад хүргэсэн (61%), ажил багассаны улмаас ажиллах боломжтой ажилчдын тоо цөөрч ажилгүй болсон (32%), түүнчлэн Баянгол, Алтайд (тус бүр 8%) алтны үнэ буурснаас нийлүүлэлтийн сүлжээ тасалдахад хүргэсэн гэх зэргээр цар тахлын нөлөөлөл бүс нутаг бүрт харилцан адилгүй байгааг харуулж байна. Жендэрээр авч үзвэл, КОВИД-19 цар тахал саад тотгор учруулж байгааг эрэгтэйчүүд (72% ба 65%) илүүтэй дурдсан

Хүснэгт 2.6-1. Цар тахлын алтны бичил уурхайд үзүүлж буй нөлөөлөл (судалгааны бүс нутаг, хүйсээр)

	Бүс					Нийт		
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=52)	Нийт (n=112)
Мэдээлсэн нөлөөлөл	75%	74%	63%	73%	49%	65%	72%	67%
Карантинаас болж ажилчдын тоо цөөрсөн	46%	61%	69%	73%	50%	64%	53%	61%


Ажил багассанаас орлогогүй/ ажилгүй болсон	33%	34%	27%	27%	39%	29%	39%	32%
Алтын үнэ буурсан	8%	0%	0%	0%	8%	2%	4%	2%
Баяжуулах цехүүд ажиллахгүй болсон	8%	1%	0%	0%	0%	1%	4%	2%
Бусад	5%	4%	4%	0%	3%	5%	0%	3%

Уурхайн талбайд КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлсэн эсэх талаарх асуултад нийт 230 уурхайчин (62%) бүс нутгийн онцлогтой урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан гэж мэдээлсэн (Зураг 2-11). Цар тахлын үед гарсан журмын хэрэгжилтийг дагаж мөрдөх нь Түнхэлд (89%) өндөр, Алтайд (15%) доогуур байсан бөгөөд КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар эмэгтэйчүүд илүү сайн мэдлэгтэй байсан.



Зураг 2-8. Ажлын байран дахь Ковид-19-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ (судалгааны бүс нутаг, хүйсээр)

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хувьд судалгаанд оролцогчдын 43% нь маск зүүж, 17% нь гараа байнга угааж, 12% нь ажлын байрандаа ариутгал хийсэн гэж тайлагнажээ.



Зураг 2-9. Судалгаанд оролцогчдын мэдээлсэн хамгаалах арга хэмжээ (n=371; олон төрлийн хариулт тэмдэглэгдсэн, нийт=461)

Түүнчлэн судалгаанд оролцогчдын 79% нь цар тахал амьжиргаанд нь ерөнхийдөө нөлөөлсөн гэж хариулав. Эдийн засгийн хямрал, инфляци (21%), ажилгүйдэл (13%), орлого буурахад хүргэсэн (30%) зэргээр КОВИД-19-ийн эдийн засгийн нөлөөллийг голчлон мэдээлж байв. Хорио цээрийн дэглэмээс үүдсэн

ерөнхий нөлөөллийг судалгаанд оролцогчдын 14% дурдсан бол сургууль хаагдсан тухай дөнгөж 4% нь дурдсан байна.

Хүснэгт 2.6-2. Судалгаанд оролцогчдын амьжиргаанд короновируст халдварын цар тахлын үзүүлж буй нөлөөлөл (олон төрлийн хариултууд; нийт=404)

	Бүс					Нийт		
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=52)	Нийт (n=112)
Нөлөө үзүүлээгүй	29%	20%	25%	8%	23%	22%	20%	21%
КОВИД-19-ийн нөлөөнд өртсөн	71%	80%	75%	82%	77%	78%	80%	79%
КОВИД-19-ийн нөлөөлөл								
Эдийн засгийн хямрал (инфляц, үнийн өсөлт)	15%	24%	21%	29%	15%	25%	20%	21%
Ажилгүйдэл	25%	17%	14%	8%	4%	10%	15%	13%
Орлого буурсан	23%	34%	27%	29%	32%	30%	30%	30%
Хүүхдийн сургууль хаагдсан	4%	4%	1%	5%	4%	1%	4%	4%
Хөл хорио	8%	12%	17%	19%	15%	8%	16%	14%
Бусад	6%	5%	4%	6%	9%	9%	5%	6%

Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь (91%) коронавирусын цар тахлын талаар хангалттай мэдээлэл авсан, өөрсдийгөө хамгаалах чадвартай гэж мэдэгджээ. Голчлон телевиз (ЭМЯ-аас цацагддаг мэдээлэл)-ийн мэдээ, утасны мессеж, фэйсбүүкээр дамжуулан мэдээлэл авдаг байна. Гэсэн хэдий ч судалгаагаар фэйсбүүкээр дамжуулан өгсөн мэдээллийн үнэн зөв байдал, судалгаанд оролцогчдын мэдлэгийн түвшин, мэдлэг, мэдээлэл тогтмол шинэчлэгдэж байгаа эсэхийг үнэлээгүй болно. КОВИД-19-ийн талаарх мэдлэг, мэдээлэл байнга өөрчлөгдөж байгааг анхаарч үзэх хэрэгтэй. Жишээлбэл, хүүхдийн дархлааны эмзэг байдал, агаараар дамжих эрсдэлийн талаар гэх мэт. Уурхайчид мэдээллийн үнэн зөв байдал, баталгаатай эсэхийг харгалзан үзэхгүйгээр мэдээлэл олж авах боломжтой болох нь судалгаанаас харагдаж байна.

2.7 Дүгнэлт

Судалгааны бүс нутгуудыг харьцуулж үзэхэд Түнхэлд хамгийн олон албажсан болон 10-аас дээш жилийн туршлагатай уурхайчид ажиллаж, уурхайчдын ихэнх нь 1,000,000 төгрөгөөс дээш орлоготой байгаа бөгөөд зөвхөн бичил уурхайгаас амьжиргаагаа залгуулах боломжтой гэж хамгийн их хүн хариулсан байна. Эдгээр үзүүлэлтүүдээр Есөнбулаг, Мандал сумд Түнхэлийн дараа орсон бол Баянгол сумын уурхайчид орлогоос бусад ангилалд дөрөвт, Алтай тавдугаарт оржээ. Судалгааны таван бүс нутгийн эдгээр тоон үзүүлэлтүүд нь бичил уурхайн салбарыг бүхэлд нь төлөөлж чадахгүй боловч Түнхэлд бичил уурхайн үйл ажиллагаа хамгийн тогтвор суурьшилтай явагдаж байхад Алтайд тогтвор суурьшил төдийлөн хангалттай бус байгааг харуулж байна.

Судалгаанд оролцогч бичил уурхайчдын тал хувь нь бичил уурхайгаас орлогын гол эх үүсвэрээ хангаж байна. Гэвч тэдний орлогын түвшин улсын болон аймгийн дунджаас доогуур, бичил уурхайн ажил нь улирлын шинж чанартай байдаг зэргээс шалтгаалан уурхайчид орлогын нэмэлт эх үүсвэр хайдаг байна. Судалгаанд хамрагдагсдын гуравны нэг нь зөвхөн бичил уурхайн орлогоор амьдарч байна. Түүнчлэн бүртгэгдсэн нөхөрлөлүүд болон БУ-н ТББ-ын хэлбэрээр

зохион байгуулагдсан уурхайчид хууль бусаар ашигт малтмал олборлогчдоос илүү орлого олох хандлагатай байна. Бичил уурхайн байгууллагын хувьд олсон орлогоо бүх гишүүддээ тэгш хуваарилдаг.

Ярилцлагад оролцсон уурхайчдын дийлэнх нь (76%) бичил уурхай эрхлэхийн тулд хууль тогтоомжийг мөрдөж зохион байгуулалтанд орсон бөгөөд голчлон бүртгэлтэй нөхөрлөл (53%) эсвэл бичил уурхайн ТББ (14%)-ын хэлбэрээр зохион байгуулагджээ. Нийт уурхайчдын 5% нь аль нэг байгууллагад харьяалагддаг байсан боловч одоогоор гэрээгүй ажиллаж байгаагаас албан бус уурхайчдын ангилалд багтаж байна. Судалгаанд оролцогчдын 19% нь ямар нэгэн албан ёсны байгууллагад харьяалагдаагүй бөгөөд хууль бусаар ашигт малтмал олборлогчдын ангилалд орж байна.

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд уурхайчид хангалттай хамрагдаж чадахгүй байгаа нь судалгаанаас харагдсан. Судалгаанд оролцогчдын зөвхөн гуравны нэг нь (36%) нь нийгмийн даатгалын шимтгэл тогтмол төлж, гуравны хоёр нь (63%) эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлжээ. Хэдийгээр албажсан уурхайчдын нийгмийн даатгалд хамрагдалт өндөр байгаа боловч, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа тогтмол бус, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцооны үр ашгийн талаарх мэдлэг, мэдээлэл хомс байдаг зэрэг нь уурхайчдыг нийгмийн даатгалд хамрагдахад гол саад бэрхшээл болдог байж болзошгүй юм. Уурхайчдын гуравны хоёр нь (64%) бичил уурхай эрхэлж буй газруудад ажиллаж байхдаа эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой гэж мэдэгдсэн бол бусад нь эрүүл мэндийн үйлчилгээ авахад институцийн болон хууль эрх зүйн саад бэрхшээл тулгарч байгааг мэдээлсэн. Гэсэн хэдий ч зан үйл, мэдлэгийн саад бэрхшээлээс шалтгаалан уурхайчид эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдахгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна. Мэргэжлийн болон мэргэжлийн бус эрсдэлт хүчин зүйлээс үүдэлтэй бөөрний өвчин гэх мэт халдварт бус өвчин, мэргэжлээс шалтгаалсан архаг эрүүл мэндийн асуудлыг (жишээлбэл, силикоз) тодорхойлдгоороо эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг чухал ач холбогдолтой юм.

Судалгаагаар коронавируст халдварын цар тахал энэ салбарт нөлөөлсөн болохыг харуулсан. Нийт оролцогчдын гуравны хоёр орчим хувь нь (67%) ажилгүй болсон буюу ажилдаа явах боломжгүйн улмаас орлогогүй болсон, түүнчлэн уурхайн талбайд хязгаарлагдмал тооны хүн ажиллаж байгаагаас үйлдвэрлэлийн хүчин чадал буурч, ажил тасалдсан гэж мэдээлсэн байна.

3. Алтны бичил уурхайн эрх зүйн орчин, албажуулалт

3.1 Алтны бичил уурхайн түүх ба Засгийн газрын арга хэмжээнүүд

1990-ээд оны сүүл, 2000 оны эхээр Монгол Улсад эдийн засгийн шилжилт, явагдаж ажилгүйдэл газар авсны зэрэгцээ байгалийн гамшгийн улмаас орон нутгийн иргэд ихэнх малаа алдаж амьжиргааны нөхцөл хүндэрсэнтэй холбоотойгоор иргэд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эхлэн газар авсан. (Бүлэг 1). Монгол Улсын Засгийн газар тухайн үед үүнийг нийгмийн түр зуурын үзэгдэл, улс орны эдийн засгийн өсөлт, уул уурхайн хурдацтай хөгжлийн үр дүнд яваандаа алга болно гэж үзэж байв. Иймээс эхний арван жилийн хугацаанд Засгийн газар бичил уурхайг хүлээн зөвшөөрч, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэмжих талаар дорвитой алхам хийгээгүй. Мөн энэ үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцож ихэвчлэн таслан зогсоох, хориглох, ял шийтгэл ногдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Гэсэн хэдий ч хувиараа ашигт малтмал олборлогчдын тоо нэмэгдэж улмаар хяналтаас гарсан бөгөөд эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны нөхцөл муу, энэ талаар огт анхаардаггүй байснаас осол аваар, амь нас эрсдэх тохиолдол газар авсан байна. Түүнчлэн байгаль орчны хууль, тогтоомжийг зөрчих, дагаж мөрддөггүй байдлаас болж хүрээлэн буй орчны доройтол ихсэхэд хүрсэн.

Тиймээс бичил уурхайг зохицуулах, арга хэмжээ авах шаардлага бий болжээ (Шигтгээ 6). “Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр”, “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам” зэрэг бичиг баримтыг баталж тухайн салбарыг зохицуулах оролдлогууд хийгдэж эхэлжээ.

Шигтгээ 6: Бичил уурхайн эрхзүйн орчин, он дараалал

2008: “Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр” батлагдсан.

2008: Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам батлагдсан.

2008: Байгаль орчны сайдын “Эрдэс боловсруулалтад мөнгөн усыг хориглох тухай” 135 дугаар тушаал гарсан.

2010: Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан.

2010: Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам батлагдсан (308-р тогтоол).

2014: Ашигт малтмалын тухай хуульд бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулсан.

2014: “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-д бичил уурхайн асуудлыг тусгасан.

2015: Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцийг Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан.

2017: Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг шинэчлэн баталсан (151-р тогтоол).

2017: Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг баталсан.

2017: Бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийг баталсан.

2019: АБУ-аас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан.

2019: Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол баталсан.

2019: Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам батлагдсан.

2020: Үнэт метал, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох, бүртгэлийн журам батлагдсан.

2010 оны 7-р сарын 1-ний өдөр Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулах тухай заалтыг оруулснаар бичил уурхайг эрх зүйн хувьд албан ёсоор хүлээн зөвшөөрсөн. Ашигт малтмалын тухай хуульд бичил уурхайн үйл ажиллагааны онцлог, нөхцөл байдлыг харгалзан үзэж бичил уурхайчид тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын үйлдвэрлэлийн бус агуулгатай эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд, илрэл бүхий талбайд ашигт малтмал олборлох эрхийг баталгаажуулж өгсөн байна (Монгол Улсын Их Хурал, 2006).

Энэ хууль батлагдсаны дараа Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг баталж (308-р Журам), төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллага, бичил уурхайчдын эрх үүргийг албан ёсоор тодорхойлж өгсөн байна. Эдгээр хууль, журмаар бичил уурхайн нөхөрлөл, хоршоо байгуулагдах, орон нутгийн захиргаатай ашигт малтмал олборлох гэрээ байгуулахыг зөвшөөрсөн.

Энэ утгаараа Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, түүний дараа Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг баталсан нь анх удаа бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг нь албан ёсоор хүлээн зөвшөөрч, Монголын хувиараа ашигт малтмал олборлогчдыг зохион байгуулалтад оруулах, албажуулах замыг нээж өгсөн юм.

3.2 Бичил уурхайн зохицуулалтын бодлого, эрх зүйн орчин

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад бичил уурхайн салбар дараах хууль, тогтоомжийн хүрээнд зохицуулагдаж байна:

1. Эрдэнэсийн сангийн тухай хууль (1994)
2. Нөхөрлөлийн тухай хууль (1995)
3. Хоршооны тухай хууль (1998)
4. Газрын тухай хууль (2002)
5. Ашигт малтмалын тухай хууль (2006)
6. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль (2006)
7. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2014)
8. Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журам (2014)
9. Эрүүгийн хууль (2015)
10. Зөрчлийн тухай хууль (2017)
11. Алт-2 хөтөлбөр (2017)
12. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам (2017)
13. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал (2017)
14. Бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм (2017)
15. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол 355 (2019)
16. Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам (2019)

17. Алтны бичил уурхайгаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр (2019)
18. Үнэт метал, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох, бүртгэлийн журам (2020).

Дараах хэсэгт бичил уурхайн олборлолт, хүдэр боловсруулах үйл ажиллагаанд гол нөлөө үзүүлж буй эрх зүйн актуудыг онцолж байна.

3.2.1 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн үндсэн бичиг баримт нь Засгийн газрын 2017 оны 5-р сарын 24-ний өдрийн 151-р тогтоолоор батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам (Бичил уурхайн журам) юм. Энэхүү журам нь үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмалыг зүй зохистой олборлох журмыг тогтоож, байгаль орчныг хамгаалах, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж ядуурлыг бууруулах зорилготой. (Бичил уурхайн журам, 2017).

Уг журам нь ус, цацраг идэвхт элемент агуулсан хүдэр, газрын тос, байгалийн хий, түгээмэл тархацтайгаас бусад төрлийн ашигт малтмалыг бичил уурхайгаар олборлох үйл ажиллагаанд хамаарна.

3.2.2 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол #355

Сүүлийн дөрвөн жилийн хугацаанд ялангуяа алтны шороон ордоос олборлолт хийдэг уурхай орчмын байгаль орчин маш ихээр сүйтгэгдсэн. Дунд оврын уул уурхайн компаниуд Бичил уурхайн журманд заасан бичил уурхайд ашиглагдаж болох тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн хүчин чадлыг нэмэгдүүлснийг далимдуулж, бичил уурхай нэрийн дор ажилладаг боловч байгаль орчны нөхөн сэргээлт хийдэггүй гэсэн мэдээлэл байдаг (Бүлэг 4.2). Тиймээс байгаль орчныг хамгаалах, уул уурхайн сөрөг нөлөөллийг арилгах, нөхөн сэргээх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор Засгийн газар 2019 оны 9-р сарын 18-ны өдөр 355 дугаар тогтоолыг (355 дугаар тогтоол) батлан гаргасан.



Зураг 3-1. Ховд аймаг, алтны шороон орд (planetGOLD)

Бичил уурхайн журам одоо хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ч 355 дугаар тогтоолоор Бичил уурхайн журмыг шинэчлэн батлах хүртэл АМГТГ-аас бичил уурхайн талбайн дүгнэлт гаргах, орон нутгийн засаг захиргаанд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ шинээр байгуулахыг хориглосон. 355 дугаар тогтоолд бичил уурхайн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт

оруулах төслийг боловсруулж, 2019 оны дөрөвдүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ гэж заасан байдаг.

Бичил уурхайн журамд нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор УУХҮЯ-аар ахлуулсан ажлын хэсгийг байгуулсан бөгөөд planetGOLD Монгол төсөл ажлын хэсэгт ажиллаж байна.

3.2.3 Алтны бичил уурхайгаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр

Монгол Улс Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцыг 2015 онд соёрхон баталж, бичил уурхайгаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр боловсруулах зорилгоор НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс техникийн туслалцаа, санхүүгийн дэмжлэг авсан. Үндэсний хөтөлбөр нь Монгол Улс тус конвенцын хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэх, байгаль орчинд хал багатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Засгийн газрын амлалт, яам хоорондын уялдаа холбоо, олон талт оролцогч талуудын хамтын ажиллагаа, санхүүжилт шаардсан өргөн хүрээний, цогц олон талт хөтөлбөр юм.

Үндэсний хөтөлбөрийг 2019 оны 8-р сарын 14-ний өдөр Засгийн газрын 317-р тогтоолоор баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэр сайдын хамтарсан 2020 оны 4-р сарын 07-ны өдрийн А/232, А/66 дугаар тушаалаар баталсан байна.

Үндэсний хөтөлбөр нь гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагаанд ашиглаж байгаа хүний эрүүл мэнд, байгаль орчинд халтай хоцрогдсон технологийг бүрэн халах, мөнгөн усны хууль бус худалдаа, хэрэглээг таслан зогсоох замаар бичил уурхайгаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, мөнгөн усны ялгарлыг өнөөгийн түвшинтэй харьцуулахад 50-иас доошгүй хувиар бууруулах зорилготой.

Уг хөтөлбөрийн хоёр дахь зорилго бол гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагааг зохицуулах төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой болгож, салбар дундын зохицуулалт, талуудын оролцоо, хамтын ажиллагааг уялдуулж, чадавхыг дээшлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах явдал юм. Энэ зорилтын хүрээнд Засгийн газар бичил уурхайн талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгож, хариуцлагын механизмыг чангатгах, бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх салбар дундын зохицуулалтыг уялдуулж, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгохыг зорьж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд хангах, хэрэгжилтэд мониторинг хийх, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий салбар дундын зөвлөл 2019 оны 11 сарын 19-нд байгуулагдсан. Тус зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох гурван яам болон түүний харьяа агентлагууд, Монгол банк, ҮСХ, МХЕГ, ИНБ-ын төлөөлөл болон planetGOLD Монгол төсөл орж ажиллаж байна.

Мөн түүнчлэн, Засгийн газар АБУ-н талаарх одоо хэрэгжүүлж буй бодлого, хууль тогтоомжид үнэлгээ хийх, шинэчлэх ажлыг хийхээр зорьж байна. Хууль

тогтоомжийн үнэлгээ нь салбарын албажуулах үйл явцад саад болж буй хийдэл цоорхой, саад бэрхшээлийг илрүүлэх (газар эзэмших, ашигт малтмал ашиглах эрх, зохистой хөдөлмөрийн нөхцөл, алтны худалдааны зохицуулалт, дотоодын болон олон улсын зах зээлийн хүртээмж), илүү өргөн хүрээтэй бодлого, журам боловсруулахад тусгах асуудлыг хамарна.

Бичил уурхайгаар алт олборлогчдын өмнө тулгарч буй гол бэрхшээлүүдийн нэг нь ашигт малтмал олборлох газрын хүрэлцээ, тусгай зөвшөөрлийн асуудал юм. Иймд УУХҮЯ-д БУ-н зориулалтаар ашиглах алтны нөөцийг зохих ёсоор нь тогтоож, бүртгэж, цаг тухайд нь мэдээлэл авах боломжийг бүрдүүлэхийг үүрэг болгожээ (Монгол Улсын Засгийн газар, 2020 он).

3.3 Холбогдох төрийн байгууллагууд

Ашигт малтмалын тухай хууль болон Бичил уурхайн журам 151-д бүх түвшний төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлсон байдаг.

Улсын Их Хурал бол төрийн хууль тогтоох дээд байгууллага юм. Хууль батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулахаас гадна хяналт тавих эрхтэй. Иймээс УИХ бичил уурхайтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбогдуулан Засгийн газраас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тавьж, Засгийн газрын саналын дагуу эсвэл өөрсдийн санаачилгаар тодорхой нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлохыг хязгаарлах, хориглох боломжтой юм.

Засгийн газар нь гүйцэтгэх засаглалын хувьд бичил уурхай (Монгол Улсын Их Хурал, 2006 он) -тай холбоотой журмуудыг батлах, яам, агентлагуудаар дамжуулан хууль тогтоомжийн хэрэгжилт, биелэлтийг хангах үүрэгтэй.

1-р бүлэгт дурдсанчлан, **Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)** нь Монгол Улсын уул уурхайн салбарын асуудлыг хариуцдаг төрийн захиргааны төв байгууллага юм. Бичил уурхайтай холбоотой түүний үндсэн үүрэг нь:

1. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлоготой уялдуулан бичил уурхайн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, нэгдсэн удирдлагаар хангах;
2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа, олборлосон ашигт малтмалын баяжуулалт, борлуулалтын ил тод байдлыг хангах;
3. Бичил уурхайн үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий салбар дундын орон тооны бус зөвлөлийг байгуулан бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;
4. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавих;
5. Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардага, үйл ажиллагааны журмыг батлах;
6. Баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журмыг батлах

УУХҮЯ-ны Уурхайн бодлогын газар нь уул уурхайн салбарын бодлого, хэрэгжилт болон уул уурхайн үйлдвэрлэл болон алтны бичил уурхайн салбарыг хариуцдаг.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) нь байгаль орчны менежмент, байгаль хамгааллыг зохицуулах, бодлого боловсруулах үүрэг бүхий Засгийн газрын тэргүүлэх чиглэлийн яам юм. Тус яам нь аймаг, нийслэл бүрт Байгаль орчин, аялал жуулчлалын газар, хэлтсүүдтэй. Тус яам нь Монгол Улсын нэгдэн орсон байгаль орчны олон конвенц, түүний дотор Минаматагийн конвенцийн хэрэгжилтийг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг. Уул уурхай, ашигт малтмал баяуулах үйл ажиллагааны хувьд яам нь тэдгээрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах ажлын тайланг хянаж баталдаг.

Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) нь УУХҮЯ-ны дэргэдэх Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм. АМГТГ-ын бүтцэд 2007-2016 онд “Бичил уурхайн хэлтэс” ажиллаж байсан боловч Засгийн газрын бүтцийн өөрчлөлтөөр хэлтсийг татан буулгасан. Одоогийн байдлаар АМГТГ-т БУ хариуцсан гурван мэргэжилтэн ажиллаж байна. Хэдийгээр БУ-н нэгжид харьяалагддаггүй боловч тэд БУ-н тодорхой асуудлуудыг хариуцдаг:

- Бичил уурхайчдын техник, технологийг үнэлэх;
- Бичил уурхайн талбайн дүгнэлт гаргах;
- Бичил уурхайн газрын хэмжээ, хил хязгаарыг тогтоох;
- Бичил уурхай боловсруулах үйлдвэрүүдийн байршлыг бүртгэх.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) нь бүх салбарт бараг бүх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг юм. МХЕГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газар нь уул уурхайн үйлдвэрлэл, бичил уурхайн үйл ажиллагаанд хяналт тавьдаг бөгөөд Ашигт малтмалын тухай хууль, Бичил уурхайн журам, байгаль орчин, химийн бодисын зэрэг холбогдох бүх хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх үүрэгтэй. Тус агентлаг нь бүх аймаг, сумдад салбар эсвэл байцаагчтай. МХЕГ тэсэлгээний материалын хяналт шалгалтын бичиг баримтыг баталдаг бөгөөд энэ нь тэсэлгээний үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бичиг баримт юм.

Бичил уурхайн журамд зааснаар Аймаг, нийслэл, сумын ИТХ нь бичил уурхайн талаар авч хэрэгжүүлж байгаа Засаг даргын ажлын тайланг сонсож чиглэл, зөвлөмж өгөх үүрэгтэй.

Шигтгээ 7: Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж

Монгол Улс нь 21 аймаг, нийслэлд хуваагддаг. Аймаг нь засаг захиргааны нэгдүгээр түвшний нэгж бөгөөд аймаг бүрийг сумдад хуваадаг. Сум бол аймгийн засаг захиргааны хоёр дахь түвшний нэгж юм. Сум нь багт хуваагдана. Нийслэл Улаанбаатар хот бие даасан Засаг даргын ажлын албатай. Нийслэл нь есөн дүүрэгт хуваагдаж, дүүрэг нь хороонд хуваагддаг. 2019 оны байдлаар Монгол Улсад 330 сум, 1639 баг, есөн дүүрэг, 169 хороо байна (ҮСХ, 2019).

Аймаг, нийслэл, сумыг дөрвөн жил тутамд сонгогддог Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ) удирддаг. Нийслэл, аймаг, сум, дүүрэг, багийн Засаг дарга нарыг ИТХ-аас нэр дэвшүүлж дөрвөн жилийн хугацаатай томилдог.

Аймаг, нийслэлийн ИТХ нь сумын ИТХ-ын оролцоогүйгээр аймаг, нийслэлийн Засаг даргын бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авах боломжтой газрын талаар гаргасан саналыг хэлэлцэн шийдвэрлэдэг.

Бичил уурхайн журамд зааснаар аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд илүү өргөн хүрээний эрх, үүрэгтэй байна. Үүнд: бичил уурхайн үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, бүсчилсэн байдлаар хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах, бичил уурхайн дүгнэлт гаргуулах тухай сум, дүүргийн Засаг даргын хүсэлтийг АМГТГ-т хүргүүлэх; бичил уурхай эрхлэгч этгээдийн талаарх нэгдсэн судалгаа бүхий мэдээллийн сан бүрдүүлэлж төрийн захиргааны болон холбогдох бусад байгууллагад хүргүүлэх, бичил уурхайн үйл ажиллагааны талаар мэдээ, тайланг сум, дүүргээс авч нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх, бичил уурхайн нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавих ажлыг зохион байгуулах, бичил уурхайн осол, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд анхан шатны тусламжийн үйлчилгээ, авран туслах үйл ажиллагааг үзүүлэх зэрэг чиг үүрэг ордог.

Журамд зааснаар **сум, дүүргийн Засаг дарга** нь засаг төрийг төлөөлж буй төрийн гол албан тушаалтан (бичил уурхайчидтай шууд харьцах) юм. Тэдний үүрэг, эрхэд дараах зүйлс орно:

- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэдийг бүртгэх,
- Мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх;
- Бичил уурхай эрхлэгч этгээдтэй бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээг байгуулах;
- Гэрээний үүргээ биелүүлээгүй зөрчсөн тохиолдолд гэрээг цуцлах;
- Бичил уурхай эрхлэгч этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих;
- Нөхөн сэргээлт хийлгэж, нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээж авах;
- Бичил уурхайчдыг нийгмийн халамжийн үйлчилгээ болон нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах;
- Химийн хорт болон аюултай бодис, хориглосон химийн бодисын хэрэглээ, хадгалалтад хяналт тавих;

Дээрх төрийн байгууллагуудаас гадна, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо (ММБУНДХ) нь үндэсний түвшний байгууллага бөгөөд бичил уурхайн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг сайжруулах, бичил уурхайд хандах олон нийтийн эерэг хандлагыг бий болгох, хөдөлмөрийн аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх замаар бичил уурхайчдын тогтвортой, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах хэрэгцээ шаардлагаар 2013 онд үүсгэн байгуулагдсан. Тус холбоо нь албажуулалт, байгаль орчны нөхөн сэргээлт, чадавх бэхжүүлэх, бодлогын түвшинд нөлөөлөх, оролцох, нөөц бололцоог дайчлах, бичил уурхайчдын бизнес эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.

3.4 Бичил уурхайн албажуулалт

Албажуулалт нь "Бичил уурхайг албан ёсны эдийн засагтай уялдуулахыг зорьж буй үйл явц" бөгөөд энэ зорилгод "төсөл, хөтөлбөрүүд болон төрийн бодлого нь БУ-н үйл ажиллагааны олон талт асуудлуудыг нэгэн зэрэг, нэгдсэн байдлаар авч үзсэн тохиолдолд" хүрч болно (UNEP, 2012: 2). Албажуулалтын эхний чухал алхам бол БУ-гаар олборлолт явуулах, хүдэр баяжуулах үйл ажиллагааны зөвшөөрлийг баталгаажуулах явдал юм. Зохион байгуулалтын хэлбэрүүд, үйл ажиллагаа явуулах гол зөвшөөрлүүдийн талаар доор авч үзнэ.

3.4.1 Зохион байгуулалтын хэлбэрүүд

Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.23-т “бичил уурхай эрхлэх” гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг хэлнэ гэж заасан (УИХ, 2006: Хуудас 5).

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд бичил уурхай эрхлэх иргэнд тавигдах шаардлагыг дараах байдлаар тодорхойлжээ:

- 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн;
- Тухайн аймаг, нийслэлд оршин суугчаар бүртгүүлсэн;
- Нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүн(Шигтгээ 8);
- Нөхөрлөл, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүдийн тоо нь 9-өөс цөөнгүй байна.

Шигтгээ 8: Бичил уурхайн байгууллагын төрөл

Нөхөрлөл гэж хэд хэдэн этгээд ашиг олох зорилгоор эд хөрөнгөө нэгтгэн энэ хуульд заасан хэлбэрээр зохион байгуулагдаж тодорхой төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахаар хэлэлцэн тохирч байгуулсан хуулийн этгээдийг хэлнэ. (2-р зүйл, Нөхөрлөлийн тухай хууль)

Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг **Хоршоо** гэнэ. Нөхөрлөлийн хувьд хамтран ажиллах гэрээ нь үйл ажиллагаа явуулах үндэс болдог бол хоршооны хувьд хоршоо үүсгэн байгуулах дүрмээ баталснаар Улсын бүртгэлийн газар бүртгүүлэх үндэслэл бий болдог байна. (3-р зүйл, Хоршооны тухай хууль)

Бүртгэгдээгүй нөхөрлөл нь Иргэний хуулийн 481-р зүйлд заасны дагуу байгуулагддаг. Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн этгээд нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болох бөгөөд хуулийн этгээдийн эрхгүй байна. Бүртгэгдээгүй нөхөрлөлийн онцлог нь (Хоршоог төлөөлж байгаа гишүүд шиг) үйл ажиллагаанаас олсон орлого нь гишүүдийн дундын хөрөнгө байна.

Бичил уурхайн байгууллагын эдгээр төрлүүдээс бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалт нь бичил уурхайчдын үйл ажиллагааны хувьд харьцангуй хялбар зохицуулалт боловч зарим сул талууд байдаг. Тухайлбал, хуулийн этгээд шиг эрхээ хэрэгжүүлэх цар хүрээ байхгүй, цаашид өсөж, өргөжих боломж хязгаарлагдмал байна. Жишээлбэл, Бичил уурхайн журам нь зөвхөн бүртгэгдсэн нөхөрлөл, хоршоодод $3,500 \text{ см}^3$ хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий механизмыг ашиглахыг зөвшөөрдөг байна. (Бичил уурхайн журам).

Нөхөрлөл байгуулах бичиг баримт бүрдүүлэх нь хоршоо байгуулахаас хамаагүй хялбар байдаг. Нөхөрлөл, хоршоо хоёулаа тухайн нутаг дэвсгэртээ улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсний дараа хуулийн этгээдийн албан ёсны эрхтэй болдог. Бүртгэлгүй нөхөрлөлийн хувьд хуулийн этгээдийн эрхгүй тул заавал бүртгүүлэх шаардлагагүй юм.

3.4.2 Гол зөвшөөрлүүд

Газрын хүртээмж: Бичил уурхайчдын албан ёсны статусын хамгийн чухал баталгаа нь хууль ёсны дагуу бичил уурхай эрхлэх газартай болох явдал юм. Уурхайчид дээр дурдсан байгууллага, хуулийн этгээдийн гишүүн болсон ч олборлолт явуулах газартаа зөвшөөрөл аваагүй бол тэднийг албажсан буюу албан ёсны уурхайчин гэж үзэхгүй.

Юуны өмнө бичил уурхайн талбайн дүгнэлт гаргуулах хэрэгтэй. Бичил уурхайн журмын 2-р зүйлд бичил уурхай эрхлэх хүсэлтэй этгээд (ихэвчлэн бичил уурхайн байгууллага) батлагдсан маягтын дагуу сум, дүүргийн Засаг даргад өргөдөл гаргах ёстой гэж заасан байдаг. Сум, дүүргийн Засаг дарга аймгийн Засаг даргад "Газрын дүгнэлт" гаргах өргөдлийг АМГТГ-т хүргүүлдэг. АМГТГ-аас тухайн газар нутгийг шүүж үзээд одоо байгаа хүчин төгөлдөр ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл, тусгай хамгаалалттай газартай давхцахгүй бол тухайн газрыг бичил уурхайгаар ашиглах боломжтой гэсэн дүгнэлт (Талбайн дүгнэлт) гаргадаг.

АМГТГ-аас гаргасан Талбайн дүгнэлтийг үндэслэн аймаг/нийслэлийн ИТХ-аас уг хүсэлтийг хянаж, тухайн газрыг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд зориулж ашиглаж болох эсэхийг ИТХ-ын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэх үеэр шийдвэрлэнэ. Газар зохион байгуулалтын асуудал хэлэлцэх хурал жилд хоёр удаа болдог бөгөөд хурлаар тухайн газар нь төлөвлөгөөнд тусгахаар батлагдсан бол аймаг/нийслэлийн Засаг дарга нар нь сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэнэ.

Журмын 4-р зүйлд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох нэгж талбайн хэмжээ таван га-аас илүүгүй байхаар хязгаарлаж, тухайн жилд нэг сум, дүүргийн нутаг дэвсгэрт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн тоо 10-аас илүүгүй байна гэж журамлажээ. Энэ нь бичил уурхайн зориулалтаар жил бүр 50 га газрыг олгож болно гэсэн үг юм.

Ашигт малтмал олборлох гэрээ: ИТХ-ын сонгосон талбайд АМГТХЭГ талбайн дүгнэлт гаргасны дараа сум, дүүргийн Засаг дарга нар бичил уурхай эрхлэгч этгээдтэй ашигт малтмал олборлох гэрээ байгуулна. Бичил уурхайн журамд гэрээний хугацааг ашигт малтмалын нөөцийг бүрэн олборлож дуусах хүртэл хугацаагаар байгуулна гэж тодорхой заасан байдаг. Гэсэн хэдий ч бодит байдал дээр орон нутгийн засаг захиргаа ихэвчлэн гэрээг зөвхөн нэг жилийн хугацаагаар хязгаарладаг. Мөн Бичил уурхайн журам нь хэрэв тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн уурхайн талбай дээр бичил уурхайчдыг олборлолт явуулахыг зөвшөөрсөн тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон бичил уурхай эрхлэгч этгээд гурвалсан гэрээ байгуулсны үндсэн дээр бичил уурхайгаар ашигт малтмал олборлож болно гэж заасан байдаг. ИТХ нь жилд хоёр удаа хуралддаг тул бичил уурхайгаар ашиглах газрыг сонгох, гэрээ байгуулахтай холбоотой шийдвэрүүд удааширдаг байна. Мөн түүнчлэн, хэрэв уурхайчин тухайн аймгийн харьяат бол аймгийн засаг захиргаатай байгуулсан ашигт малтмал олборлох гэрээний дагуу аймгийн аль ч суманд бичил уурхай эрхэлж болох бөгөөд энэ нь тухайн сумдын уурхайчидтай зөрчилдөхөд хүргэж байна.

Байгаль орчны менежмент ба байгаль хамгаалал: Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар (БОАЖЯ & УУХҮЯ, 2017). батлагдсан Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу уурхайчид байгаль орчны нөхөн сэргээлтийн төлөвлөгөө батлах, нөхөн сэргээлтийн хөрөнгө босгох, олборлолтын талбайг нөхөн сэргээх үүрэгтэй. Аргачлал нь техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх заавар, нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө гаргах, тайлагнах, мониторинг хийх, нөхөн сэргээсэн талбайг хүлээн авах маягтуудыг багтаадаг.

3.5 Судалгааны бүс нутаг дахь албажуулалтын нөхцөл байдал

Судалгаанд хамрагдсан сумдын нутгийн захиргааны байгууллагууд бичил уурхай нь нутгийн оршин суугчдын орлогын гол эх үүсвэр гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Тэд, хэрэв бичил уурхайн журам нь тогтвортой, бичил уурхай эрхлэх газар хангалттай байвал нутгийн захиргаа нь байгаль орчин, нийгэм, аюулгүй ажиллагааны хувьд бичил уурхайчдыг илүү хариуцлагатай зохион байгуулах боломжтой гэсэн нийтлэг байр суурьтай байна. Хэрэв бичил уурхайчид албажсан бол холбогдох сургалтуудыг зохион байгуулах, хүрээлэн буй орчин, аюулгүй ажиллагааны хяналт тавихад илүү хялбар болно. Баянгол аймгийн Засаг даргын хэлснээр 355 дугаар тогтоолоос шалтгаалан сүүлийн 6-8 сарын хугацаанд орон нутгийн иргэдийн эдийн засгийн байдал хүндэрсэн. Говь-Алтай аймгийн Засаг дарга уг тогтоолын дагуу бичил уурхайн бүх үйл ажиллагааг зогсоохыг үүрэг болгосон боловч хууль бус олборлолт нэмэгдэж, байгаль орчинд сөргөөр нөлөөлж, цаашид нөхөн сэргээлтийн зардал өсөх сөрөг үр дагавар гарч байна.

Манай суманд 1000 гаруй бичил уурхайчид бий. АБУ нь орон нутагт ажлын байртай болох боломжийн нэг юм. Тиймээс бичил уурхайчид журмын дагуу үйл ажиллагаа явуулж, ХАБЭА-н аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж, Газрын дүгнэлт гаргуулсан тохиолдолд бид дэмжих болно. Одоогийн байдлаар шинэ гэрээ нэмж хийгдээгүй байгаа боловч гэрээтэй бичил уурхайчид албан ёсоор ажиллаж байна.

Ганцаарчилсан ярилцлага, төрийн байгууллагын ажилтан, эрэгтэй, Сэлэнгэ аймаг

3.5.1 Бичил уурхайн байгууллага

Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооноос өгсөн статистик мэдээллээр судалгааны таван бүс нутгийн уурхайчид бүртгэлтэй болон бүртгэлгүй нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан байна (Бүлэг 1.3-ийг үзнэ үү). Хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан бичил уурхайчид байхгүй. Учир нь нөхөрлөл байгуулах нь бичиг баримт бүрдүүлэлт, үйл явцын хувьд хоршоо байгуулахаас хялбар гэж үздэг. Нөхөрлөлүүд өөрсдийн дуу хоолойгоо хүргэх зорилгоор эвлэлдэн нэгдэж, өөрсдийн ТББ-уудыг байгуулсан. Судалгааны бүс нутагт бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дөрвөн ТББ ажилладаг.

Хүснэгт 3.5-1. Нөхөрлөлүүд болон гишүүдийн тоо (судалгааны бүс нутгаар)

№	Аймаг	Сум	Нөхөрлөлийн тоо	Гишүүдийн тоо
1	Говь-Алтай	Есөнбулаг	22	214
2	Сэлэнгэ	Баянгол	27	108
3		Мандал	32	189
4		Түнхэл	8	180

5	Ховд	Алтай	11	99
Нийт			100	790

3.5.2 Олборлолтын газрын хүртээмж ба орон нутагтай байгуулсан гэрээ

2020 оны 6 сарын байдлаар Мандал, Түнхэл, Алтайд ашигт малтмал олборлох хүчин төгөлдөр гэрээтэй зарим бичил уурхайн нөхөрлөлүүд олборлолтын үйл ажиллагаа эрхэлж байна. Гэвч 355-р тогтоолын хэрэгжилтийн хүрээнд АМГТГ-аас шинээр Газрын дүгнэлт гаргах, бичил уурхайн нөхөрлөл, хоршоодтой шинээр Ашигт малтмал олборлох гэрээ байгуулахыг зогсоосон, баяжуулах цехүүдийг албан ёсоор хаасан зэргээс үүдэн тодорхойгүй байдал үүсээд байгаа бөгөөд энэ нь хууль бус олборлолтыг нэмэгдүүлэх магадлалтай.

Түнхэлд бичил уурхайн байгууллага нь 10 гаруй жил албан бусаар олборлож байсан уурхайн талбайдаа 2019 онд сумын Засаг даргатай Ашигт малтмал олборлох гэрээ байгуулсан байна. Үүний үр дүнд бичил уурхайчид илүү зохион байгуулалттай болж, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрэм журмын хэрэгжилт сайжирч, байгаль орчны хариуцлагатай болж байна. Тиймээс бичил уурхайн үйл ажиллагааг хянах, мониторинг хийхэд нь илүү хялбар болсон.

Баянголд ашигт малтмал олборлох зөвшөөрөлтэй алтны үндсэн орд байхгүй. Бичил уурхайчдын он удаан жил олборлолт явуулж байсан “Нарт” нэртэй бичил уурхайн гол талбай нь Бороо Гоулд, Сэлэнгэ минералс компаниудын лицензтэй талбайд хамаардаг. Сумын Засаг дарга бичил уурхайн талбайн асуудлыг шийдвэрлэхээр АМГТГ-т албан ёсоор Газрын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргасан боловч 355 дугаар тогтоол гарсан тул энэ ажил зогссон байна.

Одоогийн байдлаар Говь-Алтай аймгийн Алтай суманд талбайн дүгнэлт гарсан бичил уурхайн нэг нөхөрлөл байна. Хоёр жилийн өмнө Есөнбулагийн бичил уурхайчид Алтайн Засаг даргатай гэрээ байгуулж, тус газарт олборлолт явуулж байжээ. Гэсэн хэдий ч орон нутгийн уул уурхай, байгаль орчны мэргэжилтнүүд Алтай дахь “Замын ам” нэртэй талбайн геологийн нөхцөл байдал хүндэрсэн тул 2019 оны 3-р сард үйл ажиллагааг нь зогсоож, тэсэлгээний ажил гүйцэтгэх зөвшөөрөл олгох боломжгүй гэсэн дүгнэлт гаргасан байна. Мөн түүнчлэн тухайн газар нь газар хөдлөлтийн бүсэд байрладаг тул өндөр уул уурхайн үйл ажиллагаанд ихээхэн эрсдэл учруулж байна. Тус талбайн зөвшөөрөл хүчин төгөлдөр хэвээр байгаа бөгөөд олборлолтын нөхцөл хүнд байгаа тул уурхайн босоо амуудыг хааж, ихэнх уурхайчид аймгийн төв Есөнбулаг руу буцаж иржээ.

Монгол Улсад 2020 оны 10-р сарын байдлаар АМГТГ-аас 1,063.7 га газарт 292 бичил уурхайн талбайн дүгнэлт гаргажээ (АМГТГ, 2020).

Хүснэгт 3.5-2-т судалгааны бүс нутгийн хэмжээнд бичил уурхайн зориулалтаар дүгнэлт гарсан талбайн хэмжээ (шороон ордыг оролцуулан аймаг сумдаар), нөхөрлөлд бүртгэгдсэн бичил уурхайчдын тоо (хүйсээр)-г харуулав. АМГТГ-аас ирүүлсэн статистик мэдээнээс харахад 2019 онд 150 гишүүнтэй 17 нөхөрлөлд бичил уурхайн зориулалтаар 90.98 га газрыг олгосон байна. Үүнээс 9 нөхөрлөл үндсэн орд, 8 нөхөрлөл нь шороон ордод үйл ажиллагаа явуулж байжээ.


Хүснэгт 3.5-2. Уурхайн талбайн мэдээлэл (судалгааны бүс нутгаар (АМГТГ, 2019))

№	Аймаг	Сум	Уурхайн талбайн нэр	Уурхайн талбайн хэмжээ (Га)	Уурхайчдын тоо	Жендэр	
						Эрэгтэй	Эмэгтэй
1	Говь-Алтай	Алтай	Замын ам	5	12	10	2
2	Говь-Алтай	Алтай	Замын ам	5	12	10	2
3	Сэлэнгэ	Мандал	Ноёт	5	9	7	2
4	Сэлэнгэ	Мандал	Ноёт	5	12	9	3
5	Сэлэнгэ	Мандал	Ноёт	5	9	4	5
6	Сэлэнгэ	Мандал	Ноёт	0.5	11	10	1
7	Сэлэнгэ	Мандал	Ноёт	0.5	14	13	1
8	Сэлэнгэ	Мандал	Ноёт	0.5	10	6	4
9	Сэлэнгэ	Мандал	Ноёт	4.96	6	6	
10	Сэлэнгэ	Баянгол	Буян	4.96	9	6	3
11	Сэлэнгэ	Баянгол	Урт булаг	4.61	10	7	3
12	Сэлэнгэ	Баянгол	Талбай 1	4.37	9	6	3
13	Сэлэнгэ	Баянгол	Наран	4.62	10		
14	Сэлэнгэ	Баянгол	Бага мұхар	4.96	9	8	1
15	Ховд	Алтай	Майхан-1	0.23	9	7	2
16	Ховд	Алтай	Майхан-2	0.81	9	7	2
17	Ховд	Алтай	Улаан богоч	4.96	9	6	3


Судалгаанаас үзэхэд бичил уурхайн байгууллагууд болон нөхөрлөлүүдийн гишүүдийн 65% нь талбайн дүгнэлт гарсан зөвшөөрөлтэй талбайтай байна (Зураг 3-2). Зарим тохиолдолд орон нутгийн бүртгэлгүй болон бүртгэлтэй нөхөрлөлүүд нь талбайн дүгнэлтэй, дүгнэлтгүй эсэхээс үл хамааран орон нутагтай гэрээ байгуулдаг. Орон нутгийн удирдлагууд уурхайчдын байгууллагатай харилцан тохиролцож, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох боломж олгодог байна. Бичил уурхайн журмын дагуу бичил уурхай эрхлэгч этгээд нь уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон орон нутгийн засаг захиргаатай гурвалсан гэрээ байгуулж болно. Судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын 59% нь орон нутагтай ашигт малтмал олборлох гэрээ байгуулж ажилладаг гэсэн бөгөөд БУ ТББ (82%) ба хууль бусаар ашигт малтмал олборлогчид (13%) харьцангуй ялгаатай хариулт өгчээ (Зураг 3-3).

Судалгааны бүс нутгуудыг харахад Баянголын бичил уурхайчдын 28% нь АМГТГ-аас гарсан талбайн дүгнэлтэй, нийт уурхайчдын 33% нь орон нутгийн засаг захиргаатай бичил уурхайн газрын гэрээ байгуулсан гэж хариулсан боловч АМГТГ-аас алтны үндсэн ордын талбайд дүгнэлт гараагүй байна. Асуултанд “тийм” гэж хариулсан уурхайчид шороон ордод ажилладаг эсвэл хуулийн хариуцлага хүлээхээс эмээж “тийм” гэж хариулсан байж магадгүй юм. Мандалд нөхөрлөлийн гишүүдийн 72% нь талбайн дүгнэлтэй, нийт судалгаанд хамрагдагсдын 63% нь газрын гэрээтэй гэж хариулжээ. Гэсэн хэдий ч судалгаа хийх үед бичил уурхайн нөхөрлөлүүд орон нутгийн засаг захиргаатай байгуулсан гэрээгээ сунгах боломжгүй байв. Түнхэл нь албан ёсны гэрээтэй гэж мэдээлсэн хамгийн олон уурхайчинтай. Нийт нөхөрлөлийн гишүүдийн 76% нь талбайн дүгнэлтэй гэж хариулсан бөгөөд нийт оролцогчдын 88% нь ашигт малтмал олборлох гэрээтэй гэж хариулжээ. Есөнбулагт нийт түншлэлийн гишүүдийн 66% нь газрын дүгнэлтэй гэж хариулсан бөгөөд нийт оролцогчдын 79% нь газрын гэрээтэй гэсэн байна. Говь-Алтай аймгийн засаг захиргааны мэдээлснээр Алтай суманд үндсэн ордоос алтны хүдэр олборлодог талбайд АМГТГ-аас талбайн дүгнэлт гарсан боловч бичил уурхайн үйл ажиллагаа зогссон


байна. Говь-Алтай аймгийн Алтай суманд судалгаанд оролцсон нөхөрлөлийн гишүүдийн 53% нь талбайн дүгнэлттэй, 42% нь ашигт малтмал олборлох гэрээ байгуулсан гэж мэдээлсэн. Ерөнхийдөө уурхайчид хуулийн хариуцлага хүлээхээс эмээж хууль ёсны гэрээ байгуулсан эсэх талаар хэтрүүлэн мэдээлсэн байх боломжтой.



Зураг 3-2. Газрын дүгнэлттэй нөхөрлөл, гишүүдийн тоо (судалгааны бүс нутгаар)




Зураг 3-3. Олборлолтын гэрээ хийсэн байгууллагаас судалгаанд оролцогчид (судалгааны бүс нутгаар)




Зураг 3-4. Олборлолтын гэрээ хийсэн байгууллагаас судалгаанд оролцогчид (зохион байгуулалтын хэлбэрээр)

3.5.3 Уул уурхайтай холбоотой зөвшөөрөл авахад тулгарч буй бэрхшээл

Уул уурхайтай холбоотой зөвшөөрөл, гэрээ байгуулахад ямар нэг хүндрэл бэрхшээл тулгарч байгаа эсэхийг асуухад судалгаанд оролцогчдын 37% нь тийм гэж хариулжээ (Зураг 3-5). Есөнбулаг (56%), Мандал (47%) зэрэг сумдын олон бичил уурхайчид зөвшөөрөл авахад бэрхшээлтэй тулгарсан гэжээ. Эрэгтэй уурхайчдаас (34%) илүү олон эмэгтэй уурхайчид (46%) бэрхшээл тулгардаг талаар мэдээлсэн байв. Зохион байгуулалтын хэлбэрээр нь авч үзвэл зохион байгуулалтад орсон уурхайчид зөвшөөрөл авахтай холбоотой асуудлуудыг илүү их мэдээлж байсан нь хууль бус олборлогчид талбайн дүгнэлт гаргуулах, өргөдөл гаргах зэрэг албан ёсны үйл явцад оролцдоггүйтэй холбоотой байж болох юм.



Зураг 3-5. Бичил уурхайтай холбоотой зөвшөөрөл авахад хүндрэлтэй тулгарч байсан судалгаанд оролцогчид (судалгааны бүс нутгаар)



Зураг 3-6. Бичил уурхайтай холбоотой зөвшөөрөл авахад хүндрэлтэй тулгарч байсан судалгаанд оролцогчид (зохион байгуулалтын хэлбэрээр)

Судалгаанд оролцогчдын 32% нь талбайн дүгнэлт гаргуулах, ашигт малтмал олборлох гэрээ байгуулахад бэрхшээлтэй байдаг гэж хариулсан бол 9% нь байнга хөөж туудаг нь хэцүү байдаг, 8% нь шударга бус, олон төвөгтэй дүрэм журам болон бичиг баримт бүрдүүлэхтэй холбоотой асуудал гардаг гэж мэдээлсэн (Хүснэгт 3.5-3).

Хүснэгт 3.5-3. Уурхайн холбогдолтой зөвшөөрөл авах, гэрээ байгуулахад тулгарч байсан бэрхшээл, сорилтууд (судалгааны бүс нутгаар)

	Баянгол (n=20)	Мандал (n=53)	Түнхэл (n=13)	Есөнбулаг (n=35)	Алтай (n=16)	Нийт (n=137)
Олон дүрэм, журамтай	5%	2%	8%	3%	0%	3%
Шударга биш	15%	11%	0%	3%	6%	8%
Хүнд сурталтай	0%	6%	0%	14%	0%	6%
Мэдлэг мэдээлэл хомс	5%	0%	0%	0%	19%	3%
Байнга хөөж туудаг	15%	2%	8%	20%	0%	9%
Цагдаа	0%	2%	8%	0%	0%	1%
Гэрээ, зөвшөөрлийн асуудал	20%	38%	15%	37%	31%	32%
Газрын асуудал	0%	4%	15%	11%	6%	7%
Бичиг баримт бүрдүүлэх	5%	4%	31%	3%	19%	8%
Шалгалт, торгууль	5%	2%	0%	0%	0%	1%
Сонгууль	0%	4%	0%	0%	0%	1%
Нөхөн сэргээлт	0%	2%	8%	0%	0%	1%
Тэсэлгээ	0%	2%	0%	3%	0%	1%
Санхүү	5%	2%	0%	0%	0%	1%
Нөхөрлөл байгуулах	0%	6%	0%	0%	0%	2%
Бусад	25%	15%	8%	6%	19%	14%

Санал асуулга болон ганцаарчилсан ярилцлагын үр дүнг харвал уурхайчдын хувьд ашигт малтмалын гэрээ, зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдаг гэдгийг нотолж байна. Нөхөрлөл байгуулах нь бараг бүх газарт асуудалгүй бололтой. Сонирхолтой нь, судалгаанд оролцогчид санхүүжилт, тэсэлгээний зөвшөөрөл, байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой бэрхшээлийг нэрлээгүй байна.

3.6 Дүгнэлт

Иргэд бичил уурхайгаар алт олборлож байгаагийн гол шалтгаан нь хөдөө орон нутагт байнгын ажлын байр байхгүй, цалин хөлс хангалтгүй, малаа алдсан,

нэмэлт орлого олохыг хүсч байгаатай холбоотой юм. Судалгаанд оролцогчдын 50 гаруй хувь нь дүгнэлт гарсан талбайд Засаг даргатай гэрээ байгуулан ажилладаг гэж хариулсан боловч ашигт малтмал олборлох зөвшөөрөл авах нь тэдний хувьд хамгийн хэцүү асуудал хэвээр байна.

Бичил уурхайн журамд заасан ашиглаж болох тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн хүчин чадлыг (3,500 см³) буруугаар ашиглаж дунд оврын уул уурхайн компаниуд татвар, байгаль орчны хариуцлагаас зайлсхийхийн тулд бичил уурхай нэрийн дор үйл ажиллагаа явуулж байв. Энэ нь бичил уурхайн нэр хүндийг улам бүр унагах, улмаар хууль бус олборлолтыг таслан зогсоох, байгаль орчны доройтлыг бууруулах талаар арга хэмжээ авах тухай 355 дугаар тогтоол батлагдахад хүргэсэн. Энэхүү тогтоол нь салбарыг албажуулах үйл явцыг түр зогсоож, бичил уурхайгаар алт олборлогчид газар хүсэх, гэрээгээ сунгах боломжгүй болгосон байна. Бичил уурхайн журамд нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор УУХҮЯ-аар удирдуулсан ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд энэхүү судалгааг хийж байх үед нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

Бичил уурхайчдыг албан ёсны, албан бус, хууль бус гэж ангилж болох боловч албан ёсны уурхайчдын албан ёсоор ажиллах боломж нь (талбайн дүгнэлт/эсвэл орон нутгийн гэрээтэй эсэх) олборлолтын газрын хүртээмжээс ихээхэн хамаарч байгаа бөгөөд зөвхөн албан ёсны зөвшөөрөлтэй газартай, газаргүй гэж ангилах боломжтой байна. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээг ихэвчлэн нэг жилийн хугацаатай хийдэг бөгөөд байгаль орчны нөхөн сэргээлтийн гүйцэтгэлд үндэслэн сунгадаг боловч гэрээг хойшлуулах, сунгахгүй байх тохиолдол их гардаг байдаг. Гэрээ хийгээгүй үед гишүүд албан бус эсвэл хууль бусаар өөр газар үргэлжлүүлэн ажиллах гэх мэт тогтворгүй байдал их байдаг.

Түнхэлийн жишээ албан ёсны зөвшөөрөлтэй бичил уурхайд хяналт тавьж, холбогдох журмын хэрэгжилтийг хангахад илүү хялбар байдаг гэдгийг харуулж байна. Үүний эсрэгээр Баянголын Нарт нэртэй олборлолтын талбайд хүмүүс 1997 оноос хойш олборлож байсан боловч одоог хүртэл албажаагүй байна. Энэ нь хөдөлмөрийн аюулгүй байдлын хэрэгжилт, газрын нөхөн сэргээлт, байгаль орчны доройтол, мөнгөн усны далд хэрэглээг хянахад бэрхшээлтэй болгож байна.

Бичил уурхайн салбарыг албажуулах үйл явц удаашралтай, тууштай биш байгаагаас бичил уурхайчдад өнөөгийн шаардлагыг хангахад бэрхшээлтэй байдаг. Энэ нь үйл ажиллагаагаа албан ёсны байлгах хүсэлтэй бичил уурхайчдын урам зоригийг мохоож байна.

Судалгааны тайланд бичил уурхайчид үйл ажиллагаагаа албажуулах алхам хийхэд тулгарч буй бэрхшээлүүд, үр дагаврыг илүүтэй гаргаж харуулж байгаа юм. Монгол Улсын Засгийн газар Минаматагийн конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд эдгээр асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна.

4. Уул уурхайн практик үйл ажиллагаа

4.1 Хүдэр олборлолт ба баяжуулалт

4.1.1 Уул уурхайн талаарх ерөнхий мэдээлэл

Уул уурхай нь газар, түүний хэвлийгээс ашигт эрдэс баялгийг гаргаж авах үйл явц юм. Ерөнхийдөө аливаа уул уурхайн мөчлөг нь эрэл хайгуулын ажил, уурхайн төлөвлөлт, олборлолтын үйл ажиллагаа, уурхайг хаах, нөхөн сэргээх, хүлээлгэж өгөх гэсэн хэд хэдэн үе шатаас бүрдэнэ. Энэхүү уул уурхайн мөчлөгийн туршид уурхайчид хүдрийн биетийн геологийн хязгаарлалтыг судлах, хүдэр олборлох эдийн засгийн үр ашигтай байдлыг тодорхойлохын зэрэгцээ эрдэс баяжуулалтын практикийг аюулгүй, тогтвортой удаан хугацаанд барих чиглэлээр хамтран ажилладаг. Том уул уурхай болон бичил уурхайн үйл ажиллагаа нь техникийн хувьд дараах байдлаар ялгаатай байна. Үүнд:

1. Үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тоног төхөөрөмж, машин механизмын төрөл, хүчин чадал (ачааны машин, гар багаж тоног төхөөрөмж гэх мэт) нь хэр их гар ажиллагаа оролцдог гэдгийг тодорхойлдог. Жишээлбэл, Монгол Улсад бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд бичил уурхай эрхлэгч этгээдийн ашиглах тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн хүчин чадал нь 3500 смЗ-аас ихгүй байх ёстой гэж заасан байдаг.
2. Үйл ажиллагааны цар хүрээ нь олборлосон материалын хэмжээ буюу уурхайн хүчин чадлаар тодорхойлогддог;
3. Хүдрийн алтны агуулга (захын агуулга). Том уурхайд алтны агуулга нь ихэвчлэн 10 г/т-аас бага байдаг бол бичил уурхайн олборлож буй алтны агуулга 100 г/т-аас дээш байдаг нь маш өр бусын юм (АБУЗ, 2019 он)
4. ХАБЭА-н талаарх мэдлэг, мэдээлэл болон дагаж мөрдөх зэрэг болно.

Монголд Улсад алтны бичил уурхай нь шороон (аллювал) болон үндсэн (чулуун) ордод олборлолт явуулдаг (Шигтгээ 9-ийг үзнэ үү). Дараахь хэсгүүдэд ашигт малтмалын ордын энэ хоёр төрөлтэй холбоотой баяжуулалтын техник, технологийг авч үзнэ. Сүүлийн жилүүдэд Монголын бичил уурхайчид нөөц нь шавхагдаж буй шороон ордоос харьцангуй их алт олборлох боломжтой өндөр агуулгатай үндсэн орд руу шилжиж байна.

Шигтгээ 9: Алтны ордын төрөл

Аллювал/шороон орд: Аллювал буюу алтны шороон орд нь үндсэн ордын чулуулаг нар салхи, бороо, усны нөлөөгөөр элэгдэн, зөөгдөж бий болсон нягтраагүй материалд агуулагдах чөлөөт алтны мөхлөг, тоосонцор эсвэл цул алтны бөөгнөрлийн үе давхарга байдалтай хуримтлал юм. Шороон ордын алтыг тунамал чулуулгаас гар аргаар эсвэл механикжсан аргаар угаан ялгаж, баяжуулж авдаг бөгөөд маш их хэмжээний ус ашигладаг (Муфф, 2012). Шороон ордын олборлолт нь өмнө нь олборлолт хийгдэж байгаагүй талбайд эсвэл хуучин олборлолт хийгдэж байгаад орхигдсон талбайн хаягдал бүхий талбайд хоёуланд нь явагдаж болно. Монгол Улсад алтны шороон ордод мөнгөн ус ашигладаггүй боловч алт угаах процесст маш их хэмжээний ус зарцуулдаг тул машин механизм ашигладаг бусад үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай адил усны

системийг бохирдуулж болзошгүй тул байгаль орчинд мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлдэг юм. Өөр нэг мэдэгдэхүйц нөлөөлөл бол голын ландшафт-д хүнд машин механизмаар ухахад учирч болзошгүй хохирол юм. Шороон ордын "чөлөөт алт" нь ихэвчлэн том ширхэглэлтэй аль хэдийн суларсан байдаг тул шороон алтыг ялгаж авахад энгийн гравитацийн (хүндийн хүчний) аргыг ашигладаг.

Алтны үндсэн/чулуун орд: Геологийн хувьсал өөрчлөлтийн явцад чулуулагт агуулагдаж байгаа алт бусад төрлийн эрдэс чулуулагтай нэгдэж (скарн), супергенийн баяжмал, алтны судлын илэрцэд тархаж үндсэн буюу чулуун ордууд үүсдэг. Алтны үндсэн ордын ашиглалт нь ихэвчлэн алтны эрдэсжилт агуулсан ил судлын (гарш) илэрцийг олж тогтоосноосноор эхэлдэг. Цаашид хайгуулын ажил эхлэх бөгөөд хэрэв хүдэр олборлолт эдийн засгийн ашигтай гэж үзвэл алтны гол судлын дагуу босоо ам, хонгилын системийг барина. Бичил уурхайчид хүдэр олборлохдоо голчлон гар багаж (жоотуу, лоом, хүрз) ба цахилгаан багаж (цахилгаан алх, дамарт өргүүр) ашигладаг. Дараа нь шуудайлж алт баяжуулах цех рүү тээвэрлэдэг.

4.1.2 Судалгааны бүс нутаг дахь хүдэр олборлолт

Энэ хэсэгт судалгааны бүс нутагт дахь олборлолтын талбайн төлөв байдал, уурхайчдын ажиллах хэлбэр, зохион байгуулалтын бүтэц, олборлолтын нийтлэг багаж хэрэгсэл, туршлага, олборлосон хүдрийн мэдээлэл, хүдэр олборлоход тулгарч буй бэрхшээлүүдийн талаар авч үзнэ.

Олборлолтын талбайн төлөв байдал

Судалгааны бүс нутгийн хэмжээнд далд уурхай зонхилж байна. Алтны үндсэн ордын бичил уурхайн далд олборлолт нь хонгил-галерейн системээс бүрдэх бөгөөд уг далд уурхайн малталтыг байрлалаар нь босоо, хэвтээ ам гэж ялгах ба үүнийг босоо цооног, хэвтээ хонгил гэж нэрлэж болно. Хэвтээ хонгилд нь хөдөлмөр зарцуулалт бага байдаг бөгөөд аюул осол багатай байдаг. Судалгаанд хамрагдсан таван сумаас Мандал, Түнхэлд хоёр далд уурхайд хэвтээ малталт (хэвтээ хонгил) хийсэн, бусад газруудын далд уурхайд босоо малталт (цооног) хийжээ. Бичил уурхайчид босоо малталт хийгээд өндөр агуулгатай алтны судлыг дагаж хэвтээ малталт хийдэг байна. Алтны гол судлыг тогтоосны дараа уурхайчид босоо малтмалтаар цооног ухаж, эргэн тойрны хоосон уулын чулуулгийг тойруулан хамгийн өндөр агуулгатай хүдрийг сорчлон чиглүүлж хэвтээ малталтаар хонгил үүсгэж олборлолт хийдэг байна. Үүгээрээ уурхайн ашигт нөлөөлөх гол хүчин зүйл болох металл авалт өндөртэй техник технологийн сонголт багатай том уурхайн үйл ажиллагаанаас ялгаатай байна. Гол судал нарийсч эхлэхэд уурхайчид дахин судал хайж өөр чиглэлд хонгил ухах шаардлагатай болдог байна. Ийм учраас далд уурхайн босоо ам нь түүнээс салбарласан хэвтээ малталтын хонгилууд болон дэд түвшингээс бүрдэнэ.

Хүснэгт 4.1-1-т босоо амны тоо ба босоо амны хэмжээсийг судалгааны талбай тус бүрт харуулсан болно. Судалгаанд хамрагдсан алтны БУ-н талбайнуудаас Баянгол суманд уурхайчдын олборлолт явуулдаг босоо цооногийн гүн хамгийн гүн (200 м) бөгөөд энэ нь уул уурхайн том компанийн орхигдсон босоо ам юм. Гэсэн хэдий ч бичил уурхайчдын ухаж чадсан хамгийн гүн босоо ам нь 80 метрт ойрхон байна. Түнхэл тосгонд бичил уурхайчдын олборлолт явуулдаг хэвтээ хонгил хамгийн урт буюу 85 м хүрсэн байна.


Хүснэгт 4.1-1. Уурхайн амны байрлал ба төрөл

Уурхайн амны байрлал ба төрөл	Уурхайн амны тоо	Босоо цооногийн гүн, хэвтээ хонгилын урт (метр)	Амны диаметр (метр)
Баянгол, босоо цооног	5	80 (БУ), 200 (ТУУ)	1.0-1.5
Мандал, босоо цооног	6	25-30	1.0-1.5
Мандал, хэвтээ хонгил	1	80	2.0-2.5
Түнхэл, босоо цооног	16	65	1.5-1.5
Түнхэл, хэвтээ хонгил	1	85	2.0-2.5
Алтай, ГА, босоо цооног (Есөнбулагийн уурхайчид)	20	5	1.0
Алтай, ил уурхай	1	10	10*10

Уурхайчдын ажиллах хэлбэр, зохион байгуулалтын бүтэц

Уурхайн талбай дээр ажилладаг горимыг судалж үзэхэд судалгаанд оролцогчдын 45% (165 уурхайчин) ээлжээр ажилладаг гэж хариулсан бол 55% (206 уурхайчин) ээлжээр ажилладаггүй, гэхдээ шаардлагатай тохиолдолд ажилладаг гэж хариулжээ. Бүс нутаг бүрт судалгаанд хамрагдагсдын ээлжээр ажилладаггүй уурхайчдын эзлэх хувь өндөр байгаа нь уурхайн үйл ажиллагаа албажаагүйтэй холбоотой байж болох юм.

“Нарт” АБУ-н талбайд уурхайчид илүү олон удаа ээлж солигдон ажилладаг байсан нь албан бус тээрмүүд олборлолтын талбайн ойролцоо байрладаг мөн тээрмийн хүчин чадлаас хамаардаг байна. Хамгийн гол нь албан бус уурхайчид албан бус байдлаасаа болж олборлосон хүдрээ хураалгах, хэрэгт татагдахаас эмээж алт олборлох үйл ажиллагаагаа яаравчлах шаардлагатай гэж үздэг байж магадгүй юм. Доорх зурагт судалгааны бүс нутгуудын ажлын ээлжийн мэдээллийг харуулав.




Зураг 4-1. Уурхайд ажиллах нэг ээлжийн хугацаа (судалгааны бүс нутгаар (n=165))

Бид ээлжээр ажилладаг ба нэг ээлж 7 хоног орчим үргэлжилдэг. Өглөө бид олборлолтын ажлаа эхлэхдээ аюулгүй ажиллагааны дүрэмт хувцас өмсөж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, аюулгүй ажиллагааны дэвтэрт гарын үсэг зурж, дараа нь олборлолтын талбай, босоо амыг шалгана. Манай ээлжинд 5-аас 7 хүн бригад байдлаар ажилладаг: 3-4 хүн газар доор олборлолт хийдэг, нэг нь тогооч, нэг хүн дамарт өргүүр дээр ажилладаг. Бид өглөө 3-4 цаг ажилладаг, 1-2 цаг амарч, үдээс хойш 3-4 цаг ажилладаг.

Ганцаарчилсан ярилцлага, нөхөрлөлийн гишүүн, Сэлэнгэ аймаг


Олборлолтын нийтлэг багаж хэрэгсэл, туршлага

Алтны хүдэр олборлох ажлыг үндсэндээ гараар болон уул уурхайн механикжсан багаж хэрэгсэл ашиглаж гүйцэтгэдэг. Судалгааны үр дүнгээс үзэхэд хамгийн өргөн хэрэглэгддэг багаж хэрэгсэл бол цахилгаан алх, дамарт өргүүр, лоом юм. Экскаватор, шанагт түрэгч, зөөвөрлөх машин зэрэг хүнд даацын машин механизмыг бичил уурхайн журамд заасан хөдөлгүүрийн зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаарлалтаас шалтгаалж өргөн ашигладаггүй байна.



Зураг 4-2. Судалгаанд оролцогчдын ашигладаг багаж, техник, тоног төхөөрөмж (n=371)

Үндсэн ордын босоо амны гүн ихсэх тусам хүдрийн чулуулгийн хатуулаг нэмэгддэг учраас ихэнхдээ тэсэлгээ хийж чулуулгийг сулруулах шаардлагатай болдог. Хэрэв зөв гүйцэтгэсэн бол тэсэлгээ нь хүдрийг гар аргаар авахаас илүү хурдан гаргаж авах боломжийг олгодог. Гэхдээ тэсэлгээний ажил нь зөвхөн өндөр өртөгтэй төдийгүй мэргэжлийн ур чадвартай тусгай зөвшөөрөлтэй компаниудаар хийлгэх ёстой. Тиймээс ихэнх бичил уурхайчид хэдийгээр тэсэлгээ хийлгэх шаардлагатай байгаа ч тэсэлгээний ажил хийлгэж чадахгүй байна. Хүдрийг малтаж аваад шуудай/хувинд хийж гар эсвэл цахилгаан дамарт өргүүрээр бэлтгэсэн хүдрийг татаж босоо амнаас гаргаж авдаг. Судалгааны бүх талбай дээр шуудайтай хүдрийн дундаж жин 50-100 кг орчим байна. Зураг 4-3-т задаргаа харуулсан болно.



Зураг 4-3. Нэг шуудай хүдрийн дундаж жин (n=371)

Үндсэн ордоос алтны хүдэр олборлох ажиллагаа нь газрын доор явагддаг тул гадны нөлөөнөөс, ялангуяа Монгол орны хатуу ширүүн өвлийн хүйтнээс нөлөө бага байдаг тул жилийн турш явагдах боломжтой. Гэсэн хэдий ч бичил уурхайчид мал маллах, газар тариалан эрхлэх гэх мэт орлогын өөр эх үүсвэр олохоос шалтгаалан жилд ердөө 7-9 сарын хугацаагаар голчлон 4-р сараас 11-р сар хүртэл ажилладаг (Бүлэг 6.2).

Хүдэр олборлолтын хэмжээ

Хүснэгт 4.1-2-т үзүүлсний дагуу нэг нөхөрлөл өдөрт 120-370 кг, дунджаар 250 кг/хоногт хүдэр олборлодог. Жилд дунджаар 121 хоног буюу ойролцоогоор дөрвөн сарыг уурхайн талбайд хүдэр олборлоход зарцуулдаг байна. Жилийн үлдсэн 3-4 сарыг хүдэр тээвэрлэх, баяжуулах, алтаа худалдах, амрахад зарцуулдаг. Хамгийн өндөр олборлолт хийдэг Мандал сум жилд 580т хүдэр олборлодог байна. "Шижир хишиг" нөхөрлөл хэвтээ хонгилд тэсэлгээний ажил гүйцэтгүүлсний үр дүнд ийм хэмжээний хүдэр олборложээ. Хамгийн бага хэмжээтэй олборлолт хийсэн газар нь Алтай бөгөөд жилд 71 тн олборлолт хийсэн байна.

Хүснэгт 4.1-2. Хүдэр олборлолтын жилийн дундаж хэмжээ (судалгааны бүс нутгаар)

Байршил	Нөхөрлөлийн тоо	Өдрийн дундаж олборлолтын хэмжээ, нөхөрлөлөөр (кг/өдөрт)	Өдрийн дундаж олборлолтын хэмжээ, бүсээр (т/өдөрт)	Ажлын өдөр (Өдөр/жил)	Жилийн дундаж олборлолтын хэмжээ (т/жил)
Баянгол	10	237	2.37	124	294
Мандал	16	283	4.53	128	580
Түнхэл	14	225	3.15	142	447
Есөнбулаг	10	120	1.2	115	138
Алтай	2	370	0.74	96	71
Дундаж	-	247	2.4	121	306

Жилийн үйлдвэрлэлийн хэмжээний талаарх судалгааны тоо баримт нь судалгааны талбайн талаарх мэдээлэлтэй ойролцоо байсан, Мандал сум нь 20 жилийн турш алт олборлож байсан түүхэн уул уурхайн бүс нутаг юм. Үүний эсрэгээр Говь-Алтай, Ховд аймгууд нь хайгуул хязгаарлагдсан харьцангуй шинэ уурхайн бүсүүд бөгөөд Говь-Алтай аймагт зөвшөөрөлтэй баяжуулах цех байхгүй харин Ховд аймагт баяжуулах цех ч байхгүй (АБУЗ, 2019 он).


Тулгарч буй бэрхшээлүүд

Хүдэр олборлоход тулгарч буй нийтлэг бэрхшээлүүдийг эрэмбэлж үзэхэд зориулалтын тоног төхөөрөмж (судалгаанд оролцогчдын 59%), санхүүжилт (52%), тэсэлгээний ажил хийх зөвшөөрөл (50%), олборлолт явуулах газрын зөвшөөрөл (50%) дутагдалтай байгаа юм. Түнхэл зэрэг уул уурхайн илүү хөгжсөн газрууд алт олборлохын тулд олборлох хүчин чадлаа нэмэгдүүлэхийг урьтал болгож байгаа тул тэсэлгээний ажилтай холбоотой асуудлуудыг хамгийн том саад тотгор гэж тодорхойлсон болохыг тэмдэглэх хэрэгтэй. Уул уурхай төдийлөн хөгжөөгүй Есөнбулаг, Баянгол, Алтай зэрэг судалгааны талбайн уурхайчид олборлолтын газрын дүгнэлт, зөвшөөрөл авахтай холбогдсон анхан шатны асуудлыг чухалчилж эрэмбэлсэн байна.

Хүснэгт 4.1-3. Уурхайчдад тохиолддог нийтлэг бэрхшээл (судалгааны бүс нутгаар)

Хүндрэл бэрхшээл	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=71)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Нийт (n=371)
Тоног төхөөрөмж хомс	56%	47%	59%	63%	76%	59%
Санхүүгийн хомсдол	50%	53%	62%	37%	54%	52%
Тэсэлгээний зөвшөөрөл	46%	52%	73%	55%	26%	50%
Газрын зөвшөөрөл	54%	45%	45%	58%	53%	50%
Ерөнхий зөвшөөрөл	64%	53%	37%	55%	28%	47%
Хүдрийн нийлүүлэлт хомс	44%	48%	51%	37%	37%	44%
Хүний нөөцийн хомсдол	39%	36%	54%	34%	30%	38%
Тэсэлгээний хүндрэл бэрхшээл	37%	44%	54%	40%	10%	37%
Хүчин чадал бага	31%	37%	52%	40%	20%	36%
Цаг уурын нөхцөл байдал	35%	33%	39%	45%	24%	35%
Хайгуул мүү	44%	33%	47%	29%	15%	33%
Усгүйжүүлэх хүндрэл	37%	27%	31%	31%	24%	29%

Санхүүжилтийн хүртээмжийн хувьд нийт судалгаанд хамрагдагсдын 53% нь санхүүгийн байдал сайжирвал илүү сайн тоног төхөөрөмжид хөрөнгө оруулахыг илүүд үзэж байна гэж тэмдэглэжээ. Бүс нутгийн хувьд Баянгол (15.4%), Мандал (10.7%), Алтай (13.5%) сумдын уурхайчид газрын зөвшөөрөл олгох асуудлыг хоёрт эрэмбэлсэн бол Түнхэл (14.1%), Есөнбулаг (12.9%)-д бичил уурхайчид тэсэлгээний ажил хийх зөвшөөрөл авахыг урьтал болгосон байна. Зураг 4-4-т бизнесээ сайжруулах сонголтыг нарийвчлан харуулав.



Зураг 4-4. Бизнес хөгжүүлэх сонголт (n=371; 100 эмэгтэй, 271 эрэгтэй)

4.1.3 Судалгааны бүс нутаг дахь хүдэр баяжуулалт

Энэ хэсэгт баяжуулах байгууламжуудын өмчлөл, хүртээмж, сонголт, баяжуулах цехийн технологийн схем, хүдэр баяжуулах үйл ажиллагаа, хүдэр ба үйлдвэрлэлийн мэдээлэл, баяжуулалтын өртгийн талаар ярилцана.

Баяжуулах байгууламжуудын өмчлөл, хүртээмж, сонголт

Монгол Улсад АБУ-н хүдэр баяжуулалтыг зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй баяжуулах цехийн үйлчилгээ эрхлэгчид гүйцэтгэдэг. Баяжуулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг 2019 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/205 дугаар тушаалаар батлагдсан “Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам” (БУТШҮАЭЖ) -аар зохицуулдаг. Энэхүү журмаар том, жижиг хэмжээний баяжуулах үйлдвэрүүд, цехүүдийг ялгаж үздэггүй.

Хүдэр баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны зөвшөөрөл авахын тулд 40 гаруй баримт бичиг шаардагдах бөгөөд гол баримт бичиг нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ юм. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг батлах явц удаан бөгөөд батлагдахад хэцүү, ялангуяа бичил уурхайчдын хувьд нэлээд өртөг өндөртэй байдаг. Алтны хүдэр баяжуулах үйл ажиллагааны албан бус байдал нь бичил уурхайн олборлолтын талбайн

албан бус байдалтай шууд холбоотой юм. Ашигт малтмалын гарал үүслийг тогтоож чадахгүй байгаа болон албажсан бичил уурхайчдын тоо хангалтгүй байгаа нь БОАЖЯ-аас Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг батлахгүй байгаагийн гол шалтгаан болж байна.

БҮТШҮАЭЖ-д бичил уурхайчдын олборлосон алтны хүдрийн гарал үүсэл, тоо хэмжээг бүртгэх, бичил уурхайчдыг бүртгэх, бичил уурхайчидтай үйлдвэрлэлийн хог хаягдлыг зайлуулахад гарах зардлыг зохицуулах талаар зөвшилцөх, ХАБЭА-н стандартыг дагаж мөрдөх зэрэг хэд хэдэн чухал заалт багтсан болно. Баяжуулах үйлдвэрүүд холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөх, шаардлагатай бүх зөвшөөрлийг авсан байх шаардлагатай бөгөөд энэ шаардлагыг хангаагүй бол үйл ажиллагааг нь зогсоох юм. Эдгээр шаардлагууд болон Засгийн газрын 355 дугаар тогтоолын хязгаарлалтууд, КОВИД-19-ийн улмаас 2020 онд олон баяжуулах цехүүдийн үйл ажиллагаа хууль бус байжээ.


Судалгааны дүнгээс харахад манай улсад жижиг оврын алт баяжуулах 12 цех, 13 тээрэм байдаг. Гэсэн хэдий ч зөвхөн хоёр нь л зохих ёсны үйл ажиллагааны зөвшөөрөлтэй байдаг бөгөөд эдгээр нь Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутаг дахь “Хонгорын Хүдэр”, Өмнөговь аймгийн Ханхонгор сум дахь “Товийн Өгөөмөр Хайрхан” баяжуулах цехүүд юм. Зарим уул уурхайн нөхөрлөлүүд өөрсдийн албан бус баяжуулах цехийг ажиллуулдаг бол зарим нь зөвхөн гуравдагч этгээдийн баяжуулах цехүүдээр үйлчлүүлдэг бөгөөд цехийн эзний санал болгосон ихэвчлэн таатай биш нөхцлүүдийг хүлээн авч үйлчлүүлэхээс аргагүй болдог байна. Монголд улсад бидэнд мэдэгдэж байгаа алтны бичил баяжуулах цех болон тээрмүүдийг дор жагсаав.

Хүснэгт 4.1-4. Монгол Улсын хэмжээнд байгаа бичил уурхайн алтны хүдэр баяжуулах цех болон тээрмүүд

№	Баяжуулах цехийн нэр	Хэмжээ	Хүчин чадал	Байрлал
1	Говийн өгөөмөр хайрхан ХХК	Баяжуулах цех	7 т/өдөр	Ханхонгор сум, Өмнөговь аймаг
2	Хонгорын хүдэр ХХК	Баяжуулах цех	10 т/өдөр	Баян-овоо сум, Баянхонгор аймаг
3	ХАМО ХХК	Баяжуулах цех	10 т/өдөр	Борнуур сум, Төв аймаг
4	Мандал хишиг хайрхан (орон нутгийн өмчит ААН)	Баяжуулах цех	12 т/өдөр	Мандал сум, Сэлэнгэ аймаг
5	Сүрлэг мандал хоршоо	Баяжуулах цех	-	Мандал сум, Сэлэнгэ аймаг
6	Мандал төгөл ТББ	Баяжуулах цех	-	Мандал сум, Сэлэнгэ аймаг
7	Монгол Шинтан ХХК	Баяжуулах цех	-	Мандал сум, Сэлэнгэ аймаг
8	Түнхэл	Баяжуулах цех	7 т/өдөр	Мандал сум, Сэлэнгэ аймаг
9	Шижир хишиг	Баяжуулах цех	5 т/өдөр	Мандал сум, Сэлэнгэ аймаг
10	Алтан тээрэм	Баяжуулах цех	5 т/өдөр	Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг
11	Цэрэнпунцагийн баяжуулах цех	Баяжуулах цех	2 т/өдөр	Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг
12	Баяржаргалын баяжуулах цех	Баяжуулах цех	5 т/өдөр	Алтай сум, Говь-Алтай аймаг
13	Баянголын тээрмүүд	9 тээрэм	Нийт 9 т/өдөр	Баянгол сум, Сэлэнгэ аймаг
14	Алтайн говь цонж	Тээрэм	2 т/өдөр	Алтай сум, Ховд аймаг
15	Нэргүй	3 тээрэм	-	Булган, Цэцэг сумд, Ховд аймаг
16	Нэргүй	Тээрэм	-	Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг

Одоогийн байдлаар судалгааны таван бүс нутагт албан ёсоор зөвшөөрөлтэй баяжуулах цех байхгүй байна. Баянгол суманд 9 хувийн тээрэм, Мандалд зөвшөөрөлгүй 6 баяжуулах цех, Түнхэлд зөвшөөрөлгүй 1 баяжуулах цех, Есөнбулагт зөвшөөрөлгүй 2 баяжуулах цех, Алтайд зөвшөөрөлгүй 1 баяжуулах цех байна.

Бичил уурхайчдын 68% нь олборлолтын талбайн ойролцоох баяжуулах цехийг ашиглах боломжтой гэж мэдэгдсэн боловч бүс нутгаар нь авч үзвэл баяжуулах цехийн хүртээмж Түнхэлд 94%, Алтайд 5%-ийн хооронд хэлбэлзэж байв. Судалгаанд оролцогчдын 24 орчим хувь нь 100 км зам туулж баяжуулах цехэд хүрдэг гэсэн бол 2 хувь нь 400 км гаруй зам туулж баяжуулах цехэд хүрдэг гэж мэдэгджээ. Алтайн бичил уурхайчдын 95% нь ойролцоо баяжуулах цех байхгүй гэж хариулсан нь тухайн газрын алслагдсан байдал, уул уурхайн хөгжил, түүхийг илтгэж байсан бол илүү уул уурхай хөгжсөн, тогтворжсон бүс нутгуудад баяжуулах байгууламжийн дэд бүтцээр хангагдсан байв.



Зураг 4-5. Олборлолтын талбайн ойролцоо (<25 км) баяжуулах цех байгаа эсэх

Эзэмшлийн хувьд судалгаанд оролцогчдын 34% нь өөрийн баяжуулах байгууламжтай гэж хариулсан бол судалгаанд оролцогчдын дийлэнх нь (46%) хүдрээ ойролцоох баяжуулах цехэд, 22% нь өөр сумын баяжуулах цех үйлдвэр рүү зөөдөг нь тогтоогджээ. Алтай дахь цөөн тооны уурхайчид (12%) хүдрээ олборлолтын талбайгаас гэр лүүгээ баяжуулахаар зөөвөрлөж байгаа нь баяжуулах тоног төхөөрөмж байхгүй, баяжуулах цехийн хүртээмж хомс байгаа тохиолдолд мөнгөн ус ашиглаж болзошгүй гэдгийг харуулж байна.

Хүснэгт 4.1-5. Уурхайчид хүдрээ баяжуулдаг байршил

	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=71)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Нийт (n=371)
Өөрийн баяжуулах байгууламжид	37%	31%	14%	55%	39%	34%
Ойролцоох баяжуулах байгууламжид	42%	57%	54%	52%	22%	46%
Өөр сумын баяжуулах байгууламжид	15%	9%	55%	6%	28%	22%
Гэртээ/ хашаан дотроо	0%	0%	0%	0%	12%	2%
Мэдэхгүй	10%	4%	0%	0%	4%	3%
Бусад	0%	0%	0%	0%	1%	0%


Судалгааны үр дүнгээс харахад хүдэр баяжуулах байгууламжуудыг тодорхой шалтгаанаар сонгодог гэдэг нь тогтоогдов. Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь баяжуулах цехийг алт барилтын түвшинг (27%) үндэслэн сонгодог гэж мэдэгджээ. Судалгаанд оролцогчдын нийт 12% нь мөнгөн усгүй баяжуулалт хийдэг эсэх нь тэдний сонголтод нөлөөлдөг гэж хариулжээ. Судалгааны дүн нь Алтайн уурхайчдын алслагдсан байдлыг дахин онцлохын зэрэгцээ уурхайчдын 52% нь баяжуулах боломж хязгаарлагдмал гэж хариулжээ. Үйл ажиллагаа нь илүү тогтворжсон, илүү туршлагатай Түнхэлийн уурхайчид (54%) баяжуулах байгууламжийн үр ашигт байдалд тулгуурлан сонголтоо илүү их хийдэг гэж хариулжээ.

Хүснэгт 4.1-6. Тухай баяжуулах цех буюу тээрэм сонгодог шалтгаан

	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=71)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Нийт (n=371)
Санхүүжилтийн санал тавьсан баяжуулах цех	6%	12%	6%	5%	0%	6%
Олборлолтын талбайд хамгийн ойрхон	17%	19%	28%	29%	7%	20%
Бага хөлстэй	29%	21%	13%	16%	4%	16%
Өөрийн нөхөрлөлд хамаатай	10%	9%	6%	10%	11%	9%
Хувийн гэрээтэй	12%	7%	4%	2%	16%	8%
Бартерийн нөхцөлтэй	8%	3%	3%	2%	0%	3%
Мөнгөн үсгүй технологитой	12%	13%	13%	21%	1%	12%
Алт барилтын түвшин өндөртэй	15%	29%	54%	32%	4%	27%
Өөр сонголт байхгүй	25%	13%	14%	19%	58%	25%
Зөвхөн захиалгын дагуу	2%	2%	0%	3%	1%	2%
Бусад	21%	24%	15%	5%	7%	15%

Баяжуулах цехийн технологийн дамжлага

Зураг 4-6-д бичил уурхайгаар олборлосон хүдрийг баяжуулах цехийн технологийн схемийг дүрслэв. Эдгээр баяжуулах цехүүд нь бутлах, нунтаглах, гравитацийн аргаар баяжуулах, цэвэршүүлэх дамжлагуудаас бүрдэнэ.



Зураг 4-6. Хүдэр баяжуулах технологийн схем


Хүдрийг ихэвчлэн хацарт бутлуураар буталдаг боловч заримдаа цехийн онцлогоос хамаарч алхан бутлуур эсвэл гар багаж ашиглан бутладаг. Алтны мөхлөгийг хүдрээс суллахын тулд бегун тээрэм/усан тээрэм, хүрдэн тээрэм/ашиглаж хүдрийг нунтагладаг бөгөөд энэ шатны өмнө хацарт бутлуураар

хүдрийг зохих хэмжээгээр ширхэглэлийг нь багасгадаг. Дараагийн үе шат нь баяжуулалтын үе шат бөгөөд усан тээрмээс гарч буй халиа булингыг баяжуулалтын эхний шат болох резинэн эсвэл хивсэнцэр дэвсгэртэй шлюз дээгүүр урсган баяжмалыг барьж авдаг. Шлюзийн хаягдлыг хаягдлын санд хадгалдаг. Алтны нэлээд хувь нь хаягдлын санд үлддэг ба баяжуулах байгууламжийн эзэн цианидаар боловсруулах үйлдвэрт хаягдлыг дахин боловсруулахаар хадгалж байдгийг тэмдэглэх нь зүйтэй. Шлюзний баяжмал болон бегун тээрмийн уланд тунаж үлдсэн алт агуулсан баяжмалыг баяжуулах ширээн дээр гүйцээн баяжуулж, алтны өндөр агууламжтай баяжмал гаргаж авдаг ба баяжуулах ширээнээс гарсан завсрын бүтээгдэхүүнийг гараар аргаар зайлж авдаг байна. Энэ баяжмалыг баяжуулах ширээн дээр дахин баяжуулж болно, эсвэл заримдаа алт барилтын хувийг ихэсгэх зорилгоор уурхайчид мөнгөн усаар бариулах тохиолдол гардаг байж болох юм. Баяжуулах ширээний хаягдал шлюзийн хаягдалтай хамт хаягдлын санд хуримтлагддаг. Баяжуулах ширээний баяжмалыг гараар зайлж, гаргаж авсан эцсийн баяжмалыг азотын хүчлийн сулруулсан уусмалаар цэвэрлээд борийн хүчилтэй хольж хайлуулан цул алт гаргаж авдаг байна. Алт хайлуулах явцад бага зэрэг бураа буюу бор (Br)-ын хүчил нэмж хийнэ. Хүдэр баяжуулах технологийн схемийг Зураг 4-6-аас харна уу.

Бусад томоохон баяжуулах үйлдвэрүүдээс ялгаатай нь зарим уурхайчид өөрсдөө жижиг, хувийн тээрэм ажиллуулдаг. Хүдрээ ихэвчлэн хацарт бутлуураар буталдаг боловч заримдаа алхан тээрэм эсвэл гараар буталдаг байна. Хувийн тээрмүүдэд баяжуулах ширээ зэрэг технологи байхгүй тул резинэн дэвсгэр дэвссэн шлюз ашиглан хүдрээ баяжуулдаг. Алтны баяжмалыг хайлуулахаас өмнө хар шлих дотор агуулагдах соронзон шинж чанартай төмөрлөг хаягдлыг зайлуулах зорилгоор соронз ашиглаж байна. Шлюзуудтай харьцуулахад баяжуулах ширээ гэх мэт илүү боловсронгуй гравитацийн технологийг ашиглахгүй бол уурхайчид металл авалтын хэмжээг сайжруулахын тулд мөнгөн усаар алт бариулах аргыг ашиглах хандлагатай байдаг.


Хүдэр баяжуулалтын туршлага

Судалгааны дүнгээр 185 судалгаанд оролцогч (50%) хүдрийг ихэвчлэн хацарт бутлуураар буталдаг гэж хариулжээ. Гар аргаар бутлах арга нь Алтайд ихэвчлэн тархсан байв (62%). Судалгаанаас харахад хүдрийг гол төлөв алхан тээрэм (38%) эсвэл усан тээрмээр (38%) нунтагладаг байна.




Зураг 4-7. Хүдэр бутлах арга (судалгааны бүс нутгаар)

Алхан тээрэм нь хоцрогдсон, үр ашиг багатай тээрэм бол бегун тээрэм нь арай илүү боловсронгуй байдаг. Судалгааны бүс нутгаар авч үзвэл Баянгол (77%), Алтай (85%) сумдад алхан тээрмийг хамгийн их ашигладаг байна. Уул уурхайн үйл ажиллагаа илүү их явагддаг бүс нутгуудад бегун тээрмээс илүү сайн технологийг худалдан авах, эсвэл сайжруулахад илүү их хөрөнгө гаргах хандлагатай байна.



Зураг 4-8. Тээрмийн төрөл (судалгааны бүс нутгаар)

Алтыг хүдрээс янз бүрийн аргаар ялгаж авах боломжтой. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь хүдэр баяжуулахдаа (73%) гараар угаах, баяжуулах ширээ (47%) эсвэл шлюз (23%) ашигладаг гэж хариулжээ. Судалгааны тоо баримт баяжуулах ширээг шлюзнээс 2 дахин их хэрэглэдэг болохыг харуулж байгаа хэдий ч бодит амьдрал дээр судалгаанд оролцогчид баяжуулах ширээнээс илүү хүдэр баяжуулахдаа ашигладаг ганц арга нь шлюз ашиглах гэж нэрлэж байсан. Нүдэнд харагдах байдлаар хүдэр гүйцээн баяжуулах процесст бараг бүх баяжуулах ширээний 70 орчим хувь нь шлюзтэй хамт ашиглагдаж байна (АБУЗ, 2019). Мөнгөн усны ашиглалт байгаа гэж судалгаанд хамрагдагсдын зөвхөн 2% нь мэдээлсэн бөгөөд энэ нь Монгол Улс дахь мөнгөн ус хэрэглэхийг хориглосонтой холбоотойгоор дутуу мэдээлэгдсэн байх магадлалтай юм.



Зураг 4-9. Хүдэр баяжуулах арга, судалгааны бүс нутгаар

Судалгаанаас харахад уурхайчид баяжуулах цехүүдийн алт барилт/ металл авалт дунджаар 66%-тай байдаг гэж таамагладаг байна. Энэ нь алт олборлогчид олборлосон алтныхаа 34%-ийг хаягдлын санд цехийн эздийн ашиг болгон үлдээж байна гэсэн үг юм (Зураг 4-10). Уурхайчид гар аргаар угаах явцад нүдэнд үзэгдэхүйц алтыг барих туршлага, алтны судлыг таних талаар урьд өмнө эзэмшсэн мэдлэг туршлага дээр тулгуурлан металл авалтын хэмжээг тодорхойлдог байна. Уурхайчдын дөнгөж 12% нь лабораторид шинжилгээ хийлгэсэн нь хүдрийг лабораторийн шинжилгээ хийлгэх өртөг өндөр байдаг тул шинжилгээ хийлгэх нь бичил уурхайд түгээмэл биш байдаг.

Баяжуулах цехүүд Төв аймгийн Тэн Хун ХХК (Наран толгой гэж нэрлэдэг)-ий цианидаар алт боловсруулах үйлдвэрт хаягдлыг зарж дахин боловсруулдаг. Баяжуулах цехүүд ихэвчлэн жилд нэгээс хоёр удаа хаягдлаа уг үйлдвэр рүү тээвэрлэдэг. Цианидаар боловсруулах үйлдвэр нь хаягдал дахь алтны баримжаа агуулгыг тодорхойлохын тулд сорьцлолт хийж, дараа нь ашиглалтын зардлыг хасаж үлдсэн алтны хэмжээн дээр баяжуулах цехийн эзэнтэй үнэ тохиролцдог байна. Жижиг оврын алтны хүдэр баяжуулах цехийн хаягдал дахь алтны дундаж агууламж нь үйлдвэрийн үр ашгаас хамаарч 20 г/т хүртэл байж болно (АБУЗ, 2019 он).



Зураг 4-10. Алт барилтын хэмжээ (%), судалгаанд оролцогчдын мэдээлснээр (n=371)

Судалгааны явцад одоо байгаа баяжуулах цехүүдийн үйл ажиллагааг сайжруулахын тулд ямар өөрчлөлт хийх шаардлагатай талаарх уурхайчдын саналыг судлав. Судалгааны бүс нутгийн хэмжээнд тоног төхөөрөмжийг сайжруулах шаардлагатай гэсэн санал (30%) түгээмэл байв. Баянгол (43%), Есөнбулаг (34%), Алтай (25%) -ын оролцогчдын ихэнх нь ямар ч санал гаргаагүй нь уул уурхайн харьцангуй шинэ бүс нутаг тул баяжуулалтын тоног төхөөрөмжийн талаарх сайн мэдлэггүйг илтгэж магадгүй юм.

Хүснэгт 4.1-7. Баяжуулах цехүүдийн үйл ажиллагааг сайжруулах талаарх уурхайчдын санал

	Бүс					Нийт		
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)	Нийт (n=371)
Тоног төхөөрөмж сайжруулах	13%	29%	54%	18%	31%	22%	33%	30%
Үйл ажиллагааг сайжруулах	8%	5%	6%	10%	7%	7%	7%	7%
Алтны агуулгыг өсгөх	8%	4%	10%	8%	0%	7%	5%	5%
Алтыг өндөр үнээр авах	2%	11%	4%	2%	0%	5%	4%	5%
Шударга байх	8%	3%	3%	2%	1%	3%	3%	3%
Албан ёсны зөвшөөрөлтэй байх	8%	2%	0%	2%	5%	4%	3%	3%
Өөрийн цехтэй болох	2%	4%	1%	0%	7%	4%	3%	3%
Ил тод байх	2%	4%	0%	0%	0%	2%	1%	1%
Хяналтыг сайжруулах	0%	1%	1%	3%	0%	3%	0%	1%
Шинэ цех байгуулах	0%	0%	1%	0%	12%	4%	2%	3%
Хаягдлыг багасгах	2%	1%	0%	0%	3%	0%	1%	1%
Ёс зүйтэй байх	4%	1%	1%	0%	0%	1%	1%	1%
Өрсөлдөх чадварыг бий болгох	0%	3%	0%	0%	0%	1%	1%	1%
Мэдэхгүй	17%	11%	7%	8%	11%	16%	12%	13%
Санал байхгүй	26%	14%	7%	26%	14%	16%	17%	16%
Бусад	0%	8%	4%	23%	9%	5%	7%	6%

Алтны үйлдвэрлэл

Судалгааны тоо баримтаас алтны гарцыг үндэслэн алтны олборлолтын хэмжээг тооцоолохыг оролдов. Нэг тонн хүдрээс гаргаж авдаг алтны гарц болон жилд олборлодог хүдрийн хэмжээг тооцож үзэхэд жилд үйлдвэрлэдэг алтны хэмжээ Баянголд 3,4 кг/жил, Түнхэлд 22 кг/жил хүртэл хэлбэлзэж байв.

Хүснэгт 4.1-8. Алтны үйлдвэрлэлийн хэмжээ

Байрлал	Нөхөрлөлийн тоо	Хүдрийн жилийн дундаж олборлолт (т/жил)	1 тонноос гаргаж авдаг алтны хэмжээ (гр/т)	Алтны цэвэршилтийн хувь (%)	Жилд үйлдвэрлэдэг алтны хэмжээ (кг)
Баянгол	10	294	11.6	85.8	3.4
Мандал	16	580	27.4	84.1	15.9

Түнхэл	14	447	49.4	89.3	22.0
Есөнбулаг	10	138	73.6	82.6	10.1
Алтай	2	71	28.7	82.3	2.03
Дундаж	-	306	38.1	84.8	10.7
Нийт	-	-	-	-	53.4

Судалгааны бүс нутгуудыг хамгийн өндөр бүтээмжтэйгээс хамгийн бага бүтээмжтэй гэж үйлдвэрлэлийн хэмжээгээр нь дараах дарааллаар, тухайлбал, Түнхэл, Мандал, Есөнбулаг, Баянгол, Алтай гэж ангилав. Энэхүү мэдээлэл нь судалгаанд оролцогчдоос цуглуулж, 7-р бүлэгт танилцуулсан алтны худалдааны мэдээлэлтэй төстэй юм.

Хүснэгт 4.1-9. Алтны үйлдвэрлэлийн харьцуулалт

	Хамгийн их				Хамгийн бага
Б. 5 – Олборлосон хүдрийн хэмжээн дээр үндэслэн тооцсон алтны үйлдвэрлэлийн хэмжээ	Түнхэл	Мандал	Есөнбулаг	Баянгол	Алтай
Б. 7 – Алтны үйлдвэрлэлийн хэмжээ (7 хоногоор)	Түнхэл (53 гр)	Баянгол (51 гр)	Есөнбулаг (44 гр)	Мандал (39 гр)	Алтай (37 гр)
Б. 7 – Худалдсан алтны хэмжээ (7 хоногоор)	Түнхэл (34 гр)	Баянгол (32 гр)	Алтай (28 гр)	Мандал (26 гр)	Есөнбулаг (20 гр)

Энэхүү гурван багц мэдээлэл нь судалгааны бүс нутгуудаас Түнхэлийн алтны үйлдвэрлэлийн хэмжээ хамгийн өндөр гэдгийг харуулж байна. Баянгол сумын худалдсан алтны хэмжээ өндөр байгаа боловч олборлосон хүдрийн хэмжээ тийм ч их биш байна. Судалгааны бүс нутгуудаас Алтай сум алт үйлдвэрлэлийн хэмжээгээр хамгийн бага байна гэсэн дүгнэлт хийж болно.

Баяжуулалтын өртөг ба баяжуулах цех байгуулах зардал

Баяжуулалтын дундаж өртгийг бүс нутгаар нэгтгэн Хүснэгт 4.1-10-д үзүүлэв. Баяжуулалтын өртөг нь нэлээд тогтвортой бөгөөд 200,000 ₮/тонн орчим байдаг. Гэсэн хэдий ч Есөнбулаг, Алтай сумдад нэг тонн хүдэр баяжуулах өртөг арай илүү өндөр байгаа нь тухайн бүс нутгийн уурхайчдын баяжуулалтын сонголтууд хязгаарлагдмал болон одоо байгаа баяжуулах цех илүү их төлбөр авдаг гэдгийг харуулж байна. Судалгаанд хамрагдсан бүх тээрэм, баяжуулах цехүүд албан ёсны зөвшөөрөлгүйгээр ажиллаж байсан бөгөөд орон нутгийн Мэргэжлийн хяналтын хэлтсээс баяжуулах цехүүдийг Баяжуулах үйлдвэрт тавигдах шинэ шаардлагад нийцүүлэн хяналт шалгалт хийхээр хаасныг тэмдэглэх нь зүйтэй.

Хүснэгт 4.1-10. Баяжуулалтын дундаж өртөг

Хүдрийн гарал үүсэл	Баяжуулах байгууламж	Баяжуулалтын өртөг (₮/тонн)
Баянгол (Нарт)	Нарт	100,000-150,000
Мандал (Ноёт)	Мандал	150,000-200,000
Түнхэл (Бор толгой)	Түнхэл, Борнуур, Мандал	150,000-220,000
Есөнбулаг (Замын-Ам)	Алтай (ГА)	250,000-300,000
Алтай (Майхан)	Алтай	250,000

Одоогийн байдлаар баяжуулах ширээ, шлюз нь бичил уурхайчдын ашиглах боломжтой мөнгөн үсгүй цорын ганц технологи юм. Гэсэн хэдий ч Хятадаас импортолсон мөнгөн үсгүй технологийн тоног төхөөрөмж нь ойролцоогоор 200-250 сая төгрөг (70-90 мянган доллар), зохих зөвшөөрөл авахад нэмж 100 сая төгрөг (35 мянган доллар) зарцуулдаг тул баяжуулах цех байгуулахад санхүүгийн бэрхшээл их байна. Ярилцлагын үеэр Мандал дахь баяжуулах цехийн оператор

тоног төхөөрмжийн засвар үйлчилгээ нь өндөр өртөгтэй тул мэдлэг туршлага хязгаарлагдмал байдлаас шалтгаалж тоног төхөөрөмжийг зөв тохируулах, арчлахад бэрхшээлтэй байгааг дурджээ. Цианидаар алт боловсруулахгэх мэт химийн арга нь алт барилтын хэмжээг нэмэгдүүлдэг, өндөр ашигтай боловч энэ нь Монгол Улсад маш нарийн зохицуулалттай байдаг (АБУЗ, 2019 он).

4.1.4 Дүгнэлт

Хүдэр олборлолт

Бичил уурхайчид өдөрт хэдэн мянган тонн олборлох чадвартай томоохон уул уурхайтай харьцуулахад маш бага буюу жилд хэдхэн зуун тонн хүдэр олборлодог болох нь тогтоогдож байна. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогчид ийнхүү маш бага хэмжээний олборлолт хийдэг тул агуулагч чулуулгийг тойруулан алтны өндөр агуулгатай гол судлыг сорчлон олборлолт хийдэг байна. Гэсэн хэдий ч бичил уурхай эрхлэгчид малтмалын гүн хэт гүнзгийрснээс болж судлаа орхихоос өөр аргагүй болдог, учир нь гүнзгийрэх тусам ус зайлуулах хүчтэй систем ашиглах шаардлага гардаг мөн хүдрийн хатуулаг нэмэгдэхийн хэрээр тэсэлгээ хийх шаардлагатай болдог байна. Зөвшөөрөгдсөн хязгаарлалтын хүрээнд тохирох илүү боловсронгуй тоног төхөөрөмж, технологид зарцуулах хангалттай хөрөнгө, санхүүжилт дутмаг байдаг нь уурхайчид үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд саад болдог нь нийтлэг бэрхшээл байв. Геологийн эрэл хайгуул хийгдээгүй, нөөц тогтоогдоогүй зэрэг нь гол бэрхшээлүүдийн нэг бөгөөд энэ нь цаашдын хөрөнгө оруулалт буурахад ихээхэн нөлөө үзүүлдэг гэдэг нь бичил уурхайчдад тохиолддог нийтлэг бэрхшээл юм.

Энэхүү судалгаа бичил уурхайд тулгарч буй бэрхшээлүүд уул уурхайн үйл ажиллагаа нэмэгдэхийн хэрээр үе шаттайгаар улам бүр нэмэгдэж байгаа үзэгдлийг онцлон тэмдэглэж байна. Судалгааны бүс нутгийн хэмжээнд санхүүгийн хомсдол нь түгээмэл байдаг нь тогтоогдсон хэдий ч хөрөнгө оруулалт авах боломж гарвал хөрөнгө оруулалтыг олборлолтын үйл ажиллагааг боловсронгуй болгоход зарцуулна гэдэг нь харагдаж байна. Түнхэл зэрэг илүү их уул уурхай хөгжсөн судалгааны бүс нутгууд, тэсэлгээний зөвшөөрлийг хамгийн том саад тотгор гэж тодорхойлсон болно. Баянгол, Есөнбулаг зэрэг уул уурхай сул хөгжсөн газрууд олборлолтын талбайн зөвшөөрөл авах зэрэг анхан шатны асуудалд илүү анхаарал хандуулж байв.

Хүдэр баяжуулалт

Монгол Улсад албан ёсны зөвшөөрөлтэй зөвхөн хоёр баяжуулах цех байдаг тул бичил уурхайчид зөвшөөрөлгүй баяжуулах цехүүд болон хувийн тээрмүүдтэй хүдэр баяжуулах үнээ тохиролцохыг хичээдэг. Баяжуулах үйлдвэр шинээр байгуулах нь маш нарийн зохицуулалттай бөгөөд 300-350 сая ₮ (105-125 мянган ам.доллар)-ийн хөрөнгө оруулалт шаарддаг тул ихэнх АБУ-дад энэ нь боломжгүй байна.

Судалгаанд оролцогчдын 24% нь баяжуулах цех рүү хүрэхийн тулд 100 км хүртэлх зам туулах шаардлагатай гэсэн бол 2% нь хүдрээ баяжуулахын тулд 400 гаруй км зам туулдаг гэсэн нь баяжуулах цехийн сонголт, хүртээмж хомс байгааг

харуулж байна. Энэ талаар ялангуяа Алтай, Баянгол сумдад илүү их яригдаж байсан нь тухайн газар нутгийн олборлолтын талбайн алслагдсан байдал, харьцангуй уул уурхай хожуу хөгжиж эхэлснийг илтгэнэ. Судалгаанд оролцогчдын 25% нь баяжуулах процесс сайтай гэж сонгоогүй, өөр сонголт байхгүй тул сонгосон гэж хариулжээ.

Уурхайчдын ердөө 34% нь өөрсдийн баяжуулалтын тоног төхөөрөмжийг ашиглах боломжтой байдаг бол дийлэнх нь гуравдагч этгээдийн баяжуулах цехүүдээр үйлчлүүлдэг бөгөөд цехийн эзний санал болгосон ихэвчлэн таатай биш нөхцлүүдийг хүлээн авахаас аргагүй байдалд хүрдэг байна. Баяжуулах цехүүд энгийн гравитацийн аргаар баяжуулдаг бөгөөд 38% нь алхан тээрмээр, 38% нь бегун тээрмээр хүдрээ нунтагладаг байна. Хүдэр баяжуулж алтыг ялгаж авахдаа 70% нь шлюз ашиглаж байсан бол илүү боловсронгуй баяжуулах ширээг 47% нь ашиглаж байжээ. Баяжуулалтын хаягдлыг баяжуулах цехийн эзэд авч үлдэх нь нийтлэг тогтсон практик байсан нь баяжуулах тоног төхөөрөмжийг илүү боловсронгуй болгох, сайжруулах сонирхлыг бууруулж байна. Судалгааны бүс нутгуудад хүдэрт агуулагдаж байгаа алтны 66% -ийг дунжаар авч чаддаг бөгөөд үлдсэн 34% -ийг баяжуулах цехийн эзэд өөрсдийн ашиг болгон авч үлддэг гэж үздэг байна. Бодит байдал дээр баяжуулах цехийн хаягдалд тонн тутамд 20 граммаас их алт үлдэж байж болох бөгөөд энэ нь томоохон уул уурхайн анхдагч агуулгатай харьцуулахад маш их хэмжээний алт хаягдалд үлдэж байна гэсэн үг юм (АБУЗ, 2019 он).

Судалгааны бүх бүс нутагт санхүүгийн (металлургийн) бүртгэл нэлээд муу байсан нь тогтоогдсон бөгөөд олборлосон болон боловсруулсан хүдрийн хэмжээ, мөн борлуулсан болон үйлдвэрлэсэн алтны хэмжээ хоорондоо тус тус зөрүүтэй гарсан. Түүнчлэн цехийн үйл ажиллагааны хяналтын түвшин муу байсан. Алтны агуулгыг лабораторийн шинжилгээгээр тодорхойлох нь ховор байсан бөгөөд уурхайчдын дийлэнх нь ажлын мэдлэг туршлага, гар аргаар угаах явцад нүдэнд ил харагдахуйц алтыг хайж олох, усан жингийн арга гэх мэт энгийн практик аргуудад найддаг байна.


Судалгааны бүс нутгийн гурван багц мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд Түнхэлд хамгийн их хэмжээний алт үйлдвэрлэсэн байсан. Баянгол сум хамгийн их алт борлуулсан байсан боловч, хүдэр олборлолтын хэмжээгээр тийм их биш байсан. Алтай сум хамгийн бага хэмжээний алт олборлосон сумдын нэг байна гэж дүгнэлт хийж болно.

4.2 Байгаль хамгаалал болон байгаль орчны менежмент

АБУ-н салбарын байгаль орчны менежмент, байгаль хамгааллын эрх зүйн урьдчилсан нөхцөлийг 3-р бүлэгт нарийвчлан тайлбарласан болно. Энэ хэсэгт судалгааны бүс нутгийн хэмжээнд ашигт малтмал олборлохтой холбоотой байгаль орчны үйл ажиллагаа, ялангуяа бичил уурхайн журамд заасны дагуу хог хаягдлын үр дүнтэй менежмент, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө зэрэг байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрхэн дагаж мөрдөж байгааг харуулахыг зорих болно.

4.2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө


Бичил уурхайн журам 151-д заасны дагуу бичил уурхайн нөхөрлөлүүд батлагдсан байгаль орчны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг батлуулах, бичил уурхай эрхлэгч этгээдийн ашигт малтмал олборлохыг зөвшөөрсөн гэрээг баталгаажуулж гарын үсэг зурах, нөхөн сэргээлтийн санд хувь нэмэр оруулах зэрэг үүрэгтэй. Энэхүү журмын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нар хамтран Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг 2017 онд баталсан. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал нь бичил уурхайн олборлолтын улмаас эвдэрч доройтсон газрыг эдийн засгийн хувьд өртөг багатай, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, экологийн болон байгаль орчинд эерэг нөлөөтэй нөхөн сэргээх аргачлал юм. Энэхүү аргачлалыг бичил уурхайгаар эвдэрч доройтсон газрыг бичил уурхайчдаар өөрсдөөр нь нөхөн сэргээхэд зориулж тусгайлан боловсруулсан хямд төсөр нөхөн сэргээлтийн аргачлал (Хямд төсөр нөхөн сэргээлтийн аргачлал, 2016 он) дээр үндэслэн боловсруулсан болно. Нөхөн сэргээлтийн ажил нь техникийн болон биологийн нөхөн сэргээлт гэсэн хоёр хэсэгтэй. Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт дүүргэлт хийх, хэлбэршүүлэх, тэгшлэх, шимт хөрсөөр хучих зэргээр биологийн нөхөн сэргээлтэд бэлтгэх ажлын үе шатыг техникийн нөхөн сэргээлт гэнэ (Бичил уурхайн нөхөн сэргээлийн аргачлал, 2017 он). Биологийн нөхөн сэргээлт гэдэг нь нөхөн сэргээх талбайг ургамалжуулж, үржил шимийг сэргээснээр байгалийн аясаар ургамал ургах, экологийн нөхөн сэргээлт явагдах боломжийг бий болгох нөхөн сэргээлтийн үйл явцын эцсийн үе шат юм. Судалгаанд хамрагдсан уурхайчдын 69% нь тэдний байгууллага нь байгаль орчныг нөхөн сэргээх төлөвлөгөөтэй гэж хариулсан (Зураг 4-11). Судалгааны бүс нутгуудаас төлөвлөгөөтэй гэж хариулсан өгсөн оролцогчдын хувь Түнхэлд хамгийн өндөр (86%), Баянгол (52%), Алтай (55%) суманд хамгийн бага байв.



Зураг 4-11. Байгаль орчныг нөхөн сэргээх төлөвлөгөөтэй эсэх

Энэхүү дүгнэлтийг бичил уурхайн нөхөрлөлийн ахлагч нар болон уурхайчдын ганцаарчилсан ярилцлагууд бататгасан байна. Ярилцлагад хамрагдсан найман хүн тутмын тав нь байгаль орчныг нөхөн сэргээх төлөвлөгөөний талаарх журмыг дагаж мөрдсөн гэж хариулав. Ярилцлагад оролцсон уурхайчдын 82% нь уурхайнхаа талбайд нөхөн сэргээлт хийдэг гэж хариулжээ. Зөвхөн 9% нь нөхөн сэргээлт хийгээгүй гэж хариулсан бол үлдсэн 9% нь хариулах боломжгүй байна (Зураг 4-12) гэжээ. Бичил уурхайн талбайдаа нөхөн сэргээх ажилд оролцсон

уурхайчидын гуравны хоёр нь (69%) нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд ухсан нүхийг дүүргэж, битүүлсэн гэж хариулжээ. Гэсэн хэдий ч энэ нь нөхөн сэргээлт зохих ёсоор, амжилттай хийгдсэн гэсэн үг биш юм. Нарийвчилсан асуултаар дүүргэлт хийсэн үндсэн зорилго нь нөхөн сэргээлтэд зориулагдаагүй, харин бусад уурхайчдыг хүдэр хулгайлахыг зогсоох, газрын тогтвортой байдлыг хангах зорилготой байсан гэдгийг тодруулсан болно. Тиймээс бичил уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг үнэн хэрэг дээрээ хэт их дөвийлгөж мэдээлсэн байж болно. Тоон судалгаанаас харахад судалгаанд хамрагдсан уурхайчдын дөнгөж 3.8% нь газрыг хөрсжүүлэх, мод тарих зэрэг биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.



Зураг 4-12. Олборлосон талбайг нөхөн сэргээсэн байдал (n=371)

Нөхөн сэргээлтийн ажлыг ихэвчлэн орон нутгийн засаг захиргаа олон улсын төсөл, байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг болохыг сумдын байгаль орчны байцаагч нартай хийсэн ГМӨГЯ-аас тодорхой харагдсан. Тодруулбал, Азийн сангийн санхүүжилтээр Ховд аймгийн Үенч сум дахь бичил уурхай эрхэлдэг нэг талбайд, Алтай дахь хоёр талбай дээр байгаль орчны нөхөн сэргээлт хийсэн байна.

Сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Ховд аймгийн харьяа сумынхаа нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьдаг болохыг ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээс харж болно. Ажлын хэсэгт байгаль орчны хяналтын улсын байцаагч, Говийн их дархан цаазат газрын байгаль хамгаалагч, газрын даамал, Засаг даргын орлогч нар багтжээ. Энэхүү ажлын хэсгийн зорилго нь хуулийн хүрээнд албан бичил уурхайчдын эрхэлж буй үйл ажиллагаанд хяналт тавих явдал юм (Ганцаарчилсан ярилцлага, 2020 он). Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг нөхөрлөл тус бүрээр боловсруулж, орон нутгийн засаг захиргаатай байгуулсан Ашигт малтмал олборлох гэрээнд тусган ажиллуулдаг болохыг Ховд аймгийн уурхайчид дурдав.

Бичил уурхайн журамд заасны дагуу бичил уурхайн байгууллагууд тодорхой хэмжээний мөнгийг нөхөн сэргээлтийн зардал болгон орон нутгийн бичил уурхай орчны нөхөн сэргээлтийн дундын санд²⁰ байршуулах үүрэгтэй. Гэсэн


²⁰ Нөхөн сэргээлтийн дундын санд БУ-н нөхөрлөлүүд олборлолт дууссаны дараа нөхөн сэргээлт хийхэд ашиглах зорилгоор урьдчилан нөхөн сэргээлтийн баталгаа болгож мөнгө байршуулах үүрэгтэй.

хэдий ч орон нутгийн засаг захиргаа нь Монгол Улсын хууль тогтоомж, ялангуяа Төсвийн тухай хуультай зөрчилдсөнөөс орон нутгийн сангууд нь орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан гэсэн хоёр орон нутгийн сан байж болно гэсэн заалттай холбоотойгоор зарим талаар дундын сан байгуулж чадахгүй байна. Иймээс уурхайчид эдгээр хоёр сангийн аль нэгэнд мөнгө оруулахаас өөр аргагүйд хүрдэг. Ховд аймгийн уурхайчид 2019 онд Орон нутгийн хөгжлийн санд 1 га тутамд нэг сая төгрөг төвлөрүүлжээ (Ганцаарчилсан ярилцлага, 2020 он). Гэсэн хэдий ч энэ мэдээллийг бусад судалгааны бусад бүс нутгуудаас авах боломжгүй байв. Судалгаагаар бичил уурхай эрхэлдэг нөхөрлөлүүд уг санд нөхөн сэргээлтийн зорилгоор хувь нэмэр оруулж байгаа хэдий ч тэдний төвлөрүүлсэн мөнгийг аль хэдийн бусад олон нийтийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор дахин хуваарилсан байж болзошгүй тул энэ сангаас эргүүлэн хөрөнгө татан авахад бэрхшээлтэй байдаг нь тогтоогджээ (Ганцаарчилсан ярилцлага, 2020 он).

4.2.2 Уурхайн үйл ажиллагааны хог хаягдлын менежмент

Уурхайчид хуучин орхигдсон олборлолтын талбайд үлдсэн, хаягдсан бага агуулгатай хүдэр болон хүдрийн хаягдлыг олборлодог. Үүний нийтлэг хоёр шалтгаан нь өндөр агуулгатай хүдэр шавхагдаж дууссан бөгөөд ийм тохиолдолд уурхайчид бага агуулгатай материалыг их хэмжээгээр боловсруулж ижил хэмжээний алт олборлохоос өөр аргагүй болдог. Хоёрдугаарт, илүү сайн технологиуд бий болж бичил уурхайчид захын агуулгыг бууруулж бага агуулгатай материалыг үр ашигтай боловсруулж ашиглах боломжтой болсон байж магадгүй юм.


Хог хаягдлын тухайд уул уурхайн үйл ажиллагаа нь их хэмжээний органик (жишээлбэл, модны хог хаягдал) ба органик бус хог хаягдал (жишээлбэл, хуванцар, цаасны хаягдал), бага хэмжээгээр химийн болон аюултай хог хаягдал (жишээлбэл, машины тос, батерей, урвалжууд) үүсгэдэг.



Зураг 4-13. Уурхайн талбайд бий болдог хог хаягдлын төрлүүд

Уурхайчид асуудалд орохоос эмээж аюултай хог хаягдлыг, тухайлбал, машины шингэн, мөнгөн ус, азотын хүчил зэрэг алт баяжуулахад ашигладаг урвалж зэрэг химийн бодисуудыг зайлуулах зохисгүй үйл ажиллагааны талаар дурдаагүй байж болзошгүй тул энэ талаарх мэдээлэл тайланд үнэн зөв тусгагдаагүй байж болохыг сануулах нь зүйтэй.


Хог хаягдлыг шатаах (43%), булшлах (38%), хог хаягдлыг хогийн цэг рүү зөөх (35%) нь хаягдлыг зайлуулах нийтлэг арга юм. Судалгааны бүс нутгийн мэдээллийг харахад Түнхэл дэх уурхайчдын 62%, Мандал дахь уурхайчдын 53% нь хогоо хогийн цэг рүү тээвэрлэдэг бол Есөнбулаг дахь уурхайчдын 60%, Алтай дахь уурхайчдын 74% нь хог хаягдлаа шатаадаг, Баянголд уурхайчдын 38% нь хог хаягдлаа булшилдаг байна. Эдгээр аргачлалуудыг задралд ордоггүй болон химийн материалууд болох машины тос, батерей, алт ялгаж авахад ашигладаг урвалж зэргийг зайлуулахад хэрэглэвэл байгаль орчинд хортой нөлөө үзүүлнэ.



Зураг 4-14. Судалгаанд оролцогчдын хог хаягдал зайлуулах туршилага (олон хариулттай; нийт=494)

4.2.3 Олборлолтын талбай болон Баяжуулах цехийн усны эх үүсвэр

Судалгаанд хамрагдагсдын 59% нь гүний худгаас ус ихэвчлэн авдаг; Баянгол, Мандал, Түнхэлийн уурхайчид газрын гүний ус хэрэглэдэг байна. Есөнбулаг сумын судалгаанд оролцогчдын 66% нь ойролцоох гол мөрөн, цөөрмийн усыг ашигладаг гэж хариулсан бол Алтай дахь уурхайчдын 65% нь цэвэршүүлсэн усыг машинаар зөөвөрлөж авчирдаг гэжээ. Алтай сумын бичил уурхайн нөхөрлөлийн ахлагч эрэгтэйн хэлснээр Алтай, Есөнбулаг дахь усны эх үүсвэртэй холбоотой үндсэн бэрхшээл нь бичил уурхайн хөгжил болон санхүүжилт байхгүйтэй холбоотой гэж хэлсэн байна (Ганцаарчилсан ярилцага, 2020 он).



Зураг 4-15. Уурхайн талбай дээр ашиглаж буй усны эх үүсвэр

Судалгааны бүс нутгийн баяжуулах цехийн эзэдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагад оролцогчдын ихэнх нь баяжуулах үйлдвэрийн ашигладаг усны эх үүсвэрийн талаар дурдахаас зайлсхийж байсан тул хязгаарлагдмал мэдээлэл цуглуулсан. Учир нь ихэнх цехүүд байгаль орчны зохих зөвшөөрөлгүйгээр ажиллаж байсан. Зөвхөн нэг оролцогч усыг зэргэлдээ тоосгоны үйлдвэрээс авдаг гэж дурдсан (Ганцаарчилсан ярилцлага, 2020 он).

4.2.4 Баяжуулах цехүүдийн хаягдлын менежментийн туршлага

Уурхайн хог хаягдал буюу баяжуулалтын хаягдлыг баяжуулах цехийн ойролцоо орших задгай хаягдлын санд ихэвчлэн хадгалдаг. Эдгээр хаягдлын сан нь ихэвчлэн шороо нь тунадасжиж, ус нь ялгарах зориулалтаар хооронд нь шороо шавар эсвэл бетонон хавтангаар тусгаарлагдсан байдаг. Тунгалагжуулсан усыг дахин баяжуулах цехэд ашиглах боломжтой бөгөөд усыг дахин ашиглах, байгалийн аясаар ууршиж олборлолтын идэвхтэй улирлын төгсгөлд лаг нь хаягдлын санд тунаж үлддэг. Хаягдлын сангийн хэмжээ, цехийн хүчин чадлаас шалтгаалан ихэвчлэн гурван сараас нэг жилийн хугацаанд хаягдлын сан дүүрдэг байна. Хаягдлын сан дүүрсэн үед цианидаар баяжуулах үйлдвэрт ачуулахын өмнө хаягдлын сангаас баяжуулалтын хаягдал материалыг гаргаж авахад жижиг экскаватор эсвэл ачигч ашигладаг. Хүдэрт агуулагдах алтны 30-40 хувь нь боловсруулах үйлдвэрийн эзэнд хаягдал дотор үлддэг бөгөөд түүнийг 4.1-р хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласны дагуу Цианидаар баяжуулах үйлдвэр рүү ачигддаг байна.

4.2.5 Байгаль орчны мониторинг хийх зохицуулалт

Бичил уурхайн үйл ажиллагаа, баяжуулах үйлдвэрийн байгаль орчны хяналтыг өөр өөр журмаар зохицуулдаг. Бичил уурхайн үйл ажиллагааны байгаль орчны хяналтыг Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу зохицуулдаг бол Баяжуулах үйлдвэрүүдийн байгаль орчны хяналтыг том уул уурхай болон бичил уурхайн баяжуулах үйлдвэрт хүчинтэй Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагааны журам (БҮТШҮАЖ)-аар зохицуулдаг.

Бичил уурхайн нөхөн сэргээх аргачлалын дагуу байгаль орчны хяналтыг бичил уурхайн байгууллагуудын нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийг үнэлэх, нөхөн сэргээсэн газар нь хүн, зэрлэг ан амьтанд аюулгүй эсэхийг үнэлэх үйл ажиллагаа гэж тодорхойлдог. Нөхөн сэргээлтийн гүйцэтгэл, шалгуур нь нөхөн сэргээгдсэн талбай нь ямар нэг бохирдолгүй, нөхөн сэргээлтийн дараа тухайн газрыг тогтвортой ашиглах боломж нөхцөл бүрдсэн эсэх зэргээр хэмжигддэг.

Говь-Алтай аймаг дахь бичил уурхайчдын нэг нөхөрлөлийн ахлагч ганцаарчилсан ярилцлагын үеэр нөхөн сэргээлт хийсэн газруудад орон нутгийн засаг захиргаа хангалттай хяналт тавьдаггүй бөгөөд үүнээс үүдэн нөхөн сэргээлт хийсэн талбайг бусад уурхайчдын бүлгүүд ухах тохиолдол олон байдаг гэж онцолжээ (Ганцаарчилсан ярилцлага, 2020 он). Говь-Алтай аймагт хууль бусаар алт олборлогчид нь хуучин уурхайд дахин олборлолт явуулдаг бөгөөд эдгээр уурхайчид орон нутгийн төрийн байгууллагын ажилтнуудаас зугтаан, шөнийн цагаар ажилладаг тул хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг байна.

БҮТШҮАЭЖ (2019 он)-ын дагуу баяжуулах үйлдвэрүүд дараах зүйлсийг хийх шаардлагатай.

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр баяжуулах үйлдвэр, цехийн үйл ажиллагаа нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлох;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд ашигт малтмал баяжуулах үйлдвэр, цехийн үйл ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдол, хүн, ан амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг тусгах;
- Баяжуулах үйлдвэр, цехийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан нөлөөллийг тухай бүр бүртгэн, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүр гаргаж, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлэх;

4.2.6 Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн нөхөрлөлийн гуравны хоёр орчим нь бичил уурхайтай холбоотой журмын дагуу нөхөн сэргээлтийн төлөвлөгөөтэй байгаа нь ажиглагдаж байна. Бичил уурхайн байгууллагуудын ихэнх нь нөхөн сэргээлтийн үйл ажиллагаагаа зөвхөн дүүргэлт хийх үйл ажиллагаагаар хязгаарладаг бөгөөд энэ нь ихэвчлэн бусад уурхайчдын бүлэглэлүүд хүдэр хулгайлахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хийгддэг. Үржил шимт хөрс дүүргэх, мод тарих зэрэг биологийн нөхөн сэргээлт хангалтгүй байгаа нь алтны бичил уурхайн талбай дээр ажиглагдаж байна. Гэсэн хэдий ч бичил уурхайн зарим нөхөрлөлүүд орон нутгийн санд төвлөрүүлсэн нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгөө татан авахад бэрхшээлтэй байгаа тул нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлж чадахгүй байна.

Тоон болон чанарын судалгааны мэдээллээс харахад бичил уурхай, ялангуяа Алтай, Есөнбулаг дахь бичил уурхайн байгууллагууд хог хаягдлын менежментийг үр дүнтэй хэрэгжүүлдэггүй болохыг тогтоожээ. Нөхөрлөлүүд байгальд задардаггүй химийн бодисын хаягдлыг тусгайлан авч үздэггүй ба хог хаягдлыг зөвхөн булж, шатаадаг нь байгаль орчинд хор хөнөөлтэй байна.

Судалгаанд хамрагдагсад нь үйл ажиллагаандаа ашиглах усыг газрын доорх гүний худгаас, бага хэсэг нь ойролцоох гол, нуур, цөөрмөөс усны машинаар зөөвөрлөж авдаг байна. Баяжуулах үйл явцад ашиглагдах усны эх үүсвэрийг ихэвчлэн байгаль орчны зохих зөвшөөрөлгүй ашиглаж байж болзошгүй тул баяжуулах цехийн эздийн хувьд энэ нь ярианы эмзэг сэдэв юм.

Баяжуулах цехүүд баяжуулалтын хаягдлыг ойролцоох хаягдлын санд хадгалдаг бөгөөд шороо буюу усыг ялгахын тулд хаягдлын сангуудыг хооронд нь шороо/шавар эсвэл бетонон хавтангаар тусгаарласан байдаг. Энэ нь баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээг багасгахын тулд усыг дахин ашиглах боломжийг олгодог. Хатаасан хаягдлыг хаягдлын сангаас 3-12 сар тутамд ухаж гаргаж,

хаягдал дахь алтыг баяжуулахаар цианидаар баяжуулах үйлдвэр рүү тээвэрлэх хүртэл тэнд нь цуглуулдаг байна.

4.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Бичил уурхайгаар алт олборлогчид олборлолтын үйл ажиллагаандаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс төрөл бүрийн аюул, осолд өртөх эрсдэл өндөр байдаг. Үндсэн ордоос алт олборлож буй тохиолдолд олборлолтын үйл ажиллагаа нь гүн, давчуу, харанхуй орчинд явагддаг тул осолд өртөж гэмтэх магадлал илүү өндөр. Ялангуяа босоо амны бэхэлгээ хангалтгүй, хүнд машин механизм ашиглан хүдэр бутлах тохиолдолд илүү эрсдэлтэй байдаг. Үүнээс гадна уурхайчид Монгол орны хүйтэн цаг агаарын нөхцөлд олон цагаар ажиллах болдог.

Уурхайчдын аюулгүй байдалд нэг бүрийн хамгаалах хэрэгсэл (НБХХ)-ийн хэрэглээ, олборлолтын талбайн босоо ам болон бусад аюултай хэсгүүдийн бэхэлгээ, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, химийн бодис, тэсэлгээний материалтай хэрхэн харьцаж байгаа байдал зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг. Эдгээр аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүдийн хэрэгжилт, хяналт нь аюулгүй ажиллагааны дүрэм, журам тухайн бичил уурхайн байгууллагад мөрддөгдөг эсэх, жишээлбэл, аюулгүй байдал, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө бий эсэхээс хамаарна.

ХАБЭА-н стандартчлагдсан бүртгэлийн систем байхгүй, найдвартай статистик мэдээлэл дутмаг байгаа нь алтны бичил уурхайн салбарт гарсан гэмтэл, ослын тоог үнэлэхэд бэрхшээлтэй болж байна (ОУХБ, 2016). Энэ нь ялангуяа албан бус олборлолтод хамаатай бөгөөд уурхайчид ХАБЭА-н талаар хангалттай сургалтад хамрагдаагүй байж болзошгүй. Мөн дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс эмээж ослын талаар дутуу мэдээлсэн байж болно.




Зураг 4-16. НБХХ өмссөн бичил уурхайчид (planetGOLD)

Монгол Улсад бичил уурхайн аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудлыг 2010 оноос хойш Засгийн газар зохицуулж ирсэн бөгөөд 2010 оны 308 дугаар тогтоолоор баталсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг үндэслэн Ашигт малтмалын газрын даргын 153 дугаар тушаалаар Бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийг баталжээ. Бичил уурхайн салбарын ХАБЭА-н стандартыг сайжруулахын тулд Засгийн газрын 2017 оны 151-р тогтоолын хэрэгжилтийн хүрээнд УУХҮ, БОАЖ-ын сайд нарын хамтарсан тушаалаар (УУХҮЯ, БОАЖЯ, 2017) Бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийг баталсан. Эдгээр дүрэм, журам батлагдсанаар бичил уурхайчид ослоос урьдчилан сэргийлэх, ил болон далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон тоног төхөөрөмжийн шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай болжээ.


Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу сум, дүүргийн Засаг дарга нар бичил уурхайн эрхлэгч этгээдийн үйл ажиллагааны тайланг гаргаж, аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх; бичил уурхайд гарсан үйлдвэрлэлийн ослын тоог АМГТГ-т мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв осол гарсан бол Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, цочмог хордлогыг судлан, бүртгэх журмын (ЗГ, 2015) дагуу шалтгааныг нь шалгаж бүртгэх ёстой бөгөөд сум, дүүргийн Засаг даргад яаралтай мэдэгдэх үүрэгтэй.

4.3.1. Аюулгүй ажиллагааны хэрэгслийн хэрэглээ

Алтны үндсэн ордоос олборлолт хийхэд уурхайчид аюулаас тэр бүр хангалттай хэмжээнд хамгаалагдаагүй, эсвэл хувийн хамгаалах хэрэгслийг зохих ёсоор хэрэглэдэггүй нь осол гэмтэлд өртөмтгий болгодог. Судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар уурхайчдын 267 нь (72%) тэдний харьяалагддаг бичил уурхайн байгууллага нь уурхайн ам, цооног, хонгилын аюулгүй байдлыг хангадаг гэж хариулжээ (Зураг 4-17). Аюулгүй ажиллагааны дүрэм, журмын хэрэгжилт Мандал болон Түнхэлд (91% ба 93%) сайн байгаа бол Алтайд (26%) сул байна. Энэ нь Алтай суманд албан ёсны АБУ-н үйл ажиллагаа эхлээд удаагүй, туршлагагүй байгаатай холбоотой байж болох юм. Зураг 4-18-д үзүүлснээр албан бус, хууль бус ашигт малтмал олборлогчдын бүлгүүдтэй (71% ба 47%) харьцуулахад албан ёсны бичил уурхайн байгууллагууд (76%-аас 85% хүртэл) амны бэхэлгээг илүү хийдэг байна.



Зураг 4-17. Уурхайн амны бэхэлгээ хийдэг эсэх (оролцогчдын тоо, судалгааны бүс нутгаар)




Зураг 4-18. Уурхайн цооног, амны бэхэлгээ хийдэг эсэх (оролцогчдын тоо, зохион байгуулалтын хэлбэрээр)

Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийн дагуу уурхайн аманд нуралт, гулсалтаас сэргийлж шуудайтай элс, шороо, чулуу, мод, бетоноор хамгаалах ёстой. Уурхайн босоо, налуу амны амсрыг зориулалтын материалаар хашиж, хамгаалалт хүрээ хийнэ. “Аюултай” гэсэн анхааруулах тэмдгийг амны дээр, мөн дотор талд тавина. Нөхөрлөлүүд босоо амны аюулгүй байдлыг хэрхэн хангадаг талаар асуухад ихэнх нь банзаар амны хаалт хийдэг (60%), нүхний дээгүүр саравч байрлуулдаг (41%) гэж хариулсан байна (Зураг 4-20). Бусад нь анхааруулах тууз (39%), анхааруулах тэмдэг (44%) ашигладаг гэсэн бол 13% нь аюулгүй байдлын арга хэмжээ огт авдаггүй байна.




Зураг 4-19. Бэхэлгээтэй аманд ажиллаж байгаа нь (planetGOLD)




Зураг 4-20. Оролцогчдын нэрлэсэн уурхайн амны аюулгүй ажиллагааг хангахад авч хэрэгжүүлдэг арга хэмжээнүүд (n=371; олон хариулттай, нийт=744)

Хүдэр олборлох, баяжуулахтай холбоотой бүхий л ажиллагаанд төрөл бүрийн хувийн хамгаалах хэрэгсэл шаардагдана. Судалгаанд оролцогчдын 57% нь НБХХ-г тогтмол ашигладаг, 22% нь заримдаа хэрэглэдэг гэж хариулжээ (Зураг 4-19). Судалгааны бүс нутгуудын хэмжээнд НБХХ-ийн тогтмол хэрэглээ нь өөр өөр

байсан. Түнхэлд 83%, Баянголд 42% нь хамгаалах хэрэгсэл өмсдөг бол уурхайчдын бараг тал хувь нь (46%) огт хэрэглэдэггүй байна. Зохион байгуулалтын хэлбэрээр нь авч үзвэл бичил уурхайн байгууллагын (нөхөрлөл, ТББ) гишүүн уурхайчдын дийлэнх нь (үргэлж 73%) НБХХ байнга ашигладаг бол албан бус болон хууль бусаар олборлогчдын дунд энэ талаар туйлын хангалтгүй байна (35% ба 33%) (Зураг 4-21).




Зураг 4-21. Олборлолтын үед НБХХ-ийн хэрэглээ (судалгааны бүс нутгаар)



Зураг 4-22. Олборлолтын үйл ажиллагаанд оролцогчдын НБХХ-ийн хэрэглээ, (зохион байгуулалтын хэлбэрээр)

Уурхайн талбайд хувийн хамгаалах хэрэгслийг байнга эсвэл заримдаа ашигладаг гэж хариулсан 293 (79%) уурхайчид ихэвчлэн бээлий (89%), дуулга (85%), маск (58%) зэргийг өмсдөг байна.

Судалгаанд оролцсон нийт уурхайчдын тал хувь нь арьс, хөлөө хамгаалахын тулд хамгаалалтын хувцас, гутал өмсдөг. Харин чих, нүдний хамгаалах хэрэгслийг хамгийн бага хэрэглэдэг байна. Малгай, бээлий, хамгаалалтын гутал, хувцсыг хүдэр олборлох, баяжуулах бүхий л явцад өмсөхийг зөвлөдөг ба техниктэй харьцах үеийн хэт чанга дуу чимээнээс хамгаалах зорилгоор чихний хамгаалалт хэрэглэх шаардлагатай байдаг. Дуу чимээ нь эрсдэлт хүчин зүйлийн нэг гэдгийг уурхайчид ихэвчлэн дутуу үнэлдэг байна.




Зураг 4-23. Хэрэглэгдэж буй НБХХ-ийн төрөл (n=293; олон хариулттай, нийт=1,318)

Уурхайчдын дийлэнх нь хамгаалах хэрэгслээ өөрсдөө худалдаж авдаг (76%). Судалгаанд хамрагдагсдын зарим нь нөхөрлөл, ТББ-аасаа (18%), ялангуяа Мандал сумын бичил уурхайчид (29%) байгууллагаасаа авсан байна. Уурхайчдын цөөнх (3%) нь хамгаалах хэрэгслээ бусад уурхайчдаас зээлэн авч хэрэглэдэг байна.


4.3.2. Уурхайн талбай дахь аюулгүй ажиллагааны дүрэм

Аюулгүй ажиллагааны дүрэм нь уурхайчдыг аюулд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд маш чухал механизм боловч яаралтай нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан байх шаардлагатай. Жишээлбэл, босоо ам нурах, химийн бодис асгарах, гэмтэл бэртэл авахад ХАБЭА-н менежментийн төлөвлөгөө шаардагдана. Бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмэнд бүх уурхайчдыг ХАБЭА-н талаарх сургалтад хамруулах, тодорхой ажил үүргийг гүйцэтгэхээс өмнө (тухайлбал, тэсэлгээний ажил гүйцэтгэх) аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, амны үзлэг шалгалт хийх, аюулгүй байдал, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах, түүнчлэн ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн томилох зэрэг үүргүүд багтана.

Зураг 4-24-т судалгааны бүс нутаг тус бүрт олборлолтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө уурхайчдад аюулгүй байдлын зааварчилгааг тогтмол өгдөг эсэхийг харуулав. Ерөнхийдөө бичил уурхай эрхлэгчдийн 72% нь аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол авдаг бөгөөд Түнхэлд 99% нь зааварчилгаа авдаг бол Алтайд 34% нь авдаг гэж хариулжээ.




Зураг 4-24. Олборлолт эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа авдаг оролцогчид (судалгааны бүс нутаг, хүйсээр)




Зураг 4-25. Олборлолт эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа авдаг оролцогчид (зохион байгуулалтын хэлбэрээр)

Бичил уурхайн байгууллагын төрлөөр нь авч үзвэл бичил уурхайн байгууллагуудад харьяалагддаг уурхайчдын 96% нь олборлолт эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа авдаг гэж хариулсан бол хууль бус ашигт малтмал олборлогчид аюулгүй ажиллагааны зааварчилгаа хамаагүй бага (26%) авдаг байна. Судалгаанд хамрагдагсдаас аюулгүй ажиллагааны зааврыг сард хэдэн удаа авдаг болохыг асуухад тал хувь нь (52%) өдөр бүр авдаг, харин 11% нь сард 1-2 удаа л зааварчилгаа авдаг гэж хариулжээ. Аюулгүй ажиллагааны зааварчилгааны агуулга, чанарыг энд үнэлээгүй болно.

Судалгаанд оролцогчдоос БУ-н байгууллага аюулгүй ажиллагааг хангах төлөвлөгөө, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулсан эсэхийг асуухад оролцогчдын талаас илүү хувь нь (54%) “тийм” гэж хариулжээ (Зураг 4-26). Түнхэл тосгоны уурхайчид аюулгүй ажиллагааны зааварчилгаа хамгийн их авдаг (Зураг 4-26) бөгөөд ихэнх бригадууд ажлын аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө боловсруулсан байна (65%). Энэ үзүүлэлт нь Алтай суманд хамгийн доод түвшин (27%)-д байна. Зураг 4-27-д зохион байгуулалттай албажсан, албан бус, хууль бусаар ашигт малтмал олборлогчдын хоорондох тодорхой ялгааг харуулав.




Зураг 4-26. Эрсдэлийг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлын төлөвлөгөөтэй эсэх (судалгааны бүс нутгаар)




Зураг 4-27. Эрсдэлийг бууруулах, ажлын байрны аюулгүй байдлын төлөвлөгөөтэй эсэх (зохион байгуулалтын хэлбэрээр)

Бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу нөхөрлөлийн ахлагч уурхайчдынхаа ажлын байран дахь аюулгүй байдал, эрүүл мэндийн нөхцлийг хариуцдаг. Олборлолтын талбайд бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийг сахин хамгаалах үүрэгтэй нөхөрлөлийн ахлагч эсвэл ХАБЭА-н ажилтан байгаа нь эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрэм, журмыг дагаж мөрдүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах ажлын чухал үүрэг гүйцэтгэнэ. Үүнд уурхайчдын ХАБЭА-н дүрэм, журам, зааврыг дагаж мөрдөж буй байдалд хяналт тавих ажил орно. Судалгаанд оролцогчдын нийт 53% (Зураг 4-28) нь уурхайн талбайд аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтантай гэж мэдээлсэн бөгөөд бүс нутгаар нь авч үзвэл Түнхэл, Есөнбулагт энэ үзүүлэлт 79%, Алтайд ердөө 19% байна. Энэ нь Алтай сумын хувьд бичил уурхайн мэдлэг, туршлага маш зөрүүтэй байгааг илтгэж байгаа юм. Баянгол суманд одоогоор зөвшөөрөлтэй газар байхгүй тул судалгаанд хамрагдагсдын зөвхөн 27% нь аюулгүй ажиллагааны ажилтантай гэж хариулжээ. Аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг дагаж мөрдөх байдал нь байгууллагад харъялагддаг зохион байгуулалтад орсон уурхайчдын дунд хамгийн өндөр (84%) байсан бол энэ үзүүлэлт албан бус болон хууль бус уурхайчдын дунджаас хамаагүй доогуур хувьтай байна (тус тус 12% ба 22%).




Зураг 4-28. Уурхайн талбайд ХАБЭА хариуцсан ажилтантай эсэх (судалгааны бүс нутгаар, хүйсээр)




Зураг 4-29. Уурхайн талбайд ХАБЭА хариуцсан ажилтантай эсэх (зохион байгуулалтын хэлбэрээр)

Олборлолтын талбай дахь аюулгүй ажиллагааны төлөвлөгөөний нэг чухал хэсэг нь аюулгүй ажиллагааны анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ болон самбарыг ялангуяа босоо ам, химийн бодис, тэсэрч дэлбэрэх бодис зэрэг аюултай материалыг хадгалах гэх мэт аюултай газарт байрлуулах явдал юм. Судалгаанд хамрагдагсдын дөрөвний нэг орчим нь (28%) уурхайн талбай дээр аюултай газрыг тэмдэглэх ямар ч тэмдэг тэмдэглээгүй гэж хариулсан бол харин бусад нь тэмдэг (22%), тууз (16%), самбар (18%) болон бусад материал ашигладаг гэжээ. Зураг 4-30-аас харахад аюулгүй ажиллагааны тэмдэг ашиглах нь албан бус болон хууль бусаар ашигт малтмал олборлогчдын дунд харьцангуй бага байна. Харин бичил уурхайн байгууллагууд хамгийн их ашиглаж хэвшсэн байдал ажиглагдаж байна.




Зураг 4-30. Олборлолтын талбайд аюулгүй ажиллагааны анхааруулга тэмдэг, тэмдэглэгээ тавьдаг эсэх (зохион байгуулалтын хэлбэрээр)

Уурхайчдын хувьд гарч болзошгүй аюулыг тодорхойлох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэгтэй байх, дадал болгох нь маш чухал ур чадвар юм. Судалгааны үеэр судалгаанд хамрагдагсдаас уурхайн аманд аюулгүй байдлын ямар нэгэн эрсдэл ажиглагдсан эсэхийг асуусан. Энэ асуултаар дээр дурдсан шалтгаанаар уурхайчдын эрсдэлийг таньж мэдэх чадвар, эрсдэл байгаа эсэх талаар ямар нэг дүгнэлт хийх боломжгүй юм. Зураг 4-31-д үзүүлснээр нийт судалгаанд хамрагдагсдын 30% нь уурхайн аманд эрсдэл ажиглагдсан гэж хариулжээ.



Зураг 4-31. Уурхайн цооногт ямар нэг аюулгүй ажиллагааны эрсдэл байгааг ажигласан эсэх (судалгааны бүс нутаг, хүйсээр)


Эрсдэлийг тогтоосон гэж хариулсан 112 уурхайчдын ихэнх нь хад чулуу, хөрсний нурултыг томоохон эрсдэл гэж нэрлэсэн (59%), харин 7% нь бэхэлгээ муу гэж хэлжээ. Бусад нь ерөнхий эрсдэлтэй орчны талаар мэдээлсэн (13%), гэхдээ согтууруулах ундааг ажлын байран дахь эрсдэлт хүчин зүйл гэж дурдсан (2%) байна.



Зураг 4-32. Уурхайн ам, цооногт эрсдэл байгаа гэж мэдээлсэн оролцогчид (n=112)


4.3.3. ХАБЭА-н чадавхыг бэхжүүлэх

Зураг 4-33-д харуулснаар нийт судалгаанд хамрагдагсдын 59%, Есөнбулагт 81%, Алтайд 38% нь ХАБЭА-н сургалтад хамрагдсан байна. Сургалтын цар хүрээ, агуулгыг үнэлээгүй болно. Судалгаанд оролцогчдын дөнгөж 11% нь сүүлийн хоёр жилийн хугацаанд эрүүл мэндийн сургалтанд хамрагдсан гэж дурдсанаас (Бүлэг 8) үзвэл уурхайчид олборлолтын үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа гэх мэт жижиг заавар зөвлөгөөг сургалт гэж тооцон давхар мэдээлсэн гэж таамаглаж болно.



Зураг 4-33. ХАБЭА сургалтад хамрагдаж байсан эсэх (судалгааны бүс нутаг, хүйсээр)

Судалгаанд оролцогчид уурхайн талбайд ХАБЭА-н стандартыг дагаж мөрдөж байгаа эсэх талаар бараг бүх оролцогчид стандартыг хатуу, чандлан дагаж (58%) мөрддөг, (36%) дагаж мөрдөнө гэж хариулав (Зураг 4-34). Гэсэн хэдий ч судалгаанд оролцогчдын 61% нь өөрсдийгөө ХАБЭА-н сургалтанд хамрагдсан гэж хариулж байгаа нь уурхайчид зөвхөн ХАБЭА-н шаардлагын нэгээхэн хэсэг болох тухайлбал малгай өмсдөг гэдгийг ХАБЭА-н шаардлагыг биелүүлдэг гэж үзсэн учир энэ нь бодит байдлаас хэтрүүлсэн өндөр үзүүлэлт байж болох юм. Энэхүү тайлбар нь оролцогч талуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр тодорхойлогдсон ХАБЭА-н сургалтын хэрэгцээ өндөр байгаатай нийцэж байна (Бүлэг 8).



Зураг 4-34. Судалгаанд оролцогчдын уурхайн талбай дээр ХАБЭА стандартыг мөрддөг талаарх өөрийн үнэлгээ (судалгааны бүс нутгаар, хүйсээр)

Гэсэн хэдий ч судалгааны үр дүн бүс нутгуудын ялгаатай байдлыг харуулж байгаа бөгөөд Есөнбулаг, Түнхэлд ХАБЭА-н дүрэм журмын хэрэгжилт харьцангуй өндөр, Алтайд бага үзүүлэлттэй байна. Сонирхолтой нь, эмэгтэйчүүдийн ХАБЭА-н сургалтад хамрагдсан байдал өндөр байсан (7%) бөгөөд ХАБЭА-н стандартыг харьцангуй илүү дагаж мөрддөг байна (дагаж мөрддөг хүмүүсийн 3% нь эмэгтэй).

4.3.4. Дүгнэлт

Тайлангийн 4.1-р бүлэгт алтны үндсэн ордоос олборлолт явуулахад ихэвчлэн биеийн хүчний гар ажиллагаа шаарддаг тул уурхайчид тэсэлгээ хийлгэх, сайжруулсан тоног төхөөрөмж ашиглахыг хүсдэг гэдгийг тайлбарласан болно. Хэдийгээр алтны бичил уурхайд ноцтой осол аваар гараагүй гэж мэдэгдэж байгаа боловч ажил нь аюултай хэвээр байгаа бөгөөд хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартыг дагаж мөрдөх нь амин чухал хэвээр байсаар байна. Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар тодорхой ойлголтгүй, хувийн хамгаалах багаж хэрэгсэл хэрэглэдэггүй, уурхайн ам болон уурхайн талбайн бүсэд эрсдэлийн үнэлгээ хийдэггүй зэрэг байдал нь гэмтэл бэртэл авах, амь насаараа хохирох эрсдэлийг нэмэгдүүлдэг. Алтны үндсэн ордоод тэсэлгээ хийх ажлыг лицензтэй компаниар гүйцэтгүүлэх ёстой боловч санхүүгийн бэрхшээлээс шалтгаалж нууцаар тэсэлгээ хийж байгаа нь ажлын байран дахь аюул осол, уурхайн цооногт чулуулаг болон хөрсний нуралт үүсэх эрсдэл үүсгэнэ. Ганцаарчилсан ярилцлагын үеэр Сэлэнгэ аймагт олборлолт хийж байсан нэг уурхайчин олборлолтын талбайд тэсэлгээ хийсний улмаас хөнгөн гэмтэл авсан гэж хариулсан.

Энэ бүлэгт судалгааны бүс нутгаар бичил уурхайчид ХАБЭА-н дүрмийг дагаж мөрдөж байгаа байдал, зохион байгуулалтын хэлбэр нь ямар ялгаа бий болгож байгаа харуулахыг зорьсон болно. Судалгаанд оролцсон бичил уурхайчдаас уурхайн амны аюулгүй ажиллагааг хангаж ажилладаг (72%), хувийн хамгаалах хувцас тогтмол (79%) өмсдөг гэж мэдэгдсэн уурхайчдын тоо өндөр гарч байлаа. Энэ үзүүлэлт Түнхэлд илүү өндөр хувьтай гарч байгаа бол Алтайд хамгийн бага байсан боловч бүртгэлтэй байгууллагуудын хувьд мэдэгдэхүйц өндөр, харин хууль бус ашигт малтмал олборлогчдын хувьд хамгийн бага үзүүлэлттэй байв.

Аюулгүй ажиллагааны журамтай гэж хариулсан оролцогчдын тоо бага байсан ба оролцогчдын 54% нь аюулгүй ажиллагааны төлөвлөгөөтэй, 53% нь ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтантай гэж мэдээлсэн. Эдгээр нь уурхайн талбайд ХАБЭА-н арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд мониторинг хийхэд чухал ач холбогдолтой юм. Судалгааны бүс нутгаар дүн шинжилгээ хийж үзвэл Түнхэлд аюулгүй ажиллагааны талаар илүү олон удаа арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бол Алтайд цөөн удаа зохион байгуулжээ. Хууль бусаар ашигт малтмал олборлогчид аюулгүй ажиллагааны шаардлагыг хамгийн бага дагаж мөрддөг бөгөөд олборлолтын талбайд аюултай газарт тэмдэглэгээ тавих зэрэг энгийн арга хэмжээ (зөвхөн 35% -нь) авдаг байна.

Аюулгүй ажиллагааг дагаж мөрдөх чадавхийн хувьд судалгаанд хамрагдагсдын 59% нь ХАБЭА-н сургалтад хамрагдсан гэж мэдээлсэн боловч сургалтын хамрах хүрээг үнэлээгүй бөгөөд уурхайчдын дөнгөж 58% нь ХАБЭА-н дүрмийг чанд мөрддөг гэж мэдээлсэн байна. ХАБЭА-н дүрэм журмыг дагаж мөрдөж байгааг үнэлэх нь тодорхой бэрхшээлтэй тулгарч байлаа. Нийгмийн зүгээс нөлөөлдөг өрөөсгөл хандлагын улмаас асуултанд хэтрүүлэн мэдээлсэн байх магадлалтай байна. Судалгааны үр дүнг баталгаажуулахын тулд газар дээр нь хэрхэн дагаж мөрдөж байгааг ажиглах боломжгүй байв (Бүлэг 1-4-ийг үзнэ үү).

Судалгааны үр дүнгээс харахад бичил уурхайчдыг ХАБЭА-н чиглэлээр илүү чадавхжуулах шаардлагатай байгааг харуулж байна. Энэ нь зөвхөн аюулыг зайлуулах гэх мэт аюулгүй ажиллагааны зарим арга хэмжээгээр хязгаарлагдахгүй бөгөөд ХАБЭА-н эрсдэлийг хэрхэн тодорхойлох, үнэлэх, ХАБЭА-н төлөвлөгөөг боловсруулж, амжилттай хэрэгжүүлэх чадавх бий болгох хэрэгтэй байгаа юм. Судалгааны үр дүнгээс харахад зохион байгуулалттай уурхайчдын ХАБЭА-н сургалтад хамрагдалт, олж авсан мэдлэг, мэдээлэл нь харьцангуй өндөр байгааг харуулж байна. Энэ нь тухайн салбарын албажуулалтын нэг эерэг талыг баталгаажуулж байна.

5. Мөнгөн усны хэрэглээ

Мөнгөн ус нь задралд ордоггүй, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг бохирдуулагч бодис юм (АБУЗ, 2020). АБУ-н салбар нь хүний үйл ажиллагааны улмаас бий болсон мөнгөн усны ялгарлын хамгийн том эх үүсвэр болдог (НҮББОХ, 2019). Алт олборлогчид мөнгөн усыг хямд өртөгтэй, ашиглахад хялбар гэж үздэг тул алт ялган авахдаа хэрэглэх хандлагатай байдаг. Гэвч алт барилт нь дөнгөж 20-50%-тай байдаг. Бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээ нь томоохон асуудал (4-р бүлэг) дагуулдаг сэдэв юм. Иймд энэхүү судалгаанд бие даасан бүлэг болгон авч үзлээ. Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр (ҮХ) болон үйл ажиллагааны төлөвлөгөөг (Монгол Улсын Засгийн газар, 2020) “Монгол Улсын алтны бичил уурхайн салбарын цогц судалгаа”-ны үр дүнг үндэслэж боловсруулсан. Энэхүү судалгааны дүгнэлтээр 2008 оноос эхлэн мөнгөн усыг хэрэглээг хориглосон хэдий ч алт олборлогчдын дунд далд хэлбэрээр байсаар байна гэж үзжээ. Алтны шороон ордод мөнгөн ус ашигладаггүй. Шороон ордуудын нөөц буурч байгаатай холбоотойгоор бичил уурхайд үндсэн ордын олборлолт ихсэж болно. Үүнийг дагаад мөнгөн усны далд хэрэглээ, хууль бус ажиллагаа ялангуяа хяналт муу газар тархах байдал үүсч болзошгүй юм.



Зураг 5-1. Мөнгөн усаар бариулсан “спонж” алт (Өнөөдөр сонин)

Энэ бүлэгт мөнгөн устай холбоотой эрх зүйн орчин, судалгааны таван бүс дэх мөнгөн усны хэрэглээний тооцоолол (planetGOLD Mongolia төслөөс хоёр газарт мөнгөн усгүй баяжуулах цех байгуулахаар төлөвлөсөн), бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээнээс үүсэх эрүүл мэндийн нөлөөлөл зэрэг мэдээллийг тоймлон хүргэнэ.

5.1 Мөнгөн усны хэрэглээг зохицуулах талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ

Монгол Улсын Их Хурлаас 2006 онд шинэчлэн найруулсан Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиар химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Энэ хуулинд заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага химийн хорт болон аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаарх бүх бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Түүнчлэн Байгаль орчны сайдын 2008 оны 135-р тушаалаар уул уурхайн үйлдвэрлэлд /алтны хүдэр боловсруулахад/ мөнгөн ус ашиглахыг хориглосон. Мөн 2009 онд Байгаль орчны болон Гадаад хэргийн сайд нарын хамтарсан тушаалаар “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах журам” -ыг баталсан нь мөнгөн ус агуулсан нэгдлүүдийг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдаалах үйл

ажиллагааны зохицуулалтыг хянах механизмыг бий болгосон. Засгийн газрын 2011 оны 176 дугаар тогтоолоор мөнгөн ус болон түүний органик ба органик бус нэгдлүүдийг “Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн бодисын жагсаалт”-д оруулж баталсан.

Төрөөс 2008 онд мөнгөн усыг тэглэх бодлого баримталж, ашигт малтмал боловсруулахад мөнгөн ус ашиглахыг албан ёсоор хориглосон. Энэхүү хоригийн дагуу иргэдийг хууль бус химийн бодис (цианид²¹, мөнгөн ус) хадгалж, ашиглаж байгаа талаар мэдээлэхийг хөхиүлэн дэмжих олон нийтийн сурталчилгааны кампанит ажил явуулсан (НҮБХХ, 2017). Тухайн жилд энэхүү санаачилгын хүрээнд орон нутгийн удирдлагууд химийн хорт бодисыг хууль бусаар ашигласнаас болж бохирдсон хэд хэдэн газрыг цэвэрлэхэд хүч чармайлт тавьж нийт 300 кг гаруй мөнгөн ус цуглуулсан байна (Монгол Улсын Засгийн газар, 2020).

2007 онд ашигт малтмал баяжуулах үйлдвэрүүдийн мөнгөн усны хэрэглээнд хяналт тавих зорилгоор Байгаль орчны яам, Үйлдвэр, худалдааны яам, Улсын мэргэжлийн хяналтын газар (УМХГ), Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ), Улсын мөрдөн байцаах газрын холбогдох мэргэжилтнүүд оролцсон ажлын хэсэг байгуулагдаж уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, хадгалалтад шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтын үеэр алтны үндсэн ордоос гар аргаар олборлосон хүдрээс мөнгөн ус ашиглаж алт ялгаж байсан 147 бегун тээрмийг хураан авч устгажээ. Одоогийн байдлаар мөнгөн усыг орлуулах технологи болгон шлюз, баяжуулах ширээг алт ялган авахад ашиглаж байна. Гэсэн хэдий ч бичил уурхайчид худалдаж авч чадахуйц, өндөр хүчин чадалтай баяжуулах ширээ ховор байдаг. Зах зээл дээр байгаа хямд үнэтэй баяжуулах ширээ нь ихэвчлэн Хятадад үйлдвэрлэгдсэн байдаг бөгөөд боломжит түвшинд алт барьж чадах эсэх нь тодорхойгүй, засвар үйлчилгээний зардал нь өндөр тул уурхайчид сонгож авдаггүй байна (Монгол Улсын Засгийн газар, 2020). Одоогоор улсын хэмжээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо, Өмнөговь аймгийн Ханхонгор суманд албан ёсны зөвшөөрөлтэй мөнгөн усгүй баяжуулах хоёрхон цех байна.

2013 оны 10-р сарын 10-ны өдөр Монгол Улс Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцод нэгдэн орж 2015 оны 4-р сарын 30-ны өдөр соёрхон баталсан. Улмаар Засгийн газрын 2019 оны 8-р сарын 19-ний өдрийн 317-р тогтоолоор “Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”-г (ҮХ) баталсан. Уг хөтөлбөрт Минаматагийн конвенцын В хавсралтад заасны дагуу мөнгөн усны хэрэглээг халах үндэсний зорилтуудыг тодорхойлсон бөгөөд мөнгөн усны суурь судалгааны хүрээнд хийгдсэн газар дээрх бодит хэмжилтүүд, ажиглалт болон ярилцлагын явцад цуглуулсан мэдээлэл, үр дүн, дүгнэлтүүдийг үндэсний оролцогч талуудаар хэлэлцүүлэн баталгаажуулж алтны бичил уурхайн салбарт мөнгөн усны хэрэглээг бууруулах стратегийг боловсруулсан. (Монгол Улсын Засгийн газар, 2020 он).

²¹ Цианид нь ЗГ-ын 95-р тогтоолоор ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад багтдаг химийн бодис юм. (Монгол Улсын Засгийн газар, 2007 он)

5.2 Мөнгөн усны хэрэглээний тооцоолол

5.2.1 Үндэсний түвшин дэх мөнгөн усны хэрэглээ

Үндэсний хэмжээнд мөнгөн усны ялгарлын тооллогыг 2011 онд БОАЖЯ, НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэн (НҮБССХ)-тэй хамтран АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн (АНУ-ын БХА) санхүүгийн дэмжлэгтэйгээр явуулсан. Энэхүү тооллого нь Минаматагийн конвенцын Мөнгөн усны суурь үнэлгээ (МУСҮ)-ний нэг хэсэг байсан бөгөөд мөнгөн усны ялгарлын бүх эх үүсвэрийг хамруулсны дотор гар аргаар алт олборлох үйл ажиллагаанаас үүдсэн мөнгөн усны ялгарлыг багтаасан. Энэхүү тооллого нь НҮББОХ-ийн Мөнгөн усны ялгарлыг тодорхойлох, тоолох аргачлалыг ашиглаж уг тооцооллыг хийсэн байна (O'Neill & Telmer, 2017 он). 2011 онд БОАЖЯ-аас НҮБССХ болон АНУ-ын БХА-ийн дэмжлэгтэйгээр мөнгөн усны эрсдэлийн менежментийн үндэсний төлөвлөгөө боловсруулахад уг тооллогын үр дүн суурь үзүүлэлт, үндэслэх баримт бичиг болсон юм. Монгол Улс дахь мөнгөн усны ялгарлын хэмжээ жилд 548.4 тонн гэж тооцсон байна. Мөнгөн усны ялгарлын ихээхэн хувь алт олборлолтоос бий болж байгааг тогтоожээ (БОАЖЯ, 2011 он).

2018-2019 онд БОАЖЯ (хуучнаар БОНХЯ) мөнгөн усны тооллого хийх ажлыг удирдаж ажилласан ба 2019 онд НҮББОХ, ДДБОС-гийн техникийн туслалцаатайгаар “Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” боловсруулах хүрээнд хийгдсэн судалгаагаар олборлолт идэвхтэй явагдаж байгаа алтны шороон болон үндсэн ордуудын тоо, олборлосон, баяжуулсан хүдэр, алтны дундаж хэмжээг үндэслэн бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээг тооцож гаргажээ (Монгол Улсын Засгийн газар, 2020). Доорх хүснэгтэд мөнгөн усны болзошгүй хэрэглээ судалгааны бүс нутагт ямар байсныг харуулав.


Хүснэгт 5.2-1. Судалгааны бүс нутгийн мөнгөн усны хэрэглээ (мэдээлэл авах боломжтой бол) (Эх сурвалж: Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн Алтны бичил уурхайн цогц судалгаа, Монгол Улсын Засгийн газар, 2020)

Сэлэнгэ аймаг (нийт)	120.08 кг
Мандал	8.424 кг
Түнхэл	40.053 кг
Баянгол	39.143 кг
Говь-Алтай (нийт)	23.4 кг
Ховд (нийт)	20.28 кг
Үндэсний хэмжээнд нийт	235.413 кг


Дээрх тооцоог гравитацийн аргаар баяжуулахад гарах завсрын бүтээгдэхүүнээс алт ялгаж авахын тулд мөнгөн ус хэрэглэдэг гэсэн таамаглалд үндэслэсэн болно. Мөнгөн усны хэрэглээний магадлалыг үндэсний, бүс нутгийн, орон нутгийн түвшинд тооцохдоо "1.3:1" (Hg/Au) гэсэн дэлхийн дундаж харьцааг ашигласан болно (O'Neill & Telmer, 2017 он). Тооцоолох зорилгоор үндсэн орд бүхий газруудыг АБУ дахь мөнгөн ус ашиглах магадлалтай гэж үзсэн (Монгол Улсын Засгийн газар, 2020 он).

5.2.2 Судалгааны бүс нутаг дахь мөнгөн усны хэрэглээний мэдээлэл

Монгол Улсад АБУ-д мөнгөн ус хэрэглэх нь эрүүгийн хуулиар шийтгэгдэх гэмт хэрэг тул мөнгөн усны хэрэглээтэй шууд холбоотой хоёр асуултыг асуумж судалгаанд оруулсан болно. Мөнгөн усны хэрэглээний талаарх мэдээллийг судалгааны зорилгоор цуглуулахдаа ярилцагч мэдээлэл өгөхөөс болгоомжлох байдлыг харгалзан асуултыг аймгийн хэмжээнд тавьж, шударга хариулт өгөхийг хүссэн юм. Тухайн аймагт сүүлийн хоёр жилийн хугацаанд алт ялган авахад мөнгөн ус хэрэглэж байгааг харсан эсэхийг асуухад оролцогчдын 15% нь харсан, 82% нь хараагүй гэж хариулсан бол 3% нь асуултанд хариулаагүй байна. Зураг 5-2-д үзүүлснээр Баянгол (25%), Алтай (26%) -д мөнгөн усны хэрэглээ байгаа гэж үзжээ. Бичил уурхайчдын зохион байгуулалтын хэлбэрээр нь авч үзэхэд (Зураг 5-3) бүртгэлгүй нөхөрлөлүүдийн 6%, ТББ-уудын 12%, албан бус уурхайчдын 29% нь мөнгөн ус хэрэглэхийг харсан байна. Судалгаанд оролцогчид хуулийн хариуцлага хүлээхээс эмээж, мөнгөн ус хэр олон удаа хэрэглэдэг талаар дутуу мэдээлсэн байх магадлалтай. Гэсэн хэдий ч сүүлийн хоёр жилийн байдлаар судалгаанд хамрагдсан гурван аймагт мөнгөн усны хэрэглээ байгааг харж болно.




Зураг 5-2. Сүүлийн 2 жилийн хугацаанд аймгийн түвшинд мөнгөн усны хэрэглээ байгааг ажигласан эсэх, судалгаанд оролцогчид (судалгааны бүс нутаг, хүйсээр)



Зураг 5-3. Сүүлийн 2 жилийн хугацаанд аймгийн түвшинд мөнгөн усны хэрэглээ байгааг ажигласан судалгаанд оролцогчид (зохион байгуулалтын хэлбэрээр)

Оролцогчдоос танай аймагт мөнгөн ус зарж борлуулдаг уу? гэж асуухад дийлэнх нь (91%) “Үгүй” гэж хариулсан бол 8% нь мөнгөн усны худалдаа байгааг хүлээн зөвшөөрсөн байна. Хариултыг хүйсээр нь ялгаж харвал мөнгөн ус зарагддаг гэж эмэгтэйчүүдийн 10%, эрэгтэйчүүдийн 7% нь хариулжээ. Эндээс үзвэл хүйсээс хамаарсан мэдээллийн зөрүү бараг байхгүй байна. Зураг 5-3-т үзүүлснээр Мандал, Есөнбулагт аль алинд нь ижил хувьтай буюу 11% нь “Тийм” гэсэн хариулт өгчээ.



Зураг 5-4. Тухайн аймагт мөнгөн ус зарагддаг эсэх (судалгааны бүс нутгаар, хүйсээр)

Үндэсний хөтөлбөрийг боловсруулах хүрээнд хийгдсэн тооцооллоор судалгааны гурван аймагт, тодруулбал Сэлэнгэ аймгийн гурван судалгааны талбайд (Баянгол, Мандал, Түнхэл) мөнгөн усны хэрэглээ байгааг баталгаажуулсан (Бүлэг 5.2). Судалгаанд хамрагдсан газруудын бичил уурхайн байгууллагуудын удирдлагуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр мөнгөн усны хэрэглээ байж болзошгүй ч хууль ёсны бүртгэлтэй нөхөрлөл мөнгөн ус хэрэглэдэггүй гэж байв.

Манай баруун сумдад мөнгөн усыг өргөнөөр ашигладаг байж магад. Үүнийг урд хилээр оруулж ирдэг байх. Мөнгөн ус зардаг худалдаачид байдаг гэж би сонссон. Ийм худалдаа хийвэл хуулиар хатуу шийтгэдэг тул хүмүүс үүнийг маш нууцаар ашигладаг байх. Хэн ч бие биенийхээ талаар мэдээлдэггүй. Манай нөхөрлөлийн хувьд бид хууль ёсны бүртгэлтэй байгууллага тул мөнгөн ус ашигладаггүй.

Ганцаарчилсан ярилцлага, нөхөрлөлийн ахлагч, эрэгтэй, Ховд аймаг

Говь-Алтай аймгийн нөхөрлөлийн ахлагч хэлэхдээ тэдний нөхөрлөл хүдрээ мөнгөн усгүй баяжуулдаг гэв.

Бид хэзээ ч мөнгөн ус хэрэглэж байгаагүй. Бид алтаа тээрмээр ялгаж авдаг. Алтны худалдаачин дээр очиж бид өөрсдөө алтаа хайлуулж, жинлэдэг. Иймээс бидэнд мөнгөн ус хэрэглэх шаардлага байхгүй.

Ганцаарчилсан ярилцлага, нөхөрлөлийн ахлагч, эмэгтэй, Говь-Алтай аймаг

Зарим орон нутгийн удирдлага болон албан хаагчид аймагт нь мөнгөн ус хэрэглэдэг байсан талаар ярьсан.

Мөнгөн усны хэрэглээний талаарх албан ёсны мэдээллийн сан байхгүй бөгөөд нууцлагдсан байдаг. Ер нь сүүлийн 12 сарын хугацаанд мөнгөн ус хэрэглэсэн тохиолдол гарсан.

Ганцаарчилсан ярилцлага, төрийн байгууллагын ажилтан, эрэгтэй, Сэлэнгэ аймаг

Алт худалдаж авахдаа түүнийг хэрхэн яаж баяжуулсныг асуудаггүй, надад өгсөн алтыг л худалдаж авдаг. Сар орчмын өмнө би мөнгөн усаар ялгаж авсан 3 орчим грамм алт худалдаж авсан. Нийт 30-40 грамм иймэрхүү хэлбэртэй алт байсан (спонж).

Ганцаарчилсан ярилцлага, алтны худалдаачин, Сэлэнгэ аймаг

Алтыг баяжуулахдаа баяжуулалтын тээрмүүдэд мөнгөн ус ашигладаг байх. Тиймээс мөнгөн усны тэдний үйл ажиллагааг зогсоох замаар мөнгөн усны хэрэглээг зогсоож чадна гэж бодож байна. Манай аймгийн хувьд мөнгөн ус асгарсан 1 тохиолдол бүртгэгдэж, хэрэг гарсан газарт хоргүйжүүлэлт, саармагжуулалт хийсэн.

Ганцаарчилсан ярилцлага, төрийн байгууллагын ажилтан, Говь-Алтай аймаг

Одоогийн байдлаар орон нутгийн төлөвлөгөөнд мөнгөн усны хэрэглээг бууруулах талаарх тодорхой ажил тусгагдаагүй гэж орон нутгийн албан хаагч ярилцлагын үеэр мэдэгдсэн. Мандал сумын албан хаагч хэлэхдээ уурхайчдыг хууль бус үйл ажиллагаа руу түлхэх нь мөнгөн усны хууль бус хэрэглээ рүү түлхэх магадлалтай тул тухайн салбарыг албажуулах хэрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэсэн байна.

5.2.3 Судалгааны бүс нутаг дахь мөнгөн усны хэрэглээний тооцоолол

Судалгаанд хамрагдсан орон нутаг дахь мөнгөн усны хэрэглээний дундаж магадлалыг Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн Алтны бичил уурхайн салбарын цогц судалгаанд (Монгол Улсын Засгийн газар, 2020 он; O'Neill & Telmer, 2017 он) ашигласан аргачлалаар тооцохоор зорьсон. Цогц судалгааны баг орон нутгийн удирдлагуудаас авсан хоёрдогч мэдээлэлд үндэслэн тооцоогоо боловсруулсан бол төслийн баг газар дээрээс нь анхан шатны мэдээлэл цуглуулах зорилготой байв. Судалгаанд хамрагдсан таван бүсийн хүдэр олборлолт, алтны агуулга, сорьцын талаарх анхан шатны мэдээллийг уурхайчдаас цуглуулав. Мөнгөн усны хэрэглээний магадлалыг гаргахад баяжуулах дамжлагаас гарч буй завсарын бүтээгдэхүүнд мөн хэмжилт хийх ёстой. Энэ нь тухайн баяжуулах цехүүд зөвшөөрөх эсэхээс хамаарна. Дараах хүчин зүйлс, хязгаарлалтуудын улмаас судалгааны бүс нутгуудад бодитой, найдвартай тооцоолол хийх боломжгүй болсон. Тиймээс энэ удаа дээр дурдсан Цогц судалгааны мэдээллийг ашиглах, төслийн явцад тухайн газруудад мөнгөн усны хэрэглээний тооцооллыг дахин хийхээр шийдвэрлэсэн.

planetGOLD Монгол төслийн багт дараах сорилтууд тулгарч байсан болно.

Зорилтот бүлгийг тодорхойлох: Төслийн хүрээнд олж авсан мэдээллээс харахад уурхайчид завсрын бүтээгдэхүүнийг цехээс авч хувиараа баяжуулж байгаа тохиолдолд мөнгөн усыг голчлон ашиглаж байна. Бүхэл хүдэрт амалгамжуулалт хийхэд их хэмжээний мөнгөн ус шаардагдах бөгөөд энэ нь магадлал багатай учир баяжуулсан хүдрийн нийт хэмжээгээр тооцоход учир дутагдалтай юм. Иймд мөнгөн ус хэрэглэж байгаа уурхайчдын тоо (зорилтот бүлгийг тодорхойлох), тэдний боловсруулж буй хүдрийн хэмжээг тогтоох аргачлалыг боловсруулах шаардлагатай байна.

Орон нутагт ажиллах үеэр уурхайн талбайд олборлосон хүдэр, баяжуулсан хүдрийн хэмжээг үнэлэх боломжтой боловч цөөхөн хэдэн уурхайчид завсрын

бүтээгдэхүүнийг мөнгөн ус ашиглан баяжуулдаг гэсэн асуудлыг хараахан тооцож үзээгүй байна.

Анхан шатны мэдээллийн үнэн зөв байдал: Уурхайчид баяжуулалтын тоо баримтыг огт хөтөлдөггүй эсвэл нарийн тэмдэглэдэггүй тул уурхайчдын өгсөн техникийн мэдээлэлд мөнгөн усны хэрэглээний тооцоог үндэслэх нь бэрхшээлтэй байсан. Учир нь уурхайчид мөнгөн усны хэмжээг тооцоолоход ашигладаг чухал параметруудийн талаар бүртгэл муу хийдэг (Бүлэг 7.3). Жишээлбэл, бичил уурхайчдын олборлосон хүдрийн нийт хэмжээ баяжуулсан болон борлуулсан алтны нийт хэмжээтэй уялддаггүй.

Мэдээллийн дутмаг байдал: Уурхайчид алт барилтын түвшинг өмнөх баяжуулалтын туршлагаас олж авсан мэдлэг дээр үндэслэн тодорхойлохыг хичээдэг. Мөн алтны сорьцыг усан жингийн аргаар тодорхойлдог бөгөөд учир нь лабораторид сорьц тогтоолгохоор дээж илгээх нь эдийн засгийн хувьд ашиггүй байдаг байна. Энэ нь хүдрийн алтны агуулга, алт барилтын түвшинг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл хязгаарлагдмал гэсэн үг юм.

Мэдээллийн найдвартай байдал: Мөнгөн усны хэрэглээ нь хууль бус бөгөөд ял шийтгэлтэй тул алтны хүдэр олборлох, баяжуулах үйл ажиллагаатай холбоотойгоор цуглуулсан мөнгөн усны мэдээллийн хүрээ хязгаарлагдмал байсан.

Газарзүйн байршил: Уурхайчид ихэвчлэн өөр өөр газар, эсвэл өөр өөр суманд хүдэр олборлож, боловсруулдаг. Ялангуяа хүдрийн нэг хэсгийг хууль бусаар мөнгөн ус ашиглан боловсруулж байгаа тохиолдолд тогтвортой байршилд байдаггүй. Иймд мөнгөн ус хэрэглэж буй газрын байршлыг бодитоор тогтоох боломжгүй тул аймаг, сумын түвшинд гаргасан мөнгөн усны тооцооллыг орон нутгийн засаг захиргаа хэрхэн үзэж байгаагаар (хүдэр олборлож буй эсвэл баяжуулах цехийн байршил) тодорхойлох шаардлагатай болсон.

Гурван аймгийн мөнгөн усны хэрэглээний талаар ганцаарчилсан ярилцлага болон хоёрдогч тайлангуудын нэмэлт мэдээллийг дор авч үзнэ.

Сэлэнгэ аймаг

Монгол Улсад 1913 оноос алтны үндсэн ордоос хүдэр олборлож байсан Герман-Орос-Монголын хамтарсан Монголор хувь нийлүүлсэн нийгэмлэг анх мөнгөн ус ашиглан алт боловсруулж байсан тухай тэмдэглэгдсэн байдаг бөгөөд энэ туршлага нь тухайн үеийн жишиг байжээ. Монголор нь одоогийн Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт Бороогийн голын сав газарт үйл ажиллагаа явуулдаг байв. 1956 онд уг үйлдвэрийн алт баяжуулах тогоо хагарч их хэмжээний мөнгөн ус Бороо голд асгарснаар Бороогийн голын сав газарт хүний үйл ажиллагаагаар бий болсон их хэмжээний мөнгөн усаар бохирдсон. Ослын газраас урсгал дагуу 10 км-ийн цаана бохирдол илэрч байжээ. Засгийн газар 2008-2009 онд мөнгөн усаар бохирдсон газруудыг цэвэрлэх, саармагжуулах үндэсний кампанит ажил хийсэн.

Мөнгөн ус хэрэглэхтэй холбоотой зөрчлийн талаар Мандал, Баянголын орон нутгийн удирдлагууд мэдээлсэн. 2000 оноос өмнө Баянголын иргэд алт

боловсруулахдаа их хэмжээний мөнгөн ус ашиглаж байжээ. 2008 онд мөнгөн ус ашиглахыг хориглосон хэдий ч мөнгөн усыг хууль бусаар хэрэглэсээр байгаа гэж орон нутгийн засаг захиргаа үзэж байна. Ярилцлагын үеэр 2019 онд сумын өрхөөс мөнгөн ус илэрсэн гэсэн мэдээлэл өгсөн. Одоогоор сумын төлөвлөгөөнд мөнгөн усны хэрэглээ, түүнийг устгах талаар ямар нэгэн арга хэмжээ тусгагдаагүй байна.

Баянголд одоогоор мөнгөн усгүй баяжуулах цех байхгүй ч Нарт гэдэг газар олон тооны тээрэм ажиллаж байна. 2017 онд Нарт орчмоос цуглуулсан хөрс, усны дээжинд мөнгөн ус илрээгүй байна. Уурхайчид хүдрээ уурхайн талбайд баяжуулж, баяжмалыг өөр газар луу зөөж, дараа нь мөнгөн ус ашиглан нарийсгадаг гэж сэжиглэж байна. Уурхайн талбайд ярилцлага өгсөн уурхайчин хүдэр баяжуулахад мөнгөн ус ашигладаг гэж хэлсэн нь мөнгөн усны хэрэглээ байгааг баталж байна.

Мандалд хүдэр баяжуулах дөрвөн цех байдаг боловч одоогоор нэг нь ч албан ёсны зөвшөөрөлгүй байна. Нутгийн захиргааны байгууллага, ТБУТ төслийн дэмжлэгтэйгээр барьсан баяжуулах үйлдвэрт (2008 онд) тоног төхөөрөмж нь хуучирсан, баяжуулах ширээний тохируулга алдагдсан, үр дүнтэй алт ялгаж чадахгүй байна. Боловсруулах бусад гурван цех нь хувийн өмчлөлд байдаг. Гэсэн хэдий ч тус суманд мөнгөн ус ашигладаг гэсэн мэдээлэл байна. Мөнгөн ус ашиглах гол шалтгаан нь мөнгөн усгүй баяжуулах цехүүдийн алт барилт муу, алт худалдан авахдаа зах зээлийн ханшаас доогуур үнэ санал болгодогт байж болно.

Говь-Алтай аймаг

Говь-Алтайд алтны хүдэр боловсруулах гурван цех байдаг бөгөөд хоёр нь Есөнбулагт, нэг нь тус аймгийн Алтайд суманд байдаг. Гэхдээ бүгд албан ёсны зөвшөөрөл, нарийвчилсан үнэлгээгүй. Тиймээс мөнгөн усны хэрэглээг хязгаарлах, урьдчилан сэргийлэх зорилгоор 2019 онд хааж битүүмжилжээ. Үүнийг үл харгалзан тус аймагт мөнгөн ус алдагдсан хэд хэдэн тохиолдол бүртгэгдэж, тэр даруй цэвэрлэж саармагжуулсан гэсэн мэдээлэл байна.

Орон нутгийн албан тушаалтнуудын мэдээлснээр орон нутгийн удирдлагууд мөнгөн усны хэрэглээг бууруулах, хянах талаар БОАЖЯ-ны удирдамжийг дагаж мөрддөг. Үндэсний хөтөлбөрийн судалгааны баг 2018 оны 1-р сараас 4-р сар хүртэл Есөнбулаг, Алтай, Чандмань суманд ажиллах үеэр хүдэр баяжуулах цех орчмын хөрс, шлам, шламны уснаас дээж авч шинжлэхэд тэдгээрт агуулагдаж буй мөнгөн усны агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байсан байна. Сүүлийн жилүүдэд мөнгөн усны хэрэглээ мэдэгдэхүйц буурсан ч үе үе мөнгөн устай холбоотой тохиолдлууд гарч байжээ. Тухайлбал, 2019 онд сургуулийн хоолны газар, мөн аймгийн төвд байх алт, мөнгөний дархны газраас мөнгөн ус илэрчээ.

Аймгийн төлөвлөлтөд мөнгөн усны хэрэглээ, мөнгөн усыг орлуулах баяжуулалтын өөр аргыг нэвтрүүлэх талаар ямар нэгэн арга хэмжээ тусгагдаагүй байна. Бичил уурхайчдын байгуулсан баяжуулах цехийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ нь хянагдах шатандаа явж байна. Байгаль орчны байцаагч газар дээр нь шалгалт хийхэд мөнгөн ус илрээгүй. Төрийн албан

хаагчид химийн бодисын талаар практик мэдлэггүй, хориотой химийн бодис байгаа эсэхийг шалгах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлгүй гэдгээ хэлж байв. Хэрэв сэжигтэй химийн бодис хураан авсан тохиолдолд Улаанбаатар руу илгээх ёстой болдог ба үүнд зардал их гардаг байна.

Ховд аймаг

Алтайд баяжуулах цех байдаггүй. Аймгийн байгаль орчны байцаагчийн мэдээлснээр мөнгөн усны болзошгүй цэгүүдээс хөрснөөс хүнд металлын дээж авсан боловч 2018 оны байдлаар мөнгөн ус илрээгүй байна. Албан бус уурхайчид мөнгөн ус ашиглаж байна гэсэн дуудлага иргэдээс ирсэн боловч энэ нь батлагдаагүй, мөн орон нутагт мөнгөн ус илрүүлэх техникийн хэрэгсэл дутагдалтай байдаг гэж мэдээлсэн. Гэсэн хэдий ч аймгийн цагдаагийн газрын ажилтан ярилцлагадаа хувиараа ашигт малтмал олборлогчид мөнгөн ус ашигладаг, хяналт шалгалтын явцад мөнгөн ус илэрсэн хэд хэдэн тохиолдол гарсан гэж дурдсан байна.

5.3 Мөнгөн ус эрүүл мэндэд нөлөөлөх талаар мэдлэг, ойлголт

Уурхайчид мөнгөн усны хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд учруулах хор нөлөөг ойлгож мэдсэнээр мөнгөн усгүй баяжуулалтын технологи руу шилжих эрмэлзэлд чухал ач холбогдолтой юм. ҮХ-ийн хүрээнд хийгдсэн судалгааны тайланд (Монгол Улсын Засгийн газар, 2020) дурдсанаар өмнө хийгдсэн хэд хэдэн судалгаагаар алт олборлогчдын дунд мөнгөн усны хордлогын шинж илэрсэн бөгөөд цус, шээсэн дэх мөнгөн усны агууламж зөвшөөрөгдөх босго түвшнээс их буюу хамгийн багаас түгшүүр төрүүлэх түвшинд байгааг илрүүлсэн байна. ҮХ-ийн багийн хийсэн үнэлгээгээр эрүүл мэндийн ажилтнуудын мөнгөн усны хордлогыг илрүүлэх, оношлох, эмчлэх чадавх хязгаарлагдмал болохыг тогтоожээ.


planetGOLD төслийн хувьд энэхүү судалгааны хүрээнд хүн амын дунд мөнгөн усны хордлогын тархалтыг үнэлэх зорилгогүй хэдий ч судалгаанд оролцогчид мөнгөн усны эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөөг хэр мэдэж байгааг тодорхойлохыг зорьсон. Дараах хэсэгт энэ талаарх үр дүнг тоймлон харуулав.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь (94%, n=349) мөнгөн ус нь хүнд хортой гэдгийг мэддэг гэж хариулсан. Судалгаанд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд ойлголтын ялгаа байхгүй (94%, хоёулаа), судалгааны бусад газартай харьцуулбал Баянгол (10%) харьцангуй бага мэдлэгтэй байна.

Мөн шалгах асуултаар судалгаанд оролцогчдоос мөнгөн усны хэрэглээнээс үүдэж эрүүл мэндэд үзүүлдэг гол хор нөлөөг тайлбарлахыг хүссэн. Гэхдээ мөнгөн ус нь янз бүрийн эрхтэнд нөлөөлж болох ба мөнгөн усны хордлого нь өвөрмөц бус, янз бүрийн шинж тэмдгүүдээр илэрдэг тул энэ асуултаар мэдлэгийн зөрүүт үнэлэхэд хязгаарлагдмал байв. Өмнөх асуултад тийм гэж хариулсан 349 оролцогчоос 78 оролцогч (22%) энэ асуултад хариулж чадаагүй нь өмнөх хариултыг олны жишгээр хариулсан болохыг харуулж байна. Судалгаанд оролцсон 70 хүн (20%) нь ихэвчлэн мөнгөн усны хордлоготой холбоогүй нөлөө

буюу ясны сийрэгжилт, хорт хавдрыг нэрлэсэн байна. Мөнгөн усны цочмог хордлогын үед арьсны тууралт, амьсгалын замын болон хоол боловсруулах эрхтэн, элэгний гэмтэл, үргүйдэлд хүргэдэг. 23 оролцогч огт хариулж чадаагүй, эсвэл бүх биед нөлөөлдөг гэж ерөнхий хариулжээ.

Эндээс үзэхэд мөнгөн усны эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар анхан шатны мэдлэгтэй уурхайчдын тоо хамаагүй бага (54% орчим) байна. Энэ талаар эмэгтэйчүүд (57%) эрэгтэйчүүдийг (53%) бодвол арай илүү ойлголттой байна. Нийт судалгаанд оролцогчдын 44% нь мөнгөн усны хамгийн гол нөлөөллийг мэдрэлийн систем болон ургийн хөгжилд нөлөө үзүүлдэг гэж зөв нэрлэжээ. Зураг 5-4-ээс үзэхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн мэдлэгийн хооронд мэдэгдэхүйц ялгаа байсангүй.



Зураг 5-5. Мөнгөн усны хүний эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөний талаарх мэдлэг, хүйсээр

Говь-Алтайн бичил уурхайчин эмэгтэй мөнгөн усны нөлөөллийн талаар сургалт явуулах шаардлагатай байгааг дурдаад мөнгөн усны хордлогын шинж тэмдгүүд янз бүрийн байдлаар удаан илэрч гардаг, гэхдээ уурхайчид богино хугацаанд мөнгө олохын тулд хор хөнөөлийг мэдсэн ч тэр бүр тоодоггүй гэж хариулсан байна.

Гэр бүлийн гишүүд болон уул уурхайтай холбоотой бусад хүмүүс мөнгөн усны хор хөнөөлийг мэддэггүй, учир нь энэ нь ил шарх сорви шиг харагддаггүй. Түүнчлэн, зарим хүмүүс эрүүл мэндэд үзүүлэх үр дагаврын талаар мэддэг боловч өнөөдрийнхөө мөнгийг олохыг хүсдэг.

Ганцаарчилсан ярилцлага, эмэгтэй бичил уурхайчин, Говь-Алтай аймаг

Гол оролцогч талуудтай хийсэн ярилцлагаас харахад алтны бичил уурхай бүхий бүс нутагт мөнгөн усны уршиг, эрүүл мэндэд үзүүлэх бусад хор хөнөөлийн талаарх мэдлэг хангалтгүй байна. Иймд ТББ, нөхөрлөлийн ахлагч нар, бичил уурхайчид, мөн орон нутгийн төрийн албан хаагчдад энэ талаар мэдлэг олгох, чадавхжуулах хэрэгцээ шаардлага байгаа юм (Бүлэг 8). Энэхүү судалгааны хүрээнд тухайн сэдвийн эмзэг байдал, цаг хугацаа хязгаарлагдмал байсан зэргээс шалтгаалан мөнгөн усны хэрэглээ болон түүнээс үүдэн хүний эрүүл мэндэд учрах хор нөлөөний талаарх ерөнхий мэдлэг, ойлголтын асуудлуудын багахан

хэсгийг хамрууллаа. Судалгааны үеэр тавьсан асуултууд нь мөнгөн усны хордлогын талаарх бичил уурхайчдын мэдлэгийн зөрүүг үнэлэхэд хангалттай дэлгэрэнгүй биш байсан байж болох юм.

5.4 Дүгнэлт

Монгол Улсын Засгийн газар 2006 оноос хойш АБУ дахь мөнгөн усны хэрэглээг бууруулах, бохирдсон газрыг саармагжуулах арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн. 2008 онд уул уурхайн үйлдвэрлэл, хүдэр баяжуулах аливаа үйл ажиллагаанд мөнгөн ус ашиглахыг хориглосон. Өнөөг хүртэл энэ чиглэлээр хэд хэдэн эрх зүйн акт гарсны дотор хамгийн сүүлд, Монгол Улс 2015 онд Минамата конвенцод нэгдэн орсонтой холбогдуулан Засгийн газрын 317 дугаар тогтоолоор “АБУ-н үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” (ҮХ) батлагдсан юм. Бичил уурхайд мөнгөн усны далд хэрэглээ байсаар байгаа хэдий ч АБУ-д хичнээн хэмжээний мөнгөн ус ашиглаж байгааг тооцоолоход төвөгтэй байна.

Судалгаанд хамрагдсан таван бүсэд бичил уурхайчдын үйл ажиллагаа бүрэн албажаагүй байдал, мөн хэрэгт орохоос айсан болгоомжлол нь мөнгөн усны хэрэглээг зөв үнэлэхэд нэлээд бэрхшээлтэй байсан хэдий ч судалгааны үр дүн гурван аймагт мөнгөн ус ашиглах, худалдах, мөнгөн усаар хөрс бохирдсон тохиолдол гарч байсан зэрэг мэдээллээс дүгнэвэл мөнгөн усны хэрэглээ далд байсаар байгааг илтгэж байна. Энэхүү дүгнэлт нь Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн цогц судалгааны дүгнэлттэй нийцэж байгаа юм. Хэрэв уурхайчдад мөнгөн усгүй баяжуулах боломж байхгүй бол (Бүлэг 4.1-ийг үзнэ үү) мөнгөн ус үргэлжлүүлэн хэрэглэсээр байх болно. Алтны үндсэн ордод олборлолт явуулдаг бичил уурхайчид ихэвчлэн өөрсдийн мэдэлд эзэмшдэг баяжуулах цехгүй, харин хүдэр баяжуулах үйлчилгээ үзүүлдэг хөндлөнгийн цехийн эздээс хамааралтай байдаг. Одоогийн байгаа мөнгөн усгүй технологийн хувилбарын хувьд шлюз болон баяжуулах ширээний алт барилтын түвшин бага, чанар нь эргэлзээтэй байдгаас гадна засвар үйлчилгээний зардал өндөртэй. Мөн баяжуулах цехийн эзэд алт барилтын түвшинг бага, баяжуулалтын хаягдалд илүү алт үлдэхээр тоног төхөөрөмжөө тохируулдаг гэж үздэг тул одоо байгаа технологид уурхайчид итгэдэггүй байна. Заримдаа, хэрэв уурхайчид алт барилт хангалттай биш байна гэж үзвэл дамжлага дундаас гарах завсрын бүтээгдэхүүн буюу шлихээ авч харихыг хүсдэг нь шлихэд үлдсэн алтыг мөнгөн усаар амалгамжуулж ялгаж авах зорилготой байдаг. Мөнгөн усыг бүхэл хүдэрт ашиглаж байсан бол одоо ихэвчлэн завсрын бүтээгдэхүүнээс алт ялгаж авахад нууцаар ашиглаж байна. Бичил уурхайчид өөрсдийн эзэмшлийн мөнгөн усгүй, илүү сайн технологи бүхий баяжуулах цехтэй болох, эсвэл гуравдагч цехийн эзэдтэй ашгаа шударгаар хуваах боломж, нөхцөл бүрдэхгүй л бол энэ салбарт мөнгөн усны далд хэрэглээ буурахгүй. Албажсан бичил уурхайчдын хувьд алтны хүдэр олборлолт болон баяжуулалтын үйл ажиллагаандаа сайн технологи нэвтрүүлэх боломж хомс байна. Мөн хууль бус олборлолт явагдсаар байвал түүнийг дагалдан мөнгөн усны хэрэглээ байсаар байх бололтой.

Алтны бичил уурхайн салбарт ашиглагдаж буй мөнгөн усны хэмжээг нарийн тооцоолж чадсанаар асуудлын цар хүрээг ойлгох, нотолгоонд суурилсан арга

хэмжээг авч хэрэгжүүлэх, үр дүнд мониторинг хийх боломжийг бүрдүүлэх чухал нөхцөлийг бий болгох юм. Үүний зэрэгцээ Минаматагийн конвенцын тайлагналын хүрээнд мөнгөн усны хэрэглээ, нөхцөл байдалд үнэлгээ өгөх, дүн шинжилгээ хийх үндэс суурь нь болно. Судалгааны баг тухайн талбайгаас олборлосон хүдэр, баяжуулагдсан алтны тоо хэмжээ, баримт хөтлөлт дээр үндэслэн мөнгөн усны хэрэглээний тооцооллыг гаргахыг оролдсон боловч арга зүй дутагдсаны дээр ялангуяа мэдээлэл өгөхөөс зайлсхийх хандлага, бүртгэл тооцоо хөтөлж хэвшээгүй байдал, алтны агуулга, алтны сорьцыг нарийвчлалтай тогтоох арга хэрэгсэл дутагдалтай байгаа зэргээс шалтгаалж цуглуулсан мэдээллийн эх үүсвэр нь найдвартай биш. Түүнчлэн олборлосон хүдрийн болон баяжуулсан хүдрийн нийт хэмжээг тодорхойлоход бэрхшээлтэй байв. Иймд мөнгөн ус ашиглах магадлалтай завсрын бүтээгдэхүүний хэмжээг нарийн тодорхой тооцоолох боломжгүй байлаа.

Бичил уурхайчид мөнгөн усны хор хөнөөл, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учирч буй сөрөг нөлөөллийг ойлгож ухамсарлах нь мөнгөн усгүй баяжуулах технологи ашиглах эрмэлзэл бий болоход чухал түлхэц өгнө. Судалгаанаас үзэхэд, нийт оролцогчдын 54% мөнгөн усны эрүүл мэндэд үзүүлэх хор хөнөөлийн талаарх үндсэн ойлголт сул байна. Иймд энэ чиглэлээр мэдлэг, мэдээлэл олгох сургалт, чадавхжуулах үйл ажиллагаа хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна (Бүлэг 8).

6. Алтны бичил уурхай дахь жендэрийн зураглал

Энэхүү бүлгийн зорилго төслийн бүс нутгийн алтны бичил уурхайн жендэрийн динамик болон эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдад үзүүлж буй нийгэм-эдийн засгийн үр нөлөөг судалж, жендэрийн тэгш байдлыг сайжруулахын тулд тулгарч буй саад бэрхшээл болон боломжуудын талаарх мэдээллээр хангахад оршино. Судалгааны дүгнэлтэд үндэслэн жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг төслийн бүх үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллана.

6.1-р хэсэгт нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг жендэрийн өнцгөөс (2-р бүлгийг үзнэ үү) авч үзэж, боловсрол, гэрлэлтийн байдал болон орлого зэрэг жендэрийн динамикт нөлөөлөх хүчин зүйлүүдийг нэгтгэн дүгнэсэн. 6.2-р хэсэгт байгууллагын хэлбэр, ажил хөдөлмөр, манлайлал, чадавх бэхжүүлэх болон үйл ажиллагаан дахь жендэрийн хуваарийг чухалчлан үзэж, бичил уурхайн байгууллагууд дахь жендэрийн динамикийг судалсан болно. Монгол Улсад бичил уурхайчдын дийлэнх нь гэр бүлийн зохион байгуулалтад орж ажиллах хандлага түгээмэл байдаг тул ажил мэргэжил, гэр бүлийн ажил үүрэг нь хоорондоо нягт уялдаатай байдаг нь ажиглагдсан. Тиймээс 6.3-р хэсэгт шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үүрэг оролцоо, өрх гэрийн ажил үүргийн жендэрийн хуваарийг онцлон ахуйн хүрээний жендэрийн динамикийг тайлбарлана.

Жендэрийн зураглалыг бичил уурхайчдыг хамруулан явуулсан тоон судалгаа, үндэсний болон орон нутгийн төрийн байгууллагын албан хаагчид, нөхөрлөлийн ахлагч, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллүүдтэй хийсэн экспертийн ярилцлагын үр дүнд тулгуурлан гаргасан болно (1-р бүлгийг үзнэ үү). Жендэрийн асуудал нь эмзэг нарийн сэдэв тул албан ярилцлагын үед уг асуудлыг хөндөхөд хүндрэлтэй байдгийг харгалзан үзэж planetGOLD Монгол төслийн баг нь эмэгтэй бичил уурхайчидтай гүнзгийрүүлсэн ярилцлага хийсэн. Тус ярилцлагад оролцсон 30 эмэгтэй бичил уурхайчдыг тоон судалгаа хийх явцад сонгосон ба тэдний жендэрийн сэдвийн талаарх сонирхол, ойлголт болон мэдлэгийн түвшинг харгалзан үзсэн болно (аргачлалыг Хавсралт Г-ээс үзнэ үү).


6.1 Эмэгтэй, эрэгтэй уурхайчдын нийгэм-эдийн засгийн байдал

2-р бүлэгт судалгааны бүс нутаг тус бүрээр бичил уурхайчдын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тодорхойлсон. Энэ хэсэгт бичил уурхайн байгууллагуудын жендэрийн динамикт нөлөөлж болох нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтүүдийг тоймлон дүгнэсэн болно.

6.1.1 Нас болон гэрлэлтийн байдал

Бичил уурхай дахь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзвэл ерөнхийдөө насны зөрүү бага байсан ч 18-29 насны бүлэгт эрэгтэйчүүдийн дийлэнх хувийг эзэлж байгааг уг насны бүлэг дэх гэрлээгүй эрэгтэйчүүдийн тоо их байгаатай холбон тайлбарлаж болно (эмэгтэйчүүд 7%, эрэгтэйчүүд 16%) (Зураг 2-1). Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн ихэнх нь (76%) нөхөн үржихүйн насныхан (50-аас доош насныхан) байсан бөгөөд бичил уурхайд

гүйцэтгэж буй ажил үүрэг нь ургийн хөгжилд сөргөөр нөлөөлөх магадлалтайг анхаарах нь чухал. Жишээлбэл, хүнд зүйл өргөх эсвэл химийн бодисын нөлөөнд өртөх нь мэдрэлийн асуудал үүсгэж болзошгүй юм. Ерөнхийдөө судалгааны бүс нутаг бүрт гэрлээгүй эрэгтэй хүмүүсийн тоо эмэгтэйчүүдээс бага зэрэг илүү байсан бөгөөд хамгийн олон ганц бие эрэгтэйчүүд Баянгол (22%), Мандалд (21%) байна. Харин Мандалд ганц бие эмэгтэй (18%) хамгийн олон байна. Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь (эмэгтэйчүүдийн 87%, эрэгтэйчүүдийн 80%) гэр бүлтэй байна (Зураг 6-1). Гэр бүлтэй эмэгтэйчүүдийн тоо олон байгаа нь эмэгтэйчүүд энэ салбарт ихэвчлэн нөхрөө эсвэл гэр бүлийн бусад гишүүдтэйгээ хамт ажилладагтай холбон тайлбарлаж болно (Азийн сан, 2013 он). Бичил уурхайчдын дийлэнх нь гэр бүлийн зохион байгуулалтад орж ажилладаг тул гэр бүл цуцлуулсан эсвэл салсан эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдын тоо бага байсан. Мандал, Алтай сумдад бэлэвсэн бичил уурхайчин эмэгтэйчүүд (7%) цөөн байсан.




Зураг 6-1. Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдал (хүйсээр (n=100 эмэгтэй, 271 эрэгтэй))

Өрхийн ам бүлийн тоог судлахдаа (Зураг 2-2) хүүхэд болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тоог нарийвчилж асуугаагүй болно.

6.1.2 Боловсрол

Судалгаанд оролцогчдыг боловсролын түвшингээр авч үзэхэд эмэгтэйчүүдийн боловсролын түвшин өндөр байгаа нь жендэрийн урвуу зөрүү бий болсныг харуулж байна. Энэхүү дүгнэлт нь Монгол Улсын дундаж үзүүлэлттэй (IRIM, 2014) нийцэж байна. Хамгийн багадаа бүрэн дунд боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүдийн (88%) эзлэх хувь эрэгтэйчүүдээс (73%) илүү байна (Зураг 6-2). Алтай суманд бага ангийн боловсролтой (7%) болон дээд боловсролтой (бакалавр) эмэгтэйчүүдийн эзлэх хувь тус тус өндөр (29%) байв.



Зураг 6-2. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)

6.1.3 Хөдөлмөр эрхлэлт


Судалгаанд оролцогчдын тал хувь нь (эмэгтэйчүүдийн 49%, эрэгтэйчүүдийн 51%) бичил уурхайгаар алт олборлох нь тэдний үндсэн ажил гэж хариулсан (Хүснэгт 2.3-3). Харин үлдсэн хувийн дийлэнх нь хувиараа хөдөлмөр (эмэгтэйчүүдийн 13%, эрэгтэйчүүдийн 15%) эрхэлж орлого олдог бөгөөд эмэгтэйчүүдийн хувьд тэтгэвэр (7%), эрэгтэйчүүдийн хувьд мал аж ахуй (9%) орлогын эх үүсвэр болж байна. Харин эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн 7% нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй байна. Судалгаанд хамрагдагсдаас Алтай суманд ажилгүй хүмүүсийн эзлэх хувь хамгийн өндөр байна (эмэгтэйчүүдийн 21%, эрэгтэйчүүдийн 13%). Бичил уурхайгаас үндсэн орлогоо олдог эрэгтэйчүүд (37%) эмэгтэйчүүдээс (27%) илүүтэй давхар ажил хөдөлмөр эрхэлж байна. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн 15% нь газар тариалан, мал аж ахуй эрхэлж, хөдөө аж ахуйгаас орлогын эх үүсвэрээ бүрдүүлдэг бол эрэгтэй бичил уурхайчдын 17% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг гэжээ.

6.1.4 Нийгмийн үйлчилгээний хүртээмж

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, эрүүл мэнд, хүүхэд харах үйлчилгээ зэрэг нийгмийн үйлчилгээний хүртээмж нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэсэн хэдий ч төрөхийн өмнөх ба дараах эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, хүүхдээ өсгөх, асрах зэрэг асуудал нь эмэгтэйчүүдийн бие бялдар, оюун санааны эрүүл мэндийг тодорхойлох чухал хүчин зүйл ба эдгээрт анхаарал хандуулах шаардлагатай (Хэсэг 6.3-ыг үзнэ үү).

Судалгаанаас харахад эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдын гуравны нэг нь (36%) нийгмийн даатгалын шимтгэл тогтмол төлж байхад (Зураг 6-3), илүү олон эмэгтэй бичил уурхайчид эрүүл мэндийн даатгалыг тогтмол төлж (эмэгтэйчүүдийн 77% нь, эрэгтэйчүүдийн 58%) байна. Эрүүл мэндийн даатгал нь эрүүл мэндийн үйлчилгээ авахад чухал үүрэг гүйцэтгэдэг боловч эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж, хүртээмж нь чухал юм (2-р бүлгийг үзнэ үү). Судалгааны бүс нутгаар авч үзэхэд судалгаанд хамрагдсан хүмүүсийн 37% нь эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ авах боломжгүй байгаа нь тогтоогджээ. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хооронд ялгаа багатай боловч судалгааны бүс нутаг тус бүрээр авч үзвэл ялгаатай байдал харагдаж байна (Алтай суманд 50%, Түнхэл тосгонд 80% орчим). Судалгааны

явцад эрүүл мэндийн үйлчилгээний төрөл, чанарыг үнэлээгүй боловч эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдын хувьд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж нь бэрхшээлтэй хэвээр байгааг судалгааны үр дүн харуулж байна.



Зураг 6-3. Судалгаанд оролцогчдын нийгмийн үйлчилгээний хүртээмж (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)


6.1.5 Хүүхэд асран хамгаалал

Судалгааны үеэр хүүхдээ асран хамгаалах боломжийн талаарх асуудлыг хөндөөгүй боловч эмэгтэй бичил уурхайчидтай хийсэн гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр энэ асуудлыг хөндөж ярьсан байна. Судалгаанд оролцсон нийт эмэгтэйчүүдийн 80% нь, эрэгтэйчүүдийн 50% нь үр хүүхдээ асран хамгаалахад оролцдог гэж хариулсныг тэмдэглэх нь зүйтэй. Мөн түүнчлэн эмэгтэй бичил уурхайчид долоо хоногт эрэгтэйчүүдээс илүү олон цагийг өрх гэрийн ажилд зарцуулдаг (Хэсэг 6.3-аас үзнэ үү) бөгөөд хүүхэд асрах албан ёсны үйлчилгээ, гэр бүлийн дэмжлэг дутмаг байгаа нь эмэгтэйчүүдийн үйлдвэрлэлийн болон нөхөн үржихүйн асран халамжлах ажлын ачааллыг хоёр дахин нэмэгдэхэд хүргэдэг байна. Уурхайчид олборлолтын талбай дээр ажиллахын тулд түр зуурын суурьшлын бүс рүү нүүх шаардлагатай болдог. Энэ тохиолдолд албан ёсны хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах боломжгүй байдаг нь нэмэлт бэрхшээлүүд дагуулж болзошгүй юм. Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгоны судалгаанд оролцогч хоёр хүн хүүхдүүддээ боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахын тулд төрсөн нутагтаа өвөө, эмээ, хамаатан садныхаа хамт байлгадаг гэж тайлбарлаж байсан. Энэ нь эцэг эхчүүдэд олборлолтын талбай дээр илүү удаан ажиллах боломжийг олгодог байна (1-2 сар). Гэсэн хэдий ч судалгаанд хамрагдсан хоёр хүн тусдаа байгаа хүүхдүүдийнхээ бие бялдар, оюун санааны хөгжилд санаа зовж байгаагаа илэрхийлж байв. Монгол Улсад бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагаа нь улирлын шинж чанартай, эмэгтэй бичил уурхайчид олборлолтын талбай руу түр хугацаагаар шилжин суурьших шаардлага гардаг нь хүүхдийн оюун санааны эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй юм. Олборлолтын талбайд хүүхдүүдэд зориулсан хүүхэд харах үйлчилгээ шаардлагатай эсэхийг ойлгохын тулд энэ асуудлыг цаашид тодруулах хэрэгцээ байна.

6.2 Алтны бичил уурхай дахь жендэрийн динамик

6.2.1 Салбар дахь жендэрийн харьцаа ба ажиллах хугацаа

Төслийн хүрээнд хийсэн бичил уурхайн талбайн үнэлгээний үр дүнгээс харахад (planetGOLD Монгол, 2019 он) алтны бичил уурхайчдын баг нь голдуу 9 гишүүнээс бүрдэх бөгөөд 7 нь эрэгтэй, 2 нь эмэгтэй байна. Тиймээс Монгол Улсад бичил уурхайд ажиллагсадын 28% орчим нь эмэгтэй бичил уурхайчдаас бүрддэг гэсэн тооцоо гарчээ. Азийн сангаас гаргасан судалгааны тайланд дурдсанаар (2013 он) алтны үндсэн ордод ажилладаг бичил уурхайчдын 22% нь, шороон ордын 33% нь эмэгтэйчүүд байжээ. Эрэгтэйчүүд ихэвчлэн бие бялдрын хувьд хүнд хэцүү ажил (жендэрийн хөдөлмөрийн хуваарь) хийхээр уурхайд ажилд ордог бол эмэгтэйчүүдэд зориулсан ажлын байрны тоо хязгаарлагдмал байдаг. Цөөн тооны эмэгтэйчүүд хүдэр олборлох, боловсруулах чиглэлээр ажилладаг гэж хариулсан бол дийлэнх нь туслах ажилтан, захиргааны чиглэлээр ажилладаг гэж хариулсан байна. Бичил уурхайд 5-аас дээш жил ажилласан туршлагатай эмэгтэйчүүдийн тоог эрэгтэй бичил уурхайчидтай харьцуулж үзэхэд бараг ижил байна (58% ба 59%). Өнгөрсөн жил энэ салбарт ажиллаж эхэлсэн эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдтэй харьцуулбал илүү олон (эрэгтэй 14%, эмэгтэй 9%) байна. Эмэгтэйчүүд ажлын туршлагын хувьд энэ салбарт эрэгтэйчүүдтэй ижил байр суурь эзэлж байна. Гэсэн хэдий ч илүү олон эрэгтэйчүүд бүтэн жилийн турш ажилладаг (эрэгтэй 55%, эмэгтэй 40%) бол харин эмэгтэйчүүдийн 55 орчим хувь нь 4-р сараас 10-р сар хүртэл улирлын чанартай ажилладаг байна. (Зураг 6-4).



Зураг 6-4. Алтны бичил уурхайд идэвхтэй ажилладаг сарууд (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)

Хүснэгт 6.2-1. Бичил уурхайд ажилладаг хугацаа (сар, долоо хоног, өдөр тутамд) (хүйсээр)


	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)	Нийт (n=371)
Дундаж ажлын хоног- сараар			
Сард 9 хүртэл өдөр	17%	14%	15%
Сард 10 өдөр	13%	13%	13%
Сард 11 - 20 өдөр	47%	47%	47%
Сард 21 - 31 өдөр	23%	26%	25%
Дундаж ажлын хоног- 7 хоногоор			
1 өдөр	13%	15%	15%
2 - 3 өдөр	26%	26%	26%
4 - 5 өдөр	37%	34%	35%
6 - 7 өдөр	24%	25%	25%

Өдрийн дундаж ажлын цаг			
Өдөрт 2 ба түүнээс доош цаг	7%	1%	2%
Өдөрт 3 – 5 цаг	13%	12%	12%
Өдөрт 6 – 8 цаг	38%	44%	43%
Өдөрт 9 болон түүнээс дээш цаг	42%	43%	43%
Нийт	100%	100%	100%

Эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдын ажлын цаг хугацааг сар, долоо хоног, өдөр тус бүрээр авч үзвэл мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаагүй (Хүснэгт 6.2-1). Энэ нь хэдийгээр улирлын чанартай бичил уурхай эрхэлдэг эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс арай илүү байгаа ч уул уурхайн үйл ажиллагаа идэвхтэй явагддаг саруудад хоёулаа ойролцоо цаг хугацааг энэ салбарт зарцуулдаг гэсэн үг юм.

6.2.2 Зохион байгуулалт


Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд нь ижил төстэй хэлбэрээр зохион байгуулалтад орсон боловч хоорондоо ялимгүй ялгаатай байв. Эмэгтэйчүүд бичил уурхайн ТББ эсвэл бүртгэлгүй нөхөрлөлийн гишүүн байх хандлагатай байгаа бол эрэгтэйчүүд бүртгэлтэй нөхөрлөл эсвэл албан бус бүлэгт харьяалагдах буюу албан ёсны байгууллагад харьяалагддаггүй байна.



Зураг 6-5. Судалгаанд оролцогчдын байгууллагын зохион байгуулалтад орсон байдал (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)


6.2.3 Алтны бичил уурхайн ажил хөдөлмөр дэх жендэрийн хуваарь

Эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчид нь нийгэм, соёлын хэм хэмжээ, итгэл үнэмшил, боловсрол (жендэрийн хэм хэмжээ нөлөөлдөг), ур чадвар, сонирхол, эрх мэдлийн динамик, албажуулалтын түвшин зэргээс хамааран алтны нийлүүлэлтийн сүлжээнд ялгаатай үүрэг гүйцэтгэдэг. Ихэнх эмэгтэйчүүд туслах үйл ажиллагаа эрхэлдэг (91%) хэдий ч менежмент, хүдэр олборлох, боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг бол бараг бүх эрэгтэйчүүд (97%) хүдэр олборлох, боловсруулах ажлыг гүйцэтгэдэг байна (Зураг 6-6).



Зураг 6-6. Судалгаанд оролцогчдын бичил уурхайн үе шатуудад оролцдог оролцоо

Гэсэн хэдий ч дээрх дөрвөн ангиллын хүрээнд ажил үүргийн хуваарийг авч үзэхэд ажил хөдөлмөр дахь жендэрийн хуваарь илүү тодорхой харагдаж байна (Зураг 6-7). Эрэгтэй бичил уурхайчид хүдэр бутлах, алт угаах (тус бүр 59%), хүдэр олборлох, газар доорх ажлууд (тус бүр 54%), хүдэр нунтаглах (52%) гэсэн таван ажлыг давамгайлж хийдэг байна. Харин эмэгтэйчүүд туслах үйл үйлчилгээний хоол хийх (79%), хоол хүнс, бусад зүйл худалдан авах (63%), аяга таваг угаах (61%), цэвэрлэгээ хийх (55%) гэх зэрэг дөрвөн ажлыг голчлон гүйцэтгэдэг байна. Эмэгтэй бичил уурхайчдын хамгийн их оролцдог тав дахь ажил нь санхүүжилтээр хангахтай холбоотой ажил байна (49%).



Зураг 6-7. Судалгааны 5 бүс нутгийн алтны бичил уурхайн ажил хөдөлмөрийн жендэрийн хуваарь (n=100 эмэгтэй, 271 эрэгтэй; олон хариулттай, нийт=3,732)

Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэй бичил уурхайчдын 28% нь менежментийн үйл ажиллагаанд оролцдоггүй байгаа бөгөөд менежментийн үйл ажиллагаанд оролцдог эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдтэй адил тодорхой ажил үүрэг гүйцэтгэдэг байна. Тухайлбал, судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн 24% (эрэгтэйчүүдийн 13%) нь үйл ажиллагааны зөвшөөрөл авах, 23% нь санхүүгийн тооцоо бүртгэл хөтлөх ажилд оролцдог байна. Өөрөөр хэлбэл хоёр эмэгтэй тутмын нэг нь (49%) санхүүжилт олоход оролцож байна. Судалгааны таван бус нутагт ажил хөдөлмөрийн жендэрийн хуваариас харахад эмэгтэйчүүд хүдэр олборлох (ялангуяа хүдэр ялгахад 31%) болон хүдэр баяжуулахад (алт угаах, 44%) чухал үүрэг гүйцэтгэдэг байна.



Зураг 6-8. Түнхэл тосгоны уурхайн талбай дээрх хянагч ээлжийн хуваарь бөглөж байгаа нь (planetGOLD Монгол)

Тодорхой ажил хөдөлмөр дэх жендэрийн хуваарь нь судалгааны бүс нутаг тус бүрт ялгаатай байна. Тухайлбал, Алтай суманд судалгаанд оролцсон бүх эмэгтэй бичил уурхайчид хүдэр олборлох, боловсруулахтай холбоотой зарим ажил үүргүүдийг гүйцэтгэхэд оролцож байгаа бөгөөд судалгааны мэдээллээс харахад баруун аймгуудад иргэд уламжлалт соёлын хэм хэмжээг илүү дагадаг байна. Тиймээс эрэгтэй бичил уурхайчид алт худалдах, худалдан авах ажиллагаа, санхүүгийн гүйлгээнд хяналт тавих нь илүү их байдаг. Гэсэн хэдий ч Алтай сум дахь эмэгтэйчүүдийн түүврийн хэмжээ бага (n=14) байгаа тул эдгээр чиг хандлагыг орон нутгийн хэмжээнд судалгааны тоо баримтаар харуулахад хүндрэлтэй байсан болно. (Хүснэгт 6.2-2-г үзнэ үү). Судалгааны бусад бүс нутгуудад ялангуяа Мандал сум, Түнхэл тосгонд менежментийн ажлыг ихэвчлэн эмэгтэйчүүд хариуцдаг байна.

Хүснэгт 6.2-2. Удирдах ажилд эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн оролцоо, (судалгааны бүс нутгаар) (ногоон $\geq 50\%$, шар $\geq 25\%$)

	Эмэгтэйчүүд						Эрэгтэйчүүд					
	Баянгол	Мандал	Түнхэл	Есөнбулаг	Алтай	Нийт	Баянгол	Мандал	Түнхэл	Есөнбулаг	Алтай	Нийт
Судалгаанд оролцсон хүний тоо	15	28	20	23	14	100	37	84	51	39	50	271
Санхүүжилтээр хангах	53%	61%	60%	30%	26%	49%	27%	37%	49%	41%	33%	38%
Тоног төхөөрөмж/ сэлбэг хэрэгсэл худалдаж авах	7%	39%	50%	22%	11%	29%	14%	17%	39%	36%	25%	25%
Санхүү зохицуулах	0	43%	50%	22%	5%	28%	11%	13%	41%	33%	17%	22%
Санхүү, нягтлан бодох бүртгэл	0	25%	40%	26%	11%	23%	3%	11%	24%	21%	10%	13%
Алт худалдах	33%	50%	55%	22%	42%	43%	27%	33%	53%	10%	72%	41%
Аюулгүй ажиллагаа	0	36%	55%	30%	37%	35%	24%	23%	51%	41%	53%	38%
Олборлолт/үйл ажиллагааны зохицуулагч/ахлагч	7%	46%	45%	17%	26%	32%	8%	18%	27%	21%	33%	22%
Баяжуулах цехтэй	0	32%	45%	13%	11%	23%	8%	17%	27%	18%	10%	16%
Хууль ёсны зөвшөөрөл, бүртгэл гэх мэт	13%	25%	40%	22%	11%	24%	8%	11%	22%	15%	8%	13%
Оролцдоггүй	20%	18%	35%	57%	0	28%	30%	35%	14%	15%	2%	20%

Орон нутгийн төлөөллүүдийн хэлснээр хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг ТББ, нөхөрлөлийн зохион байгуулалтад шилжүүлснээр бичил уурхайд шинэ технологийг нэвтрүүлэх боломж бүрдсэн байна. Энэ нь эмэгтэйчүүдийн ажлын ачааллыг хөнгөвчилж байгаа боловч эдгээр технологийн онцлогийг энд нарийвчилж тусгаагүй болно. Алтны бичил уурхайн ТББ -ын тэргүүн болон нөхөрлөлийн ахлагч нар, иргэний нийгмийн байгууллагуудын тэргүүнтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын мэдээллээр эмэгтэй бичил уурхайчид хөрс хуулах, савлах, ангилах, шигших, алт угаах, хоол хийх, төсөв хийх, худалдан авах ажиллагаа зэрэг “хөнгөн” ажилд голчлон оролцдог. Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны ажилтан нь бичил уурхай дахь эмэгтэйчүүдийн оролцоог захиргааны болон санхүүгийн ажил үүрэгт илүү онцлон тэмдэглэж байлаа. Харин эрэгтэй бичил уурхайчид голдуу олборлох, тээвэрлэх, чулуу бутлах, газар ухах, хүнд юм өргөх зэрэг бүх хүнд хүчир ажлыг хийж гүйцэтгэдэг байна. Үүнийг нөхөрлөлийн ахлагч дараахь байдлаар тайлбарласан:

“Манай нөхөрлөлд 2 эмэгтэй, 7 эрэгтэй гишүүн байдаг. Эмэгтэйчүүд алт угаах, хоол хийх үүрэгтэй. Эмэгтэйчүүд хүнд жинтэй зүйл өргөх нь тахиромжтой бус бөгөөд бэртэл гэмтэлд илүү өртөмтгий байдаг. Хөдөлмөрийн хуваарь нь тэгш бус: амар хялбар хөдөлмөр нь эмэгтэй хүнд, хүнд ажил нь эрэгтэй хүнд ногддог. Бид олборлолтын талбай дээр 8-9 цаг ажилладаг” гэжээ.

Ганцаарчилсан ярилцлага, Ховд аймгийн нөхөрлөлийн ахлагч, эрэгтэй


Судалгааны тоон мэдээллийг нэгтгэж үзэхэд хүдэр олборлох, баяжуулахад эмэгтэйчүүд оролцож байгаа хэдий ч жендэрийн гүнзгийрүүлсэн судалгаанд оролцсон 30 эмэгтэй уурхайчнаас 17 нь алт олборлох үйл ажиллагааны хүч хөдөлмөр шаардсан хүнд ажлууд нь эмэгтэйчүүдийн хувьд энэ салбарт тулгарч буй томоохон бэрхшээл болж байгааг тэмдэглэв. Эдгээр эмэгтэйчүүдийн ихэнх нь хүнд чулуу үүрэх, багажтай ажиллах, босоо амнаас хүдэр гаргах гэх мэт хүнд хөдөлмөр эрхэлдэг байна. Баянгол, Мандал сумд болон Түнхэл тосгонд ажиллаж байгаа эмэгтэй уурхайчид нь уурхайн аманд ажиллаж байсан туршлагатай байсан. Баруун аймгуудын эмэгтэйчүүд (Алтай, Есөнбулаг сумд) энгийн технологи ашигладаг, механикжуулалтын түвшин доогуур, мөн Алтай суманд албан ёсны баяжуулах үйлдвэр байхгүйгээс хүнд чулуу зөөх зэрэг ажилд эмэгтэйчүүд түлхүү оролцох хандлагатай байдаг байна. Ярилцлагын үр дүнг газар зүйн байршлаар авч үзвэл тухайн орон нутгийн баяжуулалтын систем нь эмэгтэйчүүдийн үүрэг оролцоонд нөлөөлдөг болохыг мөн харуулсан байна. Иймээс хүдрийн ордын төрөл (шороон орд болон үндсэн орд), механикжуулалтын түвшин, түүнчлэн олборлолтын талбайн ажиллах хүчний нийгмийн бүтэц (өөрөөр хэлбэл байгууллага нь ихэвчлэн гэр бүлийн гишүүд, найз нөхөд, эсвэл хоорондоо холбоогүй хувь хүмүүсээс бүрдэж байгаа эсэх), зэрэг олон хүчин зүйлс ажил хөдөлмөр дэх жендэрийн хуваарьт нөлөөлж болно.



Зураг 6-9. Эмэгтэй бичил уурхайчид уурхайн талбай дээр. (planetGOLD)

Нийгэмд болон ялангуяа эрэгтэйчүүд давамгайлсан уул уурхайн салбарт байгаа жендэрийн хэвшмэл ойлголт, соёлын итгэл үнэмшил нь эрэгтэй уурхайчдын дунд эмэгтэйчүүдийг тодорхой ажил үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрөх ёсгүй, тэд хийх ёсгүй гэсэн ойлголтыг бий болгодог. Гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр эмэгтэйчүүдээс уламжлалт ёс, итгэл үнэмшил, нийгмийн хэм хэмжээ нь алтны бичил уурхайн салбарын жендэрийн үүрэг эсвэл нийгмийн харилцаанд нөлөөлж байгаа эсэхийг асуухад хэн ч үүнийг нотолсонгүй. 30 эмэгтэйн зургаа нь алтны бичил уурхайд эмэгтэйчүүдийн гүйцэтгэж буй ажил үүрэгт нийгэм соёлын хэм хэмжээ, үнэт зүйл нөлөөлөхгүй гэж хэлсэн. 30 эмэгтэйтэйгээс найм нь бичил уурхайд ажиллаж байхдаа сөрөг хандлагатай тулгарч байсан гэж хариулав. Эдгээр эмэгтэйчүүд хариултаа тодруулж тайлбарлаагүй хэдий ч бусад судалгаанаас үзэхэд уул уурхайг Монгол Улсад зохистой орлогын эх үүсвэр гэж үргэлж үздэггүй байна (Азийн сан, 2013 он). Гэсэн хэдий ч эмэгтэйчүүд сургалтын хэрэгцээ шаардлагын талаарх хэлэлцүүлгийн үеэр жендэрийн талаар ойлголтгүй гэдгээ илэрхийлсэн. Тиймээс эмэгтэйчүүд алтны бичил уурхайн дахь жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтыг мэддэггүй эсвэл ил гаргаж хэлэхийг хүсдэггүй байж магадгүй юм.

Судалгааны үеэр эрэгтэйчүүдийн 90%, эмэгтэйчүүдийн 81% нь уул уурхайд эмэгтэйчүүдийн хийх ёсгүй тодорхой ажлууд байдаг гэж хариулжээ (Зураг 6-8). Эдгээр ажлуудад гол төлөв босоо амны ажил, хүнд зүйл өргөх зэрэг ажлууд хамаардаг (өөрөөр хэлбэл хүдэр олборлохтой холбоотой ажлууд). Зураг 6-7-д эмэгтэйчүүдийн 66% нь олборлох үйл явцад оролцдог гэдгийг харуулж байгаа ч уурхайн босоо аманд ажилладаг эмэгтэйчүүдийн тоо бага (12%) байна. Түүнчлэн олон эмэгтэйчүүд хүдэр ангилах (31%), шуудайлах (26%), тээвэрлэх (20%) ажлыг гүйцэтгэж байна.



Зураг 6-10. Тухайн салбарт эмэгтэй хүн хийх ёстой эсвэл хийхийг зөвшөөрдөггүй ажил байдаг эсэх талаарх судалгаанд өгсөн хариулт (олон хариулттай, нийт=407)

Ерөнхийдөө эмэгтэй, эрэгтэй уурхайчдын дунд эмэгтэйчүүдийг хамгаалах зорилгоор биеийн хүчний хөдөлмөр их шаардсан, аюулд өртөж болзошгүй ажилд эмэгтэйчүүдийг оролцох ёсгүй гэсэн итгэл үнэмшил байдаг нь харагдаж байна. Энэхүү итгэл үнэмшил нь эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах

зорилгоор бус, өөрсдийг нь хамгаалах үүднээс олборлолтын талбай дахь болзошгүй аюул, эрсдлээс хамгаалагдсан байх ёстой гэсэн санаанаас үүдэлтэй боловч энэ нь эмэгтэйчүүдийн эрдэс баялгийн нөөцөөс хүртэх боломжийг хязгаарлаж болох юм. Судалгааны үр дүнгээс харахад баг дотроо гүйцэтгэж буй ажил үүргээс үл хамааран эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд орлогоо ихэвчлэн тэгш хуваарилдаг болох нь энэхүү таамаглалыг бататгаж байгаа бөгөөд энэ талаар нөхөрлөлийн ахлагч дараах байдлаар тайлбарласан болно.

“Нөхөрлөлийн гишүүд эмэгтэйчүүдийг хүнд ажил хийхээс чөлөөлдөг. Гэсэн хэдий ч хүн бүхэн олборлолтын талбай дээр ажилладаг тул орлого тэгш хуваарилагддаг . . . Эрчүүд илүү их ажил хийдэг. Ер нь олборлолтын бүх ажлыг эрчүүд хийдэг байх. Эмэгтэйчүүд хоол хийж, гэрийн ажил хийдэг”


Говь-Алтай аймгийн нөхөрлөлийн ахлагч эмэгтэй

Гэхдээ олсон ашгаа тэгш хуваарилах механизм нь уул уурхайн бүх бүлэгт нийтлэг хэрэгждэггүй нь ажиглагдсан (орлогын хэсгийг харна уу). Ийм тохиолдолд эрэгтэйчүүд биеийн хүч шаардсан ажил хийдэг тул илүү өндөр цалинтай байдаг гэсэн итгэл үнэмшил нь санаатай биш ч эмэгтэй бичил уурхайчдад эдийн засгийн хувьд сөрөг үр дагаврыг авчирдаг байж болох юм. Иймээс эрэгтэй бичил уурхайчдын биеийн хүчний хөдөлмөр их шаарддаг ажлын байрнаас олж буй орлогыг гишүүдэд эрх тэгш хуваарилахгүй бол эмэгтэй бичил уурхайчдад эдийн засгийн бэрхшээл тулгарч болзошгүй юм. МБУНДХ-ны ажилтан бичил уурхайн ажил хөдөлмөр дэх жендэрийн хуваарь нь эрдэс баялгийн нөөц болон орлогын хүртээмжид тэгш бус байдлыг бий болгож болохыг онцолсон нь салбарын хэмжээнд орлого тэгш хуваарилалт нь уурхайчдын бүлэг тус бүрт харилцан адилгүй байдаг гэдгийг харуулж байна. Иймээс орлогын эрх тэгш хуваарилалтад нөлөөлж буй хүчин зүйлүүдийг цаашид нэмж судлах шаардлагатай байна.

6.2.4 Уурхайн талбай дахь эрэгтэй, эмэгтэй бичил уурхайчдын шийдвэр гаргалт, манлайлал, эрх мэдлийн ялгаатай байдал

Шийдвэр гаргалтын ялгаатай байдал

Ажил хөдөлмөр дэх жендэрийн хуваарь нь бичил уурхайд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн гүйцэтгэж буй ялгаатай ажил үүргийг тоймлон харуулсан. Зураг 6-11-д эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчин өөрсдийгөө тодорхой үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах үйл явцад хэрхэн идэвхтэй оролцдог болохыг харуулсан болно. Хайгуулын ажилд эмэгтэйчүүдийн 2% нь оролцдог (Зураг 6-7) байхад хайгуулын ажлын талаар шийдвэр гаргахад 22% нь оролцдог гэж хариулжээ. Баяжуулалтын үе шатанд шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүд түлхүү оролцдог бол эмэгтэйчүүд хог хаягдлыг зайлуулах талаар шийдвэр гаргахад илүү оролцдог байна. Энэхүү дүгнэлт нь байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх, магадлан шинжилгээтэй холбоотой ажил үүргийг эмэгтэйчүүд хариуцдаг байх магадлал өндөр байгааг харуулж байгаа төдийгүй бусад дүгнэлттэй нийцэж байна. Үүнээс гадна эмэгтэйчүүд захиргааны асуудлаар шийдвэр гаргах үйл явцад түлхүү оролцдог төдийгүй ашиг хуваарилах, санхүү зохицуулахтай холбоотой асуудалд оролцдог байна.



Зураг 6-11. Тодорхой үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах үйл явцад эмэгтэй болон эрэгтэй уурхайчдын бичил уурхайчдын оролцоо (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй, нийт=1,139, олон сонголттой хариулт)


Гүнзгийрүүлсэн судалгааны дүгнэлт нь эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчид ажлын байранд шийдвэр гаргах, орлого хуваахад харилцан тэгш эрхтэй оролцдог байх хандлагатай байгааг нотолж байна. Өрхийн түвшинд шийдвэр гаргах, гэр бүлийн асуудлыг шийдвэрлэхэд эмэгтэйчүүд тэргүүлэх үүрэгтэй оролцдог байна (Бүлэг 6.3). Судалгааны үр дүнгээс үзэхэд ихэнх эмэгтэйчүүд (30-аас 19) уурхайн талбайд шийдвэр гаргах үйл явцад оролцдог болох нь харагдаж байна. Мөн түүнчлэн шийдвэр гаргахдаа нөхөрлөлийн гишүүдтэй харилцан ярилцсаны үндсэн дээр гаргадаг болохыг тэд онцоллоо. Цаашилбал, есөн эмэгтэй уурхайчин шийдвэр гаргах үйл явц дахь жендэрийн ялгааг онцолж, зарим нь эмэгтэйчүүд, зарим нь эрэгтэйчүүд давамгайлж байгаа тохиолдлыг олж харжээ.

Манлайллын ялгаатай байдал

Бичил уурхай дахь ажил хөдөлмөрийн жендэрийн хуваарийн талаар өгүүлсэн өмнөх хэсэгт хууль ёсны зөвшөөрөл авах, бүртгүүлэх, санхүүжилт олох, алтны худалдаа зэрэг менежментийн чухал ажилд эмэгтэйчүүдийн оролцох оролцоог тайлбарласан. Үүний зэрэгцээ, эмэгтэйчүүдийн 88% нь нийлүүлэлтийн сүлжээний төрөл бүрийн үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах үйл явцад оролцдог байна (Зураг 6-11). Эдгээр дүгнэлтүүд нь эмэгтэйчүүд олборлолтын талбайн удирдлага, зохион байгуулалттай холбоотой шийдвэр гаргахад чухал нөлөө үзүүлдэг бөгөөд үүний үр дүнд манлайллын чиг үүргийг мөн гүйцэтгэдэг болохыг харуулж байна.


Судалгаанд оролцсон 47 нөхөрлөл, ТББ-ын удирдагчдын 19 нь эмэгтэй, 28 нь эрэгтэй байв. Бүртгэгдсэн нөхөрлөлийн 26 ахлагчаас зургаа нь эмэгтэй, ТББ-ын 15 тэргүүнээс арав нь эмэгтэйчүүд байгаа нь эмэгтэйчүүд нөхөрлөлийн ахлагч байхаас илүү ТББ-ын удирдагч байх хандлагатай байгааг харуулж байна (Зураг 6-12). Судалгаанд хамрагдсан хүн амын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй бага байгаа нь Монгол Улсын алтны бичил уурхайд ажилладаг эмэгтэйчүүдийн тоо цөөн байгааг илтгэж байгаа бөгөөд зохион байгуулалтад орсон нийт эмэгтэй бичил уурхайчдын 22% нь манлайлагч нар байсан бол

зохион байгуулалтад орсон эрэгтэй бичил уурхайчдын 14% нь манлайлагч нар байна. МБУНДХ-ны ажилтнууд эмэгтэйчүүд бичил уурхайн байгууллагын удирдах албан тушаалд түлхүү ажиллах хандлагатай байгааг онцолсон бөгөөд Монгол Улсын бичил уурхайн ТББ-уудын 60 орчим хувь нь эмэгтэй тэргүүнтэй байдгийг дурдсан.



Зураг 6-12. Алтны бичил уурхайн байгууллагын гишүүд, ахлагч нарын тоо, (хүйсээр, n=282)

Гэсэн хэдий ч судалгааны таван бүс нутгийн тоон мэдээлэлд хийсэн дүн шинжилгээгээр эмэгтэйчүүдийн манлайлал нь газарзүйн байршил тус бүрт харилцан адилгүй байсан. Эмэгтэй манлайлагчтай байх нь Мандал (8 эмэгтэй удирдагч, эдгээрийн 5 нь бүртгэлтэй нөхөрлөлийн ахлагч), Есөнбулаг (6 эмэгтэй удирдагч, эдгээрийн 5 нь ТББ-ын тэргүүн) сумдад нийтлэг байсан бол Алтай суманд эмэгтэй удирдагч байгаагүй (Зураг 6-13).




Зураг 6-13. Эмэгтэй болон эрэгтэй ахлагч нарын тоо (судалгааны бүс нутгаар, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)

Манлайлагчийн сонголт

Эмэгтэйчүүдийн манлайллын эсрэг нэг талыг барьсан хандлага байгаа эсэхийг үнэлэх зорилгоор судалгаанд хамрагдсан хүмүүсээс бичил уурхайн байгууллагынхаа удирдагчаар эрэгтэй эсвэл эмэгтэй хүний алийг нь илүүд үздэг эсэхийг асуусан. Ерөнхийдөө судалгаанд оролцогчдын 42% нь эрэгтэй


удирдагчийг, харин 22% нь эмэгтэй удирдагчийг илүүд үздэг байна (Зураг 6-14). Эрэгтэйчүүдээс (18%) илүү эмэгтэйчүүд нь эмэгтэй удирдагч (31%) байхыг илүүд үзэж байв. Нийт судалгаанд хамрагдагсдын гуравны нэгээс илүү хувь нь (37%) аль нэг талыг илүүд үзэхгүй (өөрөөр хэлбэл манлайллын ур чадвараас илүү жендэрийн хувьд төвийг сахисан байр суурьтай байсан) байгааг тэмдэглэх нь зүйтэй.



Зураг 6-14. Манлайллын жендэрийн сонголт (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)


Судалгааны таван бүс нутгийн хувьд манлайлагчийн жендэрийн сонголт нь харилцан адилгүй байсан (Зураг 6-15). Эмэгтэй удирдагчийг илүүд үздэг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Есөнбулаг суманд хамгийн өндөр байсан (39% ба 46%), Баянгол суманд эмэгтэйчүүдийн хувь өндөр (40%), харин эрэгтэйчүүдийн хувь бага (5%) байсан бол Алтай суманд эмэгтэйчүүд (21%), эрэгтэйчүүд (5%) хоёулаа харьцангуй бага хувьтай байна. Эдгээр дүгнэлтүүд нь судалгааны бүс нутгуудын эмэгтэйчүүдийн манлайллын туршлагын түвшинтэй уялдаж байна. Алтай суманд судалгаанд оролцогчид эрэгтэй манлайлагчийг илүүд үздэг бөгөөд одоогоор эмэгтэй манлайлагчтай байсан туршлага байхгүй байна. Баянгол, Түнхэлд эрэгтэйчүүд эмэгтэй удирдагчийг илүүд үздэг нь одоогийн эмэгтэйчүүдийн манлайллын түвшинтэй нийцэж байна. Нөгөө талаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн аль аль нь эмэгтэй удирдагчийг илүүд үздэг Есөнбулаг суманд эмэгтэй удирдагчид илүү олон байдаг байна. Мөн түүнчлэн бичил уурхайн ТББ-ын эрэгтэй гишүүд нь эмэгтэй удирдагчийг илүүд үзэх нь хамгийн өндөр хувьтай байсан (52%) бол бүртгэлтэй нөхөрлөлийн эмэгтэй гишүүд гол төлөв эрэгтэй ахлагчийг (41%) илүүд үздэг байна.

Эмэгтэйчүүдийг илүү чадварлаг гэж үздэг тул бичил уурхай илүү хөгжсөн бүс нутгуудад илүү олон эмэгтэйчүүд удирдах алба хашдаг гэж дүгнэж болно.



Зураг 6-15. Манлайллын жендэрийн сонголт (судалгааны бүс нутгаар, хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй 108)

Жендэрийн сонголтын асуулгад оролцогчдоос яагаад эрэгтэй, эмэгтэй удирдагчийг сонгосон тухайгаа тайлбарлахыг хүссэн юм (Зураг 6-16). Судалгаанд оролцогчдын олонх нь тодорхой хариулт өгч чадаагүй бол зарим нь эрэгтэй, эмэгтэй бичил уурхайчдын манлайллын шилдэг туршлагын талаарх жишээг дурдав. Жишээлбэл, эрэгтэйчүүд илүү их ажиллах хүч тэнхээ, бие бялдрын хүч чадалтай байдаг бөгөөд ажлын хүнд нөхцөлд илүү сайн дасан зохицож чаддаг, илүү мэдлэгтэй, ур чадвартай, бусад эрэгтэй бичил уурхайчидтай хамтран ажиллахад илүү сайн байдаг. Гэсэн хэдий ч эрэгтэй, эмэгтэй бичил уурхайчид эмэгтэй удирдагчдын менежментийн ур чадвар илүү сайн, тухайлбал, санхүүг зохицуулах эсвэл хууль эрх зүйн орчны хэрэгжилтийг хангах тал дээр илүү чадварлаг гэдгийг дурдаж байсан. Мөн түүнчлэн эмэгтэйчүүдийг илүү найдвартай, хариуцлагатай гэж үздэг бөгөөд энд илүү тууштай, цаг баримталдаг, бусдад анхаарал халамж тавьдаг, архи уудаггүй гэх мэт бусад тодорхойлолтууд багтаж байв. Сонирхолтой нь, эрэгтэй бичил уурхайчид эмэгтэй удирдагчдыг эрэгтэй удирдагчаас илүү шударга гэж үзэж байв. "Бусад" гэсэн ангилалд манлайллын мэргэшилтэй шууд холбоогүй "эрэгтэйчүүд илүү сайн" эсвэл "эмэгтэйчүүд илүү эелдэг" гэх мэт ерөнхий тодорхойлолтуудыг багтаасан болно.



Зураг 6-16. Эрэгтэй эсвэл эмэгтэй манлайлагчийг сонгодог шалтгаан (хүйсээр)

Хүдэр олборлох, боловсруулах техникийн болон биеийн хүчний ажилд эрэгтэй бичил уурхайчид илүү түлхүү оролцож байгаа нь ялангуяа эрэгтэйчүүдийн хувьд эрэгтэй манлайлагчийг сонгох шалтгаан нь болдог байж болно. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүдийн зохион байгуулалт, менежмент, харилцааны ур чадварыг үнэлж байсан. Энэ нь илүү албажсан, хууль эрх зүйн орчны талаарх мэдлэг нь давуу тал болдог, удирдлагад нь эмэгтэй бичил уурхайчин байсан газруудад илүү их ажиглагдсан.

Эмэгтэйчүүдийн манлайлалд нөлөөлж байгаа өөр нэг чухал хүчин зүйл бол алтны бичил уурхайн байгууллагын эмэгтэй удирдагчид орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллах чадвар юм. Эмэгтэй бичил уурхайчидтай хийсэн гүнзгийрүүлсэн судалгаагаар бичил уурхайн байгууллагыг орон нутгийн засаг захиргааны албан хаагчид дэмжиж байгаа нь жендэрээс илүүтэй тухайн бичил уурхайн албажуулалтын түвшингээс хамаардаг гэдгийг харуулж байна. Судалгаанд хамрагдсан 30 уурхайчны 10 нь нөхөрлөл албан ёсны болсны дараа дэмжлэг авах боломжтой болно гэдгийг онцолжээ. Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон, Мандал, Баянгол сумдад орон нутгийн удирдлагын дэмжлэг эерэг байх хандлагатай байна.

6.2.5 Нөөцийн хүртээмж, ашиглалт

Энэ хэсэгт бичил уурхай дахь орлого, санхүүжилтийн хүртээмж, үйлдвэрлэлийн хэрэгсэлд тавих хяналтыг жендерийн үүднээс авч үзнэ.

Орлого

2-р бүлэгт дурдсанчлан судалгаанд оролцогчдын 77% нь бичил уурхайгаас үндсэн орлого олдог гэж хариулсан (эрэгтэйчүүдийн 78%, эмэгтэйчүүдийн 76%). Гэсэн хэдий ч эрэгтэйчүүдийн 38%, эмэгтэйчүүдийн ердөө 33% нь бичил уурхайгаас хангалттай орлого олдог гэж хариулжээ. Энэ нь нийт судалгаанд хамрагдагсдын гуравны хоёр нь заримдаа эсвэл үргэлж орлогын нэмэлт эх үүсвэр хайх хэрэгтэй болдог гэсэн үг юм. Түүнчлэн бичил уурхайгаар ашигт малтмал олборлогчдын сарын дундаж орлого 980,163 төгрөг байсан нь 2020 оны 3-р улирлын улсын сарын дундаж орлогын хэмжээ болох 1,269,100 төгрөгөөс 288,937 төгрөгөөр доогуур байна. Сарын дундаж орлого нь бүс нутгаараа ялгаатай бөгөөд Баруун бүс (916,000) ба Төвийн бүсэд (1,142,500) дунджаас доогуур байна (ҮСХ, 2020). Монгол Улсад орлогын хувьд жендерийн ялгаа ажиглагдаж байгаа бөгөөд 2020 оны 3-р улиралд эмэгтэйчүүд сард 1,135,800 төгрөг, эрэгтэйчүүд 1,395,900 төгрөгийн орлого тус тус олжээ.

Судалгаанд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй бичил уурхайчдын бичил уурхайгаас олсон сарын орлого, нийт орлогын хооронд их ялгаа байхгүй байна (Хүснэгт 2.6). Гэхдээ хамгийн бага орлоготой ангилалд багтсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь нийт орлого (эмэгтэйчүүдийн 64% нь эрэгтэйчүүдийн 62%) болон бичил уурхайгаас олсон орлогод (эмэгтэйчүүдийн 41% нь эрэгтэйчүүдийн 37%) аль алинд нь өндөр байна. Гэсэн хэдий ч бичил уурхайн орлого нь улирлын шинж чанар, өндөр агуулгатай хүдрийн олдоц, ажлын боломж зэргээс шалтгаалан ихээхэн хэлбэлзэлтэй байж болохыг анхаарч үзэх хэрэгтэй гэж нөхөрлөлийн хоёр ахлагч онцолж хэлсэн болно. Бичил уурхайд эмэгтэйчүүд эрчүүдтэй харьцуулахад жилийн турш ажилладаггүй (Ажлын цагийн хэсгийг харна уу)

учраас бичил уурхайгаас тэдний олдог жилийн орлого нь эрчүүдийн олсон орлогоос ялгаатай байдаг эсэх эсвэл нөхөрлөлийн болон ТББ-ын бүх гишүүдийн дунд жилийн туршид тэгш хуваарилагдаж байгаа эсэх нь тодорхойгүй хэвээр үлдэж байна.

Судалгааны үр дүнгээс харахад судалгааны таван бус нутагт орлогын жендэрийн тэгш бус хуваарилалт бага байгааг харуулж байна. Ижил хөдөлмөр эрхлэхэд адил цалин хөлс олгох нь жендэрийн тэгш байдлыг хангах үндсэн ойлголт бөгөөд түүний гол үзүүлэлтүүдийн нэг юм. Ганцаарчилсан ярилцлагын үеэр эрэгтэйчүүд ихэвчлэн илүү хүнд, аюул эрсдэлтэй ажил үүрэг гүйцэтгэх хандлагатай байдаг бол эмэгтэйчүүд туслах ажил үйлчилгээ, захиргааны ажилд түлхүү оролцдог хэдий ч олсон орлогоо жендэрээс үл хамааран адил тэгш хуваадаг болохыг онцолсон байна.

"Бид зарлагаа хасаад үлдсэн орлогоо гишүүддээ тэнцүү хэмжээгээр хуваадаг."

Ганцаарчилсан ярилцлага, Сэлэнгэ аймгийн хоршооны дарга, эрэгтэй

"Нөхөрлөлийн гишүүд эмэгтэйчүүдийг хүнд ажил хийхээс чөлөөлдөг. Гэсэн хэдий ч хүн бүр олборлолтын талбай дээр ажилладаг тул орлогоо тэгш хуваарилдаг."

Ганцаарчилсан ярилцлага, Говь-Алтай аймгийн нөхөрлөлийн ахлагч, эмэгтэй

Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцсон эмэгтэйчүүд байгууллага дотроо орлогоо тэнцүү хуваадаг гэдгийг баталгаажуулсан. Орлого хуваарилах болон үнийн талаар шударгаар зөвшилцөхөд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай байдлыг судалж үзэхэд, судалгаанд оролцогчдын дийлэнх (30 эмэгтэйгээс 27) нь орлого хуваарилалтын талаар маргаантай асуудал байхгүй гэж хариулжээ. Түүнчлэн ажил бүр өөрийн тогтсон үнэлгээтэй байдаг тул орлогын хуваарилалт нь жендэртэй холбоогүй гэж хариулсан байна. Хамгийн гол нь тэд ихэвчлэн гэр бүлийн харилцаа холбоонд суурилсан нөхөрлөлийн хэлбэрээр ажилладаг эсвэл гэр бүлийн зохион байгуулалтаар ажилладаг тул орлого хуваахад асуудал бага гардаг гэдгийг тэд онцолсон болно.

"Бид ихэвчлэн гэр бүл эсвэл хань ижилтэйгээ хамт талбай дээр очиж ажилладаг. Энэ хэв маяг нь алтны БУ-н бусад уурхайчдын хувьд ч түгээмэл байдаг гэж би боддог. Нэгэнт бид ойрын гэр бүл, хамаатан садантайгаа хамтарч ажилладаг байгаа учраас ажлаа эхлэхээс өмнө сайн тохиролцдог тул шударга бус цалин хөлс, хуваарилах магадлал багатай байдаг".

Гүнзгийрүүлсэн судалгаа, Говь-Алтай аймгийн бичил уурхайчин, эмэгтэй

Гэсэн хэдий ч ганцаарчилсан ярилцлагын дүнгээс Монгол Улсад бичил уурхайн байгууллага бүрт цалин хөлсний тэгш хуваарилалт нийтлэг хэрэгждэггүй болохыг харагдаж байна.

"Миний бодлоор цалингийн тэгш хуваарилалт байхгүй. Цөөхөн хэдэн бичил уурхайн нөхөрлөл цалин хөлсөө тэгш хуваадаг. Энэ нь ихэвчлэн нөхөрлөлийн ахлагчаас хамаарна. Гишүүд нөхөрлөлийн ахлагчийг байхад гомдол гаргадаггүй боловч тэднийг байхгүй үед цалингийн тэгш бус хуваарилалтын талаар ярьдаг. Тэд ажилгүй болохоос айдаг тул ахлагтайтайгаа энэ талаар ярилцаж чадахгүй. Өөрөөр хэлбэл, нөхөрлөл нь эзэн төвтэй байгууллага юм".

Ганцаарчилсан ярилцлага, төрийн байгууллагын ажилтан

Төрийн байгууллагын албан хаагчид, хүний эрхийн шинжээчид, МБУНДХ-ны удирдлагын үзэж байгаагаар ажил хөдөлмөр дахь жендэрийн хуваарь, эмэгтэй,

эрэгтэй бичил уурхайчдын эрх мэдлийн хуваарилалтын ялгаа нь цалин болон ашгийн тэгш бус хуваарилалтын шалтгаан болж байна. Энэхүү ажиглалтыг судалгааны бүс нутагт явуулсан судалгааны үр дүнгээр баталгаажуулж чадаагүй ч цаашид нэмэлт судалгаа хийх шаардлагатай байна. Түүнчлэн бичил уурхайн байгууллага дахь эмэгтэйчүүдийн манлайлал ба орлогын эрх тэгш хуваарилалтын хамаарлыг цаашид судлах нь сонирхол татаж байна. МБУНДХ-ны удирдлагын хэлснээр орлогын зөрүү хөдөлмөрийн хуваарьтай холбоотой байна. Хүчин зүйлсийн талаар зөв ойлголттой болохын тулд цалин хөлс, орлогын эх үүсвэрийн талаар илүү нарийвчилсан дүн шинжилгээг зорилтот бүс нутгуудад хийх шаардлагатай байна.


Санхүүгийн хүртээмж

Судалгаагаар эмэгтэй бичил уурхайчдад санхүүгийн хүртээмжийн талаар жендэртэй холбоотойгоор томоохон бэрхшээлүүд илрээгүй. Судалгаанд оролцсон нийт эмэгтэйчүүдийн 29 орчим хувь, харин эрэгтэйчүүдийн 34 хувь нь бичил уурхайн байгууллагын санхүүгийн шийдвэр гаргах үйл явцад оролцдог байна. Нэмж дурдахад, одоогийн байдлаар эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээс илүү зээлтэй байна гэж хариулжээ (эмэгтэйчүүд 61%, эрэгтэйчүүд 51%).

Гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр 30 эмэгтэй тутмын 22 нь санхүүжилт авахад жендэрийн ялгаатай байдал бараг нөлөөлдөггүй гэж хариулжээ. Бүх банк болон бусад санхүүгийн байгууллагуудаас зээл хүсэхэд эхнэр, нөхөр хоёроос гарын үсэг, зөвшөөрөл шаарддаг гэж тэд тайлбарлав. Тиймээс эхнэр, нөхрүүд аливаа зээлд хамрагдахаасаа өмнө санхүүгийн асуудлаар ярилцдаг байна. Гэсэн хэдий ч зээл авахад эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчид баталгаатай орлогын эх үүсвэр болон бусад шаардлагыг хангаагүйгээс бэрхшээлтэй тулгардаг гэж мэдэгдсэн. Цөөн ярилцлагад зээл авахад эрэгтэйчүүд шийдвэр гаргадаг гэж эмэгтэйчүүд хариулсан байна.

Санхүүгийн хүртээмжтэй холбоотой эмэгтэйчүүдэд тулгардаг тодорхой бэрхшээлүүд байгаа эсэхийг санал асуулгын үеэр асуухад (Зураг 6-17) судалгаанд оролцогчдын 44%-д бэрхшээл гараагүй. Бэрхшээл тулгардаг гэж мэдэгдсэн эмэгтэйчүүдийн ихэнх буюу 30% нь зээл авахад жендэртэй холбоогүй боловч барьцаа хөрөнгийн шаардлага, байнгын тогтмол орлоготой холбоотой асуудлуудыг дурджээ.

Сонирхолтой нь, Есөнбулаг сум дахь эмэгтэйчүүдийн дийлэнх нь (52%) санхүүжилттэй холбоотой асуудал эмэгтэйчүүдэд тулгардгийг мэдээлж байсан боловч энэ мэдээллийг өгсөн эмэгтэйчүүдээс зөвхөн гурав нь санхүүгийн шийдвэр гаргах явцад оролцож байжээ. Эмэгтэйчүүд энэ асуултад жендэрийн өнцгөөс биш бичил уурхайн байгууллагынхаа өнцгөөс илүү хариулсан гэж дүгнэж болно.



Зураг 6-17. Эмэгтэй уурхайчдад санхүүжилт авахад асуудал тулгардаг эсэх, (судалгааны бүс нутгаар, n=100 эмэгтэй)

Бичил уурхайн үйлдвэрлэлийн хяналт

Алтны бичил уурхай дахь жендэрийн тэгш байдлыг харуулах шалгуур үзүүлэлтэд баяжуулах үйлдвэр болон амны эзэн эмэгтэйчүүдийн тоог оруулж болно. Учир нь эдгээр 2 үзүүлэлт нь хоёулаа үйлдвэрлэлийн хяналт дахь эмэгтэйчүүдийн үүргийг илтгэн харуулдаг. Судалгаанд хамрагдсан 28 баяжуулах цехийн эздийн 9 нь (32%) эмэгтэйчүүд байгаа бөгөөд тэд Баянгол, Мандал, Түнхэл сумдад байна. Харин нийт 36 амны эзний 9 (25%) нь эмэгтэйчүүд байв. БУ-н салбарт эмэгтэйчүүдийн тоо бага байдгийг харгалзаж үзвэл дээрх мэдээлэл нь зарим эмэгтэйчүүд бичил уурхайн үйлдвэрлэлд хяналт тавидаг болохыг харуулж байна. Нөгөөтэйгүүр, эрэгтэйчүүдтэй харьцуулахад (50%) эмэгтэйчүүд (68%) голчлон туслах ажил хийдэг бол эрэгтэйчүүд уурхайчнаар (эрэгтэйчүүдийн 38%, эмэгтэйчүүдийн 13%) ажилладаг. Энэ нь салбарын эмэгтэй, эрэгтэйчүүдийн хооронд нөөцийн хүртээмж, хяналт тавих, эрх мэдлийн зөрүү их байгааг харуулж байна. Гэхдээ нөөцөөс хүртэх, өмчлөх боломж багатай эмэгтэйчүүдийн бүлгүүдийг тодруулахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай байна. Эмэгтэй бичил уурхайчидтай хийсэн гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр эмэгтэйчүүд өөрсдийн ажлын байранд шаардлагатай багаж хэрэгсэл, материалыг дундын хөрөнгөөр худалдаж авдаг тул хөдөлмөрийн багаж хэрэгсэл нь ижил тэгш хүртээмжтэй байдаг гэж хариулсан байна. Эмэгтэйчүүд ажил хөдөлмөр дэх жендэрийн хуваариас шалтгаалан хөдөлмөрийн багаж хэрэгсэлтэй бага харьцдаг гэж мэдэгдсэнийг тэмдэглэх нь зүйтэй.

6.2.6 Мэдээлэл ба чадавх бэхжүүлэх

Сургалт нь алтны бичил уурхай дахь уурхайчдын чадавхи бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд үүний үр дүнд уурхайчид уул уурхайн сайн дадал, туршлагыг эзэмших болно. 8-р бүлэгт судалгаанд оролцогчдын сүүлийн хоёр жилийн хугацаанд хамрагдсан сургалтыг тодорхойлж, судалгаанд оролцогчдын санал болгосон сургалтын хэрэгцээ шаардлагыг нэгтгэн харуулсан болно. Сургалтанд хамрагдах нь бичил уурхайн салбар дахь эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэхэд чухал идэвхжүүлэх үүрэг гүйцэтгэдэг тул 6-р бүлгийн энэ хэсэгт зөвхөн жендэртэй холбоотой хамгийн чухал үр дүнг нэгтгэн дүгнэх болно. Сургалт нь эмэгтэйчүүдэд ажиллах илүү таатай нөхцлийг бүрдүүлдэг бөгөөд эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдын жендэрийн зөрүүг арилгахад тусалдаг.

Хамрагдсан сургалтууд

Сүүлийн хоёр жилийн хугацаанд судалгаанд оролцогчдын 38% (n=141) нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбоотой сургалтанд хамрагдсанаас эмэгтэйчүүдийн оролцоо (47%, n=47) эрэгтэйчүүдээс өндөр (35%, n=97) байв. Үндэсний болон орон нутгийн төрийн байгууллагууд, хүний эрхийн, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл ганцаарчилсан ярилцлагын үеэр эмэгтэйчүүд чадавх бэхжүүлэх сургалтад илүү идэвхтэй оролцдог болохыг тэмдэглэв. Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцсон эмэгтэйчүүдийн дийлэнх нь (30-аас 22 нь) сургалтанд хамрагдах хангалттай боломж байгаа гэж хариулсан бол 6 эмэгтэй сургалтанд хамрагдах, мэдээлэл авах боломж хязгаарлагдмал байдаг гэж хэлжээ.

Сургалтад хамрагдсан байдалд жендэрийн дүн шинжилгээ хийж үзэхэд (Зураг 8-5) эмэгтэйчүүд бүх сургалтууд, ялангуяа бизнесийн удирдлага (эмэгтэйчүүдийн 16%, эрэгтэйчүүдийн 3%), байгаль орчинд ээлтэй практик дадлага (14% ба 6%), нөхөн сэргээлт (14% ба 7%) болон эрүүл мэнд (11% ба 6%)-ийн сургалтуудад идэвхтэй оролцсон болохыг тогтоожээ.

Ерөнхийдөө, эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчид хязгаарлагдмал тооны сургалтад хамрагджээ, ялангуяа жендэрийн болон хүний эрхийн сэдэвтэй сургалтуудад (эмэгтэйчүүдийн 3%, эрэгтэйчүүдийн 2%) бага хамрагдсан байна. Судалгааны явцад сургалт зохион байгуулсан байгууллагуудын талаар судалсан боловч сургалтын сэдвийг энэ судалгаанд тэмдэглээгүй байна. Тиймээс ямар байгууллага жендэрийн болон хүний эрхийн сургалтыг зохион байгуулсныг харуулах боломжгүй байна. Гэвч МБУНДХ-оос 2019 онд жендэрт суурилсан хүчирхийллийн талаар сургалт явуулсан тухай мэдээлэл байна (жендэрт суурилсан хүчирхийлэлийн хэсгийг үзнэ үү).

Сургалтын хэрэгцээ

Судалгаанд хамрагдагсдын тодорхойлсон сургалтын хэрэгцээ нь эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдын хувьд ижил төстэй хэв маягийг харуулж байна (Зураг 8-7). Жендэр ба хүний эрхийн сэдвийг эмэгтэйчүүдийн 9%, эрэгтэйчүүдийн 8% нь чухал сэдэв гэж тодорхойлжээ.

Гүнзгийрүүлсэн судалгаагаар эмэгтэйчүүд (магадгүй эрэгтэйчүүд ч) жендэрийн болон хүний эрхийн чиглэлээр яг ямар сургалт явагдах талаар хангалттай ойлголтгүй байсан нь тогтоогдсон бөгөөд эмэгтэйчүүдийн хувьд эдгээр сэдэв нь шинэ зүйл болохыг тайлбарлаад тодруулж асууж байсан. Энэ нь тухайн сэдвийг бага сонирхож байгааг илтгэж байж болох юм.

Сургалтын үеэр уул уурхайтай холбоотой сургалтын хэрэгцээнээс гадна 11 эмэгтэй оёдол, ногоо тарих, үс засах зэрэг нэмэлт орлогын эх үүсвэр бий болгох чиглэлээр сурах сонирхолтой байгаагаа илэрхийлэв. Орлогын өөр эх үүсвэртэй болох сонирхол нь бичил уурхайгаас зөвхөн улирлын чанартай орлого олдог, түүнчлэн жилийн орлогоо хангалттай олж чаддаггүйтэй голчлон холбоотой байв. Зарим эмэгтэй бичил уурхайчин уурхайн талбай руу түр хугацаагаар шилжин суурьших шаардлагатай болдог тул хүүхдүүдээ үлдээхийг хүсдэггүй

байна. Энэ нь бичил уурхайчдын ажил амьдралын тэнцвэрт байдлыг уялдуулахын ач холбогдлыг харуулж байна.

Иргэний нийгмийн ТББ-ын тэргүүн эмэгтэй хэлэхдээ гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргүүд нэмэгдэж байгаа тул Гэр бүлийн тухай хуулийн тухай сургалтанд хамруулах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байсан.

Сургалт шаардлагатай байна. Залуучуудын оролцоог сайжруулах, чадавх бэхжүүлэх чиглэлээр сургалт явуулах хэрэгтэй байна. Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг өсөх хандлагатай байна. Тиймээс Гэр бүлийн тухай хуулиар сургалт явуулах шаардлагатай. Алтны БУ эсвэл нийгмийн талаар ярих эсэхээс үл хамааран эцэст нь энэ бүхний үндэс нь гэр бүл байдаг. Бид гэр бүлийн орчин, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгох гэдэг нь юу гэсэн үг вэ гэдгийг ярих хэрэгтэй. Сургалт нь 2 цагаас хэтрэхгүй байх нь зүйтэй бөгөөд танхимын биш сургалт байх нь тохиромжтой. Та 8 цагийн турш лекцэнд суухыг зөвшөөрөх нэг ч хүнийг олохгүй.

Иргэний нийгмийн байгууллагын эмэгтэй тэргүүн

Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) нь эмзэг нарийн сэдэв тул уурхайчидтай хийсэн ганцаарчилсан ярилцлагад зөвхөн хязгаарлагдмал хэмжээгээр оруулсан болно (Алтны бичил уурхай дахь бэрхшээлүүд хэсгээс үзнэ үү). Энэхүү ганцаарчилсан ярилцлагаар ЖСХ түгээмэл байгаа бөгөөд энэ асуудал нь чухал сэдэв тул жендэрийн сургалтанд тусгах шаардлагатай болохыг харуулж байна.

Хүний эрхийн үндэсний комиссын төлөөлөл тэмдэглэхдээ төв болон аймгийн түвшний орон нутгийн төрийн албан хаагчдын дийлэнх нь жендэрийн сургалтад хамрагдсан бол сумын түвшинд, ялангуяа алслагдсан сумдын төрийн албан хаагчдыг сургах шаардлагатай байгааг онцлов. Эдгээр сумдын төрийн албан хаагчид нь бичил уурхайчидтай хамгийн ойр харьцдаг ба тэдний үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлтийг сайжруулахын тулд энэ түвшинд жендэрийн чадавхийг бэхжүүлэх нь чухал юм.

Сургалтын хэлбэрийн хувьд алтны бичил уурхай дахь үндсэн агуулгыг оруулахын зэрэгцээ эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, залуучуудын онцлог хэрэгцээнд тулгуурлан сургалтыг тусгайлан боловсруулахыг экспертүүд зөвлөсөн байна (Хэсэг 8.2).


Мэдээллийн эх сурвалж

Алтны бичил уурхайтай холбоотой мэдээллийг тогтмол авахад ашигладаг мэдээллийн эх сурвалжийн тухай 8-р бүлэгт харуулснаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хооронд мэдээлэл олж авахад мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаагүй байна. Алтны бичил уурхайн талаарх мэдээлэл олж авдаг хамгийн чухал мэдээллийн эх сурвалж нь эмэгтэйчүүдийн хувьд ТВ (65%), Фэйсбүүк (55%), утас (37%), ам дамжсан яриа (20%) гэж хариулжээ. Түүнчлэн уул уурхайн үйл ажиллагааны оролцогч талууд нь мэдээлэл авах чухал эх үүсвэр (49%) байгаа бөгөөд дараа нь мэдээллийн хэрэгсэл (28%), гэр бүл, найз нөхөд (26%) орж буй нь эрэгтэйчүүдтэй адил байна.

6.2.7 Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэл

Олборлолтын талбай дахь ажил хөдөлмөрийн жендэрийн хуваариас харахад эрэгтэйчүүд хүнд даацын юм өргөх, эсвэл аюулгүй ажиллагааны нөхцөл хангагдаагүй уурхайд ажилладгаас болж гэмтэл бэртэл, осолд өртөж болзошгүй ажил үүргийг илүү их гүйцэтгэдэг гэж дүгнэж болно. Гэсэн хэдий ч зохион байгуулалт, механикжуулалтын түвшингээс хамаарч эмэгтэй бичил уурхайчид хүдэр олборлох, баяжуулах ажиллагаанд бүс нутгуудад харилцан адилгүй оролцдог тул бие махбодийн осол, гэмтэлд өртөмтгий байх магадлалтай. Улмаар гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр эмэгтэй бичил уурхайчид ажлын байрны эрүүл мэндийн эрсдэлүүд, тухайлбал, цаг агаарын хүйтэн нөхцөлд удаан хугацаагаар ажилласнаар үе мөч, нуруу, бөөр шээсний замын эмгэгтэй болох, амьсгалын замын өвчин, харшил гэх зэргийг дурдаж байсан.

Цаашилбал, эмэгтэй бичил уурхайчид жирэмсэн байх хугацаандаа хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэл, аюулд өртөмтгий байдаг. Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн дөрөвний гурав (76%) нь нөхөн үржихүйн насныхан (50-аас доош насны) байна. Эдгээр эрсдэлүүд нь хүнд юм өргөх, химийн бодисонд хордох, төрөхийн өмнөх болон дараах үзлэгт хамрагдах эрүүл мэндийн үйлчилгээ авах, жирэмсний үеийн яаралтай тусламж авах боломж зэрэгтэй холбоотой байдаг байна. Жирэмсэн байхдаа олборлолтын талбайд ажиллаж байсан эсэх талаар асуухад судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 17% нь эерэг хариулт өгсөн бөгөөд үүнээс 11 эмэгтэй аюулгүй байдлаа хангах арга хэмжээ аваагүй байна. Аюулгүй байдлаа хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан гэж хариулсан бусад оролцогчид цөөн цагаар ажиллах, аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн талаарх зөвлөмжийг чанд мөрдөх, эм уух, цусны даралтаа хянах зэрэг арга хэмжээ авсан байна. Гүнзгийрүүлсэн судалгаанд оролцсон дөрвөн эмэгтэй бичил уурхайчин жирэмсний хугацаанд олборлолтын талбайд ажиллаж байхдаа эрүүл мэндийн асуудалтай тулгарч байсан гэж хариулсан боловч тухайн асуудлын талаар нарийвчилан тодорхой тайлбарлаагүй байна.



Зураг 6-18. Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн жирэмсэн үедээ авч хэрэгжүүлсэн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга хэмжээ (n=100)

Эмэгтэй бичил уурхайчид жирэмсэн болох үедээ нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргаад олборлолтын талбайд үргэлжлүүлэн ажиллах шаардлагагүй гэж Алтай сумын орон нутгийн төрийн албан хаагч тайлбарласан. Гэсэн хэдий ч судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн

зөвхөн 65% нь нийгмийн халамжид хамрагдахын тулд нийгмийн даатгалын шимтгэлийг тогтмол төлнө гэж хариулжээ. Жирэмсэн үеийн аюулгүй байдлаа хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах болон нийгмийн даатгалд хамрагдалтын хооронд ямар нэг хамаарал байхгүй байна. Бодит байдал дээр нийгмийн даатгалаа тогтмол төлдөг эмэгтэйчүүд жирэмсэн байх хугацаандаа аюулгүй байдлаа хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авалгүй ажиллаж байсан болохыг өмнө нь тайлбарласан билээ.

6.2.8 Мөнгөн усны өртөлт

Алтны бичил уурхайд алт ялган авахад мөнгөн усыг ашиглаж байгаа нь эх, эхийн хэвлий дэх ургийг мөнгөн усны ууршилтад өртөхөд хүргэж улмаар ургийн эрүүл мэндэд хор нөлөө үзүүлж болно. Монгол Улсад мөнгөн усны хэрэглээ нь хууль бус тул энэхүү тайланд янз бүрийн хүчин зүйл дээр үндэслэн зөвхөн түүний тархалтыг тооцоолох боломжтой (5-р бүлэг). Гүнзгийрүүлсэн судалгаанд оролцогчид нутаг дэвсгэрт нь баяжуулах цехүүд ашиглалтад орсноор Сэлэнгэ аймгийн Түнхэл, Баянгол, Мандал сумдад мөнгөн усны хэрэглээ байхгүй болсон гэж мэдэгдсэн. Ховд аймгийн Алтай сумын эмэгтэйчүүд Алтай сум болон түүнтэй залгаа сумдад, ялангуяа алтны үндсэн ордоос олборлосон хүдэр баяжуулахад хууль бусаар мөнгөн ус хэрэглэсээр байгааг мөн мэдэгдэж байсан.

Судалгаанд хамрагдагсад мөнгөн усны хэрэглээний талаар мэдээлэл өгөхөөс зайлсхийж эсвэл татгалзаж байсан тул эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд мөнгөн усаар алт ялгаж авах (мөнгөн усаар алт бариулах, ууршуулах) баяжуулалтын аль үе шатанд түлхүү оролцож байгааг үнэлэх боломжгүй байв. Бусад судалгаанаас харахад Төв аймгийн албан бус олборлолтын талбайд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү мөнгөн усаар алт бариулахад оролцдог байжээ (Навч нар, 2006). Энэ дүр зураг нь бүс нутаг тус бүрээр өөрчлөгдөж болох бөгөөд бие бялдрын хүч шаарддаггүй тул эмэгтэйчүүд мөнгөн усаар алт бариулах, ууршуулах ажлыг гүйцэтгэдэг хандлага ажиглагдаж байна. Азийн сангаас (2013 он) явуулсан судалгаанд алтны бичил уурхайн нөхөрлөлийн хэд хэдэн ахлагч нар албан болон албан бус олборлолтын талбайд жирэмсэн эмэгтэйчүүд мөнгөн устай харьцаж байхыг харсан гэж мэдэгджээ.

Мөнгөн усны элементийн ууршилтанд өртөх нь бүх хүнд хортой бөгөөд мөнгөн ус нь хөгжиж буй ургийн цусан ихэсийн хоригийг дамжин нэвтэрч мэдрэлийн эсүүдийг хордуулдаг тул нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд илүү аюултай байдаг. Мөнгөн усны хордлого умайн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө нь байнгын шинж чанартай байх магадлалтай бөгөөд улмаар хүүхдийн хэл яриа, хөдөлгөөний хомсдол зэрэг хөгжлийн бэрхшээлийг үүсгэж болзошгүй (АБУЗ, 2020 он). Нярай болон бага насны хүүхдүүдийн гол эрхтнүүд хөгжиж байдаг тул мөнгөн усны нөлөөнд илүү өртөмтгий байдаг. Гэсэн хэдий ч судалгаагаар баяжуулалтын үе шатанд мөнгөн ус ашиглах, ялангуяа ууршуулах үед нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, нялх хүүхэд, хүүхдүүд хажууд нь байсан эсэх талаар мэдээлэл цуглуулж чадаагүй байна.

6.2.9 Нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ

Олборлолтын талбайн аюулгүй ажиллагааны ерөнхий урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухайд (4.2-р бүлэг) судалгаанд оролцогч эмэгтэй, эрэгтэй бичил

уурхайчдын нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хэрэглээний түвшин ижил төстэй байна (56% ба 58%). Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтанд хамрагдсан эмэгтэй бичил уурхайчдын тоо нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байна (64% ба 57%). Мөн олборлолтын талбайд ХАБЭА-н стандартыг эмэгтэйчүүд илүү дагаж мөрддөг (61% ба 58%) болохыг харуулсан. Түүнчлэн орон нутгийн удирдлагууд ч эмэгтэй бичил уурхайчид ХАБЭА-н стандартыг илүү дагаж мөрддөг гэдгийг баталгаажуулсан. Тиймээс эмэгтэй бичил уурхайчдыг ХАБЭА-н стандарт, аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах сургалтанд хамруулах нь эмэгтэйчүүдийг илүү эрүүл, аюулгүй уул уурхайн үйл ажиллагааг төлөвшүүлэх өөрчлөлт хийх агент/идэвхжүүлэгч болгон эрх мэдэлжүүлэх боломжийг бий болгож байна.

6.2.10 Эмэгтэй бичил уурхайчдад тохиолддог хүндрэл бэрхшээл, боломжууд

Бичил уурхайн салбарт ажиллаж буй эмэгтэй бичил уурхайчдад жендэрийн онцлог бэрхшээл тулгардагч ч олон боломж бий болдог байна. Жендэр нь эмзэг нарийн сэдэв тул эмэгтэйчүүдэд тохиолддог жендэрийн онцлог бэрхшээл, боломжуудыг голчлон гүнзгийрүүлсэн судалгаагаар авч үзсэн. КОВИД-19-тэй холбоотой гарсан аюулгүй байдлын дүрэм, журмын улмаас төлөвлөсний дагуу эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчидтай фокус бүлгийн ярилцлага хийх боломжгүй байлаа.

Хүндрэл бэрхшээл

Судалгааны үеэр эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдаас олборлолтын талбай дээр эсвэл байгууллагын хүрээнд (Хүснэгт 6.2-3-т дурдсан) нийгэм, эдийн засаг, ажлын байртай холбоотой хүндрэл бэрхшээл гардаг эсэх талаар асуусан. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь (эмэгтэйчүүдийн 66%, эрэгтэйчүүдийн 59%) ямар нэг асуудал гарсан талаар мэдээлэл өгөөгүй байна. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хариулт ижил төстэй байсан. Гэсэн хэдий ч, хүчирхийлэл, жендэрт суурилсан дарамт шахалт, архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх зэрэг нийгмийн эмзэг асуудлуудын талаар дутуу мэдээлсэн байх магадлалтай тул гүнзгийрүүлсэн судалгааны үед энэ асуудлыг авч үзсэн болно.

Хүснэгт 6.2-3. Олборлолтын талбайд гардаг хүндрэл, бэрхшээл (судалгааны бүс нутгаар, хүйсээр, олон сонголттой, нийт= 490)

		Бүс					Нийт	
		Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=72)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Эмэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)
Байхгүй	Байхгүй	56%	67%	65%	63%	50%	66%	59%
Нийгмийн хүндрэл бэрхшээл	Хүчирхийлэл	8%	2%	0%	2%	8%	2%	4%
	Дарамт (ерөнхий)	6%	3%	1%	3%	5%	2%	4%
	Бэлгийн дарамт	2%	2%	1%	2%	1%	1%	2%
	Архины хэт их хэрэглээ	8%	4%	1%	10%	12%	4%	8%
	Гэмт хэрэг	4%	4%	0%	2%	1%	2%	2%
	Ялгаварлан гадуурхалт	8%	3%	3%	6%	7%	4%	5%
Эдийн засгийн хүндрэл бэрхшээл	Орлого баталгаагүй	12%	15%	18%	13%	22%	16%	16%
	Шударга биш хөлс	12%	4%	13%	3%	11%	8%	8%
	Ажлын үнэ цэнэ	12%	4%	4%	2%	4%	4%	5%
Ажлын байртай	Ажлын нөхцөл	10%	10%	7%	13%	7%	9%	9%
	Химийн бодист өртөх	6%	4%	0%	0%	1%	2%	2%
	Ажлын байрны аюулгүй байдал	4%	6%	3%	10%	9%	7%	6%

холбоотой бэрхшээл	Бусад	4%	2%	3%	2%	0%	0%	3%
-----------------------	-------	----	----	----	----	----	----	----

Эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүд хүчирхийлэл, дарамт шахалт, жендэрт суурилсан хүчирхийлэл, архидан согтуурах, ялгаварлан гадуурхах үзэгдэл түгээмэл байдаг гэж мэдээлсэн нь анхаарал татаж байна. Судалгаанд оролцогчдоос дээр тодорхойлсон асуудлуудын аль нэгэнд өртөж байсан уу эсвэл эдгээр асуудлууд уурхайн талбайд нийтлэг байдаг уу гэсэн нээлттэй хариулт бүхий асуулт асуусан тул эдгээр тоон мэдээллүүд дээр үндэслэн эмэгтэй бичил уурхайчдад тохиолддог жендэрийн онцлог шинжтэй бэрхшээлүүдийг тодорхойлох боломжгүй байсан болно.

Судалгааны бүс нутгууд дахь хүндрэл бэрхшээлийн тархалтаар тухайн асуудлын цар хүрээг орон нутгийн түвшинд тодорхойлж болно. Гэсэн хэдий ч асуудал дутуу мэдээлэгдсэн, түүврийн хэмжээ бага байсан зэрэг хүчин зүйлсийг мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд анхаарч үзэх хэрэгтэй. Жишээлбэл, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг талаар судалгааны бүс нутаг бүрт дор хаяж нэг оролцогч дурдсан байхад хамгийн их тохиолдол Алтай (10%; n=9), Есөнбулаг (12%; n=6)-т бүртгэгдсэн байна. Нийтлэг болон бэлгийн дарамт, хүчирхийллийн талаар судалгаанд оролцогч 19 хүн мэдээлсэн нь голчлон Есөнбулаг (8%, n=11), Алтай (6%, n=50)-гаас судалгаанд хамрагдсан хүмүүс байсан.

Жендэрт суурилсан хүчирхийлэл

Жендэрт суурилсан хүчирхийлэлд (ЖСХ) зөвхөн бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэл төдийгүй жендэр, жендэрийн шинж төрхөөр нь бусдыг доромжлох, хянах, үгүйсгэх, хор хохирол учруулах зорилготой үг, дохио зангаа бусад үйлдлийг багтааж болно. ЖСХ бие махбодийн, бэлгийн, нийгмийн буюу эдийн засгийн хүчирхийлэл гэх мэт янз бүрийн хэлбэрээр олон нийтийн газар, ажлын байранд эсвэл гэр ахуйн хүрээнд гэх мэт өөр өөр газарт үйлдэгддэг байна (АБУЗ, 2020 он). Олборлолтын талбай эсвэл бусад газарт үйлдэгддэг ЖСХ нь эмзэг асуудал тул тоон судалгаагаар гаргахад бэрхшээлтэй байдаг бөгөөд албан ёсны ярилцлагын үед оролцогчид энэ талаарх мэдээллийг задруулахгүй байхыг илүүд үздэг. Монгол Улсад хийгдсэн жендэрийн судалгааны тайлангаас харахад нийт хүн амын дунд ЖСХ нийтлэг тархсан байгааг харуулж байна. Жишээлбэл, ҮСХ ба НҮБ-ын Хүн амын сангаас гаргасан тайланд (2018 он) Монгол Улсын эмэгтэйчүүдийн 30% нь бие махбодийн хүчирхийлэл, 20% нь эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн болохыг тогтоожээ (жишээлбэл, эмэгтэйчүүдийг ажилд орохыг хориглох эсвэл өрхийн хэрэгцээнд мөнгө зарцуулахыг нь эсэргүүцдэг). Нийт хүн амын дунд ЖСХ, түүний дотор ажлын байран дахь бэлгийн дарамт нэмэгдэж байна. Тиймээс ЖСХ-ийн талаар ганцаарчилсан ярилцлага болон 30 эмэгтэй бичил уурхайчинтай хийсэн гүнзгийрүүлсэн судалгааны үеэр хөндөж ярилцсан болно. Гэсэн хэдий ч гүнзгийрүүлсэн судалгааны үеэр хэд хэдэн эмэгтэй ЖСХ-тэй холбоотой асуултанд хариулахыг хүсээгүй.

Судалгаанд хамрагдагсдын гуравны нэг нь (n=10) өөрсдийн амьдарч байгаа орчинд ЖСХ буюу гэр бүлийн хүчирхийллийн талаар хараагүй, сонсоогүй гэж хариулсан бол 6 оролцогч асуултанд хариулахыг хүсээгүй болно. Гэхдээ судалгаанд оролцогчдын бараг тэн хагас нь (n=14) өөрийн орон нутагт

эмэгтэйчүүд ЖСХ-тэй тулгарч байсныг сонссон эсвэл харсан байна. Эдгээрээс 6 эмэгтэй олборлолтын талбайд болсон тохиолдлыг ажигласан бол 8 эмэгтэй ЖСХ ихэвчлэн гэр ахуйн хүрээнд тохиолддог гэж хэлсэн. Ганцаарчилсан ярилцлагын зарим оролцогчид олборлолтын талбайд ихэвчлэн эхнэр, нөхрүүд хамт ажилладаг, гэр бүлийн гишүүд байдаг нь бие биедээ тодорхой хэмжээний хамгаалалт болдог тул ЖСХ-ийн тархалт бага байгаа гэж тайлбарласан байна. Ер нь судалгаанд оролцогчид дунд гэрлээгүй, ганц бие, эсвэл гэр бүл салсан эмэгтэйчүүдийн тоо бага байсан.

Энэ нь эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн дарамт зэрэг ЖСХ-ийн тархалтын түвшинг бууруулж байгаа гэж тайлбарлаж болох боловч ахуйн хүрээнд болон олборлолтын талбайд ЖСХ байхгүй гэсэн үзүүлэлт биш юм.

Эмэгтэйчүүдийн дийлэнх нь (n=18) гэр ахуйн хүрээнд болон олборлолтын талбайд гардаг ЖСХ нь ихэвчлэн архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэнтэй холбоотой байдаг гэж хэлсэн байна. Архидан согтуурах тохиолдол олборлолтын талбайд бараг гардаггүй гэж эмэгтэйчүүд мэдэгдэж байсан хэдий ч бусад судалгаа албан бус олборлолтын талбай дээр архины хэрэглээ их байгааг харуулж байна (Азийн сан, 2013 он). Алтай, Есөнбулаг сумдад архи согтууруулах ундааны хэрэглээ их байгаа нь иргэдийн орлогын хомсдол, ядууралтай холбоотой гэж үзэж байв. Ярилцлага авсан төслийн багийн зарим гишүүд орон нутгийн ард иргэд зээлийн өр, ажлын байрны хомсдол, олборлолт хийх зөвшөөрөлтэй талбай байхгүй, КОВИД-19-ийн орон нутгийн бизнес эрхлэгчдэд үзүүлсэн эдийн засгийн нөлөөллөөс болж их уур бухимдалтай болж улмаар зан байдал нь өөрчлөгдөж байгааг ажигласан байна. Үүний улмаас хүчирхийлэл ихэссэн байна. Энэхүү дүгнэлт нь орон нутгийн иргэдийн орлогын эх үүсвэрт алтны бичил уурхай чухал байр суурь эзэлдэг бөгөөд тэдгээрийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурлаас үүдэлтэй хүчирхийллийг бууруулахад дэмжлэг үзүүлдэг гэдгийг харуулж байна. Цагдаад хандах нь бас шийдэл гэж эмэгтэйчүүд үзэж байлаа.

ЖСХ-ийг арилгахын тулд холбогдох талуудыг нийгэмшүүлэх, хүний сэтгэл зүй, зан байдал (тухайлбал, жендэрийн шинж төрх, онцлог зан байдал), гэр бүлийн хөгжил зэрэг сэдвүүдийг хамарсан сургалт зохион байгуулж эрэгтэй, эмэгтэй бичил уурхайчдыг хамруулахыг эмэгтэйчүүд санал болгож байсан. 2019 онд МБУНДХ нь ЖСХ-ийн талаар сургалт зохион байгуулсан байна. Эмэгтэй бичил уурхайчид ЖСХ-ийн талаар мэдлэг эзэмшсэн тул сургалт үр дүнтэй болсон гэж орон нутгийн ажилтан дүгнэж хэлсэн. Жишээлбэл, эмэгтэй бичил уурхайчид эмэгтэй хүний биед зөвшөөрөлгүй гар хүрэх, хэл амаар дарамтлах нь ЖСХ гэж тооцогддог болохыг мэдсэн. ЖСХ-тэй холбоотой шинэ мэдлэг, мэдээлэл олж авсны дараа зарим эмэгтэй бичил уурхайчид өөрсдийгөө хамгаалах ёстой гэдгээ ойлгож авсан байна. Тэдний зарим нь нөхрөөсөө салсан тохиолдолд тэтгэмж авах ёстой гэдгийг ойлгоод, нэхэмжлэл гаргасан тохиолдол байна.

Эдгээр дүгнэлтүүд нь ЖСХ нь Монгол Улсын нийт хүн амын дунд гэхээсээ илүү алтны бичил уурхайд түгээмэл болох нь нотлоогүй ч, бичил уурхай нь ядуурлаас үүдэлтэй тохиолдолд эмэгтэйчүүд ЖСХ-д илүү өртөмтгий байж болохыг харуулж байна. Азийн сан (2013 он) бичил уурхай дахь ЖСХ нь ерөнхийдөө бага, ихэвчлэн архины хэрэглээтэй холбоотой гэсэн ижил төстэй дүгнэлт хийсэн боловч энэ

талаар маш бага мэдээлэл байсан бөгөөд эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй гэж үзэж болно.

Боломжууд

Гүнзгийрүүлсэн судалгааны үеэр эмэгтэйчүүдээс алтны бичил уурхайд ажиллахад бий болдог боломжуудыг тодорхойлохыг хүссэн. Ярилцлагад хамрагдсан бараг бүх эмэгтэй бичил уурхайчид (30 эмэгтэйгээс 27 нь) энэ салбарт ажиллахын давуу талыг тодорхойлов. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад зохион байгуулах ур чадвар сайтай тул алтны бичил уурхайн байгууллагуудад менежментийн чиглэлээр ажиллах боломж байдаг (30 эмэгтэйгээс 12 нь) гэж тодорхойлсон нь эмэгтэйчүүдэд бий болсон чухал боломжуудын нэг юм.

Судалгаагаар эмэгтэйчүүд хууль эрх зүйн орчин, зөвшөөрөл олгох үйл явцын талаар илүү сайн мэдлэгтэй болохыг тогтоожээ. Түүнчлэн зарим эмэгтэйчүүдийн хариултаас эмэгтэй бичил уурхайчид хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрмийг мөрдөж, олборлолтын талбайд эрэгтэй бичил уурхайчдаас илүү болгоомжтой ажиллах хандлагатай байдаг гэж дүгнэж болно. Эмэгтэй бичил уурхайчдын одоогийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, чадавх бэхжүүлэх сонирхол нь эмэгтэйчүүдийг алтны бичил уурхайд албажуулах, уул уурхайн илүү сайн практик туршлагууд, түүний дотор магадлан шинжилгээний удирдамжийг дагаж мөрдүүлэх талаар өөрчлөлт гаргах идэвхжүүлэгч/агент болгохын тулд эрх мэдэлжүүлэх сайхан боломжийг олгож байна.

Мөн түүнчлэн, 30 эмэгтэйн 10 нь эмэгтэйчүүдэд олдож байгаа бусад ажлын байртай харьцуулахад алтны бичил уурхайд илүү орлого олох боломж, санхүүгийн менежмент зэрэг шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалд ажиллах боломж (30 эмэгтэйн 8 нь) байгааг тэмдэглэн хэлжээ.

“Миний ойлголтоор АБУ-д ажиллах нь надад бусад ажлаас илүү их цалин авах боломж олгодог. Жишээлбэл, би орон нутгийн нэг коллежид багшаар ажилладаг байсан бөгөөд 2015 онд охиноо олон улсын теннисний тэмцээнд оролцуулахын тулд надад мөнгө (5.000.000 төгрөг) хэрэгтэй байсан. Учир нь миний охин тэмцээнд оролцохын тулд 5.000.000 төгрөгийг тус сангийн банкны дансанд байршуулах ёстой байсан. Гэсэн хэдий ч надад ийм хэмжээний мөнгө байгаагүй тул хүмүүстэй нэгдэж алтанд явахаар шийдсэн юм. Үүний үр дүнд би сарын дотор охиныхоо мөнгийг цуглуулж чадсан нь бидний хувьд том завшаан байсан”.

Гүнзгийрүүлсэн судалгаа, Ховд аймгийн эмэгтэй бичил уурхайчин

Ярилцлагад оролцсон цөөн тооны эмэгтэй бичил уурхайчин энэ салбарт ажиллаж байгаа нь эмэгтэйчүүдэд хувь хүний хөгжлийн сургалтанд хамрагдах эсвэл орон нутгийн удирдлагуудад хандаж, асуудлаа тайлбарлах, дэмжлэг хүсэх давуу тал олгодог гэж хариулав. Энэ боломж нь зөвхөн албан ёсны байгууллагад ажилладаг эмэгтэйчүүдэд байдаг. Үүгээр алтны бичил уурхайн байгууллагыг албажуулах нь орон нутгийн удирдлагаас дэмжлэг авах чухал урьдчилсан нөхцөл болж байгааг харуулж байна. Эмэгтэй бичил уурхайчид жендэртэй холбоотой асуудлаар дэмжлэг туслалцаа авахаар орон нутгийн удирдлагуудад хэр зэрэг ханддаг, орон нутгийн удирдлагууд жендэрийн онцлогтой ямар дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжтой вэ гэдгийг ойлгохын тулд гүнзгийрүүлж судалгаа хийх шаардлагатай байна. Чанарын судалгаанд оролцогчид бичил

уурхайн салбар албажсанаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд найдвартай, аюулгүй ажлын байртай болох боломжийг олгож байгааг тэмдэглэв.

Гэсэн хэдий ч алтны бичил уурхайд албажуулахын зэрэгцээ эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдад илүү таатай ажиллах орчныг бий болгох шаардлагатай байна. Энэ нь илүү олон эмэгтэй бичил уурхайчинд удирдах ажил үүрэг гүйцэтгэх, илүү олон эмэгтэйд тулгараад байгаа давхар ажлын ачаалалтай холбоотой асуудлыг (Хэсэг 6.3-аас үзнэ үү) шийдвэрлэх боломжийг олгоно. УУХҮЯ-ны ахлах мэргэжилтэн, Засгийн газар эдгээр бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор "Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2019-2026 он)"-ыг баталсан гэж тайлбарлав. Энэхүү бодлогын бичиг баримт нь том уул уурхайн үйл ажиллагаа, 14 хоногийн ээлжийн ажил болон гэр бүлээсээ тусдаа байх зэрэг асуудлуудад голчлон анхаарал хандуулсан байгаа хэдий ч зарим талаар алтны бичил уурхайд бас хамаатай юм. Энэхүү бодлого нь "Салбарын төр болон хувийн хэвшлийн бүх түвшинд зохистой, жендэрийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн, ажил-ар гэрийн амьдралын тэнцвэр хангасан орчин бүрдүүлэх, салбарын яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны захиргааны бүх хүрээнд болон аж ахуйн нэгж, байгууллагын удирдах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг хангах, бүх хүрээнд эмэгтэй, эрэгтэйчүүд тэгш үр шим хүртэхэд чиглэсэн "тусгай арга хэмжээ" болон бусад төрөл бүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх" зорилготой юм (УУХҮЯ, 2019 он).

Бичил уурхайн салбарт энэхүү бодлогыг хэрэгжүүлэх зохих арга хэмжээ авахын тулд орон нутгийн төрийн албан хаагчдын жендэрийн хариу арга хэмжээг авах чадавхыг бэхжүүлэх шаардлагатай байж магадгүй юм. Ганцаарчилсан ярилцлагын үед өгсөн мэдээллээс үзэхэд УУХҮЯ нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарын эмэгтэйчүүд ТББ-тай хамтран жендэрийн үзэл баримтлал, жендэрийн мэдрэмжтэй бодлого, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн талаар сургалт явуулахаар төлөвлөж байна.


6.3 Ахуйн хүрээн дэх жендэрийн динамик

Судалгаанд ажил мэргэжлийн буюу үйлдвэрлэлийн хүрээ, түүний жендэрийн динамикийг голчлон авч үзэхийн зэрэгцээ ахуйн хүрээн дахь хоёр асуудлыг судалсан: өрх гэрийн ажил үүргийн жендэрийн хуваарь болон өрхийн түвшинд шийдвэр гаргах эрх мэдлийн жендэрийн хуваарилалтыг авч үзэв. Бичил уурхайчид ихэвчлэн гэр бүлийн гишүүдтэйгээ хамтарч ажилладаг тул өрхийн түвшний эрх мэдлийн динамик, ажлын ачаалал нь олборлолтын талбайн жендэрийн динамикт нөлөөлж болно.


6.3.1 Өрх гэрийн ажил үүргийн жендэрийн хуваарь

Үндэсний статистикийн хорооноос 2015 онд явуулсан "Цаг ашиглалтын судалгаа" -ны үр дүнд эмэгтэйчүүд өдөрт дунджаар 203 минут, эрэгтэйчүүд 69 минутыг гэрийн ажилд зарцуулдаг болох нь тогтоогдсон ба энэ нь Монгол Улсад гэрийн ихэнх ажлыг эмэгтэйчүүд гүйцэтгэж байгааг харуулж байна. Хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд гэр бүлийн цалингүй ажилд, ялангуяа хүүхэд, өндөр

настнуудыг асран халамжлах ажилд илүү их цаг зарцуулах хандлагатай байдаг. Судалгааны үр дүнгээс харахад эмэгтэйчүүд долоо хоногт дунджаар 35 цаг (өдөрт 5 цаг), эрэгтэйчүүд долоо хоногт 27 цаг (өдөрт бараг 4 цаг) зарцуулдаг байна. Гэсэн хэдий ч Цаг ашиглалтын судалгааны тоон мэдээлэлтэй харьцуулахад цагийг хэтрүүлэн мэдээлснээс энэ мэдээлэл нь бодит байдлаас хэт хэлбийсэн байж магадгүй юм. Судалгаанд хамрагдсан 10 эрэгтэй тутмын нэг нь (21%) долоо хоногт арав хүрэхгүй цагийг гэрийн ажилд зарцуулдаг болохыг Зураг 6-20-д харуулав. Ажил үүргийн хуваарь (Зураг 6-19) нь судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүд долоо хоногт гэрийн ажил үүрэгт зарцуулдаг цагийг хэтрүүлэн мэдээлсэн болохыг харуулж байна.




Зураг 6-19. Гэр орны ажилд оролцох оролцоо болон зарцуулдаг цаг (долоо хоногт), (хүйсээр, n=100 эмэгтэй, 271 эрэгтэй)



Зураг 6-20. Гэрийн ажилд оролцоход зарцуулдаг цаг

Зураг 6-21-ээс харахад гэрийн ажлын ихэнх хувийг ялангуяа хоол хийх, угаалга, цэвэрлэгээ ($\geq 92\%$), хүүхэд, хөгшдийг асран халамжлах ($\geq 56\%$) ажлыг эмэгтэйчүүд хийдэг бол гэрээс гадуурх ажлыг эрэгтэйчүүд голчлон хийдэг (ус авах, түлээ, нүүрс цуглуулах ($>79\%$)) байна.

Судалгаанд оролцогчдын мэдээлснээр гэр орны ажилд эрэгтэй бичил уурхайчдын оруулах хувь нэмэр нь тэдний ажиллаж байгаа салбарын онцлог, тухайлбал, 8-9 цаг үргэлжилдэг ээлжийн ажлаас их хамаардаг байна. Гэсэн хэдий ч эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдын бичил уурхайд ажилладаг дундаж өдрийн тоо (долоо хоногт) болон өдөр тутмын ажлын цагийн үргэлжлэх хугацааны хувьд зөрөө бага байсан бөгөөд эрэгтэйчүүдийн хувьд бага хэмжээгээр илүү байв (Хүснэгт 6.2-1-ээс харна уу).



Зураг 6-21: Гэрийн ажлын жендэрийн хуваарь (n=100 эмэгтэй, 271 эрэгтэй; олон сонголттой хариулт, нийт=1,651)

Хэдийгээр эрэгтэйчүүд гэрийн ахуйн ажил үүргийг гүйцэтгэхэд тодорхой хэмжээгээр хувь нэмрээ оруулж байгаа боловч өрх гэрийн ажлын уламжлалт жендэрийн хуваарь нь эмэгтэйчүүдийн ажлын өдрийг уртасгах шалтгаан болж байна. Үйлдвэрлэлийн болон нөхөн үржихүйн ажил үүрэг дэх давхар ажлын ачаалал нь эмэгтэйчүүдийг бие махбодийн ядаргаа, дарамтад оруулдаг байна. Уурхайчдад зориулсан сургалтын үйл ажиллагааг төлөвлөхдөө эмэгтэйчүүдийн ажлын ачаалал их байдгийг харгалзан үзэж эмэгтэйчүүдийг энэхүү сургалтад хамрагдах цаг зав гаргах боломжоор хангах шаардлагатай.

6.3.2 Шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн байдал

Өрхийн түвшинд шийдвэр гаргах үйл явц нь гэр бүлийн жендэрийн динамикт нөлөөлдөг бөгөөд ахуйн хүрээний эдгээр динамик нь олборлолтын талбайн жендэрийн динамикт нөлөөлж болно. Жишээлбэл, шийдвэр гаргах үйл явц дахь жендэрийн динамик эсвэл нийгмийн хэм хэмжээ нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үүрэг ролийг хэрхэн үнэлэхэд нөлөөлдөг. Гэр бүлийн орлогод хэн хувь нэмэр оруулдаг, нас, боловсрол, гэрлэлтийн байдал, хүүхэдтэй, хүүхэдгүй эсэх зэрэг хүчин зүйлүүд нь өрхийн жендэрийн тэгш байдлын түвшинд нөлөөлдөг.

Судалгааны хүрээнд өрхийн томоохон зардал, өрхийн өдөр тутмын худалдан авалт, хамаатан садангийндаа зочлохтой холбоотой шийдвэрийг ихэвчлэн хэн гаргадаг талаар асуусан. Энэ нь өрхийн түвшинд шийдвэр гаргахад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн гүйцэтгэдэг үүргийг тодорхойлох зорилготой байв. Үүнийг 12 улсын эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дунд өрхийн түвшинд шийдвэр гаргах эрх мэдлийн энэхүү хуваарийг ашиглаж үзсэн (С-Өөрчлөлт 2011 он).

Өрхийн томоохон зардлын талаарх шийдвэрийг ихэвчлэн өрхийн хэд хэдэн гишүүн (60%) хамтарч гаргадаг боловч нийт шийдвэрийн 25%-ийг нөхөр нь дангаараа гаргасан болохыг хүснэгт 6-4-өөс харж болно. Хэрэв тухайн эрэгтэй өрхийн үндсэн орлогыг олдог бол чухал эд хөрөнгө худалдан авах ажлыг эрэгтэй хүн гүйцэтгэх хандлагатай байдаг. Энэ нь улмаар өмчлөл эрэгтэй хүнийх байх магадлалыг нэмэгдүүлдэг.

Хүнсний бүтээгдэхүүн гэх мэт өдөр тутмын өрхийн худалдан авалтын талаарх шийдвэрийг ихэвчлэн эмэгтэйчүүд гаргадаг байна (нийт судалгаанд оролцогчдын 66%). Хоол хийх, цэвэрлэгээ хийх гэх мэт гэрийн ажлыг эмэгтэйчүүд голлон гүйцэтгэдэг тул энэ нь гайхмаар зүйл биш юм. Энэ нь эмэгтэйчүүд өдөр тутмын гэр ахуйн асуудлаар бие даан шийдвэр гаргадаг болохыг харуулж байгаа хэдий ч эрэгтэйчүүдээс илүү шийдвэр гаргах эрх мэдэлтэй гэдгийг илэрхийлээгүй болно. Үүнийг эмэгтэйчүүд гэрийн ажлыг хариуцаж, өдөр тутмын хоол хүнс, хэрэгцээт эд зүйлийг худалдан авах үүрэгтэй гэсэн одоо болтол хадгалагдаж ирсэн эцгийн эрхэт ёсны соёл, уламжлалт зан заншилтай холбож болно. Гэр бүл, хамаатан садныдаа зочилж очих шийдвэрийг ихэвчлэн эхнэр, нөхөр эсвэл гэр бүлийн хэд хэдэн гишүүн (59%) нийлж гаргадаг байна.

Хүснэгт 6.3-1. Судалгаанд оролцогч гэрлэсэн иргэдийн өрхийн түвшинд гол шийдвэр гаргагчид (хүйсээр болон нийт)

	Эмэгтэй (n=87)	Эрэгтэй (n=211)	Нийт (n=298)
Өрхийн гол зардлын (машин, байр, мал худалдаж авах гэх мэт) талаар шийдвэр гаргадаг вэ?			
Би ганцаараа шийдвэр гаргадаг	17%	24%	22%
Манай гэр бүлийн хүн шийдвэр гаргадаг	22%	12%	15%
Би гэр бүлийн хүнтэйгээ шийдвэр гаргадаг	56%	62%	60%
Би гэр бүлийн бусад гишүүдтэйгээ шийдвэр гаргадаг	5%	2%	3%
Өрхийн өдөр тутмын худалдан авалтын талаар (хүнс, хувцас гэх мэт) хэн шийдвэр гаргадаг вэ?			
Би ганцаараа шийдвэр гаргадаг	71%	7%	26%
Манай гэр бүлийн хүн шийдвэр гаргадаг	11%	64%	48%
Би гэр бүлийн хүнтэйгээ шийдвэр гаргадаг	15%	26%	22%
Би гэр бүлийн бусад гишүүдтэйгээ шийдвэр гаргадаг	2%	4%	3%
Гэр бүл, хамаатан садныдаа зочилж очих шийдвэрийг хэн гаргадаг вэ?			
Би ганцаараа шийдвэр гаргадаг	32%	15%	20%
Манай гэр бүлийн хүн шийдвэр гаргадаг	8%	23%	19%
Би гэр бүлийн хүнтэйгээ шийдвэр гаргадаг	57%	60%	59%
Би гэр бүлийн бусад гишүүдтэйгээ шийдвэр гаргадаг	2%	2%	2%

Гүнзгийрүүлсэн судалгааны үр дүнгүүд нь шийдвэр гаргах талаарх эдгээр туршлагыг харуулж байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь (30 эмэгтэйдээс 17 нь) гэр бүлтэй холбоотой шийдвэр гаргахдаа эхнэр/нөхөр харилцан ярилцаж шийдвэр гаргадаг гэж хариулсан. Долоон эмэгтэй бичил уурхайчин гэр бүлийн асуудлыг зохицуулахад ихэвчлэн эмэгтэйчүүд голлох үүрэг гүйцэтгэдэг гэж хэлсэн бол таван эмэгтэй гэр бүлийн хэмжээнд шийдвэр гаргахад эрэгтэйчүүд илүү давамгайлдаг гэж хэлсэн байна. Эдгээр мэдээллүүд нь бичил уурхайн болон Монгол Улс дахь жендэрийн үүргийн талаарх бусад тайлангийн үр дүнтэй нийцэж байгаа бөгөөд эмэгтэйчүүд өрхийн түвшинд шийдвэр гаргахад тэгш эрхтэй эсвэл давамгайлсан эрх мэдэлтэй оролцдоггүй, гэхдээ гэр бүлийн ихэнх ажил үүргийг гүйцэтгэдэг гэдгийг баталж (Азийн сан, 2013 он) байна. Тиймээс өрх гэрийн түвшинд шийдвэр гаргах эрх мэдэл нь тухайн өрхийн жендэрийн тэгш байдлыг шууд тодорхойлох үзүүлэлт биш юм. Гэсэн хэдий ч өрх гэрээ удирдах нь эрх мэдэлтэй байх хүчин зүйл болох талаар Түнхэл тосгоны судалгаанд оролцогч дараахь зүйлийг өгүүлсэн болно:

“Миний бодлоор эмэгтэйчүүд гэр бүл дотроо эрэгтэйчүүдээс илүү удирдах үүрэгтэй байдаг. Манай гэр бүлд ихэвчлэн эхийн эрхэт ёсны хэв маягийг баримталдаг гэж би боддог. Жишээлбэл, би гэр бүлийн төсвийг зарцуулах, зохицуулах үүрэгтэй бөгөөд нөхөр маань үүнийг зөвшөөрдөг. Миний оршин суудаг газрын өрхүүд дотор гэр бүлдээ надтай

адил үүрэг гүйцэтгэдэг, өрхийн хүрээнд шийдвэр гаргахад илүү эрх мэдэлтэй оролцдог олон эмэгтэйчүүдийг би мэднэ. "

Гүнзгийрүүлсэн судалгаа, Сэлэнгэ аймгийн уурхайчин эмэгтэй

Дээрх мэдээллүүдийг дүгнэж үзэхэд монголд эмэгтэйчүүд гэр бүлийн түвшинд шийдвэр гаргах, гэр бүлийн асуудлыг зохицуулахад голлох үүрэг гүйцэтгэдэг боловч гэрийн ихэнх ажлыг хийдэг тул ажлын ачаалал нь давхар нэмэгддэг байна.

6.4 Дүгнэлт

6.4.1 Ажил үүргийн жендэрийн хуваарь

Судалгаанаас харахад алтны бичил уурхай дахь нийт ажиллагсдын 30 орчим хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд ажлын цагийн хувьд эрэгтэйчүүдтэй ижил төстэй байгаа хэдий ч эмэгтэйчүүд арай бага цагаар, улирлын чанартай ажилладаг байна.

Чанарын болон тоон судалгааны үр дүнгээс үзэхэд бичил уурхайн байгууллагуудын доторх ажил үүргийн хуваарьт ажил үүргийн жендэрийн хуваарь хүчтэй нөлөөлдгийг харуулж байгаа бөгөөд ихэнх хүнд хүчир хөдөлмөрийг эрэгтэйчүүд (хүдэр олборлох, баяжуулах) хийдэг бол эмэгтэйчүүд хүдэр шуудайлах, голчлон хоол хийх, захиргааны ажил үүрэг зэрэг туслах үйлчилгээний ажил хөдөлмөр эрхэлдэг байна. Гэсэн хэдий ч судалгаагаар энэ нь бүс нутгаар хоорондоо ялгаатай байдгийг олж тогтоосон. Баруун аймгуудад (Есөнбулаг, Алтай сум) уламжлалт соёлын хэм хэмжээг баримталдаг бөгөөд санхүү зохицуулах, тоног төхөөрөмж худалдан авах, алт худалдах гэх мэт менежментийн шийдвэрт эрэгтэйчүүд түлхүү оролцдог байна.

Эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчид аль аль нь ажил хөдөлмөр дахь жендэрийн хуваарийн шалтгааныг эмэгтэйчүүд менежментийн ур чадвар сайтай бөгөөд хүнд хүчир биеийн хүчний ажил хийх ёсгүй гэж тэмдэглэн хэлсэн байна. Ер нь эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдын дунд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж эдийн засгийн хүндрэл бэрхшээлд оруулах (тэдгээрийн нөөцөөс хүртэх боломжийг хязгаарлах) гэхээсээ илүү хамгаалах зорилгоор уурхайн гүнд ажиллах, хүнд юм өргөх зэрэг аюултай ажилд оролцох ёсгүй гэсэн итгэл үнэмшил байдаг бололтой. Судалгааны дүгнэлт нь тухайн хүний гүйцэтгэж буй ажил үүргээс үл хамааран орлогоо эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дунд ижил тэгш хуваадаг болох нь энэхүү таамаглалыг баталгаажуулж байна.

6.4.2 Эрх мэдлийн динамик ба шийдвэр гаргалт

Бичил уурхайн байгууллагуудын шийдвэр гаргах түвшинд оролцож буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдтэй харьцуулахад доогуур (88% ба 95%), уул уурхайн үйл ажиллагаанд шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүд давамгайлах хандлагатай байдаг боловч эрэгтэй, эмэгтэй бичил уурхайчид санхүүгийн болон захиргааны шийдвэр гаргахад тэгш эрхтэй оролцдог гэжээ. Энэ нь бичил уурхайн байгууллагууд дотроо харилцан ярилцаж шийдвэр гаргадаг гэсэн мэдээлэлд үндэслэсэн боловч зарим байгууллагад шийдвэр гаргах

явцад эрэгтэйчүүд эсвэл эмэгтэйчүүд давамгайл эрх эдлэх тохиолдол цөөнгүй байдаг байна.

Бичил уурхайн салбар дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг, хариуцлагын дүн шинжилгээнээс харахад Ховд аймгийн Алтай сумаас бусад зорилтот бүх сумдад нөхөрлөлийн ахлагч, бичил уурхайн ТББ-ын тэргүүн эмэгтэйчүүд харьцангуй олон байгааг харуулж байна. Түүнчлэн ганцаарчилсан ярилцлагын үр дүн алтны бичил уурхайн ТББ-ууд нь ихэвчлэн эмэгтэй тэргүүнтэй байдгийг баталгаажуулав. Гэсэн хэдий ч судалгаанд оролцогчдын дийлэнх нь (42%) эрэгтэй манлайлагчийг, 37% нь жендэрийн хувьд төвийг сахисан, 22% нь эмэгтэй манлайлагчийг илүүд үздэг байна. Зорилтот бүс нутгууд илүү олон эмэгтэй манлайлагчтай байсан бөгөөд эмэгтэйчүүдийн манлайллыг илүү тааламжтай хүлээж авдаг байна. Боловсрол дахь жендэрийн урвуу зөрүү нь (тухайлбал, эмэгтэйчүүд өндөр боловсрол эзэмшсэн, менежмент, хууль эрх зүйн шаардлагыг хангахад эмэгтэйчүүдийн оролцоо) Монгол Улсын эмэгтэйчүүдийн манлайлалд таатай нөхцлийг бүрдүүлж байна.

6.4.3 Нөөцийн ашиглалт ба хүртээмж

Чанарын болон тоон судалгааны мэдээллүүд нь орлогын хуваарилалт, санхүүжилтийн хүртээмж эсвэл үйлдвэрлэлд хяналт тавих гэх мэт нөөцийн хүртээмжид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд томоохон ялгаа, тэгш бус байдал байгаа нь тогтоогдоогүй. Гэсэн хэдий ч уурхайчдын дийлэнх нь зөвхөн бичил уурхайгаас олсон орлогоор амьдралаа залгуулах боломжгүй, бусад орлогын эх үүсвэрээс хараат байдаг гэдгийг ойлгох нь чухал юм.

Судалгааны мэдээлэл, гүнзгийрүүлсэн судалгаа нь орлогын тэгш бус байдлыг харуулаагүй боловч төрийн албан хаагчид, хүний эрхийн шинжээчид болон МБУНДХ-ны удирдлагуудын хэлснээр эрэгтэй эмэгтэй бичил уурхайчдын ажил ажил хөдөлмөр дахь жендэрийн хуваарь, эрх мэдлийн хуваарилалтын ялгаа нь цалин ба ашгийн тэгш бус хуваарилалтын шалтгаан байж болзошгүй юм. Тиймээс судалгааны бүс нутгуудын судалгааны үр дүнгээр Монгол Улсын хэмжээнд тухайн салбарыг ерөнхийд нь дүгнэх боломжгүй юм.

6.4.4 Мэдээллийн хүртээмж ба чадавх бэхжүүлэх

Судалгаанд хамрагдсан бүс нутгийн эмэгтэйчүүд сүүлийн хоёр жилийн хугацаанд эрэгтэйчүүдээс илүү олон удаа сургалтад оролцсон байна. Гол оролцогч талууд эмэгтэйчүүд чадавх бэхжүүлэх үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцдог болохыг тэмдэглэв. Гол оролцогч талууд эрэгтэй бичил уурхайчдыг сургалтад хамруулах замаар жендэрийн тэгш байдлыг сайжруулах шаардлагатай байгааг онцолж байв. Судалгаанд оролцогчдын хамрагдсан сургалтад хийсэн жендэрийн дүн шинжилгээгээр эмэгтэйчүүд техникийн, хууль эрх зүй, бизнестэй холбоотой бүх сургалтуудад илүү идэвхтэй хамрагдсан болохыг тогтоосон.

Эмэгтэйчүүд ихэвчлэн албажуулах, хариуцлагатай, илүү сайн уул уурхайн практик туршлага, технологид сонирхолтой байсан бөгөөд жендэрийн болон хүний эрхийн сургалтуудыг бага сонирхож байсан. Гэхдээ гүнзгийрүүлсэн судалгаагаар энэ нь тухайн сэдвийн талаарх мэдлэг хомс байгаатай холбоотой

болохыг тогтоожээ. Үүнтэй адилаар гол оролцогч талууд судалгаанд хамрагдагсдаас өөрсдөөс нь илүү эмэгтэй, эрэгтэй бичил уурхайчдад ямар сургалтууд чухал шаардлагатай байгааг тодорхойлсон. Үүнд, хамгийн хэрэгцээтэй байгаа сургалтын гурван гол чиглэл нь мөнгөн усны эрсдэл, хор хөнөөл, хууль эрх зүйн орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сэдэв гэж тодорхойлжээ. Түүнчлэн бичил уурхайн нөхөрлөлийн эмэгтэй ахлагч гэр бүлийн хүчирхийллийн талаар сургалт явуулах шаардлагатай байгааг хэлэв.

Сургалтын чанар, үр ашгийг дээшлүүлэхийн тулд уурхай дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажлын онцлог, чадавх бэхжүүлэх семинарт эмэгтэйчүүд илүү идэвхтэй оролцдогийг харгалзан үзэж сургалтын хөтөлбөрийг арга зүй талаас нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст зориулж өөрөөр боловсруулахыг орон нутгийн оролцогч тал санал болгосон байна.

Тоон болон чанарын судалгааны үр дүнгээс харахад бичил уурхайчдад зориулсан сургалтыг өөр өөр байгууллагууд зохион байгуулж байгаа бөгөөд эдгээрээс МБУНДХ нь хамгийн чухал үүрэг гүйцэтгэж байна. ТББ-ын экспертүүд сургалт нь оролцооны арга дээр суурилсан, богино хугацааны (8 цагаас бага, хамгийн ихдээ хоёроос дөрвөн цаг хүртэл), танхимд бус, харин идэвхтэй, ажлын байранд явагдах нь зүйтэй гэж зөвлөсөн. Сургалтын хөтөлбөр нь алтны БУ-н үндсэн агуулгыг хамрахаас гадна эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, залуучуудын онцлог хэрэгцээнд тулгуурлан тусгайлан боловсруулагдсан байх ёстой.

6.4.5 Жендэрт суурилсан хүчирхийлэл

Тоон болон чанарын судалгааны үр дүнгээс харахад бичил уурхайн байгууллагуудын хүрээнд жендэрт суурилсан хүчирхийллийн тархалт бага байгаа боловч гардаг байна. Гэр бүлээрээ хамт, архины хэрэглээг хориглосон албан ёсны олборлолтын талбайд ажиллах нь хамгаалах хүчин зүйл болдог гэж ойлгогдож байна. Гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр гэр бүлийн хүчирхийллийн талаар, ялангуяа архи согтууруулах ундааны хэт хэрэглээтэй холбож ярих нь судалгаанд хамрагдагсдын хувьд төвөгтэй байсан. Гэхдээ энэ нь салбарын онцлог асуудал биш, харин Монгол Улсын нийгмийн өөрчлөлтийн нөхцөл байдалтай холбоотой юм.

6.4.6 Өрх гэрийн ажил үүргийн жендэрийн хуваарь

Чанарын болон тоон судалгааны үр дүнгээс харахад бичил уурхайд зарцуулах ажлын цаг ойролцоо байгаа хэдий ч эмэгтэйчүүд гэр орны ажлын ачааллын дийлэнх хэсгийг үүрч байгааг харуулж байна. Хэдийгээр эрчүүд ус, түлээ зөөх зэрэг гэрийн ажилд туслахад үргэлж бэлэн байдаг ч өрх гэрийн ажил үүрэг нь эмэгтэйчүүдийн ажлын ачааллыг давхар нэмэгдүүлдэг байна. Үүний зэрэгцээ өдөр тутмын өрхийн худалдан авалтын шийдвэрийг эмэгтэйчүүд голчлон гаргадаг. "Эрэгтэйчүүд эдийн засгийн хувьд ач холбогдол багатай худалдан авалт хийх сонирхол багатай байдаг", "эмэгтэйчүүд өдөр тутмын гэрийн ажлыг хариуцдаг" гэсэн ойлголтыг үндэслэн гэр бүлд өдөр бүр шийдвэр гаргахад эрэгтэйчүүдийн оролцоо бага байгаа нь хөдөлмөрийн хуваарьт жендэрийн хэвшмэл ойлголтыг бэхжүүлдэг байна. Гэр бүлийн өдөр тутмын хэрэглээний талаар шийдвэр гаргахад эрэгтэйчүүд бага оролцдог нь тэдгээрт гэр бүлийн гишүүд болон хүүхдүүдийн ялгаатай хэрэгцээг ойлгох, эмэгтэйчүүдийн гэр

бүлийн ажил үүрэг гүйцэтгэж байгааг хүлээн зөвшөөрөхөд бэрхшээл бий болгодог байна. Ийнхүү хангалттай ойлголтгүй байдаг нь шударга шийдвэр гаргах талаар зөвшилцөх, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ажил-амьдралын тэнцвэрт байдлыг хангахад саад учруулж болзошгүй юм. Гэсэн хэдий ч өрхийн томоохон зардлуудтай холбоотой шийдвэрүүдийг ихэвчлэн эхнэр, нөхрүүд хамт гаргадаг болох нь судалгаанаас харагдаж байна.

6.4.7 Бичил уурхай дахь жендэрийн динамик

Судалгаанд оролцогчид жендэрийн динамикийг голчлон төвийг сахисан байдлаар тодорхойлсон. Олборлолтын талбайд ажил хөдөлмөрийн жендэрийн хуваарь байдаг боловч ихэнх БУ-н байгууллагуудад ашиг хуваарилах, шийдвэр гаргахад жендэрийн тэгш байдлыг хангадаг байна. Жендэрийн зураглал нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүүтэйгээр чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны ашиг тусыг хүртэж чаддаг бөгөөд олж авсан боловсрол, мэдлэг, ур чадвараа захиргааны ажил үүргийг гүйцэтгэхэд ашиглаж шийдвэр гаргах түвшинд түлхүү оролцдог болохыг харуулсан. Шийдвэр гаргахад оролцох, манлайлах боломж нь жендэрээс илүү ур чадвараар тодорхойлогддог нь ажиглагдсан. Эмэгтэй бичил уурхайчдын мэдлэг, ур чадвар, өөрийн чадавхийг бэхжүүлэх идэвх сонирхол нь тэднийг тухайн салбар дахь байгаль орчноо хамгаалах, ХАБЭА, жендэрийн тэгш байдлыг хангах зэрэг бичил уурхайг албажуулах, уул уурхайн илүү сайн туршлагыг төлөвшүүлэх, өөрчлөлт гаргах агент (идэвхжүүлэгч) болгохын тулд эрх мэдэлжүүлэх сайхан боломжийг бий болгож байна.

Гэсэн хэдий ч бүх эмэгтэйчүүд эдгээр албан тушаалд ижил тэгш хамрагдах боломжгүй бөгөөд олон эмэгтэйчүүд зөвхөн туслах ажил үйлчилгээг гүйцэтгэдэг. Бичил уурхайн байгууллага дахь ямар хүчин зүйлүүд эмэгтэйчүүдийн дунд ялгаатай байдлыг бий болгож байгааг ойлгохын тулд нэмж судалгаа хийх шаардлагатай болно. Түүврийн хэмжээ хэтэрхий бага байгаа нь энэхүү эмзэг сэдвээр цуглуулсан мэдээлэлд дүнэлт хийхэд хангалтгүй байгаа бөгөөд тухайлбал, салбарын хэмжээнд боловсролын түвшин эсвэл байгууллагын статусын аль нь жендэрт суурилсан хүчирхийллийг бий болгож байгааг тодорхойлох боломжгүй юм.

Эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээл нь алтны бичил уурхайн салбар дахь нөхцөл байдлын хүчин зүйлүүдтэй бараг холбоогүй мэт боловч соёлын хүчин зүйлүүдээс шалтгаалж эмэгтэйчүүдийн ажлын ачаалал давхар нэмэгдэж, гэр бүлийн жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх нь нэмэгддэг байна. Үүний гол шалтгаан нь архины хэрэглээ, ядуурал гэж тодорхойлсон байна.

Алтны бичил уурхай дахь уян хатан ажлын цаг, тэгш цалин хөлс, манлайллын байр сууриа бэхжүүлэх боломж зэргээс шалтгаалан тухайн салбар нь эмэгтэйчүүдийн хувьд амьжиргаагаа залгуулах боломжит хувилбар болдог байна (Азийн сан 2013 он). Түүнчлэн бичил уурхайн албажуулах явц нь албан бус секторт байдаг зарим эрсдлийг бууруулснаар эмэгтэй бичил уурхайчдын нөхцөл байдлыг сайжруулж чадна.

7. Алтны худалдаа ба нийлүүлэлтийн сүлжээ

Алтны худалдааны бодлого зохицуулалт нь Монгол Улсын алтны бичил уурхайн албажуулалтад онцгой байр суурь эзлэх боломжтой. Зөв зохистой ажиллаж байгаа алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээ нь нөөц, хөрөнгө, стандарт болон хууль эрх зүйн зохицуулалтын талаарх мэдлэг мэдээллийг бичил уурхайн оролцогч талуудад үр дүнтэйгээр түгээж, уурхайн практик үйл ажиллагааны (4-р бүлэг) чанар дээшилж, хуульд нийцсэн үйл ажиллагаа (3-р бүлэг) төлөвшинө. Нөхцөл байдлын судалгааны асуулга нь алтны худалдаа, алтны нийлүүлэлтийн сүлжээ, бичил уурхайчдын санхүү болон хөрөнгө оруулалтын хүртээмжийн талаар олон асуултуудыг агуулсан. Энэ бүлгийн гол зорилго нь тус асуулгын үр дүнг дүгнэхэд оршино. Алтны худалдааны бодлого болон практик үйл ажиллагааны талаарх дүгнэлт зөвлөмжийг төслөөс гаргах хууль эрх зүйн орчны талаарх судалгаанаас үзэх боломжтой. Тус судалгаа нь Монголын алтны бичил уурхайн бодлого, хууль эрх зүйн зохицуулалтын талаарх илүү өргөн хүрээний судалгаа юм. Монгол Улсын алтныхудалдааны бодлого, хууль эрх зүйн актуудын тухай товч мэдээллийг суурь болгон энэ хэсэгт дурдлаа.

7.1 Алтны худалдааны хууль эрх зүйн орчин


Монгол Улс алтны худалдааны бодлого хэрэгжүүлдэг ба алтны нийт албан худалдааг Монгол Улсын Засгийн газар зохицуулдаг. Энэ нь дотоодын алтны бүхий л албан худалдаа нь алтны худалдааны хууль дүрэм журамтай нийцэж, албан сүлжээнд борлуулагдах үүрэгтэй гэсэн үг юм. Бичил уурхайчид олборлосон алтаа тусгай зөвшөөрөл бүхий алтны худалдаачинд эсвэл Монголбанканд, эсвэл нэг цэгийн үйлчилгээний газруудаар дамжуулан худалдаалах үүрэгтэй.

Монголбанканд алтаа борлуулахын тулд алтны сорьцоо албан ёсны сорьцын байгууллагаар баталгаажуулсан байх ёстой. Саяхныг хүртэл албан ёсны сорьцыг зөвхөн Үнэт металлын сорьцын хяналтын газар (ҮМСХГ)-аар тогтоолгодог байсан. 2020 оны 01 дүгээр сард Монголбанк Эрдэнэсийн сангийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан бөгөөд энэхүү нэмэлт өөрчлөлтийн дагуу зөвхөн ҮМСХГ-ын сорьцыг хүлээж авахаас гадна, бусад хувийн лабораторийн тогтоосон сорьцыг хүлээн зөвшөөрөх бөгөөд Монголбанк мөн сорьц тогтоох үйлчилгээ үзүүлэх боломжтой болно (Монгол Улсын Засгийн газар, 2020 он). Эдгээр нэмэлт өөрчлөлтүүд батлагдвал алтны худалдааны төвлөрлийг сааруулахад томоохон алхам болох юм.

Ихэнх бичил уурхайчид албан, төвлөрсөн зах зээлд алтаа борлуулах цаг хугацаа болон нөөц бололцоо дутмаг учир ихэнх нь сумын болон аймгийн түвшний алтны худалдаачидтай хамтран ажилладаг. Тэдгээр худалдаачид нь бичил уурхайчдын олборлосон болон баяжуулах цехүүдийн боловсруулсан жижиг хэмжээтэй алтыг худалдан авч, илүү том хэмжээтэй алт болгон хайлуулснаар, Улаанбаатар руу тээвэрлэн, арилжааны банкуудаар дамжуулан Монголбанканд, эсвэл нийслэлийн томоохон худалдаачдад (ихэнх нь Урт цагааны гудамжинд

байрладаг), уран дархчуудад, эсвэл хууль бусаар хил дамнуулан борлуулагч зэрэгт алтаа борлуулдаг (Зураг 7-1) (НУБАҮХБ, 2017 он).

2018 онд алт сорьцлох, худалдаалах нэг цэгийн үйлчилгээний төвүүд (НЦҮТ)-ийг²² Дархан-Уул болон Баянхонгор аймгуудад, Монголбанк, ҮМСХГ болон ШХА-ын хамтын санхүүжилтээр үүсгэн байгуулсан нь алтны худалдааны төвлөрлийг сааруулж, албажуулах анхны чухал алхамуудын нэг болсон юм. Гэсэн хэдий ч төслийн судалгаанаас үзвэл тус НЦҮТ-ийн үйл ажиллагаа болон шаардлагуудыг сайжруулж, өөрчлөх хэрэгцээ байгаа.



Зураг 7-1. Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээний зураглал (planetGOLD, 2021 он)

2020 он болтол алтны худалдаачдыг зохицуулж эсвэл итгэмжлэл олгох чиглэлээр ямар нэгэн дорвитой үйл ажиллагаа хэрэгжээгүй. Санхүүгийн зарим нэг асуудлаар үр дүнгүй арга хэмжээ авч, тэр дундаа дотоодод болон хил дамнуулан борлуулж буй үнэт метал, үнэт чулуу, үнэт эдлэлийн гарал үүслийг мөшгөх, олж илрүүлэх, хууль бус худалдааг зогсоох чиглэлээр хангалтгүй бодлого хэрэгжүүлж байгаа шалтгаанаар Монгол Улс 2019 оны 10 дугаар сард

²² Монголд НЦҮТ анх 2007 үүсгэн байгуулагдсан бөгөөд 2013 оноос улс орон даяар хэрэгжиж эхэлсэн. Тус газрууд нь банкны үйлчилгээ зэрэг төрөл бүрийн үйлчилгээг аймаг, сумын түвшинд хүргэдэг (ОУХБ, 2016)

Олон Улсын Санхүүгийн Гэмт Хэрэгтэй Тэмцэх Байгууллага (ФАТФ-ОУСГХТБ)-ын “Саарал жагсаалт”-д орсон билээ. Тус “жагсаалт”-аас гарахын тулд Засгийн газар алтны худалдааг зохицуулах чиглэлээр хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулснаар, СЗХ нь алтны худалдаачдад тусгай зөвшөөрөл олгож, Мөнгө угаах, терроризмтай тэмцэх тухай хуулийн дагуу тэдгээрийн үйл ажиллагааг хянан зохицуулах үүрэгтэй болсон. Ингээд СЗХ нь 2020 оны 3 дугаар сард 150 дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ыг батаснаар алтны худалдаачид хууль ёсны дагуу үйл ажиллагаа эрхлэх суурь нь тавигдсан юм (СЗХ, 2020 он). 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 30 аж ахуйн нэгж, 399 иргэд тусгай зөвшөөрөл (СЗХ, 2020 он) аваад байна. Үүний үр дүнд орон нутгийн алтны худалдаачид албажиж, алтны худалдаа ил тод болж, орон нутгийн алтны худалдааны бүртгэл мэдээлэл сайжрах боломжтой. Тусгай зөвшөөрөлгүй алтаа борлуулсан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээх юм. Алтны худалдаачдаас авсан ганцаарчилсан ярилцлагаас үзвэл, бага хэмжээний алтны худалдаа эрхлэгчид СЗХ-ны шинэ журмын талаар мэдлэг мэдээлэлгүй байна. Энэ нь тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа хэрэгжиж эхэлж байсантай холбоотой байх магадлалтай.

7.2 Судалгааны бүс нутаг дахь алтны худалдаа

Бичил уурхайн алтны худалдаа болон нийлүүлэлтийн сүлжээний тоон мэдээлэлд дараах үндсэн чиглэлээр дүн шинжилгээ хийсэн:

1. Бичил уурхайчид алтаа хэрхэн боловсруулж, зарж борлуулдаг, мөн алтны борлуулалтын дундаж хэмжээ болон давтамж.
2. Орон нутагт алтаа борлуулах боломж болон сонголтууд: хэнд, албан болон албан бус эсэх, орон нутгийн зах зээл хэр өрсөлдөөнтэй вэ, эрх мэдлийн хуваарилалт гэх мэт.
3. Монгол Улсын өнөөгийн алтны худалдааны хөтөлбөр нь бичил уурхайн алтны албан худалдааг дэмжиж, зохистой нөхцөлийг бүрдүүлж чадаж байгаа эсэх.

Ингэснээр Монголын бичил уурхайчид алтаа хэрхэн, хэнд борлуулах шийдвэрээ гаргахад нөлөөлдөг үндсэн нөхцөлүүдэд цэгцтэй үнэлгээ хийхэд үр нөлөө үзүүлэх юм. Түүнчлэн эдгээр тоон мэдээллийн тусламжтай өнөөгийн зах зээлийн нөхцөл байдал нь албан эсвэл албан бус сувгаар алтаа борлуулахад хөшүүрэг болж байгаа эсэхэд дүгнэлт өгч, алтны худалдааны өнөөгийн хууль дүрэм журмыг сайжруулах хэрэгцээг тодорхойлох юм.

7.2.1 Алтны дундаж олборлолт болон худалдааны хэмжээ

Асуулгад оролцсон нийт 371 оролцогчид дунджаар долоо хоногт 52 грамм алт олборлодог хэмээн мэдээлжээ. Сард нийт 4 долоо хоног ажилладаг хэмээн үзвэл нийт нэг сард 208 грамм орчим алтыг олборлодог байна.

Үүнтэй харьцуулбал, долоо хоногт/сард/улиралд/жилд дунджаар хэдий хэмжээний алт борлуулдаг вэ хэмээх асуултад долоо хоногт 28 грамм, сард 98 грамм, жилдээ 229 грамм хэмээн хариулжээ. Долоо хоногт олборлодог алтны хэмжээ болох 52 грамм болон долоо хоногт борлуулдаг алтны хэмжээ болох 28 граммтай харьцуулбал зөрүү их байна. Энэ нь алтны худалдааны тоон мэдээллийн үнэн зөв байдлын талаар нэгэн зүйл илтгэнэ. Нөгөөтгээгүүр, алтны олборлолт/үйлдвэрлэл нь олон хүчин зүйлээс хамааралтай тул долоо хоногт дунджаар олборлож байгаа алтны хэмжээг тодорхойлоход арга зүйн хувьд хязгаарлалт их байдаг.

Хүснэгт 7.2-1. Алтны дундаж худалдаа, долоо хоногт, сард, жилд (судалгааны бүс нутгаар болон нийт)

	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=71)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Нийт (n=371)
Долоо хоногт	32 гр	26 гр	34 гр	20 гр	28 гр	28 гр
Сард	90 гр	98 гр	88 гр	57 гр	116 гр	92 гр
Жилд	220 гр	259 гр	221 гр	146 гр	265 гр	229 гр

Бичил уурхайн нөхөрлөл нь дунджаар 12 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 9 нь идэвхтэй бөгөөд судалгааны дүнгээс үзэхэд бичил уурхайгаас олж буй сарын дундаж орлого нь 980,163 төгрөг байна (Алтны бичил уурхайн орлогын талаар 2.3 болон 6.1 хэсгүүдийг харна уу). Бичил уурхайчны сарын орлогыг үндэслэн сард олборлодог алтны хэмжээг тооцоолон үзвэл 9 гишүүнтэй нөхөрлөл нь сард 242 грамм орчим алт олборлох шаардлагатай болно²³. Энэ нь бичил уурхайчдын судалгаанд хариулсан хариултын дүн болох сард олборлодог 208 грамм болон долоо хоногт борлуулдаг 92 грамм гэсэн мэдээлэлтэй харьцуулахад их ялгаатай байна. Үүнд үйл ажиллагааны зардалд зарцуулагдах алтны орлогыг тооцоолоогүй болно. Урьдчилан таамаглаж байсанчлан бичил уурхайчид олборлолт болон борлуулалтын худалдаагаа багасгаж мэдээлсэн нь илт байгаа бөгөөд ийм төрлийн хувийн орлоготой холбоотой нарийн мэдээлэл асуусан судалгааны хувьд хэвийн бөгөөд ойлгож болохуйц зүйл юм.



Зураг 7-2. Орон нутаг дахь алтны худалдаа (planetGOLD)

Алтны олборлолт болон худалдааны бодит хэмжээ нь бодит нөхцөл байдлаас ялгаатай байна гэдгийг онцлох нь зүйтэй. Энэ бол хувь хүний орлоготой холбоотой нууц мэдээлэл бөгөөд судалгаанд оролцогчдын хувьд энэ мэдээллийг худал мэдээлэх олон шалтгаан бий. Жишээлбэл, Есөнбулаг сумын нөхөрлөлийн ахлагчийн мэдээлснээр нэг удаа боловсруулалт хийхдээ тэд 1,500 грамм алтыг олборлодог гэж мэдээлсэн боловч асуултад 7 хоногт 20 грамм алт боловсруулж, долоо хоногт 15 грамм алтыг борлуулдаг гэж хариулсан байна. Бичил уурхайчдын тоо, хүдэртэй шуудайн тоо, боловсруулалтын хэмжээ, алтны сорьц,

²³ Ам.доллар-төгрөгийн ханш: 2,856.81= ойролцоогоор сард 343 ам.доллар. Алтны дундаж үнэ 60 грам/ам.доллар, бичил уурхайчин зах зээлийн үнэлгээний 85%-аар алтаа борлуулдаг гэж үзвэл: 60*85%=51 ам.доллар/грамм. 343 ам.долларын сарын орлого ойролцоогоор 6.73 грам байна.


хүдрийн чанартай холбоотой бусад мэдээлэл, алтны үйлдвэрлэл гэх мэт мэдээллийг харьцуулан судалснаар алтны олборлолтын бодит мэдээллийг олж мэдэн, “Долоо хоногт хичнээн хэмжээний алт боловсруулдаг вэ?” болон “Долоо хоногт хичнээн хэмжээний алт борлуулдаг вэ?” хэмээх асуултын хариултуудыг баталгаажуулах боломжтой юм. Гэсэн хэдий ч судалгааны хариултууд тодорхой хязгаарлалттай бөгөөд зарим хариулт дутуу учир судалгааны хүрээнд уг тооцооллыг хийгээгүй болно.

Судалгааны онцлох өгөгдөл (бүс нутгаар)

Доорх хүснэгт нь судалгааны таван бүс нутаг дахь алтны худалдааны тоон үзүүлэлтүүдийн хураангуй юм.

Хүснэгт 7.2-2. Алтны худалдааны судалгааны хураангуй хүснэгт

	Нийт судалгаанд оролцогчид					Худалдаа эрхлэх туршлагатай нөхөрлөлийн ахлагч нар				
	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=71)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=71)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)
Борлуулсан алтныхаа бүртгэлийг хийдэг үү?	19%	27%	35%	21%	14%	100%	45%	80%	75%	14%
Танай нөхөрлөл 7 хоногт дунджаар хэдэн грамм алт олборлодог вэ? (граммаар)	51	39	53	44	37	241	32	53	95	46
7 хоногт дунджаар хэдий хэмжээний алт борлуулдаг вэ? (граммаар)	32	26	34	20	28	154	28	53	29	40
Хүдрээ хэр давамжтай боловсруулдаг вэ? (дунджаар)	4	4	3	3	6	3	4	3	6	6
Усан жингийн аргаар сорьцолдог	29%	23%	90%	77%	8%	33%	55%	100%	75%	29%
Сорьцолдоггүй, худалдаачиндаа итгэдэг	38%	38%	7%	16%	53%	0%	18%	0%	0%	71%
Алтны үнээ хаанаас мэддэг вэ? Зөвхөн алтны худалдаачнаас	46%	34%	17%	63%	74%	0%	20%	60%	25%	43%
Алтны үнээ хаанаас мэддэг вэ? Монголбанк	13%	13%	6%	5%	9%	33%	27%	40%	13%	14%



Зураг 7-3. Алтны үнийн мэдээллийн эх үүсвэр (судалгааны бүс нутгаар, олон хариулттай, нийт=488)

Түнхэл

Түнхэл тосгоны хувьд баяжуулах цех нь голлох байр суурь эзэлдэг бөгөөд асуулгад оролцсон 5 нөхөрлөлийн ахлагч нар бүгд алтаа цехэд борлуулдаг бөгөөд өөр сонголт байдаггүй хэмээн хариулсан байна. Тэд хүдрээ сард дунджаар 3 удаа боловсруулдаг бөгөөд долоо хоногт 53 грамм орчим алтыг олборлож, худалдаалдаг (Хүснэгт 7.2-2). Хүдэр боловсруулах цехээс алтны худалдаа хамааралтай байснаар бичил уурхайчид алтны үнийг тохирох боломжгүйд хүрч, тэдний хувьд ашиггүй зүйл болж байна. Судалгаанд оролцогчдоос хэн нь ч Монголбанканд алтаа борлуулдаг хэмээн хариулаагүй. Бичил уурхайчид алтаа зөвхөн баяжуулах цехэд борлуулдаг учир 68% (бусад бүс нутагтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт) нь алтны үнийн сүүлийн үеийн мэдээллийг баяжуулах цехээс авдаг хэмээн хариулжээ (Зураг 7-3).

Түнхэл тосгоны бичил уурхайчдын алтыг албан нийлүүлэлтийн сүлжээнд оруулах болбол энэ нь баяжуулах цехүүдээс ихээхэн хамаарах юм. Монгол Улсын Засгийн Газар баяжуулах цехүүдэд анхаарлаа хандуулж, тэднийг Монголбанканд алтаа борлуулахад нь түлхэц болж, урамшуулах нь зүйтэй (9 дүгээр бүлэг).

Алтай сум

7 нөхөрлөлийн ахлагчаас ярилцлага авахад тэд долоо хоногт дунджаар 46 грамм алт олборлож, 40 граммыг борлуулдаг бөгөөд хүдрээ сард 6 удаа боловсруулдаг хэмээн хариулжээ. Алтай суманд ямар нэгэн албан ёсны, бүрэн баригдсан баяжуулах цех байхгүй. Хүдэр бутлах болон нунтаглах цөөхөн цэгүүд бий. Баяжуулах цех байхгүй учир сумын алтны худалдаачид нь алтны худалдааны голлох оролцогчид болдог бөгөөд бичил уурхайчдын хувьд алтаа борлуулах цорын ганц сонголт юм. 7 ахлагчийн 6 нь зөвхөн худалдаачдад алтаа зардаг хэмээн хариулжээ. Ахлагч нарын нэг нь алтны худалдаачин бөгөөд алтаа Улаанбаатар хот руу тээвэрлэн, тэндээ Урт Цагаанд байрлах албан бус худалдаачинд борлуулдаг. Хэдийгээр энэ худалдаачин Монголбанк алт худалдан авдаг тухай мэдээлэлтэй боловч албан бус худалдаачдад алтаа илүү өндөр үнээр борлуулж чаддаг гэж хариулсан.

Тухайн бүс нутгийн бичил уурхайчид алтаа борлуулахын өмнө алтны сорьцоо тодорхойлдоггүй бөгөөд энэ нь тэдний хувьд ашиггүй ч худалдаачид өөрт ашигтай наймааг хийх нөхцөлийг бүрдүүлж байна. Алтай суманд ярилцлагад орсон нийт бичил уурхайчдын 8% нь л усан жингийн аргачлалыг ашигладаг бөгөөд 53% нь алтаа урьдчилан сорьцлолгүйгээр алтны худалдаачинд итгэж, түүхэн дундаж сорьцын дүнг ашигладаг. Нөхөрлөлийн ахлагч нарын 43% нь бичил уурхайчдын 61% нь алтны үнийг гадны эх үүсвэрээс нягталдаггүй бөгөөд, бичил уурхайчдын 74% нь худалдаачны хэлсэн үнэнд итгэдэг байна. Бичил уурхайчид алтны сорьц, зах зээлийн үнийн талаар мэдлэг мэдээлэлгүй учир худалдаачид зах зээлийн үнэлгээнээс доогуур үнэ санал болгох эрсдэлтэй.

Мандал сум

Долоо хоногийн алтны дундаж үйлдвэрлэл 32 грамм бөгөөд долоо хоногт 28 грамм орчим алтыг борлуулдаг ба хүдрээ долоо хоногт 4 удаа боловсруулдаг.

Нөхөрлөлийн ахлагч нарын 18% нь худалдаачдын сорьцын дүнд итгэж, 20% нь алтны худалдаачдын хэлсэн үнэд итгэдэг хэмээн хариулсан нь тус бүс нутгийн бичил уурхайчид алтаа борлуулах үйл ажиллагаанд илүү туршлагатайг илтгэж байна. Нөхөрлөлийн ахлагч нарын 27% нь Монголбанкны алтны үнийг хардаг боловч алтаа Монголбанканд зардаггүй бөгөөд 60% нь Монголбанк дэндүү хол байдаг хэмээн хариулжээ.

Бусад бүсүүдтэй харьцуулахад Мандалд алтаа борлуулах сонголт их байсан бөгөөд зөвхөн нэг худалдаачинд найдах сонголт хамгийн бага байсан ба 55% нь зөвхөн нэг худалдаачинд алтаа борлуулдаг хэмээжээ. Баяжуулах цехүүд алтны худалдаанд арай бага байр суурь эзэлдэг ч бичил уурхайчдын 36% нь тэднийг алтаа борлуулах гол хамтрагчаа хэмээн нэрлэсэн. Алтны үнийн мэдээлэл авах эх үүсвэрийн хувьд Мандал сумын бичил уурхайчид худалдаачнаас (36%), цахим ертөнцөөс (20%), баяжуулах цехээс (20%) болон бусад бичил уурхайчдаас (21%) гэсэн олон эх үүсвэрээс алтны үнийн мэдээлэл авдаг гэжээ.

Есөнбулаг сум

Алтны үйлдвэрлэлийн долоо хоногийн дундаж хэмжээ 92 грамм, долоо хоногт борлуулдаг алтны дундаж хэмжээ 29 грамм бөгөөд хүдрээ сард дунджаар 6 удаа боловсруулдаг.

Алтны борлуулалтын сонголт хязгаарлагдмал бөгөөд нөхөрлөлийн ахлагч нарын 63% нь нэг худалдаачинд, 50% нь баяжуулах цех, 38% нь аймгийн худалдаачинд алтаа борлуулдаг хэмээн хариулжээ (Хүснэгт 7.2-3). Төслийн талбарын судалгаагаар Есөнбулаг суман дахь баяжуулах цехүүдийн нэг нь худалдааны үйл ажиллагаа эрхэлж байсан. Судалгаанд оролцогчид худалдаачныхаа нэрийг тодорхой дурдаагүй учир, баяжуулах цех болон алтны худалдаачин нь нэг хүн байх магадлалтай бөгөөд иймээс бичил уурхайчид алтаа зөвхөн баяжуулах цехэд борлуулдаг байж болзошгүй. Зах зээлийн сонголт хязгаарлагдмал байх нь бичил уурхайчдын үнэ тохирох эрх мэдлийг бууруулдаг бөгөөд хамаарлын эрсдэлийг үүсгэнэ. Ярилцлагын үеэр Есөнбулаг сумын баяжуулах цехийн эзэн бичил уурхайчдын үйл ажиллагаа болон алтны худалдааг албажуулахад хувь нэмэр оруулах хүсэлтэйгээ илэрхийлсэн.

Алтны үнийн хувьд алтны зах зээлийн талаарх мэдлэгээс илүү Есөнбулаг сумын байрлал болон хол зай нь асуудал үүсгэдэг байна. Тус сумын 5 нөхөрлөлийн ахлагч нарын мэдээлснээр аймгийн худалдаачин, сумын худалдаачин, Улаанбаатар хот дахь худалдаачин, Урт Цагааны худалдаачид, Монголбанк, уран дархчууд гэх мэт алтаа борлуулах олон сонголт бий. Тус 5 ахлагчийн 2 нь өмнө нь Монголбанканд алтаа борлуулж үзсэн хэмээсэн бол нэг нь ихэнхдээ Монголбанканд алтаа борлуулдаг гэж хариулжээ.

Бусад бүсүүдтэй харьцуулбал бичил уурхайчид алтаа борлуулахын өмнө сорьцлох дадал суусан бөгөөд энэ нь зөв зүйл юм. Нийт бичил уурхайчдын 77% нь усан жингийн аргыг ашигладаг. Нийт оролцогчдын 16% алтаа борлуулахын өмнө алтны сорьцоо шалгадаггүй. Нөгөөтээгүүр, нийт судалгаанд оролцогчдын 63%, ахлагч нарын 25% алтны үнээ гадны эх үүсвэрээс хардаггүй бөгөөд худалдаачны санал болгосон үнэд итгэдэг. Алтаа борлуулахын өмнө ухаалаг утсаараа хялбар хайлт хийхэд л худалдаачинтай үнэ тохирон хэлэлцэх

боломжийг бүрдүүлнэ. Зөвхөн 5% нь л Монголбанкны эх үүсвэрээс алтны үнээ хардаг гэжээ.

Баянгол сум

Долоо хоногийн дундаж үйлдвэрлэл 241 грамм, борлуулалтын дундаж хэмжээ нь 154 грамм бөгөөд бичил уурхайчид хүдрээ сард 3-4 удаа боловсруулдаг. Бусад бүс нутагтай харьцуулахад энэ нь нөхөрлөлийн ахлагч нарын мэдээлсэн хамгийн өндөр алтны хэмжээ юм.

Нийт асуулгад оролцогчдын 38% нь алтны худалдаачны сорьцын дүнд итгэдэг бол 46% нь худалдаачны хэлсэн алтны үнийг хүлээн зөвшөөрдөг, 21% нь цахим хуудаснаас алтны үнээ харж, 23% бусад бичил уурхайчдаас асуудаг боловч нөхөрлөлийн ахлагч нарын хэн нь ч худалдаачны үнэ эсвэл сорьцын үр дүнд итгэдэггүй хэмээн хариулжээ. Нийт ахлагч нарын 33% нь Монголбанкны үнийг хардаг. Бусад бүс нутгуудтай харьцуулбал Баянгол сумын ахлагч нар бүгд алтны борлуулалтын бүртгэлээ хийдэг гэж хариулжээ. Үүний нэг шалтгаан нь өмнөх бүлгүүдэд дурдсанчлан Баянгол нь бичил уурхайн үйл ажиллагаа анх эхэлсэн бүс нутгуудын нэг бөгөөд энэ сумын бичил уурхайчид илүү туршлагатай гэж үздэг. Бүс нутагт баяжуулах цех байхгүй, зөвхөн дан тээрэм болон бутлагч төхөөрөмжүүд байдаг учир бичил уурхайчид алтаа зөвхөн хоёр газар борлуулдаг бөгөөд нэг нь тухайн орон нутгийн байнгын худалдан авагч эсвэл аймгийн худалдаачин.

7.2.2 Албан ёсоор алт худалдаалахад тулгардаг саад бэрхшээл

Монголбанкны алтны зарласан үнээс цэвэршүүлэх зардал, сорьцын зардал болон татварын дүнг хассан ч дэлхийн бусад бичил уурхай бүхий орнуудын зах зээлийн үнэтэй харьцуулбал өндөр, боломжийн үнэ юм. Монголбанкны үнийг бичил уурхайчдад илүү хүртээмжтэй болгосноор тэдэнд алтны үнээ хэлэлцэж тохирох эрх мэдлийг өгч, орон нутагт алт борлуулах өрсөлдөөнт зах зээлийг бий болгох юм. Харамсалтай нь одоогоор нөхцөл байдал өөр байна. Дундын худалдаачид бичил уурхайчдад санал болгох үнээ өөрчлөх боломжтой байгаа нь бичил уурхайчид Монголбанкны ханшаар алтаа борлуулж чаддаггүйг илтгэнэ. Алтны тээвэр болон нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн төлбөр өндөр учир Монголбанкны үнээр алтаа борлуулах боломж ч хомс юм.

Хүснэгт 7.2-3. Алтаа худалдаалах сонголт (нөхөрлөлийн ахлагч нарын хариулснаар)

Алтаа худалдаалах сонголт	Баянгол (n=5)	Мандал (n=11)	Түнхэл (n=5)	Есөнбулаг (n=8)	Алтай (n=7)
Зөвхөн нэг худалдан авагчид борлуулдаг	60%	55%	100%	63%	86%
Ихэнхдээ баяжуулах цехэд борлуулдаг	0%	36%	100%	50%	0%
Ихэнхдээ аймгийн худалдаачинд борлуулдаг	40%	55%	0%	38%	86%

Өнөөгийн хууль эрх зүйн нөхцөл байдалд Монголбанк нь алтны нийлүүлэлтийн магадлан шинжилгээг хангалтгүй хийдэг бөгөөд худалдсан алтны уурхайн гарал үүслийг мөшгөх тогтолцоог шаарддаггүй. Энэ нь олон шалтгааны улмаас асуудал дагуулдаг ба үүнийг “Монголын алтны бичил уурхайн хууль эрх зүй болон хууль бус санхүүгийн урсгалын судалгаа”-ны тайлангаас илүү дэлгэрэнгүй үзэх боломжтой. Магадлан шинжилгээ болон гарал үүслийг мөшгөх тогтолцоо нь Монгол Улсын алтны худалдааны бодлого, практик үйл

ажиллагаанд оруулах шаардлагатай томоохон өөрчлөлтүүдийн нэг бөгөөд чухал харгалзах асуудал юм. Бичиг баримтын мөшгөлт болон магадлан шинжилгээний үйл явцын дутмаг байдал нь бичил уурхайн алтны борлуулалтын талаарх статистик мэдээллийн дутмаг, хангалтгүй байдалд мөн нөлөөлж байна. Алтны нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талууд болох баяжуулах цех, сум болон аймгийн худалдаачид нь өөрсдийн бүс нутгаас олборлогдож буй алт нь албан эсвэл албан бус сүлжээнд худалдаалагддаг эсэхэд хариулах боломжгүй тул тухайн алтны гарал үүсэл болон борлуулалтын эцсийн цэгийг олж тогтооход хүндрэлтэй юм.

7.2.3 Монголбанканд алтаа худалдаалахад тулгардаг саад бэрхшээл

Нийт судалгаанд оролцогч 371 бичил уурхайчдын зөвхөн 12 нь л алтаа Монголбанканд борлуулах боломжтой гэж хариулсан (Хүснэгт 7.2-4).

Хүснэгт 7.2-4. Монголбанканд алтаа худалдаалж байсан туршлага (хүйсээр)

		Хүйс		Нийт (n=371)
		Эрэгтэй (n=100)	Эрэгтэй (n=271)	
Монголбанканд алтаа борлуулж байсан эсэх	Дандаа	3%	1%	2%
	Ихэнхдээ	-	1%	1%
	Заримдаа	2%	4%	3%
	Хэзээ ч үгүй	95%	94%	94%
	Нийт	100%	100%	100%

Бичил уурхайчид алтаа Монголбанканд борлуулахад олон саад бэрхшээлтэй тулгардаг учир багахан хувь нь алтаа төв банкандаа тушаадаг нь илт байлаа. (Зураг 7-4).



Зураг 7-4. Монголбанканд алтаа борлуулахгүй байх шалтгаан (n=371, олон хариулттай, нийт = 443)

Монголбанкны газарзүйн байршил нь албан худалдаанд саад бэрхшээл болж буй гол шалтгаануудын нэг юм (нийт судалгаанд оролцогчдын 42%). Түүнчлэн албан худалдаа нь Улаанбаатар, Дархан, Баянхонгорт төвлөрсөн учир Монголбанканд алтаа борлуулах үйл ажиллагаанд цаг их зарцуулагддаг. Туулах зам урт мөн дэд бүтцийн хөгжил, замын холбоо муу учир бичил уурхайчид

олборлосон алтаа төв банканд борлуулахын тулд олон зуун километрийг хэдэн цаг эсвэл өдрөөр туулж, зорьсон газраа хүрэх шаардлагатай болно.

Дархан-Уул болон Баянхонгор нэг цэгийн үйлчилгээний газар байгуулсан нь алтны албан сүлжээг тэлж, алт олборлолтын үндсэн цэгүүд рүү хүрч ажиллах анхны алхам болсон. Энэ нь мөн алтны хууль бус худалдааг сааруулах боломжийг бүрдүүлж байна. Гэсэн хэдий ч алтны бичил уурхай бүхий өөр олон бус нутаг байгаа учир эдгээр НЦҮТ-ийн тоо хангалттай биш бөгөөд алтны худалдаанд орон нутгийн худалдаачид зонхилох байр суурь эзэлсээр байна.

planetGOLD Монгол төслийн боловсруулсан хууль эрх зүйн орчны талаарх судалгааны хүрээнд (planetGOLD Монгол, 2021), орон нутагт ажиллаж буй хоёр НЦҮТ-ийн үйл ажиллагааны үр дүнтэй байдал болон бичил уурхайчид тэдгээр НЦҮТ-үүдээр үйлчлүүлж, алтаа сорьцлуулан, борлуулдаг эсэхэд үнэлгээ хийсэн. Судалгааны үр дүнд алтны сорьц тогтооход шаардагддаг 50 граммын босго хэмжээ нь өдөр тутмын орлогоосоо хамааралтай бичил уурхайчдын хувьд томоохон асуудал үүсгэдэг нь илэрсэн. Түүнчлэн НЦҮТ-өөр ихэнхдээ алтны худалдаачид үйлчлүүлдэг тул бичил уурхайчид нь НЦҮТ-т алтны худалдаа хэрхэн явагддаг талаар мэдээлэл муутай байжээ. Дээрх дүгнэлт нь энэхүү нөхцөл байдлын судалгаагаар баталгаажсан бөгөөд асуулгад оролцогчдын 27% нь Монголбанкны шаардлагад нийцдэггүй буюу 50 граммтай тэнцэх эсвэл түүнээс бага хэмжээний алтыг борлуулах боломжгүй байдаг хэмээн хариулжээ.

Түүнчлэн судалгаанд оролцогчид захиргааны саад бэрхшээлээс үүдэн Монголбанканд үйлчлүүлдэггүй бөгөөд бусад нь үйл явцыг ойлгодоггүй (11%), дэндүү их бичиг баримт бөглүүлдэг (7%), банк дэндүү их мэдээлэл асуудал (3%), эсвэл төлбөрөө шилжүүлэхэд дэндүү уддаг (3%) хэмээн хариулжээ. Албан ёсоор алтаа борлуулах нь үргэлж албан бус борлуулалтаас илүү хүнд суртал өндөртэй байдаг. Энэ асуудлыг шийдэх гол гаргалгаа нь албан худалдаа эрхлэхэд ямар нэгэн урамшуулал байх ёстой бөгөөд нөгөөтээгүүр албан бусаар алтаа борлуулахад саад бэрхшээл, сул тал ихтэй байх нь чухал. Жишээлбэл, хууль бус алтны худалдааг хатуу хориглох. Судалгаанд оролцогчдын 6% хүдэр боловсруулсан тээрэм эсвэл баяжуулах цехийнхээ эзэнд алтаа борлуулдаг гэж хариулсан бөгөөд зарим нь алтаа өөр газар зарах эрхгүй гэдгээ хэлж байсан. Үүнээс харвал хэдийн тогтсон бизнес харилцаа нь чөлөөт худалдаанд саад учруулж байж болзошгүй.

Зарим алтны худалдаачид үйл ажиллагаагаа албажуулж, Монголбанканд алтаа борлуулах сонирхолтой гэдгээ дурдсан. Мандал сумын алтны худалдаачин СЗХ-ны алтны худалдааны тусгай зөвшөөрөл авахаар хүсэлтээ өгсөн. Харин бусад бүс нутгийн оролцогчид тус бичиг баримтын талаар мэдээлэлгүй байсан ч алтны худалдааны салбарыг хуульчиж, зохицуулалтанд оруулж байгаад таашаалтай хандаж байлаа. Жишээлбэл, Говь-Алтай аймгийн нэгэн худалдаачин “Би алтны худалдаачнаар бүртгүүлэхдээ баяртай байх болно. Хуулийн дагуу ажиллах нь надад илүү ашигтай” хэмээжээ. Алтны худалдаачидтай хийсэн ярилцлагаас үзвэл Төв банканд алтаа борлуулахгүй байх гол шалтгаануудын нэг нь Монголбанк ямар мэдээлэл шаарддаг вэ гэдгийг мэддэггүйд оршдог, эсвэл алтны гарал үүслийн талаар мэдээлэл өгөх дургүй, зарим нь Монголбанканд өмнө нь алтаа борлуулдаг байсан ч АМНАТ-ын хэмжээ 2019 оны 4 сард 2,5%-иас 5% болж

өссөнөөс хойш борлуулахаа больсон гэж хариулжээ. Монголбанканд алтаа борлуулахын давуу талыг үнэлэхийн тулд албан ба албан бус зах зээлийн харьцуулсан судалгааг хийх нь чухал юм. Хууль бус худалдааны нөхцөл байдлын талаар асуултууд энэхүү асуулгад багтаагүй бөгөөд тэдгээр мэдээлэл нь нууц байх магадлал өндөр юм. Төслийн багийнхны бичиг баримтын судалгаа, албан бус ярилцлага болон ажиглалтаас үзэхэд Монголын албан бус алтны зах зээл нь илүү нээлттэй бөгөөд Монголбанкнаас зарласан үнэтэй адил эсвэл илүү өндөр үнээр худалдаж авдаг. Яагаад гэвэл хууль бус худалдаачид 5 хувийн АМНАТ авдаггүй. Урт Цагааны гудамжинд алтаа өндөр үнээр, бэлэн мөнгөөр, тэр дор нь, илүү шаардлага, асуултанд хариулалгүйгээр борлуулах боломжтой гэдгийг уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй хэн ч болов мэддэг. Дараах дүгнэлтийг нотлохын тулд илүү нарийн судалгаа хэрэгтэй боловч цар тахал гарахаас өмнө Монголын бичил уурхайн ихэнх алт албан бус сүлжээгээр борлуулагдсан байх магадлал өндөр. Албан бус зах зээл илүү нээлттэй бөгөөд тус албан бус худалдааг хумих дорвитой арга хэмжээ авахгүй бол Монголбанканд энэхүү зах зээлтэй өрсөлдөхөд саад бэрхшээл их тулгарч, цаашид бичил уурхайн ихэнх алтыг хууль бус суваг руу алдсаар байх болно.

Алтны худалдааны албажуулалт амжилттай хэрэгжих эсэх нь доорх асуултуудаас шууд хамаарна:

“Бичил уурхайчид болон худалдаачдад Монголбанканд алтаа худалдаалах ямар нэгэн урамшуулал, давуу чанар байна уу? Түүнчлэн хууль бусаар алтны худалдаа хийхэд ямар нэгэн ноцтой саад тогтор байна уу?”

Дээрх асуултанд хариулахад шаардлагатай зарим нэг гол хүчин зүйл нь: борлуулах цэг рүү хүрэх боломж, олон улсын зах зээлийн үнэ болон хууль бус зах зээлийн алтны үнэ, алт худалдаалах нөхцөл, төлбөрийн хэлбэр болон хугацаа, санхүүжилтийн хүртээмж, итгэл, сорьцлолт болон жинлэлт, ил тод байдал, харилцаа холбоо, хууль дүрэм журмын хэрэгжилт болон албадан хэрэгжүүлэлт зэрэг юм. Хууль эрх зүйн орчны тухай судалгаа (planetGOLD, 2021 он) нь эдгээр асуудлаар дүн шинжилгээ болон зөвлөмжийг дэвшүүлэх болно.

7.3 Гарал үүслийг мөшгөх тогтолцоо ба магадлан шинжилгээ

Олон улсын алтны худалдааны хууль, дүрэм журам болон шаардлагад үйл ажиллагаа нь нийцэж байгаа эсэхийг үнэлэх нь чухал юм. Яагаад гэвэл Монголд олборлож, боловсруулсан алт хэзээ нэгэн цагт олон улсын зах зээлд борлуулагдах бөгөөд энэ нь алтны худалдаанд шууд нөлөөлдөг хүчин зүйл юм. Сүүлийн 10 жилийн турш олон улсын алтны зах зээл албажуулалт болон зохицуулалтын чиглэлээр хурдацтай өөрчлөлтөнд орсоор ирсэн. Үүнд хөтөлсөн тодорхой хүчин зүйлүүд нь зохицуулалтгүй олборлолтоос үүдэх сөрөг үр дагаврын талаарх дэлхийн ойлголт өсч, төр засгийн байгууллагууд мөнгө угаалт, терроризмын санхүүжилтийн эсрэг тэмцэж, байгаль орчноо хамгаалж, нийгмийн асуудлуудын (хөдөлмөрийн нөхцөл байдал, аюулгүй байдал, хүүхдийн хөдөлмөр) эсрэг тэмцдэг болсон.

Үүний үр дүнд Монголын алтны худалдааны зах зээл дараах 2 нөхцөлийг бүрдүүлж, дагаж ажиллах хэрэгтэй. Энэ нь уурхайн гарал үүслийг мөшгөх

тогтолцоо болон магадлан шинжилгээ юм. Олон улсад алтны грамм бүрийг олборлосон уурхай руу нь мөшгөх боломжтой бичиг баримтын бүрдэлтэйгээр борлуулахыг шаарддаг бөгөөд үүний сацуу мөн тухайн алтны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч тал бүрийн магадлан шинжилгээг хавсаргах шаардлагатай. Эдгээр шаардлага нь анх уг салбарын сайн дурын стандарт болон гарч ирсэн ч цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хууль тогтоомж болон батлагдсан юм. Товчхондоо шаардлагад нь нийцүүлэн ажиллах ёстой олон улсын хоёр үндсэн стандарт нь ЭЗХАХБ-ын Магадлан шинжилгээний удирдамж болон Лондонгийн Металлын биржийн хариуцлагатай алтны удирдамж зэрэг юм. Уурхайн гарал үүслийн тогтолцоо болон алтны нийлүүлэлтийн сүлжээнд оролцож буй алтны худалдаачин, боловсруулагч талуудын магадлан шинжилгээ зэрэг нь дээрх 2 стандартын гол хүчин зүйл. Европын холбооны “Зөрчил бүхий эрдэс баялгийн” хуулийн дагуу 2021 оны 1 дүгээр сараас эхлэн тус бүс нутагт борлуулагдаж байгаа бүхий л алтанд дээрх шаардлагыг тавьж эхэлнэ. Монгол Улс одоогоор Швейцар Улсын цэвэршүүлэгч байгууллагад алтаа борлуулж байгаа тул энэ асуудал нь мөн Монгол Улсад хамааралтай юм. Дээрх стандартад нийцүүлэн ажиллах нь тухайн улс орны банкны харилцаанд мөн нөлөөлнө.

Одоогоор Монгол Улс нь эдгээр стандарт, хууль дүрэм журамтай нийцэж ажилладаггүй бөгөөд цаашид энэ нь олон улсын алтны зах зээл болон банкны үйлчилгээний хүртээмжид саад бэрхшээл, эрсдэл учруулах сул талтай. Монголбанк одоогоор иргэдээс худалдан авч, экспортод гаргаж буй алтны гарал үүслийг тодорхойлох боломжгүй байна. Өмнө нь ямар ч иргэн өөрийн үнэмлэх болон сорьцын бичгийг үзүүлснээр алтаа Монголбанканд борлуулах боломжтой байсан. Тухайн алтыг олборлосон уурхайн мэдээлэл, албан эсвэл албан бус үйл ажиллагааны нотолгоо, бичил уурхай эсвэл том уул уурхайг ялгах бичиг баримт тодорхой нэхэгддэггүй байсан. 2020 оны 3 сард СЗХ алтны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж болон иргэдийг бүртгэж, тусгай зөвшөөрөл олгох зориулалттай журам батлагдсан. Хэдийгээр энэ нь чухал анхны алхам боловч эдгээр дүрэм журам нь олон улсын алтны зах зээлийн хүлээлтэд нийцээгүй бөгөөд тухайн алтны гарал үүсэл, олборлолт явуулсан уурхайн мэдээллийг мөшгөх боломжийг олгохгүй байна. Монгол Улс ихэнх алтаа Швейцар дахь цэвэршүүлэгч байгууллагад борлуулах нөхцөлтэй тул энд асуудал үүсч байгаа юм. Монголбанк үйл ажиллагаагаа тус Швейцарын байгууллагын дагаж мөрдөх ёстой хуульд нийцүүлэн ажиллахгүй байгаа бөгөөд үүний үр дүнд олон улсын алтны зах зээлийн зүгээс хатуу шаардлага, сөрөг үр дагавар амсаж болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Алтны гарал үүсэл тодорхой болсноор алтны худалдааны тоон мэдээлэл мөн л тодорхой болох бөгөөд Монголбанк болон бусад талууд татвар төлөлтийг хянах боломж бүрдэнэ. Одоогоор татвараас зугтааж, том уурхайн алтыг иргэний хувиар борлуулах тохиолдол их байх магадлалтай байна.

Монгол Улсын татварын хуулиар 3 тэрбум хүртэлх орлоготой аж ахуйн нэгж нь 10%-ийн орлогын албан татвар төлнө, харин 3 тэрбумаас дээш орлоготой аж ахуйн нэгж нь 25%-ийн орлогын албан татвар төлөх үүрэгтэй. Энэ нь хувь хүнээр алтаа борлуулж, татвараас зайлсхийх хүчтэй эдийн засгийн хөшүүргийг үүсгэж байна (Монгол Улсын Засгийн газар, 2020 он). Үүний үр дүнд татвараас зайлсхийх зорилгоор том уурхай болон бичил уурхайчид алтаа хувь хүнээр

дамжуулан борлуулдаг. Жишээлбэл, Монголбанк 2019 онд нийт 15.2 тонн худалдан авсан бөгөөд үүнээс 49%-ийг буюу 7.4 тонныг 423 иргэн тушаасан. Гэвч энэ алтны хэдэн хувь нь бичил уурхайчдынх, хэдэн хувь нь татвараас зугтааж буй том уурхайн алт вэ гэдэг нь тодорхойгүй байна.

Алтны худалдааг албажуулах нь алтны гарал үүслийг тогтоож, магадлан шинжилгээг хийж, хил дамнасан хууль бус худалдаа болон татвараас зугтаах зэрэг үйл ажиллагааг таслан зогсооход нэн шаардлагатай юм.

7.3.1 Алтны худалдааны бүртгэл хийх дадал

Судалгааны хүрээнд бичил уурхайчдын бүртгэл хийх дадлыг цөөн хэдэн асуултаар дүгнэсэн. Тэдгээр бүртгэл нь ил тод нийлүүлэлтийн сүлжээний чухал баримтууд юм (Хүснэгт 7.3-1). Судалгаанаас үзэхэд нийт оролцогчдын 43% нь олборлолтын бүртгэл хийдэг, үүнд Түнхэл 70%, Алтай 15%. Нийт оролцогчдын 24% нь алтны борлуулалтын бүртгэл хийдэг. Зөвхөн 11% нь алтны худалдаачнаас баримт авч байсан гэж хариулжээ. Нийт бичил уурхайчдын 29% нь үйл ажиллагааныхаа санхүүгийн бүртгэлийг хөтөлдөг хэмээн хариулсан. Ерөнхийдөө бүртгэл хөтлөх дадал хамгийн сайн тогтсон бүс нутаг нь Түнхэл, дараа нь Мандал, харин хамгийн бага дадал тогтсон нь Баянгол болон Алтай сумдууд байлаа.

Албажсан үйл ажиллагаатай уурхайнууд албан бус, хууль бус уурхайнуудтай харьцуулбал хүдрийн бүртгэл болон санхүүгийн бүртгэл хийх дадал илүү сайн тогтсон байсан нь ажиглагдлаа (Хүснэгт 7.3-2).

Хүснэгт 7.3-1. Судалгааны бүс нутаг дахь бичил уурхайчдын үйл ажиллагааны бүртгэл хийх дадал

	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=71)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Нийт (n=371)
Олборлосон хүдрийн бүртгэл	19%	48%	70%	53%	15%	43%
Алтны худалдааны бүртгэл	19%	27%	35%	21%	14%	24%
Алтны худалдаачин баримт олгодог	12%	14%	17%	8%	3%	11%
Санхүүгийн бүртгэл	21%	36%	45%	24%	12%	29%

Хүснэгт 7.3-2. Бүртгэл хийх дадал (байгууллагын төрлөөр)

	Бүртгэлтэй нөхөрлөл (n=197)	Бүртгэлгүй нөхөрлөл (n=34)	БУ ТББ (n=51)	Албан бус бичил уурхайчид (n=17)	Хууль бус бичил уурхайчид (n=72)	Нийт (n=371)
Олборлосон хүдрийн бүртгэл	48%	47%	69%	24%	11%	43%
Худалдсан алтны бүртгэл	27%	24%	33%	18%	10%	24%
Алтны худалдаачин баримт олгодог	13%	15%	12%	12%	3%	11%
Санхүүгийн бүртгэл	32%	26%	47%	18%	10%	29%

Ярилцлагын үр дүнд алтны худалдаачид худалдаа хийсэн өдөр, алт худалдаалсан хүний нэр, алтны хэмжээ болон таамаглаж буй сорьцын хэмжээг бүртгэдэг гэж хариулсан. Гэсэн хэдий ч тэд хаана, хэзээ, эсвэл хэрхэн тухайн алтны хүдрийг олборлож, боловсруулсан талаар асуудаггүй.

Алтны олборлолт болон худалдааны бүртгэл нь алтны гарал үүсэл, уурхайн мөшгөлтийн тогтолцоо болон магадлан шинжилгээтэй шууд холбоогүй ч

санхүүгийн бүртгэл үйлдэж, санхүүгийн хүртээмжинд хүрэхэд чухал хэрэгсэл юм.

7.4 Санхүү, хөрөнгө оруулалтын хүртээмж

Буруу, муу үйл ажиллагаатай бичил уурхай нь нийгмийн болон байгаль орчны томоохон сөрөг нөлөөллийн эх үүсвэр болох магадлалтай. Гэсэн хэдий ч хариуцлагатай, байгаль орчны зохих арга хэмжээний тусламжтай, алтны бичил уурхай нь ашигтай үйл ажиллагаа эрхэлж, бичил уурхайчид болон тухайн орон нутгийн хувьд нийгмийн эерэг үр ашгийг авч ирэх боломжтой. Хариуцлагатай бичил уурхай нь эдийн засгийн хөшүүрэг болон төлөвшихийн сацуу сөрөг нөлөөллөөс зайлсхийж эсвэл тэдгээрийг бууруулахын тулд тус салбарт санхүүгийн хүртээмж хэрэгтэй бөгөөд тэрхүү санхүүжилтийн тусламжтай бичил уурхайчид цэвэр, үр ашигтай технологи ашиглаж, байгаль орчны үр дүнтэй менежментийг хэрэгжүүлэх боломжтой ба эдгээрийн гол үндэс суурь нь бичил уурхайг хүлээн зөвшөөрсөн хууль эрх зүйн орчин юм. Сүүлийн хэдэн арван жилийн турш бичил уурхайн технологи болон бодлогын сайжруулалт хийгдсээр ирсэн ч албан ёсны санхүүжилтийн хувьд том саад тотгорууд тулгарсаар байна (planetGOLD, 2020 он).

Бичил уурхайчдын хувьд дараагийн нэгэн саад бэрхшээл нь одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжид уг салбарт хөрөнгө оруулалт татах талаар дурдаагүй байна. Бичил уурхайн зөвшөөрөл нь барьцаа хэлбэрээр ашиглагдах боломжгүйн улмаас хөрөнгө оруулалтыг үгүйсгэж байна. Түүнчлэн энэ нь бичил уурхайг хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг хязгаарлаж байна. Хөрөнгийн зах зээл нь олборлолтын төслүүдийн эхлэлтийн санхүүжилтийн уламжлалт эх үүсвэр билээ. Эхлэлтийн санхүүжилт байхгүйгээс үүдэн бичил уурхайчид геологийн хайгуул хийх боломжгүйд хүрч, геологийн нөөцөө тодорхойлох нөхцөл бүрдэхгүй. Хүдрийн хэмжээ болон алтны нөөцийн мэдээлэл дутмаг байгаагаас шалтгаалж, мөнгөн усгүй хүдэр боловсруулах цехийн хөрөнгө оруулалт нь илүү эрсдэл үүрнэ. Хөрөнгө оруулагч нь аливаа төслийн геологийн нөөцийн талаар мэдээлэлгүй бол тухайн төсөл хөрөнгө оруулалтыг нь эргэн төлөх боломжтой эсэхийг мэдэх боломжгүйд хүрнэ. Төсөл асуудалд орвол хөрөнгө оруулагч тус газрыг хуваан эзэмших боломж мөн байхгүй.

Албан ёсны санхүүгийн хүртээмж нь бичил уурхайчдын зах зээлийн оролцоонд томоохон саад тотгор болж байна гэдгийг ойлгох ойлголт дэлхий дахинаа нэмэгдсээр байна. Ихэнх бичил уурхайчид алтны худалдаачид болон баяжуулах цехийн оролцогчдоос бэлэн мөнгөний зээл болон төлбөрийн урьдчилгаа зэргийг түшиглэж ажилладаг. Тоног төхөөрөмж худалдаж авах хөрөнгийн хүртээмжгүйгээр бичил уурхайн талбайн үйл ажиллагаа үр ашиг хязгаарлагдмал байна. Баталгаатай, байнгын, найдвартай хөрөнгөгүйгээр бичил уурхайчид алтны худалдаачдаас зээл авч, алтны үнэ нь зах зээлийн үнэлгээнээс доогуур байсан ч алтаараа төлбөр хийх явдал их байдаг. Бичил уурхайн нөхөрлөлүүдийн албан бус байдал, өндөр эрсдэлтэй хэмээх тогтсон үзэл бодол зэргээс үүдэн бичил уурхайчдын хувьд санхүүгийн энгийн үйлчилгээ авах боломжийг нь хааж байна.

Ярилцлагын үед ихэнх бичил уурхайчид нийгмийн даатгал төлдөггүй учир банканд орлогын нотолгоогоо бүрдүүлэн өгөх боломжгүй байдаг тухай бичил уурхайн байгууллагын ахлагч нар ярьсан. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу бичил уурхайчид газрын зөвшөөрлийн бичиг баримтаа зээлийн барьцаа хөрөнгөөр ашиглаж, олборлох эрхээ бусдад шилжүүлэх эрхгүй шалтгаан нь мөн банканд хандах боломжийг нь хязгаарлаж байгаа. Нөгөөтээгүүр бичил уурхайгаас олж байгаа орлого нь эрсдэл өндөртэй бөгөөд тогтвортой бус хэмээн тооцогддог. Түүнчлэн ихэнх банкууд чанаргүй зээлээс өөрсдийгөө хамгаалах гол арга хэрэгсэл нь барьцаа хөрөнгө байдаг боловч бичил уурхайчдыг мөн л хөрөнгийн баталгаа өгөх боломжгүй гэсэн үзэл нийтлэг байна. Жишээлбэл, бичил уурхайн байгууллагын нэгэн ахлагчийн яриагаар:

“Би зээл авахаар банканд хандаж, өөрийн бичил уурхайн байгууллагын бүх албан ёсны бичиг баримт, бүртгэл, орлогын мэдээллийг өгч үзсэн. Гэхдээ банк биднийг зээл авах боломжтой гэж үзээгүй. Миний бодлоор банк санхүүгийн байгууллагуудад бичил уурхай, түүний хууль эрх зүйн орчин, албажуулалтын талаар мэдээлэл түгээх шаардлагатай юм шиг санагдсан.”

Ганцаарчилсан ярилцлага, нөхөрлөлийн ахлагч, эмэгтэй, Сэлэнгэ аймаг

Бичил уурхайчид нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн бүртгэл хийх дадалгүй нь мөн л саад бэрхшээл болдог (Хүснэгт 7.3-1). Судалгаанд оролцогчдын 71% нь санхүүгийн бүртгэл хийдэггүй хэмээн хариулсан байна. Алтны худалдаачид санхүүгийн бүртгэлээ хар дэвтэртээ тэмдэглэдэг бөгөөд энэ нь албан бус санхүүгийн баримт болдог. Монголд хар дэвтэр ашиглах явдал түгээмэл байдаг ч тухайн борлуулагдсан алтны олборлосон газар, тэр уурхай нь албан зөвшөөрөлтэй эсэхэд хяналт тавьдаггүй. Нийт бичил уурхайчдын зөвхөн 3% нь арилжааны банкнаас зээл авч чадсан байна. Нийт бичил уурхайчдын 83% нь өөрийн хөрөнгөөр олборлох үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг гэж хариулжээ (Хүснэгт 7.4-1). Бичил уурхайчдын 9%-ийнх нь мэдээлснээр алтны худалдаачид албан бус харилцаагаа баталгаажуулах зорилгоор банкнаас болон бусад санхүүгийн байгууллагаас зээл авах боломжгүй бичил уурхайчдад зээл санал болгож, алтаар эргэн төлөлт хийхийг хүлээн зөвшөөрдөг. Жижиг алтны худалдаачид мөн орон нутагт худалдаа эрхэлж, томоохон хэмжээний алт арилжаалах санхүүжилтээ Улаанбаатар хотын худалдаачдаас авах тохиолдол бий. Ганцаарчилсан ярилцлагаас үзэхэд зарим бичил уурхайн нөхөрлөлүүд гишүүдээсээ санхүүжилт босгож, бичил уурхайн үйл ажиллагааныхаа эхлэлийн хөрөнгийг бүрдүүлдэг.

Хүснэгт 7.4-1. Олборлолтын үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжууд (судалгааны бүс нутгаар, олон хариулттай, нийт=545)

	Баянгол (n=52)	Мандал (n=112)	Түнхэл (n=71)	Есөнбулаг (n=62)	Алтай (n=74)	Нийт (n=371)
Өөрийн хөрөнгө	83%	75%	85%	84%	93%	83%
Арилжааны банк	4%	4%	0%	3%	1%	3%
Банк бус санхүүгийн байгууллага	4%	3%	3%	5%	0%	3%
Алтны худалдаачид	12%	12%	7%	5%	8%	9%
Баяжуулах цех	13%	8%	7%	3%	1%	6%
Бусад	10%	18%	20%	23%	22%	19%

Ярилцлагын үед хамгийн сүүлд бичил уурхайн талбай дээр хийсэн хөрөнгө оруулалтын талаар асуухад, нөхөрлөлийн ахлагч нарын ихэнх нь хашаа барих, суурьшлын бүсээ тохижуулах, харуул хамгаалалтын цалинг тавих зэрэг үйл


ажиллагааг нэрлэж байлаа. Нөхөрлөлийн ахлагч нарын нэг нь алтны гарцаа сайжруулж, үйл ажиллагааны үр ашгаа дээшлүүлэхийн тулд нэмэлт тоног төхөөрөмж хэрэгтэй байгаа хэмээн дурдаж байв:

Бидэнд хөрөнгө оруулалтын хэрэгцээ байна. Манай нөхөрлөл том болон жижиг тээрэм, цахилгаан алх зэрэг энгийн багаж төхөөрөмжүүдтэй. Хүдрээс алтаа салгаж, боловсруулах үедээ бид их хэмжээний алтыг алдаж байна. Төсөл бидэнд хандаагүй бол бид мөнгөн ус л ашиглах байсан. Одоогоор нийт 100 грамм алтны 70%-ийг нь бид алдаж, үлдсэн 30%-ийг нь л авч чадаж байна. Шороон ордны алтыг олборлоод, ялгаж авахад хялбар байдаг, яагаад гэвэл алтны ширхэг нь том бөгөөд хаягдал багатайгаар угаагаад ялгаж болдог. Гэсэн хэдий ч үндсэн ордны алтыг боловсруулахад хүндрэлтэй байдаг яагаад гэвэл бид хүдрээ тээрэмдэхэд гурил шиг жижиг ширхэгтэй зүйл болон гарч ирдэг. Тэр жижиг ширхэгтэй нунтагийг усаар угаах тун хэцүү. Манай нөхцөлд энэ бүтээгдэхүүнийг боловсруулж чадах цорын ганц металл нь мөнгөн ус. Илүү дэвшилтэт боловсруулалт хийхийн тулд бидэнд баяжуулах цехийн тоног төхөөрөмж хэрэгтэй байна.

Ганцаарчилсан ярилцлага, нөхөрлөлийн ахлагч, эрэгтэй, Ховд аймаг

Санхүүжилт авах боломж байсан бол юунд зарцуулах байсан бэ гэдэг асуултанд асуулгад оролцогчдын ихэнх нь (53%) тоног төхөөрөмжөө сайжруулна хэмээн хариулжээ (4-р бүлэг, Зураг 4-4).

Түүнчлэн бичил уурхайчдаас банкны зээлтэй эсэх талаар асуусан боловч зээл авах шалтгаан болон хэмжээний талаар мэдээлэл асуугаагүй. Нийт судалгаанд оролцогчдын 54% нь банкны зээлтэй. Банкны зээлээрээ бичил уурхайн үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг гэж цөөн бичил уурхайчид мэдээлсэн тул дээрх зээлийг байр, орон сууц, машин, мал эсвэл бусад эд хөрөнгө худалдан авахад ашигласан байх өндөр магадлалтай, эдгээр нь мөн эргээд банкны барьцаа хөрөнгө болон ашиглагдаж болдог. Түүнчлэн бичил уурхайчдын орлого тогтмол бус учир амьжиргаагаа залгуулахад хөрөнгө мөнгө дутмаг гэсэн шалтгаанаар зээл авсан хэмээн таамаг дэвшүүлж байна.



Зураг 7-5. Банкны зээлтэй нийт оролцогчдын тоо, хүйсээр ба нийт

7.5 Дүгнэлт

Алтны нийлүүлэлтийн сүлжээг Монгол Улсын Засгийн газар болон Монголбанк удирдан зохицуулж, орон нутагт олборлосон алтыг арилжааны банкуудаар дамжуулан төвлөрүүлж, СЗХ алтны худалдаачдыг бүртгэж, тусгай зөвшөөрөл

олгож байгаа ч албан бус олборлолт болон албан бус худалдаачдыг зохицуулах чиглэлээр алтны худалдааны гарал үүслийг мөшгөх тогтолцоо, бүртгэлийн асуудлаар сайжруулах зүйлс их байна.

Монгол Улс нь одоогоор алтны гарал үүслийг мөшгөх тогтолцоо болон магадлан шинжилгээний олон улсад мөрдөгдөж буй стандарт, хууль дүрэм журамтай бүрэн нийцэж ажиллахгүй байна. Энэ нь тус улсын хувьд олон улсын алтны зах зээл болон банкны үйлчилгээний хүртээмжид саад бэрхшээл, эрсдэл учруулах үр дагавартай. Одоогоор Монголбанк хувь хүнээс худалдан авч, экспортод гаргаж буй алтныхаа гарал үүсэл болон тухайн алтыг олборлосон уурхайг мөшгөж, боломжгүй байна.

Судалгаанаас үзэхэд ихэнх уурхайчид албан сүлжээгээр алтаа борлуулахад хэрэгцээтэй нягтлан бодох бүртгэл, хүдэр болон алтны худалдааны бүртгэл, алт сорьцлолт, алтны зах зээлийн үнийг шалгах, өөрт ашигтай үнийг шаардах эрхээ хамгаалах зэрэг чухал мэдлэг, ур чадварыг эзэмшээгүй нь илэрсэн. Ашигтай үнэ шаардаж чадахгүй байгаа нь олборлосон алтаа борлуулах сонголт бага байгаатай холбоотой ба судалгаанаас үзэхэд орон нутагтаа алтаа борлуулах боломжтой алтны худалдаачин болон худалдааны цэгүүдийн сонголт нэг эсвэл хоёр л байдаг. Үүний үр дүнд өрсөлдөөн багасч, бичил уурхайчид тухайн орон нутгийн худалдаачны тогтоосон нөхцөлийг дагахаас өөр аргагүйд хүрнэ. Дархан-Уул болон Баянхонгор аймгуудад НЦҮТ байгуулсан нь алтны албан худалдааг өргөжүүлж, АБУ-н үндсэн бүс нутгуудад хүрэх эхний алхам болсон. Гэсэн хэдий ч одоогоор орон нутаг дахь алтны худалдаанд худалдаачид зонхилох байр суурьтай байгаа бөгөөд тэдгээр нь СЗХ-нд бүртгэгдэж, тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагаа эхлээд явж байна.

Үндсэн ордны бичил уурхайчдад баяжуулах цех нь үйлчилдэг орон нутагт бичил уурхайчид ихэнхдээ алтаа цехдээ борлуулах шаардлага гардаг. Иймээс баяжуулах цехүүдийг алтны худалдааны нэгэн оролцогч хэмээн үзэж, тэдний үүрэг оролцоог орхигдуулахгүй байх нь зүйтэй.

Одоогоор тогтоод буй хууль эрх зүйн зохицуулалт болон бодлогууд нь хоорондоо зөрчилдөж байгаа нь илт байна. Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулж буй гол журмын хэрэгжилт тогтворгүй байгаа ч Монголбанк хувь иргэдийн тушаасан алтны гарал үүслийг асуулгүй худалдан авалт хийдэг, харин СЗХ алтны худалдаачдыг бүртгэлжүүлж, мөнгө угаалт болон терроризмын санхүүжилтийн эсрэг хуулийг хэрэгжүүлэх зорилгоор алтны худалдаагаа бүртгэхийг шаардаж байна. Иймээс одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж, АБУ-г зохицуулж буй хууль эрх зүйн актууд хоорондын уялдаа холбоог хангаж, үүний сацуу уурхайн гарал үүслийг мөшгөх тогтолцоо болон санхүүгийн хүртээмжийг баталгаажуулах нь зүйтэй.

Санхүүгийн хүртээмж муутай бичил уурхайчид тогтворгүй орлого, эрсдэлтэй салбар хэмээх үзэл бодлоос шалтгаалан албан ёсоор банканд хандаж, санхүүгийн үйлчилгээ авах боломжгүй байна. Иймээс тэд алтны худалдаачдад хандан, албан бус зээлийн үйлчилгээг авдаг. Энэ нь алтны бичил уурхайн ил тод байдлыг бууруулахад ихээр нөлөөлж байна. Албан санхүүжилтийн хүртээмж муу байгаа нь хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагааны томоохон саад бэрхшээл бөгөөд сөрөг нөлөөллөөс ангид байж, орон нутгийнхаа эдийн засагт

хувь нэмэр оруулахаар ажиллаж байгаа бичил уурхайн амжилтыг удаашруулах талтай.

Нөгөөтээгүүр одоогоор мөрдөгдөж буй хууль эрх зүйн зохицуулалт ба бодлогын бичиг баримтанд бичил уурхайд хөрөнгө оруулалт татах талаар дурдагддаггүй. Бичил уурхайн зөвшөөрөл нь барьцаа хөрөнгө болж чадахгүй учир гадаадын хөрөнгө оруулалт татахад мөн л бэрхшээл болж байна. Үүнээс үүдэн олборлолтын төслийн анхан шатны хөрөнгө оруулалтын сонгодог хэлбэр болох хөрөнгийн зах зээлд оролцох боломж бичил уурхайчдын хувьд байхгүй. Анхан шатны хөрөнгө оруулалтгүйгээс үүдэн геологийн хайгуул, судалгааг хийх боломжгүй учир бичил уурхай нь геологийн нөөцөө тогтоох боломжгүйд хүрч байна. Цаашлаад, хүдрийн хэмжээ болон алтны нөөцийн хэмжээ тодорхойгүйн улмаас мөнгөн усгүйгээр хүдэр боловсруулах цехэд хөрөнгө оруулах боломж нь илүү их эрсдэлийг дагуулна. Аливаа төслийн геологийн нөөцийн талаарх мэдээлэлгүй хөрөнгө оруулагч нь тухайн төсөл хөрөнгийн өгөөжтэй эсэхийг урьдчилан таамаглах боломжгүйд хүрдэг.

8. Уул уурхайн сайн туршлага хэрэгжүүлэх чадавх


Албан ёсны, том уул уурхайн салбартай харьцуулахад бичил уурхайн албан ба албан бусаар алт олборлогчид өмнө нь магадлан итгэмжлэгдсэн байгууллагын ямар нэгэн сургалтад хамрагдалгүйгээр энэхүү салбарт орж ирдэг. Тэд энэ салбарт ажиллаж байх явцдаа суралцдаг. Тиймээс бичил уурхайчид одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомжийг ойлгох, салбарын зохицуулалт, уул уурхайн сайн туршлагын талаар мэдлэг олж авах, геологийн мэдээлэл эсвэл санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн олж авах талаар найдвартай, хамгийн сүүлийн шинэ мэдээлэл олж авах, сургалтад хамрагдах нь зайлшгүй шаардлагатай байгаа юм. 2005-2019 оны хооронд Монгол Улсын бичил уурхай эрхлэгчдэд зориулсан сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжсэн Тогтвортой бичил уурхай төслийн (ТБУТ) дэмжлэгтэйгээр зохион байгуулж байсан (Шигтгээ 4-ийг үзнэ үү). МБУНДХ нь ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр 2013 онд байгуулагдсан (Шигтгээ 5-ыг үзнэ үү) цагаасаа эхлэн бичил уурхайчдыг мэдээллээр хангах, сургалт явуулах гол байгууллагын үүрэг гүйцэтгэж ирсэн.

2019-2023 онд хэрэгжиж буй Алтны бичил уурхайгаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн нэг зорилт нь “Алтны бичил уурхайгаас үүдэлтэй сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй хүн ам, бичил уурхайчдад мөнгөн усны нөлөөлөл, байгаль орчин, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хууль тогтоомжийн талаар мэдлэг олгож, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх” (Монгол Улсын Засгийн газар, 2020он) явдал юм. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд холбогдох яамд, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, МБУНДХ болон олон улсын байгууллагуудтай хамтран сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

8.1 Уурхайчдын мэдээллийн эх сурвалж


Мэдээллийн хүртээмж нь уурхайчдын хувьд хууль тогтоомж, ашигт малтмалын олборлолтын сайн туршлага, алтны үнийн талаар мэдлэг олж авах чухал эх сурвалж юм. Ухаалаг гар утасны өргөн хэрэглээ, интернетийн хүртээмж уурхайчдын мэдээлэл олж авах хүрээг нэмэгдүүлж байгаа боловч энэ нь мэдээллийн чанарыг тодорхойлж чадахгүй юм. Гэсэн хэдий ч судалгааны зорилго нь уурхайчид орон нутагт төслийн үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэл авахын тулд ямар мэдээллийн сувгийг илүүд үздэгийг тодорхойлох, ойлгох явдал байсан.

Нийт судалгаанд оролцогчдын тал орчим хувь нь (51%) алтны бичил уурхайн талаарх мэдээллийг тухайн салбарын хүмүүсээс, 32% нь гэр бүл, найз нөхөд, хамаатан саднаасаа авдаг гэсэн бол Засгийн газар болон төрийн байгууллагуудыг хамгийн бага мэдээллийн эх сурвалжаар (10%) тодорхойлсон байна.



Зураг 8-1. Судалгаанд оролцогчдын ашигладаг бичил уурхайн талаарх мэдээллийн эх сурвалж (хүйсээр, олон хариулттай, нийт=503)


Бичил уурхайн Мэдлэгийн төв (бичил уурхайн оролцогч талуудад мэдээлэл солилцох, хуваалцах боломжийг олгох зорилгоор ТБУТ-ийн хөгжүүлсэн платформ <https://www.asmhub.mn/en/>)-ийн талаар уурхайчид мэддэг эсэх талаарх асуултад тэдний бараг 90% (n=331) мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна. Харин мэдлэгийн төвийн талаар мэддэг хүмүүсийн (n=40) дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь бага зэрэг өндөр байсан (эрэгтэйчүүдийн 13%, эмэгтэйчүүдийн 10%) бөгөөд эдгээр хүмүүсийн 22 нь энэ төвөөс мэдээлэл олж авах боломжтой гэж хариулсан бол 6 уурхайчин энэ талаар мэддэг, гэхдээ ашиглаж байгаагүй гэж хариулсан байна. Бичил уурхайн мэдлэгийн төвийн талаарх мэдлэгтэй уурхайчны эзлэх хувь Мандалд бага зэрэг илүү (15%), харин Алтайд хамгийн бага (7%) байв.



Зураг 8-2. Бичил уурхайн мэдлэгийн төвийн талаарх мэдээлэл (судалгааны бүс нутгаар ба хүйсээр)


Бичил уурхайн мэдлэгийн төв нь нэг төвлөрсөн платформоор дамжуулан холбогдох мэдээллээр хангах сайн арга боловч уурхайчдын дийлэнх нь энэ талаар мэддэггүй бөгөөд мэдээлэл авахыг илүүд үздэг мэдээллийн хэрэгслийн жагсаалтад оруулаагүй болохыг судалгаа харуулж байна. Судалгаанд хамрагдагсадаас өөрсдийн ажил мэргэжилтэй холбоотой мэдээлэл авахыг эрмэлздэг мэдээллийн хэрэгслийн талаар асуусан. Ойролцоогоор 55% нь

телевизээс, 46% нь гар утсаараа, 44% нь Фэйсбүүкээс мэдээлэл авахыг илүүд үздэг гэж хариулжээ (Зураг 8-3). Уурхайчин эмэгтэйчүүд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (фэйсбүүк), телевизээр мэдээлэл авахыг илүүд үздэг байсан бол эрэгтэй уурхайчид телевиз, гар утсыг илүүд үздэг байна.



Зураг 8-3. Мэдээ, мэдээлэл авах олж авахыг илүүд үздэг мэдээллийн хэрэгсэл (хүйсээр, олон хариулттай, нийт=757)

АБУ-н талаар оролцогчдын хамгийн их хувь нь газрын зөвшөөрөл, хууль тогтоомжтой (31%) холбоотой мэдээлэл авахыг хүсч байсан бол тэдэнд шаардлагатай гэж бусад мэдээллийг (21%) Зураг 8-4-т жагсаав. Судалгаанд оролцогчдыг байршлаар нь авч үзвэл хууль эрх зүйн орчны талаар мэдээлэл авахыг хүсэж байгаа уурхайчдын хувь Алтай, Баянгол, Мандал сумдад өндөр буюу тус бүр 45%, 38%, 35%-тай байна. Судалгаанд оролцогчдын зарим нь алтны үнэ, алтны нөөц, орчин үеийн технологи, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (3%-6%)-тай холбоотой мэдээллийг сонирхож байсан бол 18% нь ямар ч мэдээлэл шаардлагагүй гэжээ.




Зураг 8-4. Бичил уурхайчдын санал болгосон мэдээллийн төрлүүд (судалгааны бүс нутгаар)

8.2 Бичил уурхайчдын сургалтад хамрагдсан туршлага ба сургалтын хэрэгцээ шаардлага

8.2.1 Сүүлийн хоёр жилийн хугацаанд сургалтад хамрагдсан байдал

Сүүлийн 2 жилийн хугацаанд нийт уурхайчдын 35% (141) нь дор хаяж нэг уул уурхайн холбоотой сургалтад хамрагдсан байна. Эрэгтэйчүүдтэй (35%) харьцуулахад эмэгтэйчүүд (47%) харьцангуй олон сэдвээр илүү олон сургалтад хамрагдсан (Хэсэг 6.2-ийг үзнэ үү) байна. Уурхайчид голчлон албажуулалт (19%) ба хариуцлагатай уул уурхайн стандартын (19%) сургалтад хамрагджээ.



Зураг 8-5. Сүүлийн 2 жилийн хугацаанд бичил уурхайчдын сургалтад хамрагдсан байдал (хүйсээр болон нийт)


Сургалтад хамрагдсан байдал нь судалгааны бүс нутгаар болон эмэгтэй, эрэгтэй уурхайчдын дунд харилцан адилгүй байв (Зураг 8-6). Түнхэл (51%), Есөнбулагийн (44%) уурхайчид сургалтын талаар хамгийн их дадлага туршлагатай байсан бол Мандалын эмэгтэй уурхайчид сургалтад илүү хамрагдсан (57%) байна. Харин сургалтад хамрагдагсдын хувь Алтай (20%) болон Баянгол (22%) сумдад хамгийн бага байв.

Ховд аймгийн нөхөрлөлийн гишүүн аюулгүй ажиллагааны сургалтын ач холбогдлын талаар тайлбарлахдаа:

Бид саяхан аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж, дутагдаж байсан мэдлэг, мэдээллээ олж авсан. Энэхүү сургалтаар бид үйл ажиллагааныхаа төлөө хариуцлагатай

байх ёстой, өөрсдийн аюулгүй байдлаа хангаж, хувийн хамгаалалтын хэрэгсэл хэрэглэх хэрэгтэй. Тухайлбал олборлолтын талбайд хамгаалалтын малгай, аюулгүйн бүс байнга зүүх хэрэгтэй гэдгийг ойлгосон. Бид уурхайн талбайд дахин зохион байгуулалт хийсэн. Цаашид, тоног төхөөрөмж, технологийг хэрхэн зөв зохистой ажиллуулах, засвар үйлчилгээ хийх гэх мэт чадавх бэхжүүлэх, илүү мэргэжлийн сургалтууд хэрэгтэй байна.

Ганцаарчилсан ярилцлага, нөхөрлөлийн гишүүн, эрэгтэй Ховд аймаг



Зураг 8-6. Сүүлийн 2 жилийн хугацаанд сургалтад оролцсон хүний тоо, судалгааны бүс нутгаар (хүйсээр болон нийт)

Судалгаанд хамрагдагсдын дийлэнх (141 уурхайчдын 40%) нь өөрийн гишүүд болон бусад уурхайчдад зориулж БУ-н чиглэлээр сургалт болон бусад үйл ажиллагаа явуулдаг МБУНДХ-ны сургалтад хамрагдсан байна. Хүснэгт 8.2-1-ээс харахад ихэнх сургалтыг ТББ-ууд (54%) хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 8.2-1. Сургалт зохион байгуулагчид (судалгаанд оролцогчдын мэдээлснээр n=141)

	Байгууллага	%
1	МБУНДХ	40%
2	УБ хотоос	11%
3	Орон нутгийн байгууллагууд	9%
4	ТББ-ууд	6%
5	Төрийн байгууллагууд	5%
6	Швейцарын хөгжлийн агентлаг	4%
7	Дэлхийн зөн	4%
8	Сургалтын байгууллагаа санахгүй байна	9%
9	Бусад	12%
	Нийт	100%

8.2.2 Сургалтын хэрэгцээ



Судалгаанд оролцогсдоос цаашид ямар төрлийн сургалтад хамрагдахыг хүсч байгаа талаар асуухад (Зураг 8-7) бичил уурхайн албажуулалтыг (35%) хамгийн хээгцээтэй сургалтад оруулсан бөгөөд энэ талаар нөхөрлөлийн гишүүнтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагад доорх мэдээллийг өгсөн.

АБУ-н хууль тогтоомжийн талаар сургалт явуулах шаардлагатай байна. Энэ талаар мэдлэг дутмагаас болж уурхайчид хохирч байгаа бөгөөд цагдаа нар яагаад уурхайчдад торгууль ногдуулдаг, эсвэл хүдэр/чулуут нь хурааж авч байгаагаа тайлбарладаггүй.

Ганцаарчилсан ярилцлага, нөхөрлөлийн гишүүн, эмэгтэй, Сэлэнгэ аймаг

Бусад сургалтын хэрэгцээ шаардлагад голчлон хариуцлагатай, илүү сайн уул уурхайн стандартууд (26%), нөхөн сэргээлт (27%), технологийн сургалт (26%)-уудыг дурдсан байна. Эмэгтэйчүүд албажуулалт, бизнес, санхүүгийн

менежмент, хувь хүний хөгжил, манлайллын талаарх сургалтын хэрэгцээг илүүд үзэж байсан бол эрэгтэйчүүд хариуцлагатай, илүү сайн уул уурхайн стандарт, хөдөлмөрийн аюулгүй байдал, нөхөн сэргээлт, технологийн талаарх сургалтад хамрагдахыг сонирхож байсан.



Зураг 8-7. Судалгаанд оролцогчдын сургалтын хэрэгцээ шаардлага (хүйсээр, олон хариулттай, нийт=850)

Орон нутгийн албаны хүмүүсийн өгсөн мэдээллээр уул уурхайн эрх зүйн орчныг дагаж мөрдүүлэхийн тулд алтны бичил уурхайчдын сургалтын тэргүүлэх чиглэлд хууль эрх зүйн орчин, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, мөнгөн усны эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаарх сургалтууд шаардлагатай болохыг тодорхойлсон болно.

Уурхайчдад хууль тогтоомж, тэдний хариуцлагын талаар мэдлэг, мэдээлэл өгөх нь нэн тэргүүнд шаардлагатай; дараа нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сургалтыг чухалчилж болно. Тэд үндсэн ордод олборлолт явуулсан уурхайн талбайд байгаль орчны нөхөн сэргээлт хэрхэн хийх талаар огт мэдлэггүй.

Ганцаарчилсан ярилцлага, төрийн байгууллагын ажилтан, эмэгтэй Говь-Алтай аймаг

Ер нь манай суманд уурхайчдад сургалт, үйлчилгээ хэрэгтэй байна. Саяхныг хүртэл тэд албан бус байсан тул зохих сургалтад хамрагдаагүй байсан. Тиймээс одоо тэдний үйл ажиллагаа албан ёсны болсон тул холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд сургалтад хамрагдах шаардлагатай байна. Би өөрөө уул уурхайн аюулгүй байдлын талаар зарим зөвлөгөө өгдөг.

Ганцаарчилсан ярилцлага, төрийн байгууллагын ажилтан, эмэгтэй, Ховд аймаг

Мөнгөн усны нөлөөллийн талаар сургалт, мэдээлэл өгөөгүй. ТББ-ууд аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулдаг. Албан болон албан бус уурхайчид, тэдний гэр бүлийн гишүүдэд илүү практик сургалт явуулах шаардлагатай байна, учир нь тийм сургалт уурхайчдад нөлөөлдөг. Мөн 40-өөс дээш насныханд зориулсан орлогын эх үүсвэр нэмэгдүүлэх (амьжиргааны өөр бусад эх үүсвэрийн) талаар сургалт явуулах шаардлагатай байна. Байгаль орчны чиглэлээр сургалт явуулж, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрт тусгах хэрэгтэй.

Ганцаарчилсан ярилцлага, төрийн байгууллагын ажилтан, эрэгтэй Сэлэнгэ аймаг

Уурхайчдад мөнгөн ус ашиглах хор нөлөөллийн талаар бүх төрлийн сургалт явуулах шаардлагатай. Уурхайчид нийгэмшүүлэх сургалтад хамрагдаж, сэтгэлзүйн эмчилгээний үйлчилгээ авах боломжтой байх ёстой. Сургалт хийх хэрэгцээ үргэлж байдаг.

Ганцаарчилсан ярилцлага, төрийн байгууллагын ажилтан, эмэгтэй, Говь-Алтай аймаг

Судалгааны бүс нутгийн нөхөрлөлийн ахлагч нар, ТББ-уудын тэргүүнүүдийн тодорхойлсон сургалтын хэрэгцээний жагсаалт (Хүснэгт 8.2-2)-аас харахад мөнгөн усны талаарх мэдлэгийн хэрэгцээг хангалттай хөндөөгүй байгаа нь мөнгөн усны хэрэглээ хууль бус учраас энэ талаарх мэдлэг дутмаг байдлаа гаргаж тавихаас эмээсэн эсвэл өөрсдийгөө хангалттай чадавхгүй гэдгээ мэдэхгүй байгаатай холбоотой байж болох юм. Түүнчлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон жендэр ба хүний эрхийн талаар хангалттай чадавхгүй байна гэж хэлж болох юм (Хэсэг 6.2-оос үзнэ үү).

Хүснэгт 8.2-2. ТББ болон нөхөрлөлүүдийн ахлагч нарын онцолж хэлсэн сургалтуудын хэрэгцээ шаардлага (судалгааны бүс нутгаар) (сургалтын хэрэгцээ шаардлагын дэлгэрэнгүй жагсаалт байхгүй)

	Баянгол	Мандал	Түнхэл	Алтай	Есөнбулаг
Эрх зүйн орчин		X			
ХАБЭА	X	X		X	
Эрүүл мэнд	X			X	X
Мөнгөн усны эрүүл мэндийн нөлөөлөл	X				X
Байгаль хамгаалал		X			
Технологи					X
Бизнес					X
Нийлүүлэлтийн сүлжээ				X	
Гэр бүлийн харилцаа					X
Орлогын өөр эх үүсвэр			X		

8.2.3 Сургалтын хэлбэр

Орон нутгийн засаг захиргааны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас харахад ажлын байранд сургалт явуулах, ажлын туршлага багатай уурхайчдыг илүү хамруулахад анхаарах шаардлагатай байна. Сургалтад эмэгтэйчүүд их хамрагддаг бөгөөд эрэгтэйчүүд болон гэр бүлийн бусад гишүүдийг татан оролцуулах талаар хангалтгүй байгаа талаар сумын удирдлагууд онцолж байв. Сэлэнгэ аймгийн Бичил уурхайн ТББ-ын тэргүүн энэ талаар ганцаарчилсан ярилцлагад дурдахдаа:

Эрэгтэй, эмэгтэй хүмүүст зориулсан сургалтын хөтөлбөрийг тусад нь явуулах нь хэрэгцээтэй байж болох юм. Эмэгтэйчүүд илүү хариуцлагатай, нийгмийн идэвхтэй

байдаг тул тэднийг өөр ажлын байранд шилжүүлэх эсвэл сургалтад оролцогчдыг бүлэглээд сургалт хийх хэрэгтэй.

Ганцаарчилсан ярилцлага бичил уурхайн ТББ-ын тэргүүн, эрэгтэй, Сэлэнгэ аймаг

Орон нутгийн ТББ-уудын зарим удирдах ажилтнууд сургалтад илүү олон эрэгтэйчүүдийг хамруулах замаар жендэрийн тэнцвэрийг хангахыг санал болгож байсан. Сургалтын үр дүнг сайжруулахын тулд анги танхимын сургалтаас татгалзаж, хагас өдрийн, оролцоонд илүү тулгуурласан ажлын байрны сургалт хийх нь зүйтэй бөгөөд энэ тохиолдолд эрэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэх магадлалтай гэж ТББ-ын төлөөлөл зөвлөсөн байна. АБУ-н үндсэн агуулгыг санал болгохоос гадна эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, залуу хүмүүсийн онцлог хэрэгцээнд үндэслэн сургалтын агуулга боловсруулахыг санал болгосон. Тухайлбал, эмэгтэйчүүдийн ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн зорилтот хөтөлбөрүүд багтаж болно.

8.3 Дүгнэлт

Судалгаанд оролцогчдоос асуусан мэдээллийн эх үүсвэрийн талаарх асуултад тэд голчлон АБУ-н салбарт ажилладаг бусад хүмүүс, найз нөхөд, хамаатан саднаасаа мэдээлэл авдаг гэж хариулсан бөгөөд төрийн байгууллагаас бага хувь нь мэдээлэл авч байна. Бичил уурхайчид ТВ, гар утас, фэйсбүүкээр дамжуулан мэдээлэл авахыг илүүд үзэж байсан. Харин газрын зөвшөөрөл, хууль тогтоомжийн талаарх мэдээлэл хамгийн хомс байдаг гэж дурдсан.

Судалгаанд оролцогчдын гуравны нэг орчим нь (35%) сүүлийн хоёр жилд бичил уурхайтай холбоотой сургалтад хамрагдсан байгаа бөгөөд голчлон БУ-н албажуулалт (19%), хариуцлагатай уул уурхайн стандарт(19%) -ын сургалтад хамрагджээ. Сүүлийн хоёр жилийн хугацаанд уурхайчдад зориулсан сургалтын хамгийн том үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь МБУНДХ байсан. Судалгааны үр дүн нь уул уурхайн илүү сайн туршлагыг нутагшуулахад чухал ач холбогдол бүхий хэд хэдэн асуудлаар чадавх бэхжүүлэх шаардлагатай байгааг харуулав. Уурхайчид голчлон үйл ажиллагаагаа албажуулах, хариуцлагатай уул уурхайн практик үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн талаар сургалт зохион байгуулах шаардлагатай байгааг илэрхийлж байсан бол орон нутгийн албаны хүмүүс, удирдлагууд одоо мөрдөж буй дүрэм журмыг дагаж мөрдүүлэхийн тулд уурхайчдад хамгийн чухал сургалтын сэдэвт хууль эрх зүйн орчныг хамааруулж авч үзсэн. Мөн түүнчлэн байгаль орчны сургалт явуулахаас гадна хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, мөнгөн усны хэрэглээний хор уршгийн талаар сургалт явуулах шаардлагатай байгааг онцлов.

9. Зөвлөмж

Алтны бичил уурхайн салбар нь төвөгтэй бөгөөд олон талт арга барилыг шаардсан хөгжлийн асуудал юм. Энэхүү нөхцөл байдлын судалгааны хүрээнд тухайн салбарт тулгарч буй бэрхшээл, шалтгаануудыг судалж, түүний онцлог байдлыг тусгасан болно. Энэ бүлэгт судалгааны гол асуудлуудаар боловсруулсан зөвлөмжийг толилуулав.

9.1.1 Албажуулалт

Нэгдсэн арга барил, хандлагыг бий болгох

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг боловсронгуй болгох ажлыг бичил уурхайн салбарын олон талт асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн нэгдсэн арга хандлага бий болгоход анхаарал хандуулж эхлэх шаардлагатай байна. Энэхүү хандлагын үндэс суурь нь уурхайчид холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангаж ажиллах, тэдний ажил эрхлэлт, орлогын эх үүсвэрийг тогтвортой байлгахын тулд бичил уурхайг албажуулах үйл явцыг нэмэгдүүлэх Засгийн газрын хүчтэй дэмжлэг, төрийн төв болон орон нутгийн түвшинд бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчид, хувийн хэвшил, ИНБ болон уурхайчдыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах явдал юм.

Судалгааны явцад уурхайчид төр, хууль сахиулах байгууллагуудын шалгалт, мөрдлөг, хорих цагдахаас эмээж мэдээллээ бүрэн хуваалцахгүй хаалттай байх хандлагатай байв. Засгийн газар бичил уурхайг албажуулах талаар барьж байгаа хариуцлага тооцох, торгох шийтгэх арга барилаа өөрчлөх, мөн ядуурлыг шийдвэрлэх арга, мөнгөн усны хэрэглээ нь илүү өргөн хүрээтэй асуудлын шинж тэмдэг гэж авч үзэн хөгжилд суурилсан хандлагаар асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй болов уу.

Зөвшөөрөл авахад учирч байгаа саад бэрхшээлийг арилгах

Юуны өмнө бичил уурхайн олборлолт албан ёсоор явуулж болох газрын хүртээмжийг авч үзэх нь албажуулалтын үйл явцад ихээхэн түлхэц болж өгөх ёстой. Албан ёсны олборлолтын газар байхгүй нь хууль бус олборлолт нэмэгдэж байгаагийн хамгийн том шалтгаан болж байна. Түүнчлэн, Засгийн газар ашигт малтмалын төрөл, олборлолтын арга, уул уурхайн мөчлөгийн талаар бичил уурхайн журманд заасан тодорхой заалтуудыг эргэн харж, шийдвэрлэх шаардлагатай байгаа бөгөөд энэ нь бичил уурхайг албажуулах хүчин чармайлтад саад болж, хууль тогтоомжийг зөрчин гажуудуулж байгаа асуудлыг шийдэхэд туслах болно.

Хоёрдугаарт, Засгийн газар олборлолтын гэрээний хүрээнд нөхөн сэргээлт хийх тодорхой талбай, нөхөн сэргээлтийн арга, цаг хугацаа, түүний дотор үнэлгээг хэрхэн хийх, ирээдүйн аюулгүй байдлын арга хэмжээг тодорхой зааж өгвөл зохино.

Гэрээ байгуулах, түүний хугацааг сунгах баталгаатай үндэслэл бий болгох

Гэрээний нөхцлүүд болон гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олборлолтын гэрээг сунгахдаа уул уурхайн үйл ажиллагааны тогтвортой байдлыг харгалзан үзэх шаардлагатай. Талбайн дүгнэлт удаашрах, олборлолтын гэрээний хугацааг богино хийх зэрэг байдлыг багасгаснаар хариуцлагатай, тогтвортой үйл ажиллагаа руу шилжихэд дөхөм болох ба шаардлагатай сайжруулалт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх, түүнд оруулсан санхүүжилтийн үр өгөөжийг бий болгох боломжтой.

Одоогийн байдлаар олборлолтын газрын дүгнэлт гараагүй, гэрээний хугацаа дуусч, сунгалт хийгдээгүйн улмаас бичил уурхайчид албан бус статус руу орох, дараа нь хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээхэд тулж байна. Энэ нь бичил уурхай эрхлэхээр гаргасан хүсэлтийг шийдвэрлэх явц удаан, хугацаа хойшлогдоход хүргэж байгаа шалтгаан, хүнд суртал, дамжлагыг аль болох багасгах замаар зөвшөөрлийн процессыг хялбарчлах шаардлагатай байгааг харуулж байна.

Уурхайчдын итгэлийг сэргээх

Уурхайчид ял, шийтгэл хүртэхээс айж улмаар хамтран ажиллах сонирхолгүй байгаа тул Засгийн газраас Үндэсний хөтөлбөр болон бусад төсөл үйл ажиллагааг хэрэгжилтэнд тэднийг татан оролцуулахын тулд харилцан итгэлцэл бий болгох шаардлагатай. Үүний нэг хэлбэр нь мөнгөн усаа сайн дураар хураалгахад ямар нэг хөнгөлөлт, хариуцлага тооцохгүй байх хугацаа тогтоож болох юм. Иймэрхүү боломжийг олгохдоо бичил уурхайчдыг албажуулах, зохион байгуулалтад оруулах ажлыг хамт хийх хэрэгтэй.

9.1.2 Нийгмийн үйлчилгээ

Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг хангах, сайжруулах

Судалгаагаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж нь уурхайчдын хувьд гол асуудал болж байна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, уурхайчдад тулгамдаж буй эрүүл мэндийн асуудлууд болон мэргэжлээс шалтгаалсан архаг өвчлөлийг тодорхойлохын тулд Засгийн газраас эрүүл мэндийн үзлэгийг тогтмол хугацаанд хийх, явуулын эмнэлэг, эсвэл телемедициний буюу зайнаас эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зэрэг төрөл бүрийн шийдлүүдийг авч хэлэлцэх ёстой. Эрүүл мэндийн үйлчилгээний энэхүү арга хэлбэрүүд Монгол Улсын бусад алслагдсан бүс нутгуудын ард иргэдийн дунд аль хэдийн туршигдан хэрэгжиж байна (ДЭМБ, 2019 он). Уул уурхайн (ТББ, нөхөрлөл, холбоо) болон төрийн байгууллагууд, бусад оролцогч талууд хамтран бичил уурхайчдад эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах хэрэгцээ шаардлага, мэргэжлийн өвчлөлөөс үүдэлтэй тэдний онцлог хэрэгцээг сурталчлах, түүнчлэн уурхайчдыг одоо хэрэгжүүлж байгаа олон нийтийг хамарсан эрүүл мэндийн арга хэмжээнүүдэд хамруулах, шаардлагатай тохиолдолд бусад хувилбаруудыг судалж үзэх нь зүйтэй.

Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд нэг чухал анхаарч үзэх асуудал нь уурхайчид эрүүл мэндийн байгууллагад очсоноор өөрсдийн мэдээллээ өгч, хуулийн хариуцлагад татагдаж болзошгүй гэсэн айдас болгоомжлолыг бууруулах явдал юм. Энэ талаар дээр дурдсан “Уурхайчдын итгэлийг сэргээх” хэсгээс үзнэ үү.

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хамрах хүрээг тэлэх

Судалгааны дүнгээс харахад бичил уурхайчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах хүрээг тэлэх шаардлагатай байна. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал нь болзошгүй аюул, ослын үед санхүүгийн хамгаалалт болох учраас орон нутгийн засаг захиргаанаас уурхайчдад мэдээлэл, мэдлэг олгох, тохиромжтой даатгалын бодлогын багцыг судаж үзэх, тухайлбал ихэнх уурхайчдын хөдөлмөр эрхлэлтийн улирлын шинж чанартай онцлогийг харгалзан үзэх хэрэгтэй юм. Судалгаанд оролцсон орон нутгийн ажилтны мэдээлснээр бичил уурхайчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалыг сурталчлах кампанит ажил зохион байгуулсан нь тодорхой эерэг үр дүнд хүрсэн байна.

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын талаар өгсөн сөнөл, зөвлөмжөөс гадна хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах боломж хомс байгааг судалгаанд оролцогчид тэмдэглэсэн бөгөөд ялангуяа уурхайчин эцэг эхчүүд уурхайн талбайд ажиллахаар түр хугацаагаар шилжин суурьших шаардлагатай болдог. Уурхайчин эмэгтэйчүүд ажил хийхээр уурхайн талбай руу явах үедээ хүүхдүүдээ ихэнхдээ гэр бүлийн гишүүдийн асрамжинд үлдээдэг. Бичил уурхайчдын хөдөлмөрийн энэхүү тусгай нөхцлийг харгалзан хүүхэд харах үйлчилгээ бий болгох хэрэгцээ шаардлага эсвэл нэг өрхийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд ажлын уян хатан зохицуулалтын хуваарь хийх шаардлагын талаар нэмэлт судалгаа хийх нь зүйтэй байна.

Мэдлэг нэмэгдүүлэх

Орон нутгийн албан тушаалтнууд, нөхөрлөлийн ахлагч нартай хамтран Засгийн газрын нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд хамрагдах боломж, ашиг тусын талаар уурхайчдын мэдлэгийг дээшлүүлэх, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулбал зохино. Энэ нь зөвхөн эрүүл мэндийн хөтөлбөрт хамрагдах талаар мэдлэг түгээхээс гадна уурхайчид силикоз, булчингийн тогтолцооны өвчин зэрэг мэргэжлээс шалтгаалах өвчин, бөөрний болон элэгний өвчлөл, чихрийн шижин зэрэг архаг өвчнийг оношлох эрүүл мэндийн байнгын үзлэгт хамрагдахын ач холбогдлын талаарх мэдлэгээ дээшлүүлж, ашиг тусыг нь хүртэхэд хувь нэмэр оруулна.

9.1.3 Олборлолт, баяжуулалтын туршлага

Зөвшөөрлийн шаардлагуудыг боломж, хүчин чадалд нийцүүлэх

Судалгаанд хамруулсан ихэнх баяжуулах цехүүд (байгууламжууд)-ийн аюулгүй байдал, байгаль орчны менежментийн стандартын түвшин доогуур, зөвшөөрөлгүй байснаас гадна цехийн эзэдтэй шударга татварын тогтолцооны

талаар хамтран ажиллах, холбогдох зохицуулалтууд учир дутагдалтай болох нь харагдсан. Зөвхөн үйл ажиллагааны зөвшөөрлийн зардал болох 100 сая төгрөг нь энэ үйл ажиллагааг эрхэлж эхлэхэд саад тотгор болж эхэлдэг учир цехийн эздийг хууль бус үйл ажиллагаа явуулах эрсдэл рүү улам бүр татан оруулдаг байна. Салбарын бодит байдлыг харгалзан үзэж АБҮ-д тусгайлан боловсруулсан “Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагааны журам” нь уурхайчдыг айж эмээлгүйгээр Засгийн газартай хамтарч ажиллахыг дэмжсэн, тогтвортой, ил тод, бизнесийн системийг бий болгоно.

Мөнгөн үсгүй баяжуулах технологийг түгээх

Монгол Улсад алт баяжуулах цехүүд хоорондоо ижил төстэй байдаг. Хориг (шлюз) болон баяжуулах ширээнээс бүрдэх энгийн гравитацийн технологийг хуучирсан гэж үзэх боломжгүй боловч химийн бодис ашигладаг байгууламжуудтай харьцуулахад эдгээр алт ялган авах системүүдийн өрсөлдөх чадвар нь ихээхэн хязгаарлагдмал байдаг. Одоогийн системийг уусган баяжуулах/эсвэл хөвүүлэн баяжуулах технологитой хослуулан хэрэглэснээр ихээхэн сайжруулж, бүр орчин үеийн болгож болно. Энгийн гравитацийн технологиор ерөнхийдөө том ширхэглэлтэй алтыг л барих боломжтой байдаг бөгөөд нийт алтны 30-с дээш хувь нь баяжуулалтын явцад хаягддаг.

Алтыг ялгаж авахад химийн бодис ашиглахыг хориглосон улсуудад хориглосон химийн бодисыг хууль бусаар ашиглах, түгээх, бохирдуулах асуудлыг шийдвэрлэх шаардлага үүсдэг. Төрийн тодорхой зохицуулалтгүй бол бичил уурхайчид алт барилтыг сайжруулах боломжтой аливаа арга хэлбэрийг хэрэглэсээр байх болно. Энэ нөхцөл байдлыг давж гарахын тулд бичил уурхайн албажуулалтад суурилсан химийн бодисын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах оновчтой тактик хэрэгтэй юм. Тиймээс Монгол Улс химийн бодисын хэрэглээ, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулахад анхаарал хандуулах хэрэгтэй.

Хаягдалд үлдсэн алтны ашгийг шударгаар хуваарилах

Монгол Улсад бичил уурхайн алтны хүдэр баяжуулалт нь үндсэндээ хоёр үе шаттай явагдаж буй бөгөөд бичил уурхайчид эхний буюу цианидын боловсруулалт ашиглан баяжуулалтын хаягдлыг боловсруулахаас өмнөх шатанд оролцдог. Бичил уурхайчдад өөрсдөө хүдрээ баяжуулах боломж хязгаарлагдмал, үйлдвэр байгуулахад томоохон саад бэрхшээлтэй тулгардаг тул ихэвчлэн баяжуулах цехийн эздийн санал болгосон таагүй нөхцлийг хүлээн авснаар уурхайчид хохирч үлддэг. Харин цехийн эзэд баяжуулалтын хаягдлаа цианидаар боловсруулах үйлдвэрт зарахдаа алт барилтын түвшин бага байх хэрээр их ашиг олдог. Уурхайчид ба баяжуулагчдын хоорондох ашгийг илүү шударгаар хуваарилах нь баялгийн жигд хуваарилалтын зарчмыг хангаж, уурхайчдад өөрсдийн олборлох, баяжуулах дэд бүтцэд хөрөнгө оруулах капиталтай болох боломж олгох юм.

Ашигт малтмалын баяжуулалтын сургалтад хамрагдах боломж

Судалгааны үр дүн уурхайчдын алт боловсруулах мэдлэгийн түвшин доогуур байгаагаас уурхайчдын зохих ёсоор баяжуулалт хийх, чанарын хяналт тавих

чадавх хангалтгүй байгааг харуулж байна. Хэдийгээр баяжуулах үйлдвэрийн ажилтнууд баяжуулах цехийн үр ашгийг дээшлүүлэхэд түлхэц болох мэдлэгтэй байж болох ч ашигт малтмалын баяжуулалтын талаарх мэдлэгээ хэрэгжүүлэхэд ямар нэг урамшуулал байхгүй, мөн энэ нь цианидаар баяжуулах үйлдвэрт зарах хаягдалд хадгалагдаж үлдэх алтны хэмжээг бууруулдаг тул цехийн үйл ажиллагааг сайжруулах талаар ажилладаггүй байна.

9.1.4 Байгаль орчны хамгаалал

Нөхөн сэргээх арга хэлбэрийг төрөлжүүлж, хяналтыг сайжруулах

Бичил уурхайн байгууллагуудад техникийн нөхөн сэргээлтээс гадна биологийн нөхөн сэргээлт хийх арга хэмжээ авахыг зөвлөж байна. Нөхөн сэргээлтийн нарийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, арга хэмжээг дагаж мөрдөхийн тулд бичил уурхайн нөхөрлөлүүд болон орон нутгийн засаг захиргааны хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. Нөхөн сэргээх үйл явцад олон янзын арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Бичил уурхайн нөхөрлөлүүд нөхөн сэргээлтийн ажлыг цаг тухайд нь хийх, нөхөн сэргээлтийн зардлаа гаргаж авахад дэмжлэг үзүүлэхийн тулд нөхөн сэргээлтийн дундын санд байршуулсан хөрөнгийг буцааж авах үйл явцыг хялбаршуулж өгөх хэрэгтэй.

Цаашдын судалгаанууд улс орон даяар бичил уурхайн нөхөрлөл тус бүрээр эвдэрсэн, нөхөн сэргээсэн газрын талаар илүү их мэдээлэл цуглуулах, баяжуулах цехүүдийн усны эх үүсвэр болон АБУ дахь байгаль орчны бусад асуудлууд дээр анхаарал хандуулах шаардлагатай. Энэхүү мэдээллийн сан нь АБУ-н үйл ажиллагааны урт хугацаандаа байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хянах, мөн хамгийн их анхаарал хандуулах шаардлагатай буй газруудыг тодорхойлох чухал урьдчилсан нөхцөл болно.

Хог хаягдлын менежментийг сайжруулах

Бичил уурхайн нөхөрлөлүүдийг байгальд ээлтэй хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд сургах, хөхиүлэн дэмжих хэрэгтэй. Уурхайн үйл ажиллагаа нь батерей, хөдөлгүүрийн тос, химийн урвалж зэрэг аливаа химийн болон аюултай хог хаягдлыг аюулгүй зайлуулах хувилбараар хангагдсан байх ёстой. Хог хаягдлын менежментийн зүй зохистой үйл ажиллагааны ач холбогдлыг бичил уурхайчдад ойлгуулахад зориулсан сургалтын хөтөлбөрт тусгаж өгөх хэрэгтэй (Чадавх бэхжүүлэх хэсгийг үзнэ үү).

9.1.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Бичил уурхайчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын хэрэгжилтийг сайжруулахын тулд дараах механизмыг бэхжүүлэх шаардлагатай байна.

ХАБЭА-н сургалтыг сайжруулах

Бичил уурхайчид энэ салбарт түгээмэл тохиолддог ажлын байран дээрх осол, уурхайн босоо ам нурах зэрэг илт эрсдэлээс эхлээд дуу шуугиан, химийн хордлого гэх мэт үл мэдэгдэх эрсдлүүдийг таних, илрүүлэх сургалтад тогтмол

хамрагдаж байх ёстой. Энэхүү мэдлэг нь ХАБЭА-н стандартыг дагаж мөрдөх нь чухал гэдгийг ойлгуулахад тус болно. Албан бус болон хууль бус бүлгүүд сургалтад хамрагдах боломжгүй, аюулгүй ажиллагааны дүрмийг дагаж мөрдөх чадавх муу байгаа тул эдгээр бүлгийг ХАБЭА-н сургалтад хамруулах нь чухал юм.

ХАБЭА-н сургалтаар тодорхой мэдлэг, арга барил, хэвшлийг суулгахаас гадна төлөвлөлтийн асуудлыг хамардаг байх ёстой. Үүнд ХАБЭА-н төлөвлөгөөний ач холбогдол, чиг үүрэг, ХАБЭА-н ажилтны үүрэг, хариуцлагын талаар сэдвүүд орно. ХАБЭА-н хариуцсан ажилтнууд мэдлэгээ тогтмол дээшлүүлэх боломжоор хангагдсан байх хэрэгтэй.

Мөн, уурхайчдын нөхцөл, олборлолтын талбай дахь эрүүл ахуй, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх байдал зэргээс шалтгаалан бичил уурхайчдын эрүүл мэнд, амьдралын хэв маяг, амьжиргааг сайжруулахад чиглэсэн сургалтуудыг явуулах хэрэгтэй.

Уул уурхай эсвэл ХАБЭА-н асуудал хариуцсан орон нутгийн засаг захиргааны ажилтнууд уурхайчдад хууль эрх зүйн орчин, ХАБЭА-н чадавхыг бэхжүүлэх сургалт явуулах үүрэгтэй. Гэсэн хэдий ч эдгээр орон нутгийн албан хаагчдын ХАБЭА-н талаарх мэдлэг хангалтгүй эсвэл түвшин нь өөр өөр байна. Тиймээс тэд чиг үүргээ биелүүлэхийн тулд Бичил уурхайн журам, аюулгүй ажиллагааны дүрмийн талаар мэдээлэлтэй байх ёстой.

Мэдээлэл тайлагнах системийг боловсронгуй болгох

Хэдийгээр орон нутгийн засаг захиргаа БУ-н талаарх мэдээлийн сан бүрдүүлэх, БУ-н талаарх мэдээлийн тайланг гарсан ослын мэдээтэй хамт АМГТГ-т хүргүүлэх үүрэгтэй боловч, орон нутгийн түвшинд БУ-н ХАБЭА-н талаарх мэдээллүүд илт дутагдалтай байдаг. Ослыг орон нутагт бүртгэдэг боловч одоогоор бичил уурхайн тодорхой мэдээллийг үндэсний хэмжээнд зохион байгуулалттай тайлагнах, бүртгэх систем одоогоор байхгүй байна. Нэмж дурдахад, ихэвчлэн ХАБЭА-н эрсдэл өндөртэй хууль бус болон албан бус ашигт малтмал олборлогчдын бүлгүүдийн талаар тайлагнах бэрхшээлтэй хэвээр байсаар байна. Мэдээллийн чанар нь голчлон орон нутгийн оролцогч талуудын хамтын ажиллагаанд тулгуурладаг тул холбогдох төрийн байгууллагууд мэдээллээ шинэчилж, хүртээмжтэй байлгахын тулд уялдаа холбоогоо сайжруулах хэрэгтэй. Тухайлбал, төрийн захиргааны төв байгууллагаас мэдээлэл цуглуулах ажлыг стандартчлах зорилгоор тайлангийн загвар гаргаж өгч болох бөгөөд аймаг, сумдын оролцогч талууд бичил уурхайчдад хүрч чадахуйц системийг орон нутагт хэрэгжүүлэх ёстой.

9.1.6 Мөнгөн усны хэрэглээг бууруулах

АБУ-н салбарт мөнгөн усны хэрэглээг бууруулах, эцэслэн арилгах, цаашдын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх ажил нь зөвхөн үндэсний түвшний хууль эрх зүйн арга хэмжээ авахаас эхлээд орон нутгийн түвшинд бичил уурхайн байгууллагуудын мөнгөн усыг орлуулах өөр хувилбарын хүртээмжийг сайжруулах хүртэл төрөл бүрийн арга хэмжээг хослуулан авч хэрэгжүүлснээр үр дүнд хүрч чадна. Энэхүү судалгаанд үндэслэн дараах ажлуудыг хийхийг зөвлөж байна.

Алтны албан ёсны худалдааг сайжруулах

Эрх зүйн зохицуулалтууд нь мөнгөн усны тухай голчлон анхаарсан байгаа хэдий ч мөнгөн ус нь уурхайчдын өмнө тулгараад байгаа ядуурал, ажилгүйдэлтэй холбоотой илүү өргөн хүрээний асуудлын шинж тэмдэг юм гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Алтны худалдааны тухай бүлэгт бичил уурхайчдын эрх хэрхэн зөрчигдөж, гарцаагүй нөхцөлд ордог талаар тайлбарласан болно. Алтны бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээг шийдвэрлэхэд чиглэсэн чухал алхам бол албан ёсны зах зээл дээрх тоглогчдод алтаа худалдахыг хөхиүлэн дэмжиж, сурталчлах явдал юм. Уурхайчдад урамшуулал олгох, сайжруулсан нөхцлөөр зөвшөөрөл олгох, тавигдах шаардлагыг оновчтой болгох замаар энэхүү худалдааг дэмжиж, идэвхжүүлэх нь газар дээр нь динамикийг ихээхэн өөрчилж, мөнгөн усгүй, тогтвортой бичил уурхай бий болгох замыг засах болно. Алтны худалдааны талаарх дэлгэрэнгүй зөвлөмжийг доороос үзнэ үү.

Өөр боломжуудыг бий болгох

Бичил уурхайчдад алт барилтын түвшинг өндөр болгох боломжит хувилбаруудаас сонгох боломж олгохын тулд мөнгөн усгүй баяжуулалтын системийг бий болгох санхүүгийн болон техникийн шийдлүүдийг эрэлхийлэх хэрэгтэй. Гэсэн хэдий ч шинэ технологийг уурхайчид, орон нутгийн засаг захиргаа, олон нийт ойлгож, хүлээн зөвшөөрч, алт барилтын хэмжээ илүү сайн гэдгийг тодорхой харуулах хэрэгтэй.

Мэдээлэл цуглуулалт, тооцооллыг сайжруулах

Байгаль орчны үнэлгээнд (хөрс, ус, тоног төхөөрөмжийн болон ууршилтын үеийн агаар дахь мөнгөн усны бохирдол) ашигладаг өгөгдлийг гурвалжлах арга нь тооцооллыг бодож гаргахад илүү найдвартай тоон өгөгдлийг нотолж болох юм. Тооцооллын нарийвчлалыг сайжруулах, алдааны магадлалын түвшинг бууруулахын тулд тооллогын баг тодорхой хувьсагчдыг шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэх хэрэгтэй. Энэ нь ялангуяа хүдрийн агуулга (тухайн талбайн хүдрийн дундаж агууламж, янз бүрийн цэгээс авсан хэмжилтээр үнэлэгдсэн) болон өөр өөр баяжуулалтын системийн алт барилтын түвшинд хамаарна. Мөнгөн усны талаарх мэдээлэл цуглуулах, судалгаа, тооцоолол хийхэд үндэсний болон орон нутгийн түвшинд чадавх бэхжүүлэх нь чухал юм.

Мэдлэг бий болгох

Орон нутгийн засаг захиргааны зүгээс бичил уурхайчдад чиглэсэн мөнгөн усны талаарх мэдээлэл, сурталчилгааны ажлыг идэвхтэй хийдэггүй. Нөгөө талаар төрийн болон бусад оролцогч талууд энэ чиглэлийн сургалт, мэдээлэл авах ёстой. Мөнгөн усны эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл нь нэлээд төвөгтэй асуудал тул сайн мессэж түгээх нь ухуулан таниулах ажлыг амжилттай хэрэгжүүлэх гол түлхүүр юм. Түүнчлэн, мөнгөн усгүй төрөл бүрийн шийдлийн талаарх мэдээллийг шийдвэр гаргагчид болон уурхайчдад хүргэх хэрэгтэй.

9.1.7 Жендэр

Нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад зориулсан хүйсээр ангилсан мэдээлэл бий болгох

Судалгаагаар бичил уурхайн салбарын хэмжээнд хүйсээр ангилсан мэдээлэл хомс байгаа нь салбарын хэмжээнд жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, хяналт тавихад саад бэрхшээл болж байгааг харуулж байна. Тиймээс мэдээлэл нь жендэр, гэрлэлтийн байдал, хүүхдийн тоо, нас, байгууллагаар нь ангилах боломж бүхий мэдээллийн санг багтаасан байх ёстой. Энэ нь бичил уурхайчдад чиглэсэн нийгмийн хөтөлбөрүүд болон бусад дэмжлэг зорилтот бүлэгт хүрч байгаа эсэхийг нягтлах, мониторинг, үнэлгээ хийх ажилд дэмжлэг үзүүлэх болно.

Өнөөгийн хэрэгжиж буй бодлогыг сайжруулах

"Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2019-2026)"-ыг хэрэгжүүлэхийн тулд үндэсний судлаачид, МБУНДХ болон бусад оролцогч талууд бичил уурхайн салбарт жендэрийн зохих бодлогыг хэрэгжүүлэх стратегиудыг хэлэлцэж, санал болгох хэрэгтэй. Энэхүү стратеги нь эмэгтэйчүүдийн ажил- амьдралын тэнцвэрт байдлыг хангахад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ эмэгтэйчүүдийг тухайн салбарт удирдах албан тушаал хаших нөхцлийг бэхжүүлэх чиглэлд байвал зохино. Алтны бичил уурхайд эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр Монголын хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш байдлын ялгааг арилгахад чухал хувь нэмэр оруулах юм (Khan & Aslam, 2013 он). Мөн түүнчлэн орон нутгийн түвшинд төрийн албан хаагчдыг жендэр, жендэрийн бодлого, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн чиглэлээр илүү чадавхжуулах шаардлагатай байна.

Хүний эрхийн сургалтыг салбарын хэмжээнд зохион байгуулах

Чадавх бэхжүүлэх хэсэгт дурдсан зөвлөмжүүдээс гадна эмэгтэй, эрэгтэй уурхайчид болон удирдагчдын жендэрийн ойлголтыг дээшлүүлэх үүднээс жендэрийн шинж төрх, нийгэмд жендэрийн үүрэг роль хэрхэн бий болдог болон жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг ойлголтуудыг агуулсан жендэр ба хүний эрхийн талаар сургалт явуулах шаардлагатай байна. Энэ сургалт нь мөн жендэрт суурилсан хүчирхийллийн төрлүүд ба түүнийг бууруулах стратегийг хамарсан жендэрт суурилсан хүчирхийлэл, хүний эрхийн талаарх сургалт байх шаардлагатай бөгөөд, үүнд эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, олон нийтийн дэмжлэг, орон нутгийн удирдлагуудын оролцоо зэрэг багтана.

Эмэгтэйчүүдийн байгууллага байгуулах, түүнийг дэмжих

Зорилтот бус нутгуудад эмэгтэйчүүдийн байгууллага байхгүй байсан нь уурхайчин эмэгтэйчүүдийн зохион байгуулалтын түвшин доогуур байгааг харуулж байна. Эдгээр байгууллагууд нь эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх боломжийг бий болгох, цаашид чадавх бий болгох чухал институцийн нөхцлийг бүрдүүлж өгч чадна. Мөн эдгээр эмэгтэйчүүдийн байгууллагууд сургалтад хамрагдаж орон нутгийн жендэрийн асуудал хариуцаж ажиллах төлөөлөгчийг сонгож болно. Эдгээр төлөөлөгчид нь тухайлбал, олборлолтын талбай дахь

жендэрийн мэдрэмжтэй бодлогын хэрэгжилтийг хянах, зөрчлийн талаар мэдээлэх, эмэгтэйчүүдийн санаа бодлыг илэрхийлэх, эмэгтэйчүүдийн хэрэгцээг сурталчлах боломжтой юм.

Түүнчлэн, олборлолтын талбайн дэд бүтцийн дутмаг байдал нь эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд бэрхшээл учруулдаг. Иймд олборлолтын талбайд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бие засах газар, шүршүүрт зориулсан жендэрийн мэдрэмжтэй зохицуулалт хийх, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн онцгой хэрэгцээг тусгасан жендэрийн мэдрэмжтэй орон зайг бий болгоход дэмжлэг үзүүлэх нь ажлын байрны нөхцөл байдлыг сайжруулах болно.

9.1.8 Алтны худалдаа

Аймаг, сумын алтны арилжаа эрхлэгчдэд анхаарал хандуулах

Судалгааны бүс нутгуудад нэг удаагийн худалдаагаар борлуулагдаж буй алтны дундаж хэмжээ 50 граммаас бага байна. Гэвч Монголбанканд борлуулах алтыг сорьц тогтоолгоход тавигддаг хамгийн бага алтны хэмжээний шаардлага 50 грамм юм. Энэхүү сорьцын шинжилгээний хамгийн бага хэмжээ нь Монголбанканд алтаа шууд борлуулах боломжийг бичил уурхайчдын хувьд хязгаарлаж байгаа гол бэрхшээл хэвээр байна. Бичил уурхайчдын алтыг бүсчилсэн байдлаар нэгтгэж, Монголбанканд тушаахад сум, аймгийн алтны арилжаа эрхлэгчдийг бичил уурхайн алтны гол нийлүүлэгч болгон ашиглах стратегийг дэмжих замаар удирдаж болох юм. Энэ нь Монголбанк алтны худалдааг албажуулах зорилгоор үйл ажиллагаагаа эдгээр алтны арилжаалагч нарт төвлөрүүлэх нь чухал болохыг харуулж байна. Алтны арилжаа эрхлэгчдэд тусгай зөвшөөрөл олгох шинэ журам гарсан нь нааштай алхам болсон. Энэ нь гол сайжруулалтыг хийх боломжийг нээж өгсөн бөгөөд цаашид төсөл нь энэ боломжийг ашиглахын тулд Засгийн газартай нягт хамтран ажиллаж, ялангуяа бусад улс орнуудад алтны худалдааг албажуулахад гарсан сургамж дээр тулгуурлан зөвлөмж өгч, ажиллах шаардлагатай.

Монголбанк магадлан шинжилгээг хэрэгжүүлэх

Монголбанк худалдан авсан алтныхаа магадлан шинжилгээг зохих ёсоор хийх хэрэгтэй. Энэ нь Монгол Улсын албан ёсны алтны худалдааны бодлого, үйл ажиллагаанд чиглэсэн шинэчлэлийн нэн тэргүүний зорилт байх ёстой. Хариуцлагатай АБУ-н практик туршлагыг дагаж мөрдөхийн тулд олон улсын магадлан шинжилгээний стандартыг баталж, хэрэгжүүлэх нь шийдлүүдийн нэг байж болох юм. Монгол Улсын Засгийн газар өөрсдийн сургамжаасаа суралцаж, олж авсан туршлагаа сайжруулахын тулд Монгол Улсад хэдийн бий болсон сайн туршлага дээр тулгуурлах боломжтой. Монголбанк алтны гарал үүслийн магадлан шинжилгээний удирдамжийг хэрэгжүүлэх нь алтанд ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хураах ажилд дэмжлэг үзүүлэх бөгөөд үүний үр дүнд бий болох эдийн засгийн боломжит үр ашгийн талаар судалгаа хийхийг бид зөвлөж байна. Албан ёсны алтны нийлүүлэлтийн сүлжээнд бичил уурхайн оролцоог нэмэгдүүлэхийн тулд Төсөл нь алтны худалдааны бодлого, эрх зүй болон бусад асуудлуудыг сайжруулахад Монголбанк болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах болно.

Алтны арилжаа эрхлэгчдэд олгох тусгай зөвшөөрлийг өргөжүүлэх

Алтны худалдаа эрхлэгчдийг сургах, алтны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах болон Монголбанканд алт борлуулахыг дэмжих стратеги боловсруулж, бичил уурхайн алтны нийлүүлэлтийн дийлэнх хувийг төвлөрүүлэх нь анхаарах чухал зүйл болохыг зөвлөж байна.

Алтны албан ёсны худалдааг дэмжих

Бичил уурхайчдад алтаа албан ёсоор худалдах нь албан бусаар зарахаас илүү олон шат дамжлагатай байна. Үүнийг даван туулах гол хөшүүрэг бол алтаа албан ёсоор худалдахыг зохих ёсоор урамшуулах явдал бөгөөд эсрэгээрээ хууль бус алтны худалдааг зогсоох, хориглох, хяналтад авах зэргээр таслан зогсоох явдал юм. Түүнчлэн захиргааны ажил хариуцдаг уурхайчид алт худалдах процессын шат дамжлагыг ойлгохын тулд сургалтад хамрагдах ёстой. Хэрэв албан бус зах зээл илүү хүртээмжтэй бөгөөд алтны албан бус худалдааг үр дүнтэй таслан зогсоох хөшүүрэг байхгүй бол Монголбанк энэ зах зээлтэй өрсөлдөхөд бэрхшээлтэй тулгарч, үндэсний хэмжээнд бичил уурхайн алтны нийлүүлэлтийн ихээхэн хэсгийг алдсаар байх болно.

Нэг цэгийн үйлчилгээг нэмэгдүүлэх

Алтны сорьц тогтоох үйлчилгээний төвлөрлийг сааруулахын тулд Үнэт металлын сорьцын хяналтын газар (ҮМСХГ) -аас бусад оролцогч талуудад сорьц тогтоох үйлчилгээг хувьчлах арга замыг эрэлхийлэх, алтны агуулгыг тодорхойлох шинжилгээний өөр арга замыг албан ёсоор хүлээн зөвшөөрч, нэвтрүүлэхийг зөвлөж байна. Шинээр боловсруулсан Эрдэнэсийн сангийн тухай хуулийн төсөл нь хөдөө орон нутагт сорьц тогтоох үйлчилгээ, алт худалдах үйл явцын төвлөрлийг сааруулах, либералчлах арга хэлбэр болж болох юм.

Баяжуулах цехүүдэд анхаарал хандуулах

Эрх бүхий байгууллагууд яагаад баяжуулах үйлдвэрүүдийг зохицуулах болон Монголбанканд алтаа борлуулахад урамшуулал олгоход онцгой анхаарал хандуулах ёстойг уг тайланд тусгасан болно. Алтны худалдааг албажуулах талаар ямар нэг стратеги боловсруулахад баяжуулах үйлдвэр/ цехийн эздийг гол үүрэг гүйцэтгэх тоглогч гэж үзэж анхаарлаа төвлөрүүлэхийг бид зөвлөж байна. Баяжуулж байгаа хүдрийн магадлан шинжилгээг хийж олборлолтын газрын гарал үүслийг тогтоож, албан ёсоор алтаа зарж борлуулж байгаа баяжуулах үйлдвэрүүдийг зохицуулсан үр дүнтэй стратеги хэрэгжүүлэх нь зүйтэй. Энэ нь бусад олон орны хэрэгжүүлж буй алтны худалдааны эрх зүйн стратегитэй нийцэж байгаа бөгөөд тэдгээр улс оронд алтны худалдааг албажуулах, магадлан шинжилгээ хийх болон гарал үүслийг тогтооход үүрэг хүлээсэн, нийлүүлэлтийн сүлжээний гол тоглогчид болох экспортлогчид, баяжуулах үйлдвэрүүд, цэвэршүүлэгч байгууллагууд зэрэг талуудыг хариуцлагажуулах гол зорилготой ажилладаг. Баяжуулах цехүүд нь эдийн засгийн хувьд илүү боломж ихтэй, уурхайчидтай харьцуулахад алтны нийлүүлэлтийн сүлжээний харьцангуй их хувийг эзэлдэг тул дээрх бодлого, стратегийг хэрэгжүүлэх нөөц бололцоо өндөр байдаг.

Баяжуулах үйлдвэрүүдэд стандартын нийцлийг хариуцах ажилтныг томилох

planetGOLD төсөл нь албажуулалт, стандартын нийцлийг хариуцах ажилтныг мөнгөн үсгүй баяжуулах цехийн үндсэн ажилтны орон тоонд оруулж томилох боломжийг судлах бөгөөд ингэснээр эдгээр үйлчилгээг бүс нутгийн бичил уурхайчдад хүргэх боломжтой болно. Энэ нь албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд алтаа зарж борлуулах ажлыг бичил уурхайчдын хувьд хөнгөвчилж, урамшуулж болох юм. Цаашид planetGOLD төслийн түншүүдтэйгээ хамтран судлах бас нэг стратеги бол бүс нутгийн мөнгөн үсгүй баяжуулах үйлдвэрүүдийг нэг цэгийн худалдан авах төвийн загвартай нэгтгэх явдал юм.

Алтны худалдаатай холбоотой чадавхийг сайжруулах

Судалгаанд оролцогчдын олонх нь ялангуяа Алтай сумын уурхайчид хүдрээ сорьцолдоггүй эсвэл алт худалдахаасаа өмнө алтны үнийг шалгаж үздэггүй байв. Алтаа борлуулахаас өмнө хүдрийн агуулгыг сорьцлохын ашиг тусын талаарх сургалт, АБУ-н Мэдлэгийн төвийн платформоор дамжуулан мэдлэг олгох (ТБУТ-ийн БУ-Н мэдлэгийн төвтэй төстэй боловч тус мэдлэгийн төвийг судалгаанд оролцогчид бараг ашигладаггүй байсан тул илүү хүртээмж сайтай болгох), мөн Монголбанк болон алтны зах зээлийн үнийн онлайн эх үүсвэрийг шалгах нь худалдаачидтай үнэ тохиролцох чадварыг нэмэгдүүлэх боломжтой.

9.1.9 Санхүү, хөрөнгө оруулалт

Санхүүгийн салбарын оролцогч талуудад зориулан АБУ санхүүгийн мэдээллийг боловсруулах

Зөв хөрөнгө оруулалт, санхүүгийн хүртээмжтэй байдал нь хариуцлагатай бичил уурхайг төлөвшүүлэх, хөгжүүлэх хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэг юм. Тиймээс, санхүүгийн байгууллагууд болон боломжит хөрөнгө оруулагчдыг (өөрөөр хэлбэл нөлөө бүхий хөрөнгө оруулагчдыг) эрсдэл, жишээлбэл, давхардсан шаардлагууд, зөвшөөрлүүд гэх мэт, хөрөнгө оруулалтын өгөөжид нөлөөлөх хүчин зүйлүүд тухайлбал, үйлдвэр/цехийн хүчин чадал, нэвтрүүлэх чадвар, алт барилт, алтны нөөц зэрэг холбогдох мэдээллээр хангах нь чухал юм. Мөн гол мэдээлэлд албажуулалтын нөхцөл байдал, алтны нийлүүлэлтийн сүлжээ, энэ салбарын онцлог шинжүүдийг тусгавал зохино.

Хариуцлагатай БУ-н санхүүгийн хүртээмжийг сайжруулах

Засгийн газарт алтны албан ёсны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хариуцлагатай бичил уурхайг төлөвшүүлэх, санхүүгийн хүртээмжийг сайжруулахад чиглэсэн АБУ-н тусгай зээлийн хөтөлбөр боловсруулах замаар уурхайчид, худалдаа эрхлэгчдийг урамшуулах, санхүүгийн хүртээмжийг нь нэмэгдүүлэхийг зөвлөж байна. Бичил уурхайчидтай зээлийн албан бус сүлжээ байгуулсан алтны худалдаа эрхлэгчдийг энэ хөтөлбөрт хамруулах боломжийг судлах нь зүйтэй.

АБУ-н хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах

Бичил уурхайн төслүүдэд банкнаас зээл авахад хэцүү ч бусад улс оронд бичил уурхайн төсөлд хөрөнгө оруулалт татах гол арга замуудын нэг нь санхүүжилтийн хариуд хувьцаа зардаг байна. Гэсэн хэдий ч Монголын өнөөгийн БУ-н журам нь энэ салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломжийг хязгаарласан байдаг. Тиймээс бичил уурхайн холбогдох хууль тогтоомжийг эргэн харж, энэ салбарт хөрөнгө оруулалтыг татах суурийг бүрдүүлэх нь чухал юм.

9.1.10 Чадавх бэхжүүлэх

Бичил уурхайчдын чадавхи бэхжүүлэх, ялангуяа албажуулалт, уул уурхайн сайн туршлага, үүний дотор ХАБЭА-н болон байгаль орчны асуудлаар чадавх нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна. Үүнээс гадна дор дурдсан нэмэлт зөвлөмжүүдийг санал болгож байна:

Эмэгтэйчүүдийн сургалтыг нэмэгдүүлэх

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн мэдээлснээр сургалтад эмэгтэйчүүд илүү идэвхтэй оролцдог байна. Энэ нь эрэгтэйчүүдийг сургалтад түлхүү хамруулахад анхаарах хэрэгцээтэй болохыг харуулж байгаа ч санхүүжилт олох, албажуулалт, бизнес хөгжүүлэх зэрэг байгууллагын удирдлагад тодорхой үүрэг гүйцэтгэдэг эмэгтэйчүүдэд чиглэсэн чадавхи бэхжүүлэх үйл ажиллагааны явуулах нь тэднийг уул уурхайн үйл ажиллагааг сайжруулах, энэ салбарт жендэрийн тэгш байдлыг хангах өөрчлөлт авчрах чухал агент болгож чадна. Энэ нь эмэгтэйчүүдэд өндөр цалин авах, одоо байгаа орлогын зөрүүг арилгахад мөн туслах болно. Тиймээс туслах ажилчдаас эхлээд менежер, удирдагч эмэгтэйчүүдийг сургалтын хөтөлбөрт хамруулах нь чухал юм.

Жендэрийн болон хүний эрхийн сургалт явуулах

Хэдийгээр жендэр болон хүний эрхийн сургалтыг цөөн хэдэн уурхайчид санал болгосон боловч гүнзгийрүүлсэн ярилцлагаас уурхайчдын дунд жендэрийн талаарх мэдлэг хязгаарлагдмал байгаа нь харагдсан. Иймд уурхайчдыг жендэр, хүний эрхийн талаар зохих мэдлэгтэй болгох, тэдний эрхийг мэдэж хамгаалах нь чухал юм (жендэрийн талаархи зөвлөмжийг үзнэ үү).

Уурхайчдын хэрэгцээнд нийцүүлж сургалтыг шинэчлэх

Сургалт нь эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн (сургалтад хамрагдах сонирхол багатай хүмүүс) хагас өдрийн оролцоонд тулгуурласан, ажлын байрны сургалт хэлбэртэй байх бөгөөд АБУ-н үндсэн агуулгыг санал болгохоос гадна эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, залуу хүмүүсийн онцлог хэрэгцээнд үндэслэн тусгайлсан сургалтын агуулгыг санал болгох хэрэгтэй.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, одоо байгаа мэдлэгийн платформыг ашиглах

АБУ-н талаар ерөнхий, сүүлийн үеийн шинэ мэдээллээр уурхайчдыг хангах, түүнчлэн аль болох олон уурхайчдад хүрэхийн тулд Фэйсбүүк хуудас, группууд гэх зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглахыг зөвлөж байна. Бичил уурхайтай холбоотой мэдээ, газрын асуудал, санхүүжилт, сургалт болон бусад үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээхэд одоо байгаа платформ, сүлжээг ашиглахыг санал болгож байна. Мэдээлэл хэрхэн авах талаар судалгаанд оролцогчдын санал болгосон сонголтод үндэслэн олон нийтийн сүлжээ, телевиз зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулж мэдлэг, мэдээлэл хүргэх, мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх, аль болох олон оролцогчдод хүрэх нь чухал юм.

10. Ашигласан номын жагсаалт

А. Нямбаяр (2019 он). Д.Батмагнай: Хэдийгээр Говь-Алтай аймгийн нийт нутаг дэвсгэрийн 51% нь тусгай хамгаалалтад орсон ч энэ нь нэмэгдэх төлөвтэй. Монголиан Майнинг Журнал. <http://www.mongolianminingjournal.com/a/70536>

Алтны бичил уурхайн зөвлөл (2020 он). Алтны бичил уурхайд хэрэглэгддэг химийн бодисын хор хөнөөл. https://www.artisanalgold.org/wordpress/wp-content/uploads/2020/07/AGC_Health-brochure_Chemical-hazards-in-ASGM.pdf

Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо (2019 он). БУ-г албажуулах үйл явц. <http://sam.mn/infographics>

Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо (2020 он). <http://bichiluurhai.mn>

C-Change (2011он). Жендэрийн хэмжүүрийн товч тэмдэглэл. http://gender.careinternationalwikis.org/media/c-change_gender_scales_compendium.pdf

Бернийн Их сургуулийн Хөгжил, хүрээлэн буй орчны төв. (2015 он). ASM Formalisation Atlas and Map Mongolia. <https://boris.unibe.ch/66334/1/CODEP-ASM%20Final%20Report%202015-v7.pdf>

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ, 2020 он): Үнэт метал, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох, бүртгэлийн журам

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ, 2020 он): СЗХ-ны 2020 оны үйл ажиллагааны тайлан. http://www.frc.mn/a/3466?fbclid=IwAR1-PgmUG2FneKcakN2t4h9CynN69nxVk70wcDXVtDrZW8GnemC05Pv_3VkJ

Канад Улсын Гадаад хэргийн яам. Жендэрт суурилсан хүчирхийллийн мэдлэгийн төв. <https://cfc-swc.gc.ca/violence/knowledge-connaissance/index-en.html>

Говь-Алтай аймгийн Статистикийн хэлтэс (2020 он). Говь-Алтай аймгийн Статистикийн мэдээлэл-2019

Засгийн газрын 20 дугаар тогтоол, Алт-2 хөтөлбөр батлах тухай (2017 он). <https://www.legalinfo.mn/law/details/12431>

Засгийн газрын 151 дүгээр тогтоол, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай (2017 он). <https://www.legalinfo.mn/annex/details/7870?lawid=12681>

Засгийн газрын 355 дугаар тогтоол, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай (2019). <https://www.legalinfo.mn/law/details/14652>

Засгийн газрын 269 дүгээр тогтоол “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм (2015 он) <https://www.legalinfo.mn/annex/details/6863?lawid=11263>

Засгийн газрын 317 дугаар тогтоол: Алтны бичил уурхайгаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр (2019 он)
http://www.mercuryconvention.org/Portals/11/documents/NAP/Mongolia_NAP_June-2020.pdf

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (2016 он). *Хүртээмжтэй, ил тод, үр дүнтэй төрийн үйлчилгээний хүргэх нэг цэгийн үйлчилгээний төв*.
https://socialprotection-humanrights.org/wp-content/uploads/2016/04/Mongolia_One-stop-shop_2016.pdf

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (2016 он). Монголын тухай товч мэдээлэл: *Уул уурхай дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй*.
https://www.ilo.org/beijing/what-we-do/publications/WCMS_532829/lang-en/index.htm

Монгол Улсын Хараат бус судалгааны хүрээлэн (2014 он). *Монгол Улсын жендэрийн нөхцөл байдал - Бичиг баримтын судалгаа*.
<https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/en/SDC-Gender-%20Overview-Mongolia-%202014-EN.pdf>

Монгол Улсын Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM). 2021 он (удахгүй эцэслэгдэнэ). “Бичил уурхайн эрх зүйн орчны үнэлгээ” ба *Алтны бичил уурхай дахь хууль бус санхүүгийн урсгал. Судалгааг planetGOLD Монгол төсөлд зориулж гүйцэтгэсэн*.

А.Жигжидсүрэн, Т.Бямбаа, Э.Алтангэрэл, С.Батбаатар, Saw, Y. M., Kariya, T., Yamamoto, E., & Namajima, N. (2019). Монгол Улс дахь үнэ төлбөргүй анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж: Үйлчилгээний авах боломж, бэлэн байдлын үнэлгээ. 19(1), 129. <https://doi.org/10.1186/s12913-019-3932-5>

Khan, T. & Aslam, M. (2013 он). *Монгол Улс: Хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн ялгаа, бодлогын зөвлөмж*. Дэлхийн банк, Вашингтон муж
<https://openknowledge.worldbank.org/handle/10986/16500> License: CC BY-NC-ND 3.0 IGO

Ховд аймгийн Статистикийн хэлтэс (2020 он). Ховд аймгийн Статистикийн мэдээлэл -2019 он

Ашигт малтмал, газрын тосны газар. Ашигт малтмал, газрын тосны статистик (2019 он). <https://mrpam.gov.mn/public/pages/133/2019.12eng.pdf>

Ашигт малтмал, газрын тосны газар. Ашигт малтмал, газрын тосны статистик (2020). <https://mrpam.gov.mn/public/pages/165/2020.01.stat.report.eng.pdf>

Ашигт малтмал, газрын тосны газар (2015 он). “Алт 2025” суурь үнэлгээний тайлан. <https://bit.ly/2YtEhoS>

Ашигт малтмал, газрын тосны газар (2019 он). Монгол Улсын Алтны үйлдвэрлэл <https://www.mongolbank.mn/documents/ayan/gold/04.pdf>

Байгаль орчин, аялал жуулчлалын яам (2011 он). *Үндэсний мөнгөн усны тооллого*.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (2019 он) "Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого 2019-2026. http://portal.merit.mn/dataset/ca7a917c-a444-46a2-9dca-557e9f5e24a/resource/6c171949-6b74-4f12-b6a8-2552ef794e54/download/gender-policy_en.pdf

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан А/226 & А/188 тушаалаар батлагдсан Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал (2017). <https://asmhub.mn/uploads/files/baygal-orchny-nkhn-sergeeltiyn-argachlal.pdf>

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан А/115 ба А/123 тушаалаар батлагдсан Бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм. (2017 он). <https://www.legalinfo.mn/law/details/12790>

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаал No. А/205 Баяжуулах цехэд тавигдах шаардлага, үйл ажиллагааны журам (2019 он). <https://www.legalinfo.mn/law/details/14720>

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (2020 он). Уул уурхайн салбарын өнөөгийн байдал, илтгэл.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Швейцарын хөгжлийн агентлаг болон Азийн сан (2016 он). *Нөхөн сэргээлтийн аргачлал (FRM)*. <https://asiafoundation.org/wp-content/uploads/2016/04/Frugal-rehabilitation-methodology-FRM-eng.pdf>

Үндэсний статистикийн хороо (2020 он). Сарын дундаж цалин хөлс, *үндэсний, аймаг, жендэрээр*. https://www.1212.mn/Хүснэгтс.aspx?TBL_ID=DT_NSO_0400_021V1

Үндэсний статистикийн хороо & НҮБ Хүн амын сан. (2018 он). Тэгш байдлын төлөө аниргүйг эвдэхүй. *2017 Монгол Улс дахь жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх үндэсний судалгаа*. <https://mongolia.unfpa.org/sites/default/files/pub-pdf/2017%20National%20Study%20on%20Gender-based%20Violence%20in%20Mongolia.pdf>

Үндэсний статистикийн хороо (2020 он). Монгол Улсын нийгэм-эдийн засгийн байдал (2020 оны 11 сар). <https://www.en.nso.mn/content/343>

Үндэсний статистикийн хороо (2019 он). Засаг захиргаа, нутаг дэвсгэр. https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L01

Үндэсний статистикийн хороо (2015 он). Цаг ашиглалтын судалгаа. <http://web.nso.mn/nada/index.php/catalog/TUS/dataset>

Үндэсний статистикийн хороо (2020 он). Монгол Улсын нийгэм-эдийн засгийн байдал (2020 оны 11 сар). <https://www.en.nso.mn/content/343> (орлогын статистик)

Үндэсний статистикийн хороо (2013 он). Бичил уурхай нэгдсэн судалгаа, 2012 он <https://asmhub.mn/uploads/files/7-asm-survey-report-nso-eng-2012.pdf>

Үндэсний статистикийн хороо (2017 он). Бичил уурхай нэгдсэн судалгаа - 2016.
https://asmhub.mn/uploads/files/ASM_Survey_Report-2016_eng.pdf

Т.Навч, Ц. Болормаа, Б.Энхцэцэг, Д.Хүрэлмаа, & Б.Мөнхжаргал. (2006). Монгол Улс дахь албан бус алтны уурхай: *Төв аймгийн Борнуур, Заамар сумын суурь судалгаа*. Олон Улсын хөдөлмөрийн байгууллага.
https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/documents/publication/wcms_bk_pb_123_en.pdf

O'Neill & Telmer. (2017 он). Алтны бичил уурхай дахь туршлагыг баримтжуулах ба мөнгөн усны хэрэглээний тооцоолол. Женев, Швейцар Улс, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр. <https://www.artisanalgold.org/publications/products/>

Монгол Улсын Их Хурал: Хоршооны тухай хууль (1998 он).
<https://www.legalinfo.mn/law/details/528>

Монгол Улсын Их Хурал: Газрын тухай хууль (2002 он).
<https://www.legalinfo.mn/law/details/216>

Монгол Улсын Их Хурал: Ашигт малтмалын тухай хууль (2006 он).
<https://www.legalinfo.mn/law/details/63?lawid=63>

Монгол Улсын Их Хурал: Эрдэнэсийн сангийн тухай хуулийн төсөл (2020 он).
<http://forum.parliament.mn/projects/10780>

Монгол Улсын Их Хурал: Нөхөрлөлийн тухай хууль (1995 он).
<https://www.legalinfo.mn/law/details/419>

Монгол Улсын Их Хурал: Нийгмийн даатгалын тухай хууль (1994 он).
<https://www.legalinfo.mn/law/details/390>

planetGOLD Mongolia (2019 он): Төслийг хэрэгжүүлэх бүс нутгуудын үнэлгээний тайлан (төслийн дотоод бичиг баримт).

planetGOLD. (2020 он): Алтны бичил уурхай дахь санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэх нь. https://www.planetgold.org/sites/default/files/2020-08/Improving_Access_to_Formal_Finance_in_ASGM-planetGOLD_Issue_Brief.pdf

ПХА, Анагаахын шинжлэх ухааны их сургууль (АШУИС) болон ДЭМБ. (2014 он). Монгол Улсын бичил уурхайчид тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн түргэвчилсэн үнэлгээ. <https://asmhub.mn/uploads/files/20140927-rapid-health-assmt-report-eng-from-phc.pdf>

Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтэс (2020 он). Сэлэнгэ аймгийн Статистикийн мэдээлэл-2019

Г.Сонинбаяр (2019 он). Адлагдсан ч аминд орсон алт хөтөлбөрүүд.
<http://eagle.mn/r/55330>

Азийн сан (2013 он). Монгол Улсын бичил уурхай дахь жендэрийн судалгаа.
https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/en/ASM_Gender_2013_Mongolia.pdf

НҮББОХ (2012 он). Эквадор, Монгол, Перу, Танзани болон Уганда Улсын алтны бичил уурхайг албажуулах арга барилд хийсэн дүн шинжилгээ.
<https://wedocs.unep.org/handle/20.500.11822/31275>

НҮББОХ (2019 он). Даян дэлхийн мөнгөн усны үнэлгээ 2018.
<https://www.unep.org/resources/publication/global-mercury-assessment-2018>

НҮБАҮХБ, Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг олон улсын санаачлага, Левин Сорсес ба ДДБОС (2017). *Мөнгөний ул мөрөөр: Монгол Улсын бичил уурхайн алт болон санхүүгийн урсгалын түргэвчилсэн үнэлгээ.*
<https://www.levinsources.com/assets/pages/Follow-the-Money-Artisanal-and-Small-Scale-Gold-Mining-in-Mongolia-GEF.pdf>

НҮБАҮХБ (2017 он). *Ерөнхий тайлан: Монгол Улсад химийн зохистой менежментийг дэмжих замаар хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндийн мөнгөн усны өртөлийг буурулах нь.*
https://open.unido.org/api/documents/6215344/download/20170906_Synthesis%20Report.pdf

Дэлхийн банк (2003 он). Монгол Улсын уул уурхайн салбар.
<http://documents1.worldbank.org/curated/en/867261468323101510/pdf/332480ENGLISH01ng1sector1report1ENG.pdf>

Дэлхийн банк (2007 он). Монгол дахь хөгжлийн эх үүсвэрүүд, Улсын эдийн засгийн санамж бичиг. <https://openknowledge.worldbank.org/handle/10986/7806>

Дэлхийн банк (2018 он). *Нөхөн үржихүйн түвшин, нийт - Монгол Улс.*
<https://data.worldbank.org/indicator/SP.DYN.TFRT.IN?locations=MN>

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (2019 он). *Монгол Улс: Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг сайжруулах замаар эрүүл мэндийн түгээмэл үйлчилгээнд дэвшил авчрах нь* <https://www.who.int/mongolia/news/feature-stories/detail/mongolia-progress-towards-universal-health-coverage-through-strengthening-primary-health-care>

11. Хавсралтууд

Хавсралт А: Тоон судалгааны асуулга



АЛТНЫ БИЧИЛ УУРХАЙН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Сайн байна уу? Танд энэ өдрийн мэнд хүргэе. Судалгаа, шинжилгээний ЭС АЙ СИ ЭЙ ХХК-аас "Алтны бичил уурхайн салбарын нөхцөл байдлын" судалгааг явуулж байна. Энэхүү судалгааны зорилго нь planetGOLD Mongolia төслийн зорилтот аймаг, сумдад алтны бичил уурхай салбарын нийгэм, эдийн засаг, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчин, жэндэрийн нөхцөл байдал болон мөнгөн усны хэрэглээг судлах явдал юм. Энэхүү асуулгаар авсан мэдээллийн нууцыг Монгол Улсын "Статистикийн тухай" болон "Хувь хүний нууцын тухай" хуулийн дагуу чандлан хадгалж, зөвхөн судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглах болно.

Та судалгаанд оролцохыг зөвшөөрч байна уу?

Тийм ☐

Үгүй ☐

СУДААЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ

/бичих/ _____	Хариултыг тайлбарлах		Хариултыг бичих
1 2 3 4 5	Нэг хариулттай асуулт, зөвхөн нэг хариултыг сонгоно уу		Хариултыг бичих
A B C D E	Олон хариулттай асуулт, 1- 3 хүртэлх хариултыг сонгоно уу		Алгасах асуулт
	Эрэмбэлэх 1 - 10		

№	Асуулт	Хариулт	Тайлбар
1	Судлаачийн мэдээлэл	Ярилцлага авагчийн дугаар: Асуулгын дугаар:	
2	Таны ажилладаг алтны бичил уурхайн төрөл юу вэ?	Зөвхөн Үндсэн орд Зөвхөн Шороон орд Аль аль нь	Зөвхөн шороон орд бол судалгаа авахгүй болно.
3	Таны бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагаа хаана байршдаг вэ?	Баянгол (Сэлэнгэ) Мандал (Сэлэнгэ) Түнхэл (Сэлэнгэ) Есөнбулаг (Говь - Алтай) Алтай (Ховд)	
4	Таны ажиллаж буй уурхайн нэр нь юу вэ?		Одоогийн байдлаар ажиллахгүй байгаа бол өмнө нь ажиллаж байсан уурхай болон газрын талаар бичнэ

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

	Асуулт	Хариулт	Тайлбар
1	Таны хүйс:	Эмэгтэй Эрэгтэй	Ажиллалтаар бичнэ
2	Таны нас:		
3	Таны амьдардаг аймаг, сум/ баг:	Хот, Аймаг Сум, баг	Уурхайн үйл ажиллагаа эрхлэхээр өөр газраас ирсэн бол байнгын оршин суудаг, үндсэн хаягийг бичих.
4	Танай өрхийн сууцны төрөл:	Монгол гэр Амины орон сууц Оюутан сурагчдын дотуур байр Орон сууц Бусад/бичих/	
5	Гэрлэлтийн байдал:	Огт гэрлээгүй Гэрлэсэн Хамтран амьдардаг-батлуулаагүй Тусгаарласан тусдаа амьдардаг-баталгаагаа цуцлаагүй Цуцалсан Бэлэвсэн	
6	Ам бүлийн тоо:		
7	Таны боловсролын түвшин:	Боловсрол эзэмшээгүй Бага болон суурь (1- 4 анги) Бүрэн бус дунд (5-9 анги) Бүрэн дунд (10-12) Техник болон мэргэжлийн коллеж Дээд боловсрол Бусад/бичих/	

2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ				
8	Таны үндсэн хөдөлмөр эрхлэлтийн байдал:	Алтны бичил уурхай Төрийн байгууллагад ажилладаг Хувийн хэвшилд ажилладаг Төрийн Бүс Байгууллагад ажилладаг Хувиараа хөдөлмөр эрхэлдэг Газар тариаланч Малчин Сурагч/ оюутан Тэтгэвэрт гарсан Ажилгүй Бусад/бичих/	1 2 3 4 5 6 7 8 9 10 11	Зөвхөн 1 хариултыг сонгоно уу
9	Та давхар хөдөлмөр эрхэлдэг үү? Эрхэлдэг бол хаана юу хийдэг вэ?	Алтны бичил уурхай Төрийн байгууллагад ажилладаг Хувийн хэвшилд ажилладаг Төрийн Бүс Байгууллагад ажилладаг Хувиараа хөдөлмөр эрхэлдэг Газар тариаланч Малчин Сурагч/ оюутан Тэтгэвэрт гарсан Давхар ажил эрхэлдэггүй Бусад/бичих/	A B C D E F G H I J K	1-3 сонголтыг сонгоно уу
10	Та ямар бичил уурхайн байгууллагад харьяалагддаг вэ?	Нөхөрлөл Бүртгэлгүй нөхөрлөл Алтны бичил уурхайн ТББ Албан бус бүлэг Би ямар нэгэн байгууллагад харьяалагддаггүй Бусад/бичих/	A B C E F G	Хариултуудыг уншиж өгнө үү Асуулт 12-рүү шилжинэ Асуулт 12-рүү шилжинэ
11	Та бичил уурхайн байгууллагад ямар гишүүнчлэлтэй вэ?	Нөхөрлөлийн гишүүн Нөхөрлөлийн ахлагч Хоршооны гишүүн Хоршооны ахлагч Алтны бичил уурхайн төрийн бүс байгууллагын гишүүн Алтны бичил уурхайн төрийн бүс байгууллагын тэргүүн Бусад /бичих/	1 2 3 4 7 8 9	Олон сонголттой
12	Та нөхөрлөл/ хоршооны удирдагчаар эмэгтэй, эрэгтэй хүний аль нь байхыг илүүд үзэх вэ?	Эрэгтэй /дэлгэрэнгүй/ _____ Эмэгтэй /дэлгэрэнгүй/ _____ Ялгаагүй	1 2 3	Хариулт бичнэ үү
13	Та бичил уурхайд ямар ажил эрхэлдэг вэ?	Уурхайчин Амны эзэн Туслах ажилтан Бусад /бичих/	1 2 3 4	
14	Та бичил уурхайн салбарт хэр удаан ажиллаж байгаа вэ?	1 сар хүртэл 1 - 3 сар 6 - 9 сар 9 - 12 сар 1 - 2 жил 2 - 3 жил 4 - 5 жил 6 - 9 жил 10 ба түүнээс дээш жил	1 2 3 4 5 6 7 8 9	Зөвхөн 1 хариултыг сонгоно уу
15	Та жилийн аль аль саруудад алтны бичил уурхай эрхэлдэг вэ?	1-р сар 2-р сар 3-р сар 4-р сар 5-р сар 6-р сар 7-р сар 8-р сар 9-р сар 10-р сар 11-р сар 12-р сар	A B C D E F G H I J K L	Боломжит бүх сонголтын сонгоно уу
16	Та сард хэдэн өдөр ажилладаг вэ?	1 сард 9 хоног хүртэлх 1 сард 10 хоног 1 сард 11 - 20 хоног 1 сард 21 - 31 хоног	1 2 3 4	Зөвхөн 1 хариултыг сонгоно уу
17	Та нэг өдөрт дунджаар хэдэн цаг ажилладаг вэ?	Өдөрт 2 хүртэлх цаг Өдөрт 3 - 5 цаг Өдөрт 6 - 8 цаг Өдөрт 9 ба түүнээс дээш цаг	1 2 3 4	Зөвхөн 1 хариултыг сонгоно уу
18	Та 7 хоногт дунджаар хэдэн өдөр ажилладаг вэ?	Өдөр бүр 2 - 3 өдөр	1 2	Зөвхөн 1 хариултыг сонгоно уу

	ажилладаг вэ?	4 - 5 өдөр 6 - 7 өдөр	3 4	уу
--	---------------	--------------------------	--------	----

3. ОРЛОГО				
19	Таны орлогын эх үүсвэр юу вэ?	Бичил уурхай/гар аргаар алт олборлох Хувийн бизнес Мал аж ахуй Газар тариалан Тэтгэвэр, тэтгэмж Цалин хөлс Бусад /бичих/	1 2 3 4 5 6 7	Орлогын эх үүсвэрээ эрэмбэлнэ үү /1 хамгийн гол орлогын эх үүсвэр/
20	Таны 1 сарын дундаж орлогын хэмжээ	1,000,000 төгрөг ба түүнээс доош 1,000,001 - 1,500,000 төгрөг 1,500,001 - 2,000,000 төгрөг 2,000,001 - 2,500,000 төгрөг 2,500,001 - 3,000,000 төгрөг 3,000,001 төгрөгөөс дээш	1 2 3 4 5 6	Хариултуудыг уншиж өгнө. Зөвхөн 1 хариултыг сонгоно уу
21	Таны бичил уурхайн үйл ажиллагаанаас олдог 1 сарын дундаж орлогын хэмжээ хэд вэ?			Хариултаа бичнэ үү. ***Энэ асуулт нь яг алтны бичил уурхайгаас олдог орлогын хэмжээг тодорхойлно. Асуулт 19,20 оос өөр***
22	Таны бичил уурхайнаас олдог сарын орлого та болон танай гэр бүлийн амьжиргааг хангадаг уу?	Тийм Үгүй Заримдаа	1 2 3	Зөвхөн 1 хариултыг сонгоно уу
23	Та нийгмийн даатгал төлдөг үү?	Тийм Үгүй Заримдаа Мэдэхгүй	1 2 3 4	Зөвхөн 1 хариултыг сонгоно уу□
24	Та эрүүл мэндийн даатгал төлдөг үү?	Тийм Үгүй Заримдаа Мэдэхгүй	1 2 3 4	Зөвхөн 1 хариултыг сонгоно уу□
25	Та бичил уурхайгаар ажиллаж байгаа орон нутагтаа эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж чаддаг уу? (Жишээ нь сумын эмнэлэг)	Тийм Үгүй	1 2	Асуулт 27-руу шилжинэ үү
26	Хэрэв үгүй бол танд ямар бэрхшээл тулгардаг вэ?			

4. АЛБАЖСАН БАЙДАЛ				
27	Танай нөхөрлөл алт олборлох газрын дүгнэлтэй юу?	Тийм Үгүй Мэдэхгүй	1 2 3	***Хэрэв нөхөрлөлд харьяалагддаггүй бол асуултыг алгасах**
28	Танай нөхөрлөл орон нутгийн байгууллагатай алт олборлох зөвшөөрөл олгох тухай гэрээ байгуулсан уу?	Тийм Үгүй Мэдэхгүй	1 2 3	
29	Та болон бусад уурхайчдад алт олборлох зөвшөөрөл болон гэрээ байгуулахтай холбоотой хүндрэл учирч байсан уу?	Тийм Үгүй Мэдэхгүй	1 2 3	Асуулт 31-руу шилжинэ үү Асуулт 31-руу шилжинэ үү
30	Хэрэв тийм бол ямар бэрхшээл тулгардаг вэ?			Хариултаа бичнэ үү

5. ХҮДЭР ОЛБОРЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА				
31	Танай нөхөрлөл/ бүлэг хэдэн гишүүнтэй ажилладаг вэ? /эрэгтэй, эмэгтэй/	Нийт: Эрэгтэй: Эмэгтэй:		Хоосон зайг нөхнө үү. ***нөхөрлөл гэдэг нь бүртгэлтэй зөвшөөрөлтэй, албан бус хүмүүсийг бүлэг бригад гэнэ***
32	Олборлолтын талбайд тогтмол ажилладаг идэвхтэй гэж үздэг хэдэн гишүүн байдаг вэ?	Нийт: Эрэгтэй: Эмэгтэй:		Хоосон зайг нөхнө үү
33	Та ээлжээр ажилладаг уу?	Тийм Үгүй	1 2	Асуулт 35-рүү шилжинэ үү
34	Хэрэв тийм бол 1 ээлж хэдэн өдөр үргэлжилдэг вэ?	Өдөр:		Хоосон зайг нөхнө үү

35	Нэг удаад хичнээн хэмжээний хүдэр олборлодог вэ?	_____		Хариултаа бичнэ үү ***Жишээ нь: кг эсхүл тонн-оор илэрхийлнэ үү***
36	Та хүдрээ баяжуулах цехрүү тээвэрлэх хүртэл хэдэн хоног олборлолт хийдэг вэ?	Бусад /би мэдэхгүй хариултыг (0) тоогоор тэмдэглэх/		Хоосон зайг нөхнө үү.
37	Та хүдрээ баяжуулах цехрүү тээвэрлэх хүртэл хэдэн ажилчин/уурхайчин идэвхтэй оролцдог вэ?	өдөр: _____		Хоосон зайг нөхнө үү.
38	1 өдөрт хэдэн кг хүдэр олборлодог вэ?	Нийт: _____ Эрэгтэй: _____ Эмэгтэй: _____		Хоосон зайг нөхнө үү
39	Хэрэв шуудайгаар хэмждэг бол 1 шуудайнд хэдэн кг хүдэр багтдаг вэ?	_____ Кг		Хоосон зайг нөхнө үү ***Жишээ нь: 100кг, 101-300кг, 301-500кг, 501-800кг, 801-1,000кг***
40	Та эсвэл танай нөхөрлөл/бүлэг хүдэр олборлолтын бүртгэл болон тэмдэглэл хийдэг үү?	Бусад /би мэдэхгүй хариултыг (0) тоогоор тэмдэглэх/		Хоосон зайг нөхнө үү ***Жишээ нь: 40кг/шуудай, 60кг/шуудай, 80кг/шуудай, 100кг/шуудай***
41	Олборлох явцад танд тулгардаг хамгийн том бэрхшээл юу вэ? /Эрэмбэлнэ үү/	Тийм Үгүй Мэдэхгүй Гүний ус гардаг Хайгуул хийдэггүй Хүдрийн нөөц бага Тоног төхөөрөмжийн дутмаг байдал Хүний нөөц дутмаг Тэсэлгээ хийгддэггүй байдал Цаг агаар Газрын зөвшөөрөл Олборлолтын хүчин чадал дутмаг Тэсэлгээ хүндрэл Зөвшөөрөл Санхүүжилтийн дутмаг байдал Бусад /Бичих/		1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 Зөвхөн 1 хариултыг сонгоно уу Хариултыг уншиж өгнө. Хамгийн том бэрхшээлээс эхлэн эрэмбэлнэ үү
42	Та хөрөнгийн эх үүсвэртэй байсан бол олборлох үйл ажиллагааг хэрхэн сайжруулах байсан бэ?	_____		***Жишээ нь: Шинэ тоног төхөөрөмж***

6. ТЭЭВЭРЛЭЛТ

43	Та эсвэл танай нөхөрлөл/бүлэг олборлосон хүдрийг хаашаа тээвэрлэдэг вэ?	Өөрийн баяжуулах цех _____ км Ойролцоох баяжуулах цех _____ км Өөр сумын баяжуулах цех _____ км Гэртээ _____ км Мэдэхгүй _____ км Бусад /Бичих/ _____ км	A B C D E F	Боломжит бүх сонголтын сонгоно уу
44	Та эсвэл танай нөхөрлөл/бүлэг олборлосон хүдрийг хэрхэн тээвэрлэдэг вэ?	_____		
45	Танд тээвэрлэлтэд ямар нэгэн бэрхшээл тулгардаг уу? Хэрэв тийм бол, яагаад?	_____		
46	Олборлосон хүдрээ олборлолтын талбайгаас баяжуулах цехрүү ямар давтамжтайгаар тээвэрлэдэг вэ?	_____		
47	Баяжуулах зорилгоор хүдэр тээвэрлэхэд дунджаар хэр их зардал гардаг вэ?	_____		

7. АЛТНЫ ХҮДЭР БАЯЖУУЛАХ

48	Та баяжуулах цех эзэмшдэг үү?	Тийм Үгүй	1 2	
49	Хүдрийг хэрхэн буталдаг вэ?	Гараар Хацарт бутлуур Алхан бутлуур Бусад /Бичих/	1 2 3 4	Хариултыг унших шаардлагагүй ***Гар аргаар - алах, хүрз, лантуу, Хацарт бутлуур нь эрүүг тогтмол хөдөлгөөж, шахаж материалыг хуссэн хэмжээгээр нь бутлах, Алх бутлуур нь төрөл бүрийн материалыг хувиулдаг

			материалыг цилиндр өсөл замаар бутладаг***
50	Хүдрийг хэрхэн нунтагладаг вэ?	Алхан тээрэм (Саваачик) Бигүүн тээрэм Бөмбөлөгт тээрэм Бусад /бичих/	1 2 3 4 Хариултыг унших шаардлагагүй***алхан тээрэм-хуурай, сул материалыг бутлагч, бигүүн тээрэм - цилиндр хэлбэртэй хос өнх өрүүлүүд, бөмбөгөн тээрэм - материалуудыг ган бөмбөг бүхий цилиндр эргүүлэх замаар бутлан нунтаглана***
51	Хүдрээс алтыг яаж ялгаж авдаг вэ?	Гар аргаар түмлэнд угаах (лотки) Шлюз, резин Сэгсрэх ширээ Химийн уусгалт Хайлуулах Мөнгөн усаар бариулах Бусад /бичих/	A B C D E F G Боломжит бүх сонголтыг сонгоно уу. ***Хэрээ уурхайчин мэдэхгүй бол уншиж өгнө үү***
52	Таны болон танай нөхөрлөлийн ашигладаг баяжуулах цех-ын алт барилт ойролцоогоор хэдэн хувь байдаг вэ ? (Баяжуулах цехийн нэрийг бич)	_____	***Жишээ нь: 0-100%-аар тэмдэглэнэ.дундаж нь 50 -70% байдаг***
53	Та сард дунджаар хэдэн удаа хүдрээ баяжуулдаг вэ?	_____	Хариултаа бичнэ үү. ***Жишээ нь: 1 удаа/сар, 2-3 удаа/сар, 4-5 удаа/сар, 5 болон түүнээс дээш/сар***
54	Та 7 хоногт хэдэн кг хүдэр баяжуулдаг вэ?	200 хүртэлх кг 201 - 500 кг 501 - 800 кг 801 - 1,100 кг 1,101 - 1,400 кг 1,401 - 1,700 кг 1,701 ба түүнээс их кг /бичнэ үү/	1 2 3 4 5 6 7 Зөвхөн 1 хариулт сонгоно уу. Хэрэв 1,701кг-с илүү бол хариултыг бичнэ үү
55	Та ойролцоогоор 1 удаагийн баяжуулалтаар хэдэн кг хүдрээс хэдэн грам алт авдаг вэ?	_____	Хүдэр алтны аль нэг утга нь 0 байж болно
56	Та эсвэл танай нөхөрлөл/бүлгийн үйл ажиллагаа явуулж буй орон нутагт хүдэр баяжуулах цех байдаг уу?	Тийм Үгүй Мэдэхгүй	1 2 3
57	Та болон танай нөхөрлөл/бүлгийн ашигладаг баяжуулах цехийг нэрлэн, алт барилтыг нь 1-10 оноогоор үнэлнэ үү.	1 2 3 4	Оноо Хариултаа бичнэ үү. (10 хамгийн шударга, 1 хамгийн шударга бус)□
58	Та баяжуулах цехийг ямар шалтгаанд үндэслэн сонгодог вэ?	Баяжуулах цех санхүүжилт санал болгодог учраас Уурхайн талбайд хамгийн ойр учраас Хямд үнэтэй Манай нөхөрлөл/ бүлгийн эзэмшлийнх Хувийн харилцаатай Бартерийн нөхцөлтэй учраас Мөнгөн ус ашигладаггүй учраас Алт барилт нь өндөртэй учраас Өөр сонголтгүй учраас Заавар удирдамжийн дагуу Бусад /бичих/	A B C D E F G H I J K Хариултыг унших шаардлагагүй. 1-3 хүртэлх сонголтыг сонгоно уу
59	Та баяжуулах цехийг илүү шударга болгохын тулд ямар өөрчлөлт хийх саналтай байна вэ?	_____	Хариултаа бичнэ үү
60	Таны бодлоор хэр их алт шламд хаягддаг вэ?	_____	Хэмжээг бичнэ үү.

8. АЛТНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ / НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ

61	Та худалдсан алтны хэмжээгээ бүртгэдэг үү?	Тийм Үгүй	1 2
	Та эсвэл танай нөхөрлөл/бүлэг дотроо		Хариултаа бичнэ үү *** Цэнгээр хариулал өг-д

62	хоногт дунджаар хэр их хэмжээний алт гаргаж авдаг вэ?			шилжүүлж бичнэ. 1 цэн = 3,75 гр 1 лан = 37,5гр***
63	Таны эсвэл танай нөхөрлөл/бүлгийн алтны дундаж сорьц хэд байдаг вэ?			Хариултаа бичнэ үү.
64	Та алтны сорьцоо хэрхэн тодорхойлуулдаг вэ?	Лабораторид сорьцыг тогтоодог /УБ, Баянгол, Дархан-д байдаг/ Усан жин ашигладаг Чулуун дээр зурж үздэг Тухайн орон нутгийн дундаж сорьц хэмжээг дагадаг Алтны худалдаачинд итгэдэг Мэдэхгүй Бусад/бичих/	A B C D E F G	Хариултыг уншиж өгөх шаардлагагүй, 1-3 хүртэлх сонголтыг сонгоно уу
65	Та алтны ханшын мэдээллийг хаанаас авдаг вэ?	Интернет Банкнаас Уурхайчдаас Амны эзэн Монгол Банкны вебсайтаас Баяжуулах цехээс Алт худалдан авагч Мэдэхгүй Бусад /бичих/	A B C D E F G H I	1-3 сонголтыг сонгоно уу
66	Та алтаа хаана худалдах боломжтой байдаг вэ? Хэрэв нэг ангилалд нэгээс олон худалдан авагч байгаа бол хэдийг гэдгийг бичнэ үү.	Уурхай дах алтны худалдаачдад(#____) Баяжуулах цехд (#____) Сумын худалдаачдад (#____) Аймгийн худалдаачдад (#____) Улаанбаатарын худалдаачдад (#_0____) Монгол Банк Урт цагааны алтны худалдаачдад БНХАУ-ын худалдан авагчдад (#____) Орон нутгийн алтны дархан (#____) Арилжааны банк Мэдэхгүй Бусад /бичих/ (#____) /би мэдэхгүй (0) тоогоор тэмдэглэх/	A B C D E F G H I J K L	Хариултыг уншиж өгөх шаардлагагүй, 1-3 хүртэлх хариултыг сонгоно уу. Энэхүү асуултын зорилт нь уурхайчдад алтаа зарах бүх сонголтыг тодорхойлж өгөх юм. Бүлэг бүрт хэдэн худалдан авагч байгаа бичээрэй. Бид боломжит бүх худалдан авагчдын тоог тооцоолох боломжтой байх ёстой.
67	Та өмнөх удаад алтаа хэнд зарсан бэ?	Уурхай дах алтны худалдаачдад Боловсруулах үйлдвэрт Сумын худалдаачдад Аймгийн худалдаачдад Улаанбаатарын худалдаачдад Монгол банк Урт цагааны алтны худалдаачдад БНХАУ-ын худалдан авагчдад Орон нутгийн алтны дархан Арилжааны банк Мэдэхгүй Бусад /бичих/	A B C D E F G H I J K L	Хариултыг уншиж өгөх шаардлагагүй. Шаардлагатай тохиолдолд өмнөх асуултанд дурдсан худалдан авагчдыг санал болгоно уу. Хамааралтай 1 - 3 хүртэлх сонголтыг сонгоно уу ***Боломжтой бол тэд худалдан авсан алтаа хаана зардгийг бичнэ үү***
68	Та хэнд алтаа хамгийн олон удаа зарсан бэ?	Уурхай дах алтны худалдаачдад Боловсруулах үйлдвэрт Сумын худалдаачдад Аймгийн худалдаачдад Улаанбаатарын худалдаачдад Монгол банк Урт цагааны алтны худалдаачдад БНХАУ-ын худалдан авагчдад Орон нутгийн алтны дархан Арилжааны банк Мэдэхгүй Бусад /бичих/	A B C D E F G H I J K L	Хариултыг уншиж өгөх шаардлагагүй. Шаардлагатай тохиолдолд өмнөх асуултанд дурдсан худалдан авагчдыг санал болгоно уу. Хамааралтай 1 - 3 хүртэлх сонголтыг сонгоно уу ***Боломжтой бол тэд худалдан авсан алтаа хаана зардгийг бичнэ үү***
69	Та алтаа Монгол банкинд зарж байсан уу?	Үргэлж Ихэвчлэн Хааяа Үгүй	1 2 3 4	Ихэвчлэн гэдэг нь нийт борлуулалтын 50%-иас илүү хувийг эзэлдэг гэсэн үг. Тийм бол Асуулт 71-руу шилжинэ үү
70	Хэрэв үгүй бол шалтгаан нь юу вэ?	Дэндүү хол Үйл явцыг нь ойлгодоггүй Би банкнаас тавьсан шаардлагыг хангадаггүй Үнэ нь тохирдоггүй Тэд төлөх гэж хэтэрхий их уддаг Банк маш их мэдээлэл асуудаг Маш олон маягт бөглөх шаардлагатай Бусад /бичих/	A B C D E F G H	Хариулт уншиж өгөх шаардлагагүй, шаардлагатай тохиолдолд хариултыг бичнэ үү
71	Алтны худалдаачин танд орлого	Тийм	1	

	зарлагын баримт гаргаж өгдөг үү?	Үгүй Мэдэхгүй	2 3	
72	Та хэр их хэмжээний алт зардаг вэ? /7 хоногт /сард /улиралд /жилд /	7 хоногт 1 Сард 1 улиралд (1-3 сар) 1 жилд Бусад /би мэдэхгүй хариултыг (0) тоогоор тэмдэглэх/	грам грам грам грам	Хариултаа бичнэ үү
73	Орон нутгийн засаг захиргаанаас та ямар нэгэн тусламж, дэмжлэг авч чаддаг уу? Дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү			Хариултаа бичнэ үү
74	Та одоо ямар нэгэн зээлтэй байгаа юу?	Тийм Үгүй	1 2	
75	Та эсвэл танай нөхөрлөл/бүлэг үйл ажиллагаагаа хэрхэн санхүүжүүлдэг вэ?	Өөрийн хөрөнгө Арилжааны банкны зээлээр Банк бус санхүүгийн байгууллага Алтын худалдаачид Баяжуулах цех Ломбард Бусад алт олборлогчидоос Найз нөхөд болон гэр бүл Бартер болон үйлчилгээгээр Бусад /бичих/	A B C D E F G H I J	1-3 сонгоолтыг сонгоно уу
76	Санхүүжилт авахад ямар бэрхшээлүүд тулгардаг вэ?			Хариултаа бичнэ үү
77	Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдэд: Санхүүжилт авахад зөвхөн эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээлүүд байдаг уу?	Тийм (дэлгэрэнгүй) Үгүй Мэдэхгүй	1 2 3	Хариултаа бичнэ үү.
78	Та санхүүгийн бүртгэл/тэмдэглэл хөтөлдөг үү?	Тийм Үгүй Мэдэхгүй	1 2 3	Асуулт 80-руу шилжинэ үү.
79	Хэрэв тийм бол, энэ нь таныг зээл авахад баталгаа болж чаддаг уу?	Тийм Үгүй Мэдэхгүй	1 2 3	

9. ХӨДӨЛМӨРИЙН БА ТЕХНИКИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

80	Та хүдэр олборлоход ямар багаж хэрэгсэл/ тоног төхөөрөмж/ машин технологи ашигладаг вэ?	Экскаватор Өрөм Ачааны машин Ачигч Цахилгаан алх (молдок) Гар тайль Жоотуу (юм хагалдаг багаж) Лоом Шуудай Хувин Түрдэг тэрэг Цахилгааны генератор Компрессор Багаж, түлхүүр Бусад /бичих/	A B C D E F G H I J K L M N O	Боломжит бүх сонголтын сонгоно уу.
81	Та эсвэл танай нөхөрлөл/бүлэг цооног (амны) дотоод бэхэлгээ хийдэг үү?	Тийм Үгүй	1 2	Асуулт 83-рүү шилжинэ үү
82	Хэрэв тийм бол, цооног (амны) дотоод бэхэлгээг юугаар хийдэг вэ?			*** Жишээ нь: шургааг (бэлдтсэн урт урт холтсыг нь салгаагүй нарийн, шулуун мод), банз (нимгэн зүссэн урт хавтхай мод), унанги, ургаа мод, палка.м***
83	Та болон танай нөхөрлөл/бүлэг цооногийн аюулгүй ажиллагааг хэрхэн хангадаг вэ?	Цооногийн амыг түгждэг/тагладаг Анхааруулах тууз татдаг Анхааруулах тэмдэг байрлуулдаг Цооногийн дээр саравч тавьдаг Бусад /бичих/	A B C D E	Боломжит бүх сонголтын сонгоно уу.
84	Та уурхайн талбай дээр ажиллахдаа иж бүрэн хамгаалах хэрэгсэл хэрэглэдэг үү?	Тийм үргэлж Тийм хааяа Үгүй	1 2 3	Асуулт 87-рүү шилжинэ үү
		Амьсгалын бүрэн маск Амьсгалын тоосны маск	A B	

85	Хэрэв хэрэглэдэг бол та ямар төрлийн хэрэгсэл ашигладаг вэ? (Хамгаалалтын хэрэглэл)	Ажлын бээлий Хамгаалалтын малгай /дуулга/ Чихний хамгаалалт Нүдний хамгаалалт Зориулалтын гутал Дүрэмт хувцас Бусад /бичих/	C D E F G H I	Олон хариулт сонгож болно ***Гарын авлага***
86	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан хувцас хэрэгслийг хэрхэн авдаг вэ?	Өөрөө худалдан авдаг Бусдаас зээлдэг Цаанаас хангадаг Бусад /бичих/	1 2 3 4	Зөвхөн 1 хариултыг сонгоно уу
87	Та уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа авдаг уу?	Тийм Үгүй	1 2	Асуулт 89-рүү шилжинэ уу
88	Хэрэв тийм бол, та сард хэдэн удаа зааварчилгаа авдаг вэ?	өдөр		*** Жишээ нь: Сард 1 удаа Сард 2 удаа 7 хоногт 3 удаа Өдөр бүр ***
89	Та хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр сургалтанд хамрагдаж байсан уу?	Тийм Үгүй Мэдэхгүй	1 2 3	
90	Та алтны бичил уурхайд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг хэрхэн мөрдөж ажилладаг вэ?	Би чанд мөрдөн ажилладаг Би дагаж мөрдөхийг хичээдэг Би дагаж мөрддөггүй Би энэ талаар мэдэхгүй	1 2 3 4	
91	Танай уурхайн газарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан хүн байдаг уу?	Тийм Үгүй Мэдэхгүй	1 2 3	
92	Таны ажигласнаар танай олборлолтын талбайд ямар нэгэн эрсдэлтэй, аюултай зүйл байгаа юу?	Тийм Үгүй Мэдэхгүй	1 2 3	Асуулт 94-рүү шилжинэ уу
93	Хэрэв тийм бол тайлбарлана уу?			
94	Танай нөхөрлөл/бүлэгт аюулгүй ажиллагааны журам болон эрсдэлийг бууруулах төлөвлөгөө байдаг уу?	Тийм Үгүй Мэдэхгүй	1 2 3	
95	Та эсвэл танай нөхөрлөл/бүлэг олборлолтын талбайд аюулгүй ажиллагааны ямар анхааруулах тэмдэг тэмдэглэгээ хийдэг вэ?			
96	Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдэд: Та бие давхар байхдаа алтны бичил уурхайд ажиллаж байсан уу? Тийм бол аюулгүй байдлын арга хэмжээ?	Үгүй Бие давхар болж байгаагүй Тийм, гэхдээ урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй Тийм, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан /бичих/	1 2 3 4	

10. БАЙГАЛЬ ОРЧИН

97	Та эсвэл танай нөхөрлөл/бүлэг олборлолтоос үүссэн хаягдлаа (хоосон чулуулаг) яаж хаядаг вэ?			***Жишээ нь: Тусдаа овоолдог, тэнд нь орхидог, дүүрээлт хийдэг г.м***
98	Олборлолтын явцад цооногийн гүнд хүхрийн хүчлийн шүүрэлт гардаг уу?	Тийм Үгүй Мэдэхгүй	1 2 3	*** цооног гэдэг нь (хүдэр олборлохоор эц доош чиглэлтэй нарийн бөгөөд гүнзгий нүхийг хэлнэ. ***
99	Та хэрэглэсний усаа хаанаас авдаг вэ?	Ойролцоох гол/ нуур Гүний уснаас/ худаг Шугамд холбогдсон худаг Зөөврийн усан хангамжтай худаг Борооны ус Бусад усны нөөц Бусад /бичих/	A B C D E F G	1-3 сонголтыг сонгоно уу.
100	Олборлолтын талбайд ямар төрлийн хог хаягдал гардаг вэ?	Цаасны хаягдал Модны хаягдал Хуванцрын хаягдал Зайны хаягдал Шатахуун, машины тосны үлдэгдэл Хүчлийн хаягдал Мөнгөн усны хаягдал Бусад /бичих/	A B C D E F G H	1-3 сонголтыг сонгоно уу.
		Шатааж	A	

		20 Хүдрийг цэвэрлэх / угаах 21 Алтны хүдэр нунтаглах 22 Хайлуулах 23 Химийн боловсруулалт 24 Алт жинлэх 25 Алтны бүртгэл хөтлөх / мэдээлэл бүртгэх 26 Боловсруулах үйлдвэрт тээрэм цэвэрлэх 27 Бусад	S T U V W X Y Z	
		109.4 Менежментийн үйл ажиллагаа 28 Санхүүгийн тооцоо хийх 29 Тоног төхөөрөмж / хангамж худалдан авах 30 Мөнгөний гүйлгээг хянах 31 Нягтлан бодох бүртгэл 32 Алт зарах 33 Аюулгүй байдал хянах 34 Уурхай / үйл ажиллагааны хяналт тавих 35 Боловсруулах үйлдвэрийн зохицуулагч хийх 36 Хууль эрх зүйн байдлыг хянах (зөвшөөрөл, бүртгэл гэх мэт) /Бусад/ сонголтыг нэмэлтээр оруулах	AA BB CC DD EE FF GG HH II JJ	
110	Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийг оролцуулдаггүй эсвэл хийх боломжгүй ажлууд байдаг уу?			Хариултыг бичнэ үү. ***Жишээ: хүнд хүдэр өргөх, алт боловсруулахад оролцуулах, санхүү барих г.м***
111	Та гэрийнхээ ямар ажлыг гүйцэтгэдэг вэ?	Хоол хийх Хувцас угаах Цэвэрлэгээ хийх Хүүхдэд харах Ахмад настанг халамжлах Түлээ, нүүрс цуглуулах Усанд явах/авах Бусад /бичих/	A B C D E F G H	Боломжит бүх сонголтын сонгоно уу.
111.1	Та долоо хоногт гэрийн ажилд дунджаар хэдэн цаг зарцуулдаг вэ?	цаг / 7 хоногт		Хариултыг бичнэ үү.
111.2	Танай гэр бүлийн өрхийн томоохон зардал гаргах шийдвэрийг хэн нь гаргадаг вэ? (Машин худалдаж авах, шинэ байр худалдаж авах, газар худалдан авах, сургуулийн төлбөр г.м)	Би ганцаараа шийдвэр гаргадаг Миний эхнэр/нөхөр шийдвэр гаргадаг Эхнэр/нөхөр бид хоёр хамтдаа шийдвэр гаргадаг Бусад гэр бүлийн гишүүдээрээ шийдвэр гаргадаг Бусад /бичих/	1 2 3 4 5	Зөвхөн 1 хариултыг сонгоно уу
111.3	Танай гэр бүлийн өдөр тутмын худалдан авалтын шийдвэр гаргадаг вэ? (хүнс цуглуулах, хувцас худалдан авах, тавилга худалдан авах, мах авах г.м)	Би ганцаараа шийдвэр гаргадаг Миний эхнэр/нөхөр шийдвэр гаргадаг Эхнэр/нөхөр бид хоёр хамтдаа шийдвэр гаргадаг Бусад гэр бүлийн гишүүдээрээ шийдвэр гаргадаг Бусад /бичих/	1 2 3 4 5	Зөвхөн 1 хариултыг сонгоно уу
111.4	Танай гэр бүл ахмад хамаатан садан дээр айлчлахдаа ихэвчлэн хэн нь шийдвэр гаргадаг вэ? (ахмад настан, хадмууд гэх мэт)	Би ганцаараа шийдвэр гаргадаг Миний эхнэр/нөхөр шийдвэр гаргадаг Эхнэр/нөхөр бид хоёр хамтдаа шийдвэр гаргадаг Бусад гэр бүлийн гишүүдээрээ шийдвэр гаргадаг Бусад гэр бүлийн гишүүдээрээ шийдвэр гаргадаг	1 2 3 4 5	Зөвхөн 1 хариултыг сонгоно уу
112	Та бичил уурхайн ямар асуудал дээр шийдвэр гаргахад түлхүү оролцдог вэ?	Ашигт малтмалын ордыг ашиглах Зохион байгуулах Хүдэр олборлох Хүдэр боловсруулах Ашгийн хувиарлах Борлуулах Гарал үүслийг бүртгэх Хог хаягдлыг зайлуулах Санхүүжилт олох Бусад /бичих/	A B C D E F G H I J	Боломжит бүх сонголтын сонгоно уу. □
113	Таны ажлын байран дээр дараах бэрхшээлүүд гарч байсан уу?	Ялгаварлан гадуурхах Ажлын байрны нөхцөл Хөдөлмөрийн үнэлэмж Хүчирхийлэл Дарамт (ерөнхийдөө) Бэлгийн хүчирхийлэл Архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх Химийн хордлого Ажлын байран дээрх аюулгүй байдал Гэмт хэрэг Орлогын найдваргүй байдал Шударга бус цалин Бусад /бичих/	A B C D E F G H I J K L M	Боломжит бүх сонголтын сонгоно уу. Хариултыг уншиж өгнө.
13. БИЧИЛ УУРХАЙЧДЫН МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ				
114	Та алтны бичил уурхайтай холбоотой мэдээллийг аль эх сурвалжаас олж авдаг вэ?	Гэр бүл / найз нөхөд / хамаатан садан Олон нийтийн байгууллага / төрийн байгууллага Төрийн бус байгууллага Бичил уурхайн салбарын хэн нэгэн (жишээ нь, уурхайчид) Хэвлэл мэдээлэл Бусад /бичих/	A B C D E F	1 - 3 сонголтын сонгоно уу.
		Сонин	A	

115	Та ихэвчлэн ямар мэдээллийн хэрэгслийг ашигладаг вэ?	Телевиз Радио Фэйсбүүкт Твиттер Нийгмийн сүлжээний хэрэгслийн бусад хэрэгсэл Зурвасаар дамжуулан Гар утсаар Ам дамжсан яриа Вэбсайтууд Бусад /бичих/	В С D E F G H I J K	Боломжит бүх сонголтын сонгоно уу.
116	Та бичил уурхайтай холбоотой ямар төрлийн мэдээлэл авахыг хүсч байна вэ?			Хариултыг бичнэ үү.
117	Та алтны бичил уурхайн мэдлэгийн төвийн (www.asmtub.mn) тухай мэдэх үү?	Тийм Үгүй	1 2	Асуулт 118 руу шилжих
118	Хэрэв тийм бол та дээрх вебсайтнаас хэрэгцээтэй мэдээлэл авч чадаж байна уу?			

14. КОВИД - 19 АСУУЛТУУД

119	Корона вирус таны алтны бичил уурхайн үйл ажиллагаанд нөлөөлсөн үү? Хэрэв тийм бол яаж вэ?	Тийм /бичих/ Үгүй	1 2	***Жишээ: орлого, алтны борлуулалт, үйлдвэрлэлд, түлш, нийлүүлэлт, мөнгөн ус г.м***
120	Та корона вирустай холбоотой уурхайн талбайд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан уу?	Тийм /бичих/ Үгүй	1 2	***Жишээ: тусгаарлах, гар ариутгах, бактери устгах бүтээгдэхүүн хэрэглэх г.м***
121	Корона вирусийн тахал таны амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ?			***Жишээ: хүнсний аюулгүй байдал, гэрийн ажлын ачаалал ихсэх, хүүхэд харах г.м***
122	Та өөрийгөө Коронавирусаас та өөрийгөө хэрхэн хамгаалах талаар хангалттай мэдээлэл авсан гэж бодож	Тийм /бичих/ Үгүй	1 2	

15. МӨНГӨН УСНЫ АСУУЛТУУД

123	Танай аймагт сүүлийн хоёр жилийн хугацаанд алт боловсруулахад мөнгөн ус ашиглаж байсан тохиолдлыг та харж байсан уу?	Тийм Үгүй Би хэлэхийг хүсэхгүй байна	1 2 3	Хариултыг уншиж өгөхгүй. Оролцогчдын зан байдлыг ажигла. Хэрэгтэй бол тэмдэглэл хөтөлж болно.
124	Танай аймагт мөнгөн ус зарагдаж байгаа эсэх талаар та мэдэх үү?	Тийм Үгүй Би хэлэхийг хүсэхгүй байна	1 2 3	Хариултыг уншиж өгөхгүй. Оролцогчдын зан байдлыг ажигла. Хэрэгтэй бол тэмдэглэл хөтөлж болно.
125	Та мөнгөн ус хүний биед хортой гэдгийг мэдэх үү?	Тийм Үгүй	1 2	Оролцогчдын зан байдлыг ажигла. Хэрэгтэй бол тэмдэглэл хөтөлж болно.
126	Хэрэв тийм бол, мөнгөн ус нь хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдөг вэ?	Тархины мэдрэлийн системд Бөөрөнд Зүрх судасны системд Ургийн хөгжилд нөлөөлдөг Бусад /бичих/ Би мэдэхгүй	1 2 3 4 5 6	Хариултыг уншиж өгөхгүй.

СУДАЛГААНД ХАМРАГДСАНД ТАЛАРХЛАА.

Хавсралт Б: Ганцаарчилсан ярилцлагад оролцсон байгууллага, албан тушаалтнууд

Улаанбаатар	Сэлэнгэ аймгийн Мандал сум	Сэлэнгэ аймгийн Баянгол сум	Сэлэнгэ аймгийн Түнхэл баг	Говь-Алтай аймгийн Есөнбулаг (Алтай) сумд	Ховд аймгийн Алтай (Жаргалант) сумд
	Сумын Засаг дарга	Сумын Засаг дарга	Сумын Засаг дарга	Сумын Засаг дарга	Сумын Засаг дарга
ММБУНДХ	Орон нутгийн БУ-н ТББ	-	Орон нутгийн БУ-н ТББ	Орон нутгийн БУ-н ТББ	Орон нутгийн БУ-н ТББ
	Аймгийн БУ-н ТББ				
УУХҮЯ	Аймгийн байцаагчид (уул уурхайн)			Орон нутгийн байцаагчид (Уул уурхайн)	-
--	Цагдаагийн хэлтэс	Цагдаагийн хэсэг	-	Цагдаагийн хэлтэс	Цагдаагийн газар
БОАЖЯ	Сумын байгаль орчны ажилтан	Сумын байгаль орчны ажилтан	-	Сумын байгаль орчны ажилтан	Аймгийн байгаль орчны ажилтан
	Аймгийн байгаль орчны ажилтан				
АМГТГ	Аймгийн хөрөнгө оруулалт, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн			Сумын уул уурхайн мэргэжилтэн	Аймгийн уул уурхайн мэргэжилтэн
ХЭҮК	Аймгийн нийгмийн бодлогын мэргэжилтэн			Нийгмийн бодлогын мэргэжилтэн	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
-	Орон нутгийн баяжуулах цех	Орон нутгийн баяжуулах цех	Орон нутгийн баяжуулах цех	Орон нутгийн баяжуулах цех	-
-	Алтны худалдаачид	Алтны худалдаачид	Алтны худалдаачид	Алтны худалдаачид	Алтны худалдаачид
-	-	Иргэдийн төлөөлөл (түхэйлбал, малчид, оршин суугчид)	-	Иргэдийн төлөөлөл (түхэйлбал, малчид, оршин суугчид)	Иргэдийн төлөөлөл (түхэйлбал, малчид, оршин суугчид)
-	-	Байгаль орчны идэвхтэн	-	Байгаль орчны идэвхтэн	Байгаль орчны идэвхтэн
-	Нийгмийн даатгалын хэлтэс	Нийгмийн даатгалын хэлтэс	Нийгмийн даатгалын хэлтэс	Нийгмийн даатгалын хэлтэс	Нийгмийн даатгалын хэлтэс
-	Аймгийн ТББ (эмэгтэйчүүдийн)			ТББ (Эмэгтэйчүүд)	ТББ (Эмэгтэйчүүд)
-	-	БУ-ын ТББ-ын гишүүн	-	БУ-ын ТББ-ын гишүүн	БУ-ын ТББ-ын гишүүн
-	-	Цехийн ажилтан	-	Цехийн ажилтан	-
-	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	-	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	-
-	БУ-н нөхөрлөлийн ахлагч нар	-	БУ-н нөхөрлөлийн ахлагч нар	БУ-н нөхөрлөлийн ахлагч нар	БУ-н нөхөрлөлийн ахлагч нар
-	БУ-н нөхөрлөлийн гишүүд	БУ-н нөхөрлөлийн гишүүд	БУ-н нөхөрлөлийн гишүүд	БУ-н нөхөрлөлийн гишүүд	-

Хавсралт В: Ганцаарчилсан ярилцлагын асуултууд

Ганцаарчилсан ярилцлагын танилцуулга

- Ярилцлага 1 цаг орчим үргэлжилнэ.
- Оролцогчийн ерөнхий мэдээллийн хуудас бөглөнө.
- Зөвхөн судлаачийн асуултаар хязгаарлагдахгүйгээр та санал бодлоо чөлөөтэй илэрхийлж болно.
- Ярилцлагын дундуур саад болохгүйн тулд та утасныхаа дууг хааж, чимээгүй тохиргоог тавина уу.

Ерөнхий мэдээллийн хуудас

Нэр:	
Хүйс:	
Нас:	
Холбогдох утасны дугаар:	
И-мейл хаяг:	
Байгууллагын нэр:	
Албан тушаал:	
Энэхүү албыг хашиж буй хугацаа:	
Ярилцлагын байршил:	
Огноо:	
Эхэлсэн цаг:	
Дууссан цаг:	
Судлаач:	

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь төслийн бус нутгуудын АБУ-н салбар дахь мөнгөн усны хэрэглээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, олборлолт, байгаль орчин, нийгэм эдийн засгийн байдал, жендэрийн асуудлыг судлахад оршино. Энэхүү судалгаагаар цуглуулсан мэдээлэл нь Монгол Улсын “Статистикийн тухай хууль” болон “Хувь хүний нууцын тухай хууль”-ийн дагуу чандлан хадгалагдаж, зөвхөн судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглагдах болно.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Асуултууд:

1. Та алтны бичил уурхайн (АБУ) өнөөгийн нөхцөл байдлын талаар ерөнхий мэдээлэл өгнө үү?
2. Энэ салбарт тулгараад байгаа гол асуудал юу вэ?
3. Яамнаас орон нутгийн нөхөн сэргээлтийн сангийн зохистой ашиглалт дээр хяналт тавьдаг уу? Хэрхэн тавьдаг вэ?
4. Мөнгөн усны хэрэглээг бууруулах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт ямар түвшинд байгаа вэ? Энэ хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд оролцогч талуудад та юу гэж зөвлөх вэ?
5. Мөнгөн усны хэрэглээ өндөртэй аймаг/сумдын талаарх баримт, тоон мэдээллийг өгнө үү?
6. Мөнгөн усны хэрэглээг хэрхэн хэмждэг вэ? Мөнгөн ус хэмждэг тусгай багаж танайд байдаг уу?
7. Таны бодлоор мөнгөн усны хэрэглээг бууруулах/зогсооход юу хийх хэрэгтэй вэ?
8. Мөнгөн усны хэрэглээг бууруулах талаар яам болон холбогдох агентлагаас ямар сурталчилгаа/арга хэмжээ/үйл ажиллагаа зохион байгуулдаг вэ? Эсвэл зохион байгуулахаар төлөвлөж байна вэ?
9. Таны бодлоор бичил уурхайчдад ямар сургалт хэрэгцээтэй вэ? Албажуулалт, байгаль орчин нийгмийн хяналт, ХАБ, мөнгөн усны сөрөг нөлөөлөл, алтны нийлүүлэлтийн сүлжээ, жендэр болон захиргааны эрх зүйн талаарх гэх мэт сургалтууд тэдэнд шаардлагатай юу? (Хэнд зориулсан ямар сургалт гэдгийг онцолно уу)
10. Таны хувьд planetGOLD төслийн хүрээнд хамрагдах сургалтын хэрэгцээ байна уу?

Хүний эрхийн үндэсний комисс

Асуултууд:

1. Алтны бичил уурхайн салбартай холбоотой бодлого, хөтөлбөрүүдэд жендэрийн тэгш байдал, эрхийн асуудлууд хэр сайн тусгагдсан гэж та үзэж байна вэ?
2. Жендэрийн талаар баримтлах бодлого болон хөтөлбөрүүд манай улсад хангалттай хэрэгжиж байна гэдэгтэй та санал нийлүүлэх үү? Яагаад? Эдгээр бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд, ялангуяа уул уурхайн салбарт хэрэгжүүлэхэд ямар гол бэрхшээл тулгарч байна вэ? Үр дүнтэй хэрэгжүүлэхэд түлхэц болох ямар хүчин зүйл байна гэж та бодож байна?
3. Таны бодлоор эрэгтэй, эмэгтэй бичил уурхайчид ямар асуудлууд, хүндрэл бэрхшээлтэй тулгарч байдаг вэ?
4. Таны бодлоор, гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагаа байгаль орчин, хүний эрүүл мэнд, бичил уурхайн ойр орчны ард иргэдэд ямар нөлөөлөл үзүүлдэг вэ?

5. Таны бодлоор, бичил уурхайчдад жендэртэй холбоотой сургалтын ямар хэрэгцээ байна вэ? Цаашид бичил уурхай эрхлэгчдэд зориулан хийх сургалтад ямар сэдвүүдийг тусгах хэрэгтэй гэж та бодож байна? Танд санал болгох сэдвүүд байна уу?
6. Таны бодлоор, төрийн албан хаагчдад жендэртэй холбоотой сургалтын ямар хэрэгцээ байна вэ? Төрийн албан хаагчдад зориулан хийж байсан сургалтуудаас аливаа сургамж байна уу, байвал та бид нартай хуваалцана уу?

БОАЖЯ-ны Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Асуултууд:

1. Алтны бичил уурхайн салбартай холбоотой бодлого, хөтөлбөрүүдэд жендэрийн тэгш байдал, эрхийн асуудлууд хэр сайн тусгагдсан гэж та үзэж байна вэ?
2. Жендэрийн талаар баримтлах бодлого болон хөтөлбөрүүд манай улсад хангалттай хэрэгжиж байна гэдэгтэй та санал нийлэх үү? Яагаад? Эдгээр бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд, ялангуяа уул уурхайн салбарт хэрэгжүүлэхэд ямар гол бэрхшээл тулгарч байна вэ? Үр дүнтэй хэрэгжүүлэхэд түлхэц болох ямар хүчин зүйл байна гэж та бодож байна?
3. Таны бодлоор, гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлодог эрэгтэй, эмэгтэй хүмүүс ямар гол асуудлуудтай тулгардаг вэ? Эмэгтэй бичил уурхайчдад тулгардаг тодорхой саад бэрхшээл эсвэл хүндрэлтэй асуудлууд байдаг юу?
4. Таны бодлоор, мөнгөн ус хэрэглэх, түүнтэй харьцах, устгах явцад эрэгтэй, эмэгтэй бичил уурхайчдын хөдөлмөрийн хуваарилалт, тухайлбал тэдгээрийн ажил үүргийн хуваарьтай холбоотойгоор хэн хамгийн эмзэг хэсэгт хамаарч байна вэ? Өөрөөр хэлбэл, хэн (эрэгтэй эсвэл эмэгтэй бичил уурхайчид) нөлөөлөлд өртөх илүү их эрсдэлтэй вэ?
5. Таны бодлоор гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагаа байгаль орчин, хүний эрүүл мэнд, бичил уурхайн ойр орчны ард иргэдэд ямар нөлөөлөл үзүүлдэг вэ?
6. Сүүлийн 2 жилийн хугацаанд та жендэртэй холбоотой сургалтад, тэр дундаа ялангуяа алтны бичил уурхайн салбар дахь жендэрийн асуудлаарх сургалтад хамрагдаж байсан уу?
7. Таны бодлоор, бичил уурхайчдад сургалтын ямар хэрэгцээ байна вэ? Цаашид бичил уурхай эрхлэгчдэд зориулан хийх сургалтад ямар сэдвүүдийг тусгах хэрэгтэй гэж та бодож байна? Танд санал болгох сэдвүүд байна уу?

УУХҮЯ-ны Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Асуултууд:

1. Одоо хэрэгжиж байгаа жендэрийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрүүд алтны бичил уурхайн асуудлуудыг ямар хэмжээнд, хэрхэн авч үзсэн байгаа вэ?

2. Алтны бичил уурхайн салбартай холбоотой бодлого, хөтөлбөрүүдэд жендэрийн тэгш байдал, эрхийн асуудлууд хэр сайн тусгагдсан гэж та үзэж байна вэ?
3. Алтны бичил уурхайн ерөнхий нөхцөл байдлын талаар та товч ярьж өгнө үү. Та энэхүү нөхцөл байдлыг хэрхэн дүгнэх вэ?
4. Алтны бичил уурхайн салбарт тулгамдаж буй ямар гол асуудлууд байна вэ? Гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох илүү сайн үйл ажиллагаа, арга туршлага олж авахад эмэгтэй, эрэгтэй хүмүүст одоогоор тулгардаг аливаа саад бэрхшээл байна уу? Нөгөөтэйгүүр, сайн туршлага, үйл ажиллагаанд суралцахад дэм болох аливаа боломж байна уу? Тухайлбал, мэдээллийн хүртээмжтэй байдал, сургалтад хамрагдах боломж, гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагааг албан ёсны болгох, мэргэшүүлэх, санхүүгийн болон технологийн хүртээмж хүртээмжтэй байдал зэрэгт саад бэрхшээл, боломж байна уу?
5. Таны бодлоор, мөнгөн ус хэрэглэх, түүнтэй харьцах, устгах явцад эрэгтэй, эмэгтэй бичил уурхайчдын хөдөлмөрийн хуваарилалт, тухайлбал тэдгээрийн ажил үүргийн хуваарьтай холбоотойгоор хэн хамгийн эмзэг хэсэгт хамаарч байна вэ? Өөрөөр хэлбэл, хэн (эрэгтэй бичил уурхайчид эсвэл эмэгтэй бичил уурхайчид) нөлөөлөлд өртөх илүү их эрсдэлтэй вэ?
6. Алтны бичил уурхайн салбарт жендэрийн нөхцөл байдал ямар байгаа вэ? Энэхүү нөхцөл байдлыг та хэрхэн дүгнэн харж байна вэ? Аливаа асуудал байна уу?
7. Цаашид алтны бичил уурхайн салбарт жендэртэй холбоотой хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бодлого / арга хэмжээ байна уу?
8. Алтны бичил уурхайн сайт дээр жилд дунджаар хэдий хэмжээний хүдэр олборлодог вэ (тонн/жил/уурхайн сайт)?
9. Томоохон хэмжээний алтны уурхайн компаний сайт дээр жилд дунджаар хэдий хэмжээний хүдэр олборлодог вэ (тонн/жил/уурхайн сайт)?
10. Сүүлийн 2 жилийн хугацаанд та жендэртэй холбоотой сургалтад, тэр дундаа ялангуяа алтны бичил уурхайн салбар дахь жендэрийн асуудлаарх сургалтад хамрагдаж байсан уу?
11. Таны бодлоор, бичил уурхайчдад сургалтын ямар хэрэгцээ байна вэ? Мөн жендэртэй холбоотой сургалтын ямар хэрэгцээ байна гэж та бодож байна вэ? Цаашид бичил уурхай эрхлэгчдэд зориулан хийх сургалтад ямар сэдвүүдийг тусгах хэрэгтэй вэ? Танд санал болгох сэдвүүд байна уу?

Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо

Асуултууд:

1. Та алтны бичил уурхайн (АБУ) өнөөгийн нөхцөл байдлын талаар ерөнхий мэдээлэл өгнө үү?
2. Жендэрийн асуудлыг оролцуулан энэ салбарт тулгараад байгаа гол асуудал юу вэ? (хүйсийн хөдөлмөрийн хуваарилалт, мөнгөн усны хэрэглээнд эмзэг бүлгүүд, тээвэрлэлт, хэрэглээ, хаягдал, эрүүл мэндийн асуудал)
3. Өнөөгийн нөхцөл байдлыг сайжруулах талаар та юу зөвлөх вэ?
4. Алтны БУ талаарх ерөнхий тоон мэдээллийг хуваалцана уу? (албан ба албан бус), БУ-чдын тоо

5. Бичил уурхайчдын алтны олборлолт, боловсруулах технологийн талаар бидэнд мэдээлэл өгнө үү? БУ-чдын орлогын мэдээлэл, ашиг хуваарилалтын байдал нь үйл ажиллагаанд оролцогч талууд/уурхайчид/жендэрийн хувьд ялгаа байдаг уу?
6. Мөнгөн усны хэрэглээний одоогийн байдал ямар түвшинд байна вэ? Байгал орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийн талаар тоон мэдээлэл байна уу?
7. БУ-н газрын зөвшөөрөл авахад хир хүндрэлтэй вэ? Зөвшөөрөл авахад зарцуулдаг дундаж хугацааг хэлнэ үү? Сайжруулах санал байна уу?
8. Олборлолтын талбай дах ажил үүргийн хуваарилалт эрэгтэй, эмэгтэй хүний хувьд ямар байдгийг тайлбарлана уу?
9. Ажил үүргээ гүйцэтгэх явцад тоног төхөөрөмж, мэдлэг, зээл, мэдээлэл гм нөөцийг ашиглахад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд ялгаа байдаг уу? Үүнээс гадна мэдээллийг ашиглахад жендэрийн хувьд ялгаа байдаг бол эрэгтэй, эмэгтэй хүмүүс ямар сувгаар мэдээллийг түлхүү авдаг вэ? (аман байдлаар, ТВ, интернэт, нийгмийн сүлжээ, радио гм)
10. БУ-чид үйл ажиллагаа явуулж буй сум, орон нутагтаа нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж чаддаг уу? Тэдэнд ямар бэрхшээл тулгардаг вэ? Сайжруулах арга зам байна уу?
11. Таны бодлоор бичил уурхайн сайн туршлагыг нэвтрүүлэхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүст аливаа саад, бэрхшээл тулгардаг уу?
12. БУ-чдын шийдвэр гаргалт хэрхэн явагддаг талаар хуваалцана уу? Нөхөрлөлийн шийдвэр гаргалтад эмэгтэйчүүд адил тэгш оролцдог уу?
13. Бичил уурхай дах мөнгөн усны хэрэглээг бууруулах талаар танай байгууллагад стратеги болон нарийвчилсан үйл ажиллагааны төлөвлөгөө байгаа юу?
14. Мөнгөн усны хэрэглээг бууруулах талаар ямар сурталчилгаа/арга хэмжээ/үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулдаг вэ? Тийм бол ойрын хугацаанд хийхээр төлөвлөсөн үйл ажиллагааны төлөвлөгөө төсөв байна уу? Ийм төрлийн үйл ажиллагаа хир үр дүнтэй байдаг вэ? БУ-чдын бүлэг, олон нийт хир хүлээж авдаг вэ?
15. Таны бодлоор мөнгөн усны хэрэглээг хэрхэн бууруулах/зогсоох вэ?
16. Танд ямар нэгэн сургалтын хэрэгцээ байгаа юу? (Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувьд ялгаатай сэдвүүд байна уу?)

Ганцаарчилсан ярилцлагад оролцогч орон нутгийн байгууллагууд

Орон нутгийн засаг захиргаа

Асуултууд:

1. Та алтны бичил уурхайн (АБУ) өнөөгийн нөхцөл байдлын талаар ерөнхий мэдээлэл өгнө үү?
2. Идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг алтны БУ ордын тоо, зөвшөөрөлтэй/зөвшөөрөлгүй БУ эрхлэгчдийн тоо?
3. Том уурхайн тоо, тэдгээрийн ажиллагсдын тоо?
4. Зөвшөөрөлтэй/зөвшөөрөлгүй баяжуулах цехүүдийн тоо, ажиллагсдын тоо?
5. Алтны БУ-гаас олборлодог алтны хүдрийн хэмжээ нэг жилд дунджаар хэд байдаг вэ? (орд/жил/тон)

6. Алтны том уурхайгаас олборлодог алтны хүдрийн хэмжээ нэг жилд дунджаар хэд байдаг вэ? (орд/жил/тон)
7. БУ-н нийгэм эдийн засагт үзүүлж байгаа эерэг болон сөрөг нөлөөг юу гэж үздэг вэ?
8. Танай нутагт БУ-гаас байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл хир байдаг вэ? Мөнгөн усны хэрэглээ байдаг уу? Бусад химийн элементийн хэрэглээ ямар түвшинд байна вэ?
9. БУ нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ хэд байдаг вэ? (м/квад?) Одоогийн байдлаар нөхөн сэргээлт шаардлагатай талбайн хэмжээ хэд байдаг вэ? (м/кв)
10. БУ-н олборлолтын талбайд осол аваар их гардаг уу? Ихэвчлэн ямар төрлийн осол аваар гардаг вэ? Сүүлийн 12 сарын хугацаанд хүний амь эрсэдсэн осол гарсан уу? БУ-н олборлолтын талбайд хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартыг зөрчсөн асуудал гардаг уу?
11. БУ-н газар хүссэн өргөдөл сард хэд ирдэг, танайхаас эцэслэн шийдвэрлэдэг дундаж хугацаа хэд байдаг вэ?
12. Зөвшөөрөлтэй БУ байгууллагууд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө байдаг уу?
13. БУ нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд хэрхэн хяналт тавьдаг вэ?
14. Нөхөн сэргээлтийн дундын сангийн ашиглалт ямар байдаг вэ?
15. Зөвшөөрөлгүй, албан бус БУ үйл ажиллагаанд болон мөнгөн усны хэрэглээнд хэрхэн хяналт тавьдаг вэ?
16. Албан бус БУ болон мөнгөн усны хэрэглээг бууруулах стратеги, төлөвлөгөө байдаг уу?
17. Танай аймагт мөнгөн усгүй технологиор баяжуулах цех байгуулах төлөвлөгөө байгаа юу?
18. Таны бодлоор бичил уурхайчдад ямар сургалт хэрэгцээтэй вэ? Албажуулалт, байгаль орчин нийгмийн хяналт, ХАБ, мөнгөн усны сөрөг нөлөөлөл, алтны нийлүүлэлтийн сүлжээ, жендэр болон захиргааны эрх зүйн талаарх гэх мэт сургалтууд тэдэнд шаардлагатай юу?
19. Төрийн байгууллагын ажилтнуудад БУ албажуулалт, байгаль орчин, хяналт, жендэр, захиргааны эрх зүй гэх мэт сургалтуудад хамрагдах хэрэгцээ байна уу?

Бичил уурхайн ТББ-ын тэргүүн, гишүүд, ажилчид

Асуултууд:

1. Та алтны бичил уурхайн (АБУ) өнөөгийн нөхцөл байдлын талаар ерөнхий мэдээлэл өгнө үү?
2. Алтны БУ тоон мэдээллийг хуваалцана уу? (нөхөрлөлийн тоо ордын тоо, зөвшөөрөлтэй/ зөвшөөрөлгүй БУ эрхлэгчдийн тоо?)
3. БУ байгууллагын бүтэц ямар байдаг вэ? (амны эзэн, нөхөрлөлийн гишүүд, уурхайчид, цалинтай ажилчид г.м, хүйсээр нь ангилж хэлнэ үү?)
4. Алтны бичил уурхайг хэрхэн зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй, хууль бус гэж ялгадгийг та мэдэх үү?
5. БУ газрын зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдаг уу?
6. Танд сайжруулах санал байна уу?

7. Та орон нутгийн засаг захиргаатай хэрхэн хамтарч ажилладаг вэ? Тэд БУ үйл ажиллагааг хэрхэн дэмждэг вэ?
8. Та албан ёсны санхүүгийн байгууллагаас зээл авч чаддаг уу? Хэрэв тийм бол ямар санхүүгийн байгууллага вэ? Авсан зээлээ юунд зарцуулдаг вэ? Хэрэв үгүй бол яагаад? Хэрэв зээл авч чадвал та юунд зарцуулах вэ?
9. Таны бодлоор эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд зээл авахад ямар нэг хүндрэл бэрхшээл гардаг уу?
10. Та санхүүгийн бүртгэл, тэмдэглэл хөтөлдөг үү?
11. Та орон нутагтаа нийгмийн ямар, ямар үйлчилгээнд хамрагддаг вэ? (боловсрол, эрүүл мэнд, хүүхэд)
12. Орон нутгаас ямар төрлийн нийгмийн үйлчилгээ авдаг вэ? (жишээлбэл: боловсрол, эрүүл мэнд, сургууль, цэцэрлэгийн гэх мэт)
13. Нийгмийн үйлчилгээ авахад бэрхшээл тулгардаг уу?
14. Танай байгууллагад нөхөн сэргээлтийн төлөвлөгөө байгаа юу? Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлдэг вэ?
15. Нөхөн сэргээлтийн дундын санд мөнгө өгдөг үү?
16. Танай байгууллагад хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг хэн төлөвлөж, шийдвэр гаргадаг вэ?
17. Та мөнгөн усны талаар юу гэж боддог вэ?
18. Хөдөлмөрийн хүйсийн хуваарилалтад үндэслэн мөнгөн усны хэрэглээнд хамгийн эмзэг бүлгүүд (эрэгтэй, эмэгтэй, хүүхдүүдэд) хэн бэ?
19. Мөнгөн усны хэрэглээг бууруулах талаар саналаа хэлнэ үү?
20. Танай байгууллага гишүүд болон бичил уурхайчдаас гомдол санал хүлээн авдаг уу? Ямар төрлийн санал, гомдол/хэр их/хэрхэн шийдвэрлэдэг?
21. Эрэгтэй эмэгтэй уурхайчдын дунд ажлын хуваарилалт ямар байдаг талаар тайлбарлана уу?
22. Ерөнхийдөө жендэрийн асуудал уурхайн олборлолтын талбайд ямархуу байдалтай байдаг вэ? Эрэгтэй, эмэгтэй хүмүүс адил эрх, боломжтой байдаг уу эсвэл санхүүгийн үйлчилгээнд хамрагдах байдал, технологи, мэдээлэл, сургалт, албажуулалттай холбоотойгоор бэрхшээл тулгардаг уу?
23. Гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийлэл гарч байсан уу? Хэрэв тийм бол жишээ дурдах?
24. Эмэгтэй уурхайчдад орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай харилцахад хүндрэл гардаг уу?
25. Таны бодлоор хариуцлагатай бичил уурхай гэж юу вэ?
26. Сургалтын хэрэгцээ: Танд албажуулалт, байгаль орчин, нийгмийн мониторинг, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, мөнгөн усны нөлөөлөл, алтны нийлүүлэлтийн сүлжээ, жендэр, хууль эрх зүйн чиглэлээр ямар нэгэн сургалтын хэрэгцээ байгаа юу? (эмэгтэйчүүдэд эдгээрээс өөр хэрэгцээтэй байдаг эсэх). Бичил уурхайн салбар дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүст тусгайлан зориулсан сургалтын хэрэгцээ шаардлага байдаг уу?
27. БУ-д олон нийт сөргөөр ханддаг уу? Та бичил уурхайчдын талаар нийгэмд яаж зөв ойлголт өгөөсэй гэж хүсэж байна вэ?

Олборлолтын талбай дахь бичил уурхайчдын бүлэг (нөхөрлөлийн ахлагч нарыг оролцуулан)

Алтны худалдаачид

Асуултууд:

1. Та алтны худалдаачнаар хэдэн жил ажиллаж байна вэ?
2. Таны өдөрт/долоо хоногт/сард худалдаж авдаг алтны хэмжээ?
3. Таны худалдаж авдаг/худалддаг алтны үнэ хэд байдаг вэ? Үнээ хэрхэн тогтоодог вэ?
4. Таны худалдаж авдаг алтны төрөл/хэлбэр/хэмжээ ямар байдаг вэ? (нунтаг ширхэглэг/нунтаг/спонж алт (парлонон хэлбэртэй)/хайлуулж хэвлэсэн)
5. Худалдан авсан алтаа хүний нэрээр/байршил/сорьц -оор нь тэмдэглэл хөтөлдөг үү?
6. Танай нутгийн алтны сорьц/агууламж хэд байдаг вэ?
7. Та хэдэн уурхайчнаас /нөхөрлөлөөс алт худалдан авдаг вэ?
8. Та алт худалдан авахдаа алтны сорьцыг хэмжихийн тулд ямар төхөөрөмж, багаж ашигладаг вэ?
9. Та үйлчлүүлэгчээсээ алтаа хэрхэн боловсруулсан талаар асуудаг уу?
10. Та уурхайчдад/алтны БУ нөхөрлөлд зээл өгдөг үү?
11. Та уурхайчдад/алтны БУ нөхөрлөлд өөр ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?
12. Та одоогийн ажилтайгаа холбоотой ямар нэгэн сургалтад хамрагдах хэрэгцээ байна уу?
13. Та хэнд алтаа худалддаг вэ?
14. Хэр зэрэг тогтмол хугацаанд алтаа худалддаг вэ?
15. Алтаа худалдаахаасаа өмнө хэр зэрэг хэмжээний алтыг худалдан авах чадвартай байдаг вэ?
16. Та Монгол банканд алтаа өгч байсан уу?
17. Хэрэв тийм бол Монгол банканд ямар мэдээлэл, бичиг баримт, анкет шаарддаг вэ?
18. Монгол банк танаас алтныхаа гарал үүслийг тодорхойлохыг шаарддаг уу?
19. Монгол банкнаас илүү ханш өгдөг алтны худалдаачид байдаг уу?
20. Монгол банкны алт худалдан авах нөхцөлийн (үнийн нөхцөл, төлбөрийн хугацаа, төлбөрийн арга, процесс) талаар танд санал байна уу?
21. Монгол банкны алт худалдан авалтыг сайжруулахад танд санал байна уу?
22. Та алт худалдаалах албан ёсны зөвшөөрөлтэй юу?
23. Та алтны худалдаа эрхлэгчдийг баталгаажуулах шинэ журмын талаар мэдэх үү?
24. Хэрэв тийм бол та баталгаажуулалтад хамрагдах уу?

Баяжуулах цех

Асуултууд:

1. Алтны хүдрийг хэрхэн боловсруулдаг вэ? Боловсруулах явц/үйл ажиллагааны диаграммыг тайлбарлана уу? (ямар үе шатанд ямар химийн болон хортой бодис ашигладаг)? Цэвэршүүлэх (хайлуулах) процессын дэлгэрэнгүй мэдээлэл, ашигласан химийн бодисын дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэглээ? Та үүнийг яаж худалдаж авдаг вэ, үнэ нь хэд вэ? Эдгээр химийн бодисын гаж нөлөөг та мэдэх үү? Цэвэршүүлсний дараа химийн хог хаягдлыг хаана хаядаг вэ? Та тэдгээрийг үйлдвэрт хэрхэн хадгалдаг вэ?

2. Нийт тоног төхөөрөмжийн мэдээлэл? Эдгээрийг хаанаас худалдан авсан вэ?
3. Баяжуулах цех/үйлдвэр байгуулах зөвшөөрөл, барилгын ажилд хэр их цаг хугацаа, мөнгө зарцуулсан бэ?
4. Та болон уурхайчдын аюулгүй байдал, аюулгүй байдлын стандарт / журмыг хэрхэн дагаж мөрддөг вэ? Танай байранд аюулгүй байдлын эрсдэл байна уу?
5. Танай байгууллагад хэчнээн ажилтан ажилладаг ба тэд ямар үүрэгтэй байдаг вэ? Ажилтнууд яаж цалинждаг, тэдэнд ямар урамшуулал олгодог вэ? Боловсруулах үйл ажиллагаанд уурхайчид оролцдог уу?
6. Өдөр бүр / долоо хоногт / сар бүр боловсруулдаг хүдрийн хэмжээ хэд вэ?
7. Өдөр бүр / долоо хоног тутам / сар бүр олборлосон/хайлуулдаг алтны хэмжээ хэд вэ?
8. Өдөрт/ долоо хоногт/ сард хэдэн уурхайчин /үйлчлүүлэгч байдаг вэ?
9. Танай хүдэр боловсруулах төлбөр хэд вэ?
10. Нэг тонн хүдэр боловсруулах зардал хэд вэ?
11. Өдрийн/ сарын боловсруулах үйл ажиллагааны зардал хэд вэ? Цахилгаан, ус, химийн бодисын ... гэх мэт
12. Өдөрт/ долоо хоногт / сард хэр хэмжээний ус, цахилгаан хэрэглэдэг вэ? Хэрэглээний хомсдол бэрхшээлтэй тулгардаг уу?
13. Үйлдвэр/цех ажиллах хугацаандаа боловсруулан гаргадаг алтны хувь хэд вэ?
14. Шламны боловсруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл? Уурхайчдын хүдрийг боловсруулсны дараа та шламыг яадаг вэ? Уурхайчдад буцааж өгдөг эсвэл алтны цианидын үйлдвэрт зардаг уу, эсвэл өөр аргаар?
15. Алтны цианиджуулах үйлдвэрт зардаг бол нэг тонноос хэдэн төгрөгийн орлого олдог вэ?
16. Өдөрт / долоо хоногт/ сард хэчнээн хэмжээний хаягдал шлам гардаг вэ?
17. Хаягдал шламын цөөрмийн хэмжээс ба төрлийн дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү? Өвлийн улиралд хаягдлыг хэрхэн яаж зохицуулах вэ? Хаягдлын цөөрмөөс усыг эргэлт болгон ашиглаж байна уу?
18. Цех байгуулахад ямар зөвшөөрөл, албан ёсны баримт бичгийг шаардлагатай вэ? Жишээ нь: газар, цахилгаан, усны худаг, байгаль орчин, химийн, ТЭЗҮ гэх мэт.
19. Танай байгууламжид цианид уусмал ашиглах зөвшөөрөлтэй юу? Яагаад, яагаад үгүй гэж? Та цианидын зөвшөөрөл авахаар оролдож байсан уу? Хамгийн том саад бэрхшээлүүд юу вэ? Та цехдээ цианид эсвэл бусад төрлийн химийн уусмал ашиглах үү?

Том уурхайн компаниуд

Асуултууд:

1. Том уурхайн нэр болон байршлуудыг хэлж өгнө үү?
2. Та хүдэр боловсруулахдаа ямар арга хэрэглэдэг вэ? (Боломжтой бол ямар химийн бодис, ямар түвшин/хэмжээнд ашигладаг талаар хэлж өгнө үү?)
3. Өдөрт/7 хоногт/сард хэдий хэмжээний хүдэр боловсруулдаг вэ?
4. Анхдагч хүдрийн алтны агуулга ерөнхийдөө ямар хэмжээтэй байдаг вэ?
5. Алтны сорьцын хэмжээ ямар байдаг вэ?

6. Алтны бичил уурхайн тухай ямар зураглал эсвэл мэдлэг, ойлголттой байна вэ? Алтны бичил уурхайн тухай ямар мэдээллийн эх үүсвэр сурвалжид илүү итгэлтэй байдаг вэ?
7. Та алтны бичил уурхайтай хамтран ажилладаг уу? Хамтран ажиллах хүсэлтэй байдаг уу?
8. Алтны бичил уурхайтай холбоотой ямар нэгэн зөрчил, асуудал үүсэж байсан уу?
9. Та жижиг хэмжээний алт баяжуулах цехийн хаягдал, шлам худалдан авдаг бол, та дээж авах процессийг хэрхэн хийдэг вэ? 1 тонн хаягдал, шлам ямар үнэтэй вэ?

Орон нутгийн байгаль орчны байцаагч

Асуултууд:

1. Алтны бичил уурхайн нөхцөл байдлын талаар та ерөнхий мэдээлэл өгнө үү?
2. Энэ салбарт тулгамдаж буй гол асуудлууд юу вэ?
3. Газрын зөвшөөрөлтэй бичил уурхай хэр их байна вэ? (хэдэн газар/газрын хэмжээний хувьд хэдэн м.кв, хэдэн нөхөрлөл)
4. Танай орон нутагт ерөнхийдөө зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй уурхайчид хэд байдаг вэ?
5. Зөвшөөрөлгүй алтны бичил уурхайг багасгах талаар ямар нэгэн бодлого/стратегии/төлөвлөгөө хэрэгжүүлж байгаа юу?
6. Алтны бичил уурхайн үйл ажиллагааг зөвхөн зөвшөөрөлтэй газруудад зохистой хэрэглэх тал дээр хяналт тавьж ажиллах цаашдын бодлого юу вэ?
7. Бичил уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөө үзүүлсэн газруудын байршлыг хэлж өгнө үү.
8. Байгаль орчинд нөлөө үзүүлсэн нийт газар нутгийн хэмжээ хэд вэ? (га)
9. Нийт нөхөн сэргээсэн газар нутгын хэмжээ хэд вэ? (га)
10. Орон нутгын санхүүжилт ашиглан нөхөн сэргээлтийг хийх ажил дээр танайх хяналт тавьдаг уу? Хэрхэн хяналт тавьдаг вэ?
11. Байгаль орчны яамтай ямар түвшинд хамтран ажилладаг вэ? Мөнгөн усны хэрэглээг багасгах эсвэл хориглох тал дээр үндэсний/аймгийн/орон нутгийн хэмжээнд стратеги төвлөвлөгөө бий юу?
12. Алтны бичил уурхайтай холбоотой ямар нэгэн сурталчилгаа, арга хэмжээ эсвэл үйл ажиллагаа зохион байгуулдаг уу?
13. Танд planetGOLD төслийн үйл ажиллагааны хүрээнд хамрагдахыг хүсэж буй сургалтын хэрэгцээ байна уу?

Орон нутгийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын газар

Асуултууд:

1. Хэдэн нөхөрлөлийн гишүүд/уурхайчид эрүүл мэнд, нийгмийн даатгалаа төлдөг вэ?
2. Сард дунджаар эрүүл мэнд, нийгмийн даатгалд хэдийг төлдөг вэ?
3. Уурхайчид эрүүл мэнд болон нийгмийн ямар төрлийн үйлчилгээ авдаг вэ?

4. Таны бодлоор мөнгөн ус болон бусад химийн бодис хэрэглэснээр ямар эмзэг бүлгийн хүмүүсийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна вэ? Яагаад?
5. Уурхайчид ямар нэгэн мэргэжлийн онцлоготой өвчинд өртдөг үү?

Нийгмийн бодлогын мэргэжилтэн / Нийгмийн халамжийн ажилтан

Асуултууд:

1. Уурхайчид ямар нийгмийн асуудлуудтай тулгардаг вэ? Эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн хувьд ялгаатай байдаг уу?
2. Танай орон нутагт жендэр дээр суурилсан хүчирхийлэл эсвэл гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлууд бий юу? Уурхайчдын хувьд ямар байдаг бол? Таны бодлоор ямар шалтгаанаас үүсдэг вэ?
3. Хэр олон уурхайчид нийгмийн халамжийн үйлчилгээ авах боломжтой байдаг вэ? Эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн хувьд ямар саад бэрхшээл тулгардаг вэ?
4. Таны бодлоор алтны бичил уурхайчдын санхүүгийн, технологийн, мэдээллийн, сургалтын, албажих байдлын тал дээр ямар асуудал тулгардаг вэ? Уурхайчдад илүү боломж бололцоо бий болгохын тулд юу хийгдэх ёстой вэ? Нийгмийн зүгээс гарах сөрөг хандлагаас болж алтны бичил уурхайчид нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх тохиолдол байдаг уу?
5. Уурхайчдад зориулсан санал болгох тодорхой сургалтын сэдэв бий юу? Хэд хэдэн жишээ хэлж өгнө үү.

Орон нутгийн байгаль орчны идэвхитэн, идэвхитэй иргэд

Асуултууд:

1. Алтны бичил уурхайн нөхцөл байдлын талаар та ерөнхий мэдээлэл өгнө үү?
2. Энэ салбарын гол асуудлууд юу вэ?
3. Бичил уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн байгаль орчны нөлөөлөлтэй газруудын байршлыг хэлж өгнө үү.
4. Таны бодлоор алтны бичил уурхайн үйл ажиллагаа нь хүний эрүүл мэнд, байгаль орчин ба хүрээлэн орчинд ямар нөлөөлөл үзүүлж байна вэ?
5. Мөнгөн усны хэрэглээг багасгах эсвэл хориглох тал дээр холбогдох яамдын зүгээс одоо хэрэгжүүлж буй стратеги төвлөвлөгөөнүүд байна уу?
6. Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай ямар түвшинд хамтран ажилладаг вэ?
7. Танд planetGOLD төслийн үйл ажиллагааны хүрээнд хамрагдахыг хүсэж буй сургалтын хэрэгцээ байна уу?

Орон нутгийн иргэдийн төлөөлөл (малчид, иргэд)

Асуултууд:

1. Та алтны бичил уурхайн талаар хэр зэрэг /ямар ойлголттой байдаг вэ?
2. Та алтны бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байсан удаа бий юу?
3. Та алтны бичил уурхайн байршлуудыг мэдэх үү?

4. Алтны бичил уурхайн эерэг болон сөрөг нөлөөлөл юу бэ?
5. Гол нөлөөлөл юу вэ?
6. Танай орон нутаг алтны бичил уурхайнуудын үйл ажиллагаатай холбоотой зөрчилдөөн байдаг уу?
7. Таны бодлоор танай орон нутагт алтны бичил уурхайтай холбоотой ямар том асуудлууд байдаг вэ? Яагаад тэгэж бодож байна вэ?

Орон нутгийн төрийн бус байгууллага (жендэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг)

Асуултууд:

1. Танай орон нутагт жендэртэй холбоотой ямар асуудлууд байдаг вэ? Таны бодлоор нийгэм дахь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн үүрэг оролцооны ялгаа юу бэ?
2. Таны бодлоор эмэгтэй уурхайчид уурхайд ямар ажил хийдэг/эрхэлдэг вэ?
3. Таны бодлоор алтны бичил уурхайн холбоотой ямар асуудал тулгардаг вэ? Яагаад тэгэж бодож байна?
4. Таны бодлоор эрэгтэй эмэгтэй хүмүүсийн санхүүгийн болон бусад нөөц ашиглах боломж бололцоо (санхүү, тоног төхөөрөмж, хэрэгсэл ба мэдээлэл) адилхан байдаг гэж бодож байна уу? Яагаад?
5. Эрэгтэй болон эмэгтэй хүмүүс нийгмийн халамжийн үйлчилгээ авахад ямар саад бэрхшээл тулгардаг вэ? Энэ нөхцөл байдлыг хэрхэн сайжруулах вэ?
6. Таны бодлоор эмэгтэйчүүдийг болон бусад эмзэг бүлгийг хэрхэн чадавхжуулах вэ? Иргэний нийгмийн байгууллагууд энэ тал дээр юу хийж чадах вэ?
7. Та өнгөрсөн 3-н жилийн хугацаанд ямар сургалтанд хамрагдсан бэ? (сургалтын сэдэв)
8. Та жендэрийн холбогдолтой ямар сургалтанд хамрагдахыг хүсэж байна вэ? Та жишээ болгож дурдана уу.
9. Алтны бичил уурхайн салбарын хүрээнд жендэрийн сургалтанд ямар сэдэв оруулах шаардлагатай гэж бодож байна вэ?

Орон нутгийн мэргэжлийн хяналтын газар, мэргэжлийн хяналтын байцаагч

Асуултууд:

1. Алтны бичил уурхайн нөхцөл байдлын талаар та ерөнхий мэдээлэл өгнө үү?
2. Алтны бичил уурхайд мөнгөн усны хууль бус импортын тохиолдол гардаг уу? Хаана гардаг вэ?
3. Та мөнгөн усны хэрэглээг хэрхэн тодорхойлж, хэмждэг вэ?
4. Аймаг, сум(багт хэдэн мэргэжилтэн) ажилчин ажилладаг вэ?
5. Танай орон нутгийн алтны бичил уурхайн бүсэд хүрээлэн буй орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөний талаарх хяналтын тайлан байдаг уу?
6. Алтны бичил уурхайн чиглэлээр ХАБЭА-н шаардлагыг хангаагүйн улмаас гарсан осол, аваарын талаарх тайлан байгаа юу? Хэрэв гарсан бол тухайн

осол гэмтлийн төрөл, нас баралтын түвшин, ослын шалтгааны статистик мэдээллийн жилээр гаргаж өгнө үү?

7. Мөнгөн ус их хэмжээгээр хэрэглэдэг байршлуудыг мэдэх үү? Мэддэг бол хэлж өгнө үү?
8. Танд байгаа мэдээллээр одоогоор ямар хэмжээний мөнгөн ус аль байршил, сумдад хэрэглэгдэж байгаа вэ?
9. Та мөнгөн усны хэрэглээг хэрхэн хэмждэг вэ? Мөнгөн усны хэрэглээг хэмжих тусгай тоног төхөөрөмж/хэрэгсэл бий юу?
10. Мөнгөн усны хэрэглээг бууруулах орон нутгийн стратеги, төлөвлөгөө байгаа юу?
11. Мөнгөн усны хэрэглээнээс үүдэлтэй байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах зорилгоор ямар нэгэн сурталчилгаа, арга хэмжээ, зохион байгуулдаг уу? Хэрхэн, ямар давтамжтай зохион байгуулдаг вэ? Хэрэв тийм бол үндсэн санаа нь юу вэ? Мөнгөн усыг хэрэглэх сөрөг үр дагаврыг дөвийлгөн айдас төрүүлэх болон мөнгөн уснаас зайлсхийх эерэг үр дагаврыг хэрхэн яаж тэнцвэржүүлэн санаагаа хүргэдэг вэ?
12. Таны бодлоор мөнгөн усны хууль бус хэрэглээг хэрхэн бууруулах/хориглох вэ?
13. Таны бодлоор уурхайчдад ямар сургалт хэрэгтэй вэ? Жижиг уурхайн ажилчдад хэрэгтэй сургалт, семинарын сэдвүүдийг бидэнтэй хуваалцана уу?
14. Цаашид сайжруулан хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмж өгнө үү.

Орон нутгийн Цагдаагийн газар

Асуултууд:

1. Алтны бичил уурхайн нөхцөл байдлын талаар та ерөнхий мэдээлэл өгнө үү?
2. Хэрэв боломжтой бол, Экологийн цагдаагийн ерөнхий үүрэг, ялангуяа алтны бичил уурхайтай холбоотой ямар үүрэгтэй талаар тайлбарлаж өгнө үү?
3. Алтны бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээ/байршил/хууль бус худалдааны талаарх мэдээлэл, тоо баримт байвал хуваалцана уу?
4. Танай орон нутагт гэмт хэргийн ерөнхий түвшин, тухайлбал жендэрт суурилсан хүчирхийлэл ямар байдаг вэ?
5. Алтны бичил уурхайн салбартай холбоотой бүртгэгдсэн хүчирхийллийн тохиолдол, гэмт хэрэг үүсэх нөхцөл байгаа юу?

Хавсралт Г: Жендэрийн гүнзгийрүүлсэн судалгааны арга зүй

Бичил уурхай дахь Жендэрийн гүнзгийрүүлсэн судалгаа

Гүнзгийрүүлсэн ярилцлагын зорилго

Энэхүү нөхцөл байдлын судалгааны хүрээнд орон нутгаас мэдээлэл цуглуулах явцад planetGOLD Монгол төслийн ажилтнууд Нөхцөл байдлын судалгаа болон мэргэжлийн хүмүүстэй хийх ганцаарчилсан ярилцлагын үед бүрэн илрэхгүй байж болзошгүй, эмэгтэй бичил уурхайчдад тулгардаг асуудлуудыг тодорхойлохын тулд манлайлал, шийдвэр гаргах эрх мэдэл, ажлын байр ба өрхийн түвшин дэх орлогын хуваарилалт, хувь хүний хөгжил/сургалтад хамрагдах боломж, хүртээмж, жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, эрүүл мэндийн асуудал, архи согтууруулах ундааны хэрэглээ зэрэг АБУ-н олон талт асуудлыг хамарсан жендэрийн судалгааг тусад нь хийсэн болно. Эдгээр сэдэв нь маш эмзэг нарийн асуудал тул албан ёсны ярилцлагын явцад асуултанд хариулахад эмэгтэйчүүдэд таагүй мэдрэмж төрүүлж болзошгүй, ердийн стандарт асуулгаар цуглуулсан мэдээлэл нэг талыг барьсан өрөөсгөл байж болно. Тиймээс эдгээр сэдвүүдийн талаар эмэгтэй ярилцлага авагч нарыг оролцуулан асуулга, ярилцлага хосолсон хагас бүтэцтэй гүнзгийрүүлсэн ярилцлагыг тусад нь хийхээр шийдвэрлэсэн юм.

Гүнзгийрүүлсэн ярилцлага нь тухайн сэдвийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах нээлттэй хариулт бүхий асуулт, асуудлыг илрүүлэхэд чиглэсэн ярилцлагын хосолсон арга юм. Гүнзгийрүүлсэн ярилцлага нь чанарын судалгааны арга бөгөөд судалгаанд оролцогчийн санаа бодол, туршлага, мэдрэмж, хэтийн төлөв байдлыг гүнзгийрүүлэн судлах зорилготой юм. Мөн энэхүү ярилцлагаар төсөл хэрэгжиж байгаа бүс нутгийн эмэгтэй бичил уурхайчдад АБУ-д ажилласнаар бий болж байгаа боломж, давуу талуудыг олж илрүүлэхийг чухалчилсан болно. Эдгээр гүнзгийрүүлсэн ярилцлага нь Төсөл болон бичил уурхайчдын хооронд илүү сайн харилцаа холбоо бий болгох ач холбогдолтой гэж үзэж байгаа юм.

Дээрх зорилгод хүрэхийн тулд ярилцлагууд нь дараах бүтцийн дагуу явагдсан:

- АБУ-д эмэгтэй бичил уурхайчдад тулгардаг гол бэрхшээлүүд болон боломж, давуу талууд
- Шийдвэр гаргах болон нөөцийг хянах эрх мэдэл
- Ажил мэргэжлээс шалтгаалсан эрүүл мэндийн асуудлууд
- Мэдлэгийн зөрүү ба сургалтын хэрэгцээ
- Жендэрт суурилсан хүчирхийлэл ба ялгаварлан гадуурхалт

Түүврийн стратеги ба гүнзгийрүүлсэн ярилцлагын удирдамж

Түүврийн стратегийг боловсруулах: Бичил уурхайчдын дунд явуулсан нөхцөл байдлын судалгааны тоон мэдээлэл цуглуулах явцад жендэрийн сэдвийг сонирхдог, АБУ дахь жендэрийн талаарх мэдлэг, туршлагатай, мэдээлэл хуваалцах боломжтой эмэгтэй бичил уурхайчдыг ярилцлагад оруулахаар сонгосон. Ярилцлага авагч (төслийн ажилтан) эдгээр эмэгтэйчүүдээс АБУ дахь

жендэрийн талаар илүү дэлгэрүүлж ярилцах сонирхолтой байгаа эсэхийг асуусан болно. Судалгааны бүс нутаг тус бүрийн түүврийн хэмжээ болон урьдчилан тооцоолсон үргэлжлэх хугацааг дор үзүүлэв:

Судалгааны 5 бүс нутаг тус бүрийн зорилтот түүврийн хэмжээ: 6 эмэгтэй.

Ярилцлага тус бүрийн үргэлжлэх хугацаа: 30 минут

Гүнзгийрүүлсэн ярилцлагыг судалгааны 5 бүс нутаг болох Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол сум, Түнхэл тосгон, Ховд аймгийн Алтай, Жаргалант сум, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумдад явуулсан бөгөөд нийт 30 эмэгтэй бичил уурхайчин ганцаарчилсан ярилцлагад оролцов (Хүснэгт 1-ийг үзнэ үү).

Гүнзгийрүүлсэн ярилцлагын чиглүүлэх асуултууд:

Гүнзгийрүүлсэн ярилцлагын чиглүүлэх асуулт нь ярилцлагыг зохион байгуулах, ярилцлагын үеэр шаардлагатай бүх чухал сэдвүүдийг хамарч байгааг баталгаажуулах арга юм. Тиймээс төслийн багийнхан Монгол Улс дахь бичил уурхайн салбарын жендэрийн асуудлаар хийсэн жендэрийн дүн шинжилгээ (дотоод тайлан) болон газар дээр нь очиж ажиллах үеэр цуглуулсан мэдээлэл, ажиглалт (дотоод тайлан) дээр үндэслэн гүнзгийрүүлсэн ярилцлагын чиглүүлэх асуултыг боловсруулсан болно. Төслийн баг нь гүнзгийрүүлсэн ярилцлагын чиглүүлэх асуултуудыг дараах стратегид тулгуурлан боловсруулсан.

Судалгаанд оролцогчдын санаа бодлыг тодруулах зорилгоор нээлттэй хариулт бүхий асуултууд тавьсан.

Судалгааны өмнөх хариултуудыг илүү нарийвчлан нягтлах эсвэл дэлгэрүүлэх зорилгоор шалгах асуултуудыг ашигласан.

Чиглүүлэх асуултууд нь судалгаанд оролцогчид хариулахад хялбар, ойлгомжтой, энгийн байсан.

Ярилцлага авагч нар хариултад нөлөөлж болзошгүй гэдэг үүднээс жишээ татаж тайлбарлахад болгоомжтой хандсан.

Төслийн баг нь Алтны бичил уурхайн зөвлөлийн төв оффис дахь Эрүүл мэнд, жендэрийн хөтөлбөрийн менежерийн дэмжлэгтэйгээр дээрх стратеги дээр үндэслэн чиглүүлэх асуултуудыг бэлтгэв. Нарийвчилсан чиглүүлэх асуултуудыг Зураг 1-д заасны дагуу таван дэд ангидалд ангилав:

Зураг 1: Гүнзгийрүүлсэн ярилцлагын чиглүүлэх асуултууд

1. АБУ-н эмэгтэй бичил уурхайчдад тулгардаг гол бэрхшээлүүд болон давуу талууд

1. АБУ-д ерөнхийдөө ямар бэрхшээлүүд тулгарч байна вэ? Эмэгтэй хүний хувьд танд ямар нэг тодорхой бэрхшээл тулгардаг уу? Тухайлбал, та эмэгтэй учраас хийхийг зөвшөөрдөггүй ажил АБУ-д байна уу? Эсвэл хийхэд таагүй санагддаг тодорхой ажлууд байдаг уу? Итгэл үнэмшлийн талаарх уламжлалт зан заншил байдаг уу?
2. АБУ-д ажилласнаар эмэгтэйчүүдэд бий болдог боломж/давуу талууд юу вэ? Та үүнийг мэдэрч байсан уу?
3. Орон нутгийн үүл уурхайн байгууллагуудтай харьцахад танд хүндрэл бэрхшээл байдаг уу?

2. Шийдвэр гаргах болон нөөцийг хянах эрх мэдэл

1. Олборлолтын талбайд шийдвэр гаргах үйл явцад оролцоход эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд ялгаа байдаг уу? Шийдвэр гаргахад оролцоход танд болон бусад эмэгтэйчүүдэд ямар нэгэн бэрхшээл тулгардаг уу?
2. Орлогоо хуваахад эсвэл шударга үнийн талаар тохиролцоход эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд ялгаа байдаг уу?
3. Танд болон бусад эмэгтэйчүүдэд өрхийн хүрээнд шийдвэр гаргахад ямар нэгэн бэрхшээл тулгардаг уу?
4. Олборлолтын талбайд ажлын материал, багаж хэрэгслийг эрэгтэйчүүдтэй адилхан ашиглах боломжтой юу?
5. Санхүүжилт авах боломжтой юу? Санхүүжилт авахад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд ялгаа бий юу?

3. Мэргэжлээс шалтгаалсан эрүүл мэндийн асуудлууд

1. АБУ-д ажиллаж буй эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд онцгой эрсдэл байдаг уу? Эдгээр нь юу вэ? Хийхэд тааламжгүй, тухгүй санагддаг ажил, үүрэг байдаг уу?
2. Танай олборлолтын талбайд мөнгөн үс ашигладаг эсэхийг та мэдэх үү?
3. Мөнгөн үс нь хортой бөгөөд ялангуяа хөгжиж буй ураг болон хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүйг та мэддэг үү?

4. Хэрэгцээ/сургалтын хэрэгцээ

1. Таны хувьд мэдээлэл авах, сургалтанд хамрагдах боломжтой юу?
2. Хувь хүний хөгжлийн үр чадвараа дээшлүүлэхийн тулд бизнес, санхүү, эрүүл мэнд, жендэрийн мэдлэг гэх мэт ямар зүйлийг сурмаар байна вэ?
3. Сургалт нь эмэгтэйчүүдэд үр өгөөжтэй байхын тулд ямар байх ёстой вэ?
4. Эмэгтэй бичил уурхайчны хувьд байр сууриа бэхжүүлэхэд танд ямар нэгэн өөр дэмжлэг хэрэгтэй байна уу (жишээлбэл, эрх баригчидтай харьцахад гэх мэт)?

Хэрэв ярилцлагад орж байгаа хүнд мэдээлэл солилцоход тав тухтай байвал эмзэг сэдвүүдийн талаар ярилцаж болно.

5. Жендэрт суурилсан хүчирхийлэл ба ялгаварлан гадуурхалт

1. Жендэрт суурилсан хүчирхийлэл (ажлын байран дээр/гэртээ) эсвэл ялгаварлан гадуурхалттай тулгарсан эмэгтэйчүүдийн талаар та сонссон/харсан уу? Яагаад тийм зүйл болсныг тайлбарлаж өгөхгүй юу?
2. Таны бодлоор асуудлыг шийдвэрлэхийн тулд ажил дээрээ эсвэл гэртээ ямар зүйл хийх хэрэгтэй вэ?
3. Архи, согтууруулах ундааны хэт хэрэглээ, мансууруулах бодис хэрэглэх нь олборлолтын талбайд эсвэл бичил уурхайчдын дунд асуудал үүсгэдэг үү? Хэрэв тийм бол тайлбарлана уу?

Судалгааны бүс нутгуудад гүнзгийрүүлсэн ярилцлага зохион байгуулах

Төслийн баг судалгааны 5 бүс нутагт (Сэлэнгэ аймгийн Мандал, Түнхэл, Баянгол сум; Ховд аймгийн Алтай, Жаргалант сумд; Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум) ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан. Гүнзгийрүүлсэн ярилцлага хийхэд тав тухтай ярилцлагын уур амьсгал бүрдүүлэх нь чухал байдаг тул ярилцлагад оролцогчдод тохиромжтой, тохилог орчинд ярилцлага хийв. Төслийн 4 ажилтан (эмэгтэй ажилтнууд) өөр өөр бүс нутагт ярилцлага хийхээр томилогдсон. Эдгээр ярилцлагыг оновчтой хөтөлж явуулах, үр дүнгийн харьцуулалт хийх боломж бүрдүүлэх зорилгоор ярилцлага авагч төслийн ажилтнууд чиглүүлэх асуултуудыг удирдлага болгон ярилцлагыг хэрхэн, яаж явуулах талаар төслийн жендэрийн мэргэжилтнээс заавар зөвлөгөө авсан. Жендэртэй холбоотой мэдээлэл цуглуулах арга зүйн талаар planetGOLD-ын жендэрийн удирдамж (төслийн дотоод баримт бичиг)-д тусгасан болно.

Удирдамжийн дагуу ярилцлагыг амжилттай явуулахын тулд ярилцлагын үеэр идэвхтэй сонсогч байх, тэвчээртэй байх, чиглүүлэх асуултыг яриаг тасалдуулахгүйгээр уян хатан байдлаар ашиглах зэрэг зарим гол стратегийг

амжилттай нэвтрүүлсэн болно. Цаг хугацааны хувьд Гүнзгийрүүлсэн ярилцлагыг тоон судалгаатай нэг өдөр хийсэн тул зарим эмэгтэйчүүд гүнзгийрүүлсэн ярилцлагад удаан хугацаагаар оролцох сонирхолгүй байсан. Гэсэн хэдий ч судалгаанд оролцогчдын ихэнх нь судалгааны багийнханд цаг хугацаа хязгаарлагдмал байгааг ойлгож, хүлээн зөвшөөрч, ярилцлага хийхийг зөвшөөрсөн. Үүний үр дүнд зорилтот 5 бүс нутгийн 30 эмэгтэй бичил уурхайчинтай ганцаарчилсан ярилцлагыг амжилттай зохион байгуулж, зорилтот түүврийн хэмжээнд хүрсэн.

Хүснэгт Г-1. Ярилцлагад оролцсон эмэгтэй бичил уурхайчдын тоо, зорилтот бүс нутгаар

Аймаг	Сүм	Ярилцлагад оролцсон эмэгтэй бичил уурхайчдын тоо
Сэлэнгэ	Мандал	5
	Баянгол	5
	Түнхэл	6
Ховд	Алтай	5
	Жаргалант	3
Говь-Алтай	Есөнбулаг	6
Нийт		30

Ярилцлага авсан ажилтнууд ярилцлагад оролцогчдоос аман зөвшөөрөл авсны үндсэн дээр ярилцлагыг дуу хураагуур ашиглан бичиж авсан болно. Судалгааны 5 бүс нутгаас ярилцлага өгсөн хүмүүсийн зөвшөөрөлтэйгээр бүх ярилцлагуудын дуу бичлэг хийгдсэн. Хожим чанарын өгөгдлийн дүн шинжилгээ хийхэд ярилцлагыг текст хэлбэрт хөрвүүлсэн.

Гүнзгийрүүлсэн ярилцлагад дүн шинжилгээ хийх

Мэдээллийн дүн шинжилгээг дараах байдлаар хийсэн:

1. Ярилцлагын бүх дуу бичлэгийг шалгаж, аудио бичлэгийг бичмэл хэлбэрт хөрвүүлсэн;
2. Үндсэн сэдэв, уялдааг ангиллын дагуу өгөгдлийг кодлох замаар тэмдэглэлийг эмхэлж цэгцлэх;
3. Ярилцлагын бүх тэмдэглэлийг хуулж авч буулган нэг баримт бичиг болгох;
4. Ярилцлагад оролцогчдыг байршил болон тоогоор кодолж хүснэгтэд хуваарилах;
5. Асуултанд хариулагч бүрийн хариултын тэмдэглэлийг асуултанд (хариулагч тус бүрт 18 асуулт) нийцүүлэн хүснэгтэд ангилах;
6. Ангилсан тэмдэглэлүүдийг эрэмбэлэх, бүлэглэх, гүнзгийрүүлсэн ярилцлагын зорилгод нийцүүлэн нэгтгэн дүгнэх.

Мэдээллийн дүн шинжилгээний зорилго нь тухайн хариултуудын хэв маяг, харилцан хамаарлыг олж мэдэх, өөрөөр хэлбэл 18 асуултад өгсөн хариултууд хэр зэрэг төстэй эсвэл ялгаатай байгааг тодруулахад чиглэсэн. Иймд мэдээллийн дүн шинжилгээнд ярилцлагад оролцогчдын өгсөн хариултын давтамж, цар хүрээ, тулгамдсан байдал, өвөрмөц онцлог зэрэг чухал асуудлуудыг хамруулна.



planetGOLD

Making a world of difference
in small-scale gold mining.

A GEF Initiative



Санхүүжүүлэгч:



Үндсэн хэрэгжүүлэгч:



Хамтран хэрэгжүүлэгч:



UNITED NATIONS
INDUSTRIAL DEVELOPMENT ORGANIZATION



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



planetgold.org